

**МОНГОЛ УЛС ДАХЬ**  
**ХҮҮХДИЙН ЭРХИЙН**  
**НӨХЦӨЛ БАЙДЛЫН**  
**ҮНЭЛГЭЭ - 2020**



**Save the Children**

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХИЙН  
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

**2020**

ДАА 340.009  
ННА 67.3  
М-692

## ГАРЧИГ

Хүснэгтийн жагсаалт.....	7
Хураангуй.....	9
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ .....</b>	<b>11</b>
1. ТАНИЛЦУУЛГА .....	12
1 а. Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ – 2020 .....	13
1 б. Хүүхдийг Ивээх Сангийн тухай .....	15
2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР ОЙЛГОХОД СУУРЬ БОЛОХ МОНГОЛ УЛСЫН ТАЛААРХ ТОО БАРИМТ .....	16
2 а. Хүн ам, газар зүй, цаг уур, эдийн засаг, нийгэм, орчны бохирдол.....	17
Монгол Улсын хүн ам, газар зүй, цаг уур .....	17
Эдийн засгийн нөхцөл байдал .....	20
Нийгмийн нөхцөл байдал.....	31
Орчны бохирдол .....	58
2 б. Нэгдэн орсон олон улсын болон бүсийн хүний эрхийн гэрээ конвенц.....	62
2 в. Эрх зүйн болон улс төрийн тогтолцоо .....	65
Улс төрийн нөхцөл байдал .....	65
Хэвлэл мэдээллийн эрх чөлөө .....	76
Дэд хэсгийн дүгнэлт .....	77
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ .....</b>	<b>79</b>
3. НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ.....	80
3 а. Салбар дамнасан хүүхдийн эрхийн зарчим, тогтолцоо .....	81
Хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээ.....	81
Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомж.....	81
Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн төсөв, санхүүжилт.....	106
Ерөнхий зарчмууд.....	108
Хүүхдийн тодорхойлолт .....	109
Дэд хэсгийн дүгнэлт .....	109
3 б. Хүүхдийн эрхийн үндсэн сэдвүүд.....	111
<b>БОЛОВСРОЛ.....</b>	<b>111</b>
Сургуулийн өмнөх боловсрол.....	115
Ерөнхий боловсрол.....	118
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрх.....	124
Хэлний цөөнх хүүхдийн сурах эрх .....	128

### Судалгааг удирдаж, эмхэтгэн боловсруулсан, судалгааны багийн ахлагч:

Энхбатын Цолмон, Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

### Судалгааны багийн гишүүд:

Амарбаясгалангийн Хишигтөгс, Алтанхуягийн Алтанбаяр, Мөнхтөмөрийн Маралмаа, Базаррагчаагийн Отгон, Бадамцэцэгийн Баясгалан

ISBN: 978-99978-895-4-6

Малчдын хүүхэд .....	130
Боловсролын байгууллага дахь хүүхэд хамгаалал.....	133
Боловсролын санхүүжилт .....	137
Дэд хэсгийн дүгнэлт .....	138
<b>ЭРҮҮЛ МЭНД.....</b>	<b>140</b>
Эх хүүхдийн эрүүл мэнд ба эндэгдэл .....	142
Нялхсын эрүүл мэнд.....	146
Агаарын бохирдлын асуудал.....	148
Халдварт өвчний асуудал .....	150
Сэтгэцийн эрүүл мэнд.....	151
Хорт хавдрын өвчлөл .....	151
Осол, гэмтэл .....	152
Хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл.....	152
Хоол тэжээлийн асуудал.....	155
Иод дутал .....	155
Илүүдэл жин ба таргалалт.....	155
Өсөлт хөгжилт.....	155
Дархлаажуулалт .....	158
Нөхөн үржихүйн эрүүл мэнд.....	158
Цэвэр ус, усан хангамж .....	159
Ариун цэврийн байгууламжийн асуудал.....	160
Орчны аюулгүй байдлын асуудал.....	160
Нэгээс тав хүртэлх насны хүүхэд .....	162
5-19 насны хүүхдийн өвчлөл нас баралтын шалтгаан .....	163
Анхан ба лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ .....	168
Ядуу, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж.....	170
Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт.....	171
COVID-19 -ийн нөхцөл байдал .....	175
Эрүүл мэндийн бодлого.....	177
Дэд хэсгийн дүгнэлт .....	180
<b>ИРГЭНИЙ ЭРХ БА ЭРХ ЧӨЛӨӨ .....</b>	<b>183</b>
Ялгаварлан гадуурхалт .....	183
Хайр халамж .....	184
Шашин шүтэх эрх чөлөө.....	188
Гэмт хэрэг .....	192
Бүртгэл, шилжилт хөдөлгөөн.....	193
Мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэн оролцох эрх .....	199
Дэд хэсгийн дүгнэлт .....	201

<b>ХҮҮХЭД ХАМГААЛАЛ .....</b>	<b>203</b>
Тусгай хамгааллын арга хэмжээ: Хүүхдийн эсрэг гэмт хэрэг .....	203
Гэр бүлийн хүчирхийлэл .....	204
Хүн худалдаалах гэмт хэрэг .....	211
Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг ..	214
Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхэд .....	216
Хохирогч хамгаалалт .....	217
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль ба хэрэгжилт.....	220
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт .....	224
Хурдан морины уралдаанч хүүхэд.....	231
Хараа хяналтгүй, тэнэмэл хүүхэд .....	236
Дэд хэсгийн дүгнэлт .....	238
Гэр бүлийн орчин хүүхэд хамгаалал.....	238
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлийн орчин .....	250
Эцэг, эхийн эрх хасах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх.....	251
Хүүхэд үрчлэлт.....	252
Асрамж халамжийн үйлчилгээ.....	253
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамж .....	253
Үүргийн мөргөлдөөн.....	261
Дэд хэсгийн дүгнэлт .....	262
<b>САЛБАР ДАМНАСАН ХҮЧИН ЗҮЙЛС БА ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧИД .....</b>	<b>265</b>
Хүүхдийн эрхийн улсын байцаагч.....	265
Хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх нь .....	267
Хүүхдийн ядууралд өртөж буй нөхцөл байдал.....	268
Уур амьсгалын өөрчлөлт .....	270
Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхдийн эрх, хамгаалал .....	273
Цахим орчин дахь хүүхэд хамгаалал .....	276
Лесбиян, гей, бисексуал, трансжендер хүүхдүүд.....	278
Төсвийн зохистой хуваарилалт.....	281
4 б. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон оролцогч талуудын үүрэг.....	282
Хүүхдийг Ивээх Сангийн зөвлөмж .....	284
Эх сурвалж.....	293

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖАЙКА	Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
ЗЦГ	Замын цагдаагийн газар
ЛГБТ	Лесбиян, гей, бисексуал, трансжендер
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
НБГ	Нийслэлийн Боловсролын Газар
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХГБХГ	Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБЗНС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Онцгой Байдлын үед зарцуулах Нэгдсэн Сан
ОУБ	Олон улсын байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СЭЗДС	Санхүү, эдийн засгийн дээд сургууль
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
УИХ-ын ТГ	Улсын Их Хурлын Тамгын газар

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоодын хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭНБҮ	Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлт
Хүснэгт 2	Ядуурлын түвшин, гүнзгийрэлт
Хүснэгт 3	Хүний хөгжлийн индекс
Хүснэгт 4	Жендэрийн ялгаатай байдлын индекс
Хүснэгт 5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
Хүснэгт 6	ЕБС болон СӨБ-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бүсийн дүнгээр
Хүснэгт 7	Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн
Хүснэгт 8	Хүн амын нягтрал
Хүснэгт 9	Гамшигт үзэгдэл, хохирол
Хүснэгт 10	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд
Хүснэгт 11	Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн статистик мэдээлэл
Хүснэгт 12	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв
Хүснэгт 13	Боловсролын салбарын товч статистикийн мэдээлэл
Хүснэгт 14	СӨБ болон ЕБС-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр
Хүснэгт 15	Эх, хүүхдийн эрүүл мэнд

- Хүснэгт 16 Осол гэмтлээс үүдсэн нас баралт  
 Хүснэгт 17 Монгол хүүхдийн биеийн дундаж хэмжээ  
 Хүснэгт 18 5-19 насны хүүхдийн өвчлөл  
 Хүснэгт 19 Сүм хийдийн тоо  
 Хүснэгт 20 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо  
 Хүснэгт 21 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо  
 Хүснэгт 22 Өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр  
 Хүснэгт 23 Өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр шилжилт хөдөлгөөний өсөлт/бууралт  
 Хүснэгт 24 Гэрлэлт, цуцлалтын тоо  
 Хүснэгт 25 Монгол Улсад оршин суугаа хүүхдийн тоо, насны бүлгээр  
 Хүснэгт 26 Үрчлүүлсэн хүүхдийн тоо, насны бүлгээр  
 Хүснэгт 27 Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдийн тоо  
 Хүснэгт 28 Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг гэрээт байгууллагууд  
 Хүснэгт 29 Хүүхдийн орлогын болон олон хэмжээст ядуурлын нөхцөл байдал
- Зураг 1 Засаглалын үзүүлэлтүүд  
 Зураг 2 29 хоногтойгоос 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан 2018  
 Зураг 3 Нийслэлд орчны аюулгүй байдлыг алдагдуулж байгаа асуудал, тоогоор  
 Зураг 4 Нийслэлд орчны аюулгүй байдлыг алдагдуулж байгаа асуудлууд, төрлийн давтамжаар  
 Зураг 5 Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл  
 Зураг 6 Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаан  
 Зураг 7 Гэр бүлийн тухай хуулиар хэрэг хянан шийдвэрлэсэн байдал

## ХУРААНГУЙ

Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гарсаар байгаа хэдий ч бүсчилсэн тэнцвэртэй хөгжлийг бий болгож чадахгүй байгаатай холбоотой үүсэж буй хот суурин газрын хэт төвлөрөл, зарим аймаг сумдын хөгжлийн зогсонги байдал, орчны бохирдол, алслагдан нутаг дахь малчин ардын амьдралын хэв маяг, эрс тэс уур амьсгал, байгалийн гамшиг, улс төр, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг улс орны онцлогтой холбоотой олон бэрхшээл хүүхдийн эрхийг ханган ажиллахад тулгарсаар байна.

Тэгш эрхийг хуулиар хамгаалж буй боловч тэгш боломжийг олгож чадахгүй байна. Хөгжлийн урт, богино хугацааны бодлогуудыг хэрэгжүүлж буй боловч хэрэгжилтийн хөндлөнгийн хяналтын механизм хөгжөөгүй байна. Боловсрол, эрүүл мэнд, хамгаалал зэрэг нийгмийн үйлчилгээнд гарч буй ахиц дэвшил бүх хүүхдэд адил тэгш хүрэхгүй байгаа учраас нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, бусад зорилтот дэмжлэгийг бий болгох нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Тус улс тайлант хугацаанд хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийг богино хугацаанд үргэлжлүүлэн өрнүүлж байгаа боловч бодлогын уялдаа холбоогүй байдал, санхүү, хүний, институц, материаллаг баазын нөөц, чадавхын хязгаарлагдмал байдал зэргээс үүдэн тухайн чиглэлээрх хууль тогтоомж, бодлогуудын үр дүнтэй хэрэгжилтийг хангахад томоохон сорил, эрсдэлтэй тулгарч байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарсан, хүн амын үе үеийн эрх тэгш тэгш байдлыг хангасан, байгаль орчноо хамгаалсан, тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг бий болгох, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чадавхыг сайжруулах, засаглалыг бэхжүүлэх нь нэн чухал байна.

Хүүхдийн эрхийг цогцоор нь хэрэгжүүлэхэд системийн сэтгэлгээтэйгээр, хэмжигдэхүйц үр дүнд чиглэсэн, үр ашигтай ажиллах, хууль тогтоомж, бодлогын нотолгоонд суурилсан хэлэлцүүлгийг мэргэжлийн талуудыг оролцуулан, иргэний нийгмийн оролцоотойгоор тогтмолжуулж үр дүнг ашиглаж байх нь зүйтэй байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



# 1. ТАНИЛЦУУЛГА

## 1А ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ – 2020

Хүүхдийг Ивээх Сан (цаашид ХИС гэх) нь Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээг 2015, 2018 онд тус тус хийсэн. 2018 оны 6 дугаар сараас 2020 оны 7 дугаар сар хүртэлх Монгол Улс дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн ерөнхий дүр зургийг тодорхойлохоор Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээг (цаашид ХЭНБҮ гэх) 2020 оны 3 сарын 25-наас 7 сарын 25-ныг дуустал хийж гүйцэтгэв.

Тус үнэлгээг ХИС-гийн Олон улсын эвслийн боловсруулсан Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээний удирдамжид заасан үзэл баримтлал, зарчмын дагуу, тус байгууллагын Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрөөс ХИС-гийн Олон улсын эвслийн санхүүжилттэй гүйцэтгэсэн юм.

Тус үнэлгээг гүйцэтгэхдээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, баримт бичгийн судалгааны арга, оролцогч талуудын үүрэг хариуцлагын шинжилгээ, GAP шинжилгээ зэрэг олон төрлийн дүн шинжилгээний аргуудыг ашигласан. Анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх сурвалжуудад олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны ажил, хамтран ажилладаг байгууллагуудын тайлан, ХИС-гийн хөтөлбөрийн ажилтнууд болон хамтран ажилладаг байгууллагын ажилтнуудтай хийсэн ярилцлага, албаны хүмүүсийн ярилцлага, мэдээлэл, хүүхдүүд, эцэг эх, багш нартай ярилцсан ярилцлага зэрэг олон төрлийн эх сурвалж хамаарна. Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээг гүйцэтгэсэн баг нь анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх сурвалжуудыг хамтран цуглуулж боловсруулсан. Үнэлгээний хугацаанд хамаарах шинэчлэгдсэн мэдээлэл олдоогүй сэдвүүдэд 2018 оны үнэлгээний товхимолд орсон мэдээллийг ашигласан болно.





**7 удаагийн  
цахим уулзалт,  
7 удаагийн  
хэлэлцүүлгийг  
зохион байгуулав.**

Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ-2020 судалгааг хийх үед дэлхий дахинаа шинэ төрлийн коронавирус буюу COVID-19 цар тахал дэлгэрсэн, Монгол Улс Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн байлаа. 2020 оны 7 сарын 25-ны байдлаар 15.6 сая хүн өвчилж, 639 мянган хүн нас барсан бөгөөд Монгол Улсад 288 зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдсэн байв. Мөн Монгол Улс төдийгүй дэлхийн улс орнууд сургалт, боловсролын байгууллагыг бүрэн хааж, хөл хориог тогтоосноос үүдэн бид олон тооны хүний хурал цуглаан, хэлэлцүүлэг зохион байгуулаагүй бөгөөд шаардлагатай эх сурвалжуудыг хэвлэмэл болон албан ёсны цахим эх сурвалжууд, ХИС-гийн нөөц материалуудыг ашиглан, утсаар болон онлайнгаар ярилцлагад тулгуурлан тус үнэлгээг хийлээ. Үнэлгээг хийхдээ нийт 7 удаагийн цахим уулзалт, 7 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж аюулгүй байдлыг ханган ажиллалаа.



15

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ТУХАЙ



Олон улсын, бие даасан хүүхдийн эрхийн байгууллагын хувьд ХИС нь дэлхий нийтийн хүүхдэд хандах хандлагад төдийгүй хүүхдийн амьдралд нэн шаардлагатай болон урт хугацааны, тогтвортой өөрчлөлт, дэвшлийг бий болгохыг зорьдог. ХИС нь 1919 онд Англи улсад байгуулагдсан ба өдгөө дэлхийн 120 гаруй улсад үйл ажиллагаагаа явуулж байна. Үүсгэн байгуулагч хатагтай Еглантин Жебб нь хүүхдийн эрхийн асуудлыг олон улсад анх дэвшүүлэн тавьж, Хүүхдийн эрхийн тунхагийг боловсруулсан ба тунхагийг Үндэстнүүдийн Холбоо 1924 онд баталж, улмаар 1989 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцод тусгагдсан. Нэгэн зуун жилийн турш бид онцгой байдлын үе дэх хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаас эхлэн урт хугацааны хүүхдийн хөгжлийн асуудлуудад анхаарч, хүүхдийг өөрт байгаа боломж бололцоогоо бүрэн дүүрэн нээх, ашиглахад нь тусалж, тэдний эрхийг бүхий л салбарт хангахын төлөө ажиллаж ирлээ. Хүүхдийг Ивээх Сан нь Монгол Улсад 1994 оноос тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. 1994-2009 онд Английн Хүүхдийг Ивээх Сангийн, 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор Монгол Улс дахь Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргагүйг танилцуулахыг чухалчлан ажиллаж байна. Бид айл өрхийн түвшинд хүүхдүүд, гэр бүлд эерэг өөрчлөлтийг бий болгохын сацуу үндэсний хэмжээнд хүүхдэд ээлтэй боловсрол, хамгааллын тогтолцоог цогцлоохын төлөө ажиллаж байна.<sup>1</sup>



ХИС-гийн 2019-2021 оны стратеги төлөвлөгөө нь боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, хүүхдийн ядуурлыг бууруулах арга хэмжээ, эрүүл мэнд, хүмүүнлэгийн тусламж үйлчилгээний чиглэлд үйл ажиллагаагаа чиглүүлж байна. ХИС-гийн 2019-2021 оны стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын хүүхдийн эрхийн нөхцөлд тохирсон, тус байгууллагын ололт амжилтыг харгалзсан, мөн Монгол Улс дахь Хүүхдийг Ивээх Сан нь ХИС-гийн Олон улсын эвслийн бүрэлдэхүүнд багтахын хувьд, олон улсын хэмжээнд ХИС-гийн 2030 онд гэхэд хүрэх хөтөлбөрийн зорилготой нийцүүлэн боловсруулагдсан юм.

<sup>1</sup> Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2018, 13-р тал

## 2. ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР ОЙЛГОХОД СУУРЬ БОЛОХ МОНГОЛ УЛСЫН ТАЛААРХ ТОО БАРИМТ

2A

### ХҮН АМ, ГАЗАР ЗҮЙ, ЦАГ УУР, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ОРЧНЫ БОХИРДОЛ

#### Монгол Улсын хүн ам, газар зүй, цаг уур

Монгол Улс нь Азийн эх газрын төв хэсэгт хойд өргөргийн 410 35' – 520 08', зүүн уртрагийн 870 44' – 1190 55'-ийн хооронд оршдог, нийт 1,564,116 км квадрат нутаг дэвсгэртэй, нэг квадрат километрт 2 хүн ноогддог дэлхийн хамгийн бага хүн амын нягтшилтай. Монгол Улсын хилийн нийт урт 8252.7 км, хойд талаараа Оросын Холбооны Улстай 3543 км, өмнө талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 4709.7 км хиллэдэг. Нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 2392 км, хойноос өмнө цэг хүртэл 1259 км, нийт 1564.1 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Монгол Улсын нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш дунджаар 1580 метр өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Хүйтэн уулын оргил 4374 метр, хамгийн нам цэг нь Хөх нуурын хотгор 532 метр болно. Нийслэл Улаанбаатар хот далайн түвшнээс дээш 1350 метрт оршдог. Монгол Улс нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ дэлхийд 19 дүгээр байранд ордог.<sup>2</sup> Манай орны хувьд эдийн засгийн эргэлтэд орсон газар нутгийн хэмжээ нийт нутаг дэвсгэртэй харьцуулахад харьцангуй бага, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах газрын нөөц Улаанбаатар хотоос бусад байршилд хангалттай хэмжээтэй байгаа юм.<sup>3</sup>

<sup>2</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>3</sup> Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн хүрээ (2018-2025), iv тайлан, УХГ, НҮБ, 2018 он, 7-р тал



**Нийт хүн амын  
36.8% буюу  
1,213,279 нь  
0-18 насны  
хүүхэд байна.**


Монгол Улсын хүн ам 2019 онд 3,296,866 болсон бөгөөд нийт хүн амын 36.8% буюу 1,213,279 нь 0-18 насны хүүхэд байна. Үүний 31.78%-ийг 0-4 насны, 30.74%-ийг 5-9 насны, 23.04%-ийг 10-14 насны, 14.44%-ийг 15-18 насны хүүхэд эзэлж байна.<sup>4</sup> Ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1358.6 мянга байгаагаас 730.6 (53.8%) мянга нь эрэгтэй, 628.0 (46.5%) мянга нь эмэгтэйчүүд байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн амын 1253.0 (92.2%) мянга нь ажиллагчид, 105.6 (7.8%) мянга нь ажилгүй иргэд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам 868.0 мянга байгаагаас 320.7 (36.9%) мянга нь эрэгтэй, 547.3 (6.1%) мянга нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг шалтгаанаар нь авч үзэхэд тэтгэвэрт байгаа, өндөр настан хүмүүс 280.0 мянга, сурахаар явах гэж байгаа болон суралцагчид 261.1 мянга, хүүхэд асарсан 117.2 мянга, гэрийн ажилтай 71.1 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 68.5 мянга, өвчтэй 21.1 мянга, өвчтөн, өндөр настан асарсан 12.9 мянга, хөдөлмөр эрхлэхийг хүсээгүй 11.3 мянга, бусад шалтгаантай 24.8 мянган хүн байна. Мөн хот, хөдөөгөөр авч үзэхэд, 663.7 (76.5%) мянга нь хот, суурин газарт, 204.3 (23.5%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.<sup>5</sup>

Монгол Улсын хүн ам 1962 онд 1 сая, 1988 онд 2 сая, 2015 онд 3 саяд хүрч байсан бол Үндэсний Статистикийн Хорооны (цаашид ҮСХ гэх) тооцооллоор 2031 онд 4 сая, 2045 онд 5 саяд хүрнэ гэж тооцоологдсон байна.<sup>6</sup> 2019 оны Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суваргаас харвал тус улс залуу хүн амын бүтэцтэй бөгөөд 0-9 насныхны нийт хүн амд эзлэх хувь хамгийн өндөр, насанд хүрэгчдээс 30-34 насны хүн амын тоо өндөр байна. Нийт хүн амын гуравны нэг нь хүүхдүүд байгаа “Хүн амын цонх үе” үргэлжилж байгаа тус улсад нийгмийн суурь үйлчилгээний төлөвлөлт, багтаамжинд онцгойлон анхаарах, бүх салбарт ур чадвар сайтай залуу боловсон хүчин бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх, гэр бүлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Хэрэв хангалттай ажлын байрыг нэмэгдүүлж чадахгүй бол эдийн засгийн өсөлт удаашрах, ядуурал болон ажиллах хүчний өсөлтөөс шалтгаалсан ажилгүйдэл нэмэгдэж, үүнийг дагасан нийгмийн сөрөг үр дагаврууд буюу гэмт хэрэг, архидалт, хүчирхийлэл нэмэгдэх

<sup>4</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>5</sup> Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2018, ҮСХ, 31-р тал

<sup>6</sup> Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, 2017



**Улсын  
хэмжээнд  
171,16 мянган  
малчин өрх  
бий.**

аюултай байдаг.<sup>7</sup> Залуучууд олноороо ажиллах хүчинд нэгдэх тул үлэмж хөрөнгө оруулалтаар хөдөлдөг уул уурхайн салбар төдийгүй олон бүтээлч салбаруудад ажлын байр олноор бий болгох шаардлагатай. Түүнчлэн хүүхэд, залуучуудын хөгжилд хөрөнгө оруулж, ур чадварыг нь сайжруулах, ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн хувьд оролцох шударга, эрх тэгш нөхцөлийг дэмжих нь шийдвэрлэх ач холбогдолтой байх болно.<sup>8</sup>

Монгол Улсын зун өвлийн дундаж температур +30°C -аас -30°C-ын хооронд хэлбэлздэг, эрс тэс уур амьсгалтай төдийгүй тус улсын бүх нутаг дэвсгэрт цаг уурын өөрчлөлт явагдаж, байгаль цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж олширч, нутаг дэвсгэрийн ихэнх нь хуурайшилт, цөлжилт, хөрс усны доройтолд өртөж, бэлчээрийн ургац муудаж байна.<sup>9</sup> Улсын хэмжээнд 171,16 мянган малчин өрх бий<sup>10</sup> бөгөөд ажил эрхэлдэг арван хүн тутмын гурав нь мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хөдөлмөр эрхэлж байна.<sup>11</sup> Хөдөөгийн малчин хүн ам нь өргөн уудам нутагт таруу суурьшин амьдардаг учраас төрийн үйлчилгээг зохион байгуулахад өртөг өндөртэй байдаг.<sup>12</sup>

<sup>7</sup> Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2018, 16-р тал

<sup>8</sup> “Ядуурлын дүр төрх” тайлан, ҮСХ, Дэлхийн Банк, 2018

<sup>9</sup> Цаг уур, орчны шинжилгээний газар, 2018

<sup>10</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>11</sup> Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2018, ҮСХ, 49-р тал

<sup>12</sup> Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2018, 17-р тал

## Эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улс бол хөдөө аж ахуй, эрдэс баялгийн арвин нөөц баялагтай, багдунд орлоготой хөгжиж буй орон юм. Түүхий эдийн үнэ буурч, ашигт малтмалын экспортын чанар үечлэлийн улмаас буурснаар уул уурхайн салбарын гүйцэтгэл саарч, улмаар эдийн засгийн өсөлт 2017 онд 5.4 хувь, 2018 онд 7.2 хувь хүрсэн бол 2019 онд 5.1 хувь болж суларсан.<sup>13</sup> Инфляци 2019 онд 5.2 хувь байсан нь Монгол Банкны 8 хувийн зорилтот түвшингээс доогуур байгаа юм.

Үнэлгээнд хамаарах хугацаанд 2018 оны 6 дугаар сараас 2020 оны 4 дүгээр сарын хугацаанд Монгол Улсад жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас (цаашид ЖДҮХС гэх) Улсын Их Хурлын (цаашид УИХ гэх) зарим гишүүд өөрийн эзэмшлийн болон хамаарал бүхий компаниар дамжуулан зээл авсан хэрэг ил болж, Монголын арилжааны банкуудын нэг болох Капитал банк дампуурч, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын (FATF) гаргадаг саарал жагсаалтад Монгол Улс хоёр дахь удаагаа орсон төдийгүй 2020 онд Европын холбоо хар жагсаалтад оруулахаа мэдэгдсэн, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг баталсан, шинэ төрлийн коронавирус буюу COVID-19 цар тахал дэлхийн улс орнуудад төдийгүй тус улсад дэгдсэн зэрэг улсын эдийн засагт нөлөө үзүүлэх хэмжээний үйл явдлууд өрнөлөө.

<sup>13</sup> <https://www.worldbank.org/mn/country/mongolia/overview>



**Хүснэгт 1. Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлт**

	2016	2017	2018	2019
ДНБ өсөлт (%)	1.2	5.3	7.2	5.1
Нэг хүнд ногдох ДНБ (мянган төг)	7,910.0	8,999.1	10,259.8	11,566.5
Инфляцийн түвшин (%)	1.3	6.4	8.1	5.2
Ажилгүйдлийн түвшин (%)	10	8.8	7.8	-
Гадаадын хөрөнгө оруулалт (сая төг)	2,866,379.2	6,899,292.5	7,390,766.0	7,948,918.4
Нийт гадаад өр (сая \$)	24,624.5	27,492.7	28,714.9	30,677.8
Гадаад худалдаа (сая \$)	1558.2	1863.3	1136.7	1492.3
Экспорт				
Импорт				
Үндэсний нийт орлого (сая төг)	21,971,134.9	23,951,371.7	29,255,161.3	32,738,370.9
Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (сая төг)	-3,660,289.1	-1,742,456.9	-3,019.1	-627,770.7

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Үндэсний статистикийн хороо, Монголбанк, 2019



**Уул уурхайн салбар нийт экспортын 90%-ийг эзэлдэг, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72%-ийг бүрдүүлдэг**

ДНБ нь Монгол Улсад дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээг хэлэх бөгөөд 2019 онд 37 их наяд төгрөг буюу 2018 оноос 5.1 хувийн өсөлттэй байжээ. Голлох салбаруудыг авч үзвэл барилга 4.1, боловсруулах үйлдвэр 11.2, хөдөө аж ахуй, газар тариалан 10.9<sup>14</sup>, уул уурхай 25 хувийг бүрдүүлж байна<sup>15</sup>. Мөн тэнцвэржүүлсэн орлого 10.8 их наяд, тэнцвэржүүлсэн зардал 11.4 их наяд төгрөг байсан бөгөөд төсвийн гүйцэтгэлийн тэнцэл -627.8 тэрбум буюу зарлага нь орлогоосоо өндөр байжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд төлөвлөгдөж, хийгдэж байгаа ч 2018 онд шинээр эхлүүлэхээр баталсан зураг, төсөв шаардлагатай 423 төсөл, арга хэмжээний 80.6 хувь нь хуулийн шаардлага хангаагүй байжээ<sup>16</sup>. Мөн орон нутагт эрх шилжсэн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудын хийсэн дүнгээр 2018 онд 332 зөрчил буюу мөнгөн дүнгээр 43.5 тэрбум төгрөгийн зөрчилтэй байжээ.<sup>17</sup>

Сүүлийн 20 орчим жилийн хугацаанд Монгол Улс мал аж ахуйн салбар түшиглэсэн эдийн засаг бүхий улсаас уул уурхайн салбар түшиглэсэн эдийн засагтай улс болсон. Гэсэн хэдий ч уул уурхайн салбар ДНБ-ий дөрөвний нэгийг, нийт экспортын 90%-ийг эзэлдэг, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72%-ийг бүрдүүлдэг<sup>18</sup> төдийгүй нийт экспортын 80%-ийг БНХАУ-д экспортолдог нь Монгол Улсыг, олон улсын түүхий эдийн зах зээл дээрх үнийн савалгаа болон БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдлаас шууд хамааралтай болгосон. Иймд эрдэс баялгийн түүхий эдийн үнээс шалтгаалах эдийн засгийн мөчлөгийг сөрөхийн тулд олон тулгуурт бодлогоор эдийн засгийг тэлэх шаардлагатай нүүр тулж байна.<sup>19</sup>

14 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

15 Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2019

16 Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, гүйцэтгэлийн аудитын дүн

17 Мөн тэнд


18 Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2019

19 Дэлхийн Банк, Дэлхийн Банк Монголд Тойм, 2018

Мал, тэжээвэр амьтдын тооллогын 2019 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 71.0 саяд хүрч, өмнөх оныхоос 4509 мянган толгойгоор буюу 6.8 хувиар өссөн. Нийт 285.5 мянган малчид байна. Мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутагт үндсэндээ гар аргаар боловсруулсан хэвээр байна. Харин арьс, шир, ноос, ноолуурын маш багахан хувийг дотоодын үйлдвэрт боловсруулж, ихэнх хэсэг нь нэмэгдсэн өртөг шингээгүй, боловсруулалт хийлгүйгээр угаасан, самнасан байдлаар гадаад зах зээлд гаргаж байна. Иймд бүс нутгийн тулгуур төв болон шаардлагатай газруудад нь мал аж ахуйн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж байгуулах нь хүлээгдэж байгаа зорилт хэвээр байна. Бэлчээрийг сэлгэн ашиглах, отор нүүдлийг зайлшгүй хийдэг болгох хөшүүрэг бүхий механизмыг малчдын дунд бий болгох шаардлагатай байна. Бэлчээрийн доройтол нь малын тоо толгойг хязгаартай байлгахыг шаардаж байна. Улсын хэмжээгээр 2019 онд нийт 526.0 мянган га-д тариалалт хийсэн нь өмнөх оныхоос 14.2 мянган га буюу 2.8 хувиар өсжээ. Газар тариалангийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 833.3 тэрбум төгрөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 445.3 тэрбум төгрөгт хүрч, 2018 оныхтой харьцуулахад оны үнээр 7.1 тэрбум төгрөгөөр буюу 0.9 хувиар, зэрэгцүүлэх үнээр 21.2 тэрбум төгрөгөөр буюу 5.0 хувиар тус тус өссөн байна. Монгол Улс 2019 онд 433.3 мянган тонн үр тариа, 192.2 мянган тонн төмс, 99.5 мянган тонн хүнсний ногоо, 121.1 мянган тонн таримал тэжээл, 34.0 мянган тонн техникийн ургамал тариалжээ.<sup>20</sup>

Монгол орны гол мөрний усны нөөцийн 60 хувь нь гадагшаа гардаг. Ийм онцлог нөхцөлийг

20 YCX, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2019



**Бэлчээрийн доройтол нь малын тоо толгойг хязгаартай байлгахыг шаардаж байна.**



**Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны байдлаар 30.7 тэрбум ам.доллар байна.**

харгалзан үзвэл хаврын цасны ус, зуны борооны үерийн усны нөөцийн тодорхой хэсгийг далан хаалт байгуулж усан санд хуримтлуулах замаар газар тариалан, мал аж ахуйд ашиглах нь хуурай уур амьсгалтай орны хувьд зайлшгүй хийгдэх ажил болж байна.<sup>21</sup>

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны байдлаар 30.7 тэрбум ам.доллар байна. Үүнээс Засгийн газрын өр 7.7 тэрбум ам.доллар<sup>22</sup> бөгөөд Монгол Улс 2021 оноос эхлэн Мазаалай бонд, 2022 оноос Чингис бонд, 2023 оноос Гэрэгэ бонд, 2024 оноос эхлэн Хуралдай бондын өрийг төлнө<sup>23</sup>. Гадаад өрийн хэмжээсээр авч үзэхэд зохистой түвшингээс өндөр байгаа бөгөөд томоохон бонд төлөх төлөх хугацаа ойртож, үүнээс үүдсэн валютын ханш сулрах, эрдсийн үнэ унах зэрэг шокууд илрэхэд өрийн үйлчилгээний зардал өсөх, улмаар санхүүгийн салбар

21 YCX, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2019

22 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

23 Монгол Улсын өрийн өнөөгийн байдал, Монгол банк, 2018

доройтох эрсдэлтэй байна. Гадаад өрийн хэмжээ өндөр түвшинд хүрснээр эдийн засагт хүндрэл үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх бодлогын орон зай хязгаарлагдаж байна. Гадаад өрийн менежментийг оновчтой хийж, төрөөс урт хугацааны төлөвлөгөө боловсруулан батлах нь зүйтэй<sup>24</sup>.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх; нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх; тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэж нэгэн зэрэг хангагдсан байх төсвийн тусгай шаардлагуудыг заасан. Түүнчлэн, “... өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцааг 2016 оны төсвийн жилд 88.0 хувиас, 2017 оны төсвийн жилд 85.0 хувиас, 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас, 2019 оны төсвийн жилд 75.0 хувиас, 2020 оны төсвийн жилд 70.0 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас ...” тус тус хэтрүүлэхгүй байхаар, өрийн хэмжээг жил дараалан багасгах” арга барилын дагуу хуульчилжээ.<sup>25</sup> “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэж заасан байдаг.<sup>26</sup>

Өнөөгийн байдлаар улсын төсвийн зарлагыг нэмэгдүүлсэн, гадаадын зээлийн эргэн төлөлтийн цаг хугацаа нь болсон,

<sup>24</sup> Мөн тэнд,

<sup>25</sup> Сангийн яам, Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн танилцуулга, 2016, 279 дэх тал

<sup>26</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010



**2020 оны  
эхний 6 сарын  
гүйцэтгэлээр  
гадаад  
худалдааны нийт  
бараа эргэлтийн  
хэмжээ өмнөх  
оны мөн үеэс  
23%-иар буурсан.**

экспортын бүтээгдэхүүний төрөл зүйл хязгаарлагдмал хэвээр байгаагийн сацуу Засгийн газрын өрийн хязгаарыг 2021 он хүртэл улам бүр бууруулахаар тогтоосон учраас хүүхдэд чиглэсэн аливаа шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхэд бэрхшээл, эрсдэл тулгарч болохоор байна.

2020 онд Монголын төдийгүй дэлхийн эдийн засагт коронавирус буюу COVID-19 цар тахлын дэгдэлтээс үүдсэн хямралууд бий болж байна. Инфляцийн түвшин 2020 оны 6 дугаар сард 2.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.5 пунктээр буурсан байна. Инфляци төв банкны зорилтод түвшнээс (8%) буурч байгаа нь эдийн засгийн идэвх суларсныг илтгэж байна.<sup>27</sup> Монгол Улс урьдчилан сэргийлж хөл хорио тогтоогоод буй энэ үед дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүний тасалдал үүсгэхгүй төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж байна<sup>28</sup>. 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23%-иар буюу 1,544 сая ам.доллараар буурч 5,288 сая ам.доллар байв. Үүнд экспорт 28%-иар буюу 1,111 сая ам.доллараар, импорт 15%-иар буюу 434 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Энэ хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 677 сая ам.доллараар буурч 368 сая ам.долларын ашигтай гарлаа. 2020 оны эхний 6 сард уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 834 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 277 сая ам.доллараар буурлаа. Үүнээс чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 828 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 344 сая ам.доллараар тус тус буурав. Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж 61 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан мөн 108 сая ам.доллараар буурсан. Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 6 дугаар сард 1,736 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 27%-иар, өмнөх сараас 1%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,755; 103 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 2%-иар,

<sup>27</sup> ҮСХ, Коронавирус ба эдийн засаг, 2020

<sup>28</sup> ҮСХ, Коронавирус ба эдийн засаг, 2020

төмрийн хүдэр 5%-иар буурсан бол зэсийн үнэ болон төмрийн хүдэр өмнөх сараас 10%-иарт тус тус өслөө. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 6 дугаар сард 75 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 17%-иар, өмнөх сараас 9%-иар буурлаа. 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15%-иар буюу 434 сая ам.доллараар буурав.

Импортын 15 нэгж хувийн бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.<sup>29</sup> Монгол банкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар, юаньтай харьцах сарын дундаж ханш 1.0 хувиар, рубльтэй харьцах сарын дундаж ханш 5.9 хувиар суларсан байна. Улсын төсөвт төвлөрч буй аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын орлого энэ оны эхний хагас жилд өмнөх оноос буурч байгаа нь дотоодын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд доголдол учирсныг харуулж байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр, хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр тус тус өссөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2020 оны эхний хагас жилд 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар буурсан бол дотоод худалдааны салбарын борлуулалт 2020 оны эхний 5 сард

<sup>29</sup> Гадаад худалдааны тойм, Монгол Банк, 2020 оны 6 сар







**Монгол Улс нэг хүнд ногдох орлогын өсөлт, ядуурлыг бууруулах тал дээр ахиц гаргасан ч, гурван хүн тутмын нэг нь ядуу, амьжиргаа залгах гол үүсвэр нь нийгмийн халамж байгаа явдал нь энэ ололт амжилтыг эмзэг гэж үзэх шалтгаан юм.**

8.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буураад байна. Монгол Улсын хувьд аялал жуулчлалын салбарын орлого гадаадын жуулчдад үзүүлж буй үйлчилгээний хөлс дээр тогтдог. Дотоодын аялал жуулчлал хөгжөөгүй манайх шиг орны хувьд хил хаалттай байх нь энэ салбарыг шууд зогсонги байдалд хүргэж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар манай улсад аялахаар ирсэн жуулчдын тоо өмнөх оны мөн үеэс 79.9 хувиар буураад байна.<sup>30</sup>

COVID-19 цар тахлын дэгдэлт болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн. Хэдийгээр хорио цээрийн дэглэмд буй ч ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх нь эдийн засгийн эргэлтийг хэвийн байлгахад чухал үүрэгтэй хэмээн үзэж, УОК-ын шийдвэрээр хилийн боомтуудыг хэсэгчлэн нээж, ачаа тээврийн үйл ажиллагаа явагдаж байна. Үүнтэй зэрэгцээд БНХАУ-ын эдийн засаг хүлээлтээс хурдан сайжирч, он гарснаас хойш буураад байсан нүүрсний экспорт сэргэж байна. Нүүрсний экспорт 2020 оны 2 дугаар улиралд 437.9 сая америк доллар болж, өнгөрсөн улирлаас 73.1 хувиар нэмэгдсэн байна. Харин 6 дугаар сард нийт экспорт 822.1 сая америк доллар болж, өмнөх сараас 29.9 хувиар өссөн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг нүүрсний тээврийг автозамаар тээвэрлэдэг ба авто тээврээр 2020 оны эхний хагас жилд 8.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.5 (55.5%) сая тонноор буурсан бол өмнөх улирлаас 2.2 (69.4%) сая тонноор өссөн байна.<sup>31</sup>

<sup>30</sup> ҮСХ, Коронавирус ба эдийн засаг, 2020

<sup>31</sup> ҮСХ, Коронавирус ба эдийн засаг, 2020

## Нийгмийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд ДНБ харьцангуй өсөлттэй байгаа ч ядуурлын бууралтын хурд саарчээ. Ядуурлын мэдрэмжийн өсөлт нь нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт болон ДНБ-ий өсөлт ядуурлын бууралтад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарладаг үзүүлэлт юм. Монгол Улс нэг хүнд ногдох орлогын өсөлт, ядуурлыг бууруулах тал дээр ахиц гаргасан ч, гурван хүн тутмын нэг нь ядуу, амьжиргаа залгах гол үүсвэр нь нийгмийн халамж байгаа явдал нь энэ ололт амжилтыг эмзэг гэж үзэх шалтгаан юм.

Ядуурлын түвшин 2016 оноос 2018 оны хооронд улсын дүнгээр 1.2 хувиар, ядуурлын гүнзгийрэлт 0.5 хувиар буурсан байна. Хөдөө ядуурлын гүнзгийрэлт буурсан байгаа бол Улаанбаатар хотод ядуурлын түвшин нэмэгдсэн бөгөөд Улаанбаатар хоттой харьцуулахад ядуурлын түвшин хөдөө орон нутаг, аймаг, сумын төвийн ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт илэрхий муу үзүүлэлттэй байна.



2015 онд ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (цаашид ТХЗ гэх) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн бөгөөд Монгол Улсын хувьд 2016 оны УИХ-ын 16-р тогтоолоор “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг баталсан.

Энэ баримт бичигт ядуурлын түвшинг 2030 он гэхэд 0 түвшинд хүргэнэ гэж заасан ч 2014 оны суурь түвшнээс (21.6 хувь) 6.8 хувь өссөн байна. Дотоодын хүн амын хэрэглээ нэмэгдсэн ч энэхүү хэрэглээний өсөлт, үр өгөөжийг ядуу хүн ам хүртэж чадахгүй байгаа юм. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилтууд нь Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулах үндэслэл болсон.



**Гурван тулгуурт хөгжлийн бодлогод дэвшүүлсэн 22-27 дугаар зорилтууд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэж байна.**

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгагдсан “Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна” гэсэн зорилтууд, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах” гэсэн зорилтууд, Гурван тулгуурт хөгжлийн бодлогод дэвшүүлсэн 22-27 дугаар зорилтууд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэж байна.

Улсын төсвөөс нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх зориулалтаар олгож буй санхүүжилт хангалтгүй, зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй, үр ашигтай бус (орлогын дахин хуваарилалтын оновчтой механизм бүрдээгүй) зэрэг олон асуудлууд гарч байна. Тухайлбал, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зорилтот бүлэгт бүрэн чиглээгүй, зорилтот



**4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүй.**

бүлгийг тодорхойлохдоо өрх, иргэний амьжиргааны түвшинд бус категорийн аргад илүү суурилсан хэвээр байна. Халамжид зарцуулж байгаа хөрөнгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл бага, бэлэн мөнгөний нөхцөлт бус хөтөлбөрүүд ихтэй, үйлчилгээнд суурилсан хөтөлбөрүүд багатай байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн болж жилд дунджаар 800 орчим мянган хүнийг хамруулж, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүйг харуулж байна.<sup>32</sup>

Ядуурлын шалтгаан нь иргэдийн мэдлэг, боловсрол, ур чадвар, хөдөлмөрийн хандлагын дутагдалтай байдал, эрүүл мэнд, амьдралын нөхцөл боломж муу зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй байгааг харгалзан ядуурлын түвшингээс доогуур орлоготой өрх, иргэдийн амьжиргааны нөхцөл байдал, эрэлт хэрэгцээ, чадавх боломжид тохирсон ажилгүйдлийг бууруулах, ядуурлаас гаргахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.<sup>33</sup>

<sup>32</sup> Алсын хараа 2050, 38-39-р тал

<sup>33</sup> Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2019

**Хүснэгт 2. Ядуурлын түвшин, гүнзгийрэлт**

Бүс, байршил	Ядуурлын түвшин		Ядуурлын гүнзгийрэлт	
	2016	2018	2016	2018
Улсын дүн	29.6	28.4	7.7	7.2
Баруун бүс	36	31.8	9.7	7.8
Хангайн бүс	33.6	30.8	8.2	7.3
Төвийн бүс	26.8	26.1	7	6.6
Зүүн бүс	43.9	37.4	12.5	10
Улаанбаатар	24.8	25.9	6.4	6.7
Аймгийн төв	31.8	30.1	8.8	8.2
Сумын төв	32.3	28.9	8.5	7

Эх сурвалж: Ядуурлын дүр төрх судалгаа, 2018



**Ядуурлын хамралтын түвшин сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд 20 хувиас буураагүй.**


2018 оны дүнгээс харахад нийт хүн амын 28.4 хувь буюу 904.9 мянган хүн ядуу амьдарч байгаа<sup>34</sup> бөгөөд ядуурлын түвшин аймгийн төвд хамгийн өндөр буюу 30.1 хувь, гүнзгийрэлт 8.2 хувь байна. Аймгийн төв болон сумын төвийн ядуурлын түвшин, гүнзгийрэлт 2016 онтой харьцуулахад буурсан ч хүн амын гуравны нэг нь амьдарч буй Улаанбаатар хотод нэмэгдсэн байна. Хөдөө орон нутагт ядуу хүмүүс ихээр амьдарч байгаа ба хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг хурдасгах, хөдөөд ядуурлыг илүүтэй бууруулах нь амин чухал болоод байна.<sup>35</sup> Ядуурлын хамралтын түвшин сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд 20 хувиас буураагүй, гурван хүн тутмын нэг нь ядуу байгаа нь ядуурал бодитой, улам бүр ужигарч байгааг харуулж байна.<sup>36</sup>

Засгийн газар COVID-19 вирусийн халдвараас сэргийлж 2020 оны 1 сараас эхлэн улсын хэмжээнд хөл хорио тогтоосон бөгөөд тус улс Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хэсэгчилсэн зэрэгт шилжсэн. Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд хэрхэн тусаж байгааг

<sup>34</sup> Мөн тэнд, 12-р тал

<sup>35</sup> Дэлхийн банк, Монголын эдийн засгийн тойм, 2018, 8-р тал

<sup>36</sup> МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 11-р тал



**Хөл хорионы үеэр ихэнх өрх хүнсэндээ илүү мөнгө зарцуулдаг болжээ.**

судалсан “COVID-19 ба Хөгжлийн бэрхшээл” судалгаагаар, өрхийн зардал нэмэгдсэн нь байнга гэртээ байгаа өрхийн гишүүдийн хүнс болон ахуйн хэрэглээ өсөхтэй зэрэгцээд юмны үнэ нэмэгдсэнээр тайлбарлажээ. Цалингийн хэмжээ буураагүй байтал өдөр тутмын амьдралд хүрэлцэхгүй болж байгаа тухай судалгаанд оролцогчид онцолжээ. Тухайлбал, хоол хүнсний зардал, цахилгаан, ус, кабель, түлш зэрэг ахуйн хэрэглээний зардал, мөн интернэтийн зардал өссөнийг онцолжээ. Хөл хорионы үеэр ихэнх өрх хүнсэндээ илүү мөнгө зарцуулдаг болжээ. Ердийн үед хүүхдүүд сургууль, цэцэрлэг дээрээ долоо хоногийн таван өдөр завгүй байхын зэрэгцээ цэцэрлэгийн хоол, сургуулийн үдийн цай, өөрөө худалдаж авсан хоол, хүнсний зүйл хэрэглэдэг бол энэ үед өрхүүд гадуур хооллохгүй байгаа тул дэлгүүрээс худалдаж авах хоол, хүнсний хэмжээ нэмэгджээ. Гэртээ байнга хүнтэй байгаа болохоор өрхийн цахилгаан, ус, түлш, кабель, интернэтийн зардал өссөн байна. Хүүхдүүдийн интернэтийн хэрэглээ нэмэгдэж, төлбөр нь “өрхийн эдийн засагт нөлөөлөх” хэмжээнд хүрсэн тухай мөн тэмдэглэжээ. Өрхийн орлого нэмэгдээгүй боловч зардал өсөж байгаа энэ үед сардаа гардаг зардлаа нэмэгдүүлэхгүйн тулд хэмнэлт хийж байгаа ажээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ витамин, нэмэлт тэжээл, эм тариа, живх авч өгч чадахгүй байгаадаа маш их санаа зовж байна гэж эцэг эх хариулжээ.<sup>37</sup> Судалгаанд оролцогчид мөн хөл хорио тогтоосны улмаас төрийн олон үйлчилгээ цахимаар материал бүрдүүлэх хэлбэрт шилжсэн нь үйлчлүүлэгчдэд илүү амар болсон тухай тэмдэглэжээ.

Монгол Улс дахь Хүүхдийг Ивээх Сангаас COVID-19 цар тахал, түүнээс урьдчилан сэргийлэхээр тогтоосон хөл хорио, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосноос үүдэн өрх гэр бүл, хүүхдийн амьдралд гарч буй өөрчлөлтийг судлан хэрэгцээг нь тодорхойлох зорилгоор түргэвчилсэн үнэлгээг хийж гүйцэтгэв. Судалгааны үр дүнгээс үзэхэд цар тахал нь судлагдсан нийт өхийн багадаа тал хувийнх нь орлогын эх үүсвэр, орлого болон хэрэглээнд нөлөөлсөн байна. Үүнийг хувьчилбал 43%-д бага зэрэг, 42%-д ихээр болон маш ихээр нөлөө үзүүлсэн байв. Мөн салбарын

<sup>37</sup> Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, COVID-19 ба Хөгжлийн бэрхшээл, 2020

үйлчилгээ үзүүлэгч нараас тодруулахад 71% нь өрхийн орлого ихээр буурсан гэж дүгнэсэн байна. Хүүхдээс авсан судалгаагаар 45% нь аав, ээж нь тэдний шаардлагатай хэрэгцээг хангаж чадаагүй ба голчлон хувцас, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, ном зэрэг байв. Хүнсний аюулгүй байдлын хувьд өрхүүд энгийн үетэй харьцуулахад мах, гурил, будаа буюу үндсэн хэрэглээгээ нэмэгдүүлэх замаар хоол хүнсний хэрэгцээгээ хангаж байгаа бөгөөд нарийн ногоо, жимс жимсгэнэ, өндөг зэрэг илүү тэжээллэг хүнсний хэрэглээгээ илт бууруулсан байна. Энэ нь өрхийн орлогын эх үүсвэр хумигдсан, орлого нь буурах зэргээс шалтгаалсан байх талтай юм. Өрхийн хүнсний аюулгүй байдлын нэг хэсэг болгож хүүхдийн хооллох хэвшилд өөрчлөлт орсон эсэхийг хүүхдүүдээс лавлахад тэдний 46% нь хоол хүнсний чанар муудсан буюу олон төрлийн хүнсний ногоо, тэжээллэг хоол хүнс иддэг байснаа цөөн тооны орцтой хоол идэх болсон, 41% нь өдөрт иддэг хоол, цайны хэмжээ буурсан гэв. Үүнээс харахад COVID-19 цар тахал нь өрх гэр бүлийн хүнсний аюулгүй байдал, хоол хүнсний хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ хэрэглэдэг байсан бүтээгдэхүүний нэр төрөл цөөрөх, улмаар өдөр тутамдаа чанартай тэжээллэг хоол хүнс хэрэглэх нь багасх нөлөөлсөн байна. Тухайн өрхийн үүссэн бэрхшээлийг хэрхэн даван туулж буйг (negative coping strategy) сүүлийн долоо хоногийн нөхцөл байдлыг тодруулах замаар судалж үзэхэд бэрхшээлтэй буюу шар өнгийн ангилалд 42%, хямралт буюу улбар шар ангилалд 12%, улаан буюу ноцтой нөхцөлд нийт судлагдсан өрхийн 3% хувь байна. Энэ нь зорилтот бүлгийн өрхийн амьжиргааны нөхцөл байдалд COVID-19 -ийн нөхцөл байдал, үүнээс сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 57%-д нь бэрхшээл, хямралт, ноцтой байдлыг үүсгэсэн байгааг харуулж байна. Тэр дундаа, хямралт нөхцөлд буй өрхийн хувь хотод





**Хүүхдүүдийн  
7% нь гэр бүлд  
нь санхүүгийн  
бэрхшээл  
үүссэнээс ажил  
хийсэн гэж  
хариулсан байна.**

илүү (10%) байгаа нь харагдаж байна. Мөн хүүхдүүдийн 7% нь гэр бүлд нь санхүүгийн бэрхшээл үүссэнээс ажил хийсэн гэж хариулсан байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдал цаашид удаан үргэлжилбэл хүүхдийн хөдөлмөр, цаашлаад хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтийн асуудал нэмэгдэж болзошгүйг харуулж байна. Түүнчлэн өрхийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хомсдол үүссэн эсэхийг судлахад харьцангуй олдоцтой байгаа гэж гарсан бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байв. Өрх гэр бүлд энэхүү цар тахлын үед ямар тусламж хамгийн хэрэгцээтэй болон тохиромжтойг судлахад 56% нь витамин болон дархлаа дэмжих бүтээгдэхүүн, 48% ажил хийлгэж цалинжуулах, 46% мөнгөн тусламж, 35% хүнсний талон, 33% хоол хүнсний тараалт гэж хариулсан байна. Витамин болон дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг талаас илүү хувь нь тохиромжтой гэж үзсэн байв. Тус түргэвчилсэн үнэлгээгээр Засгийн газар эн тэргүүнд өрхийн амьжиргааг хамгаалах, хоол хүнсний хэрэгцээг нь хангах нөхцөлт бус мөнгөн тусламжийн хөтөлбөр болон амьжиргааг сэргээн босгох чиглэлээр бичил санхүүжилт олгох, хэрэгцээт тоног төхөөрөмж болон хөрөнгөөр дэмжих, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд холбох зэрэг үйл ажиллагааг богино болон урт хугацаанд авч хэрэгжүүлэх, ингэхдээ эмэгтэйчүүдийг тусгайлан анхаарч үзэх, үүссэн

нөхцөл байдалд нийцүүлэн зорилтот эмзэг бүлгийн хүн амд хандсан ажил олгох, ажилд холбох боломжоор хангах, дэмжих, залуучуудад ажил эрхлэх, хувийн бизнес эрхлэхэд нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгох, өрхийн даван туулах чадварыг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл орлогын олон эх үүсвэр бий болгох, өрхийн хадгаламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, орлого зарлага хянадаг санхүүгийн боловсролыг дэмжих зэрэг ажлуудыг үе шаттай авч хэрэгжүүлэхийг зөвлөмжилсөн юм.<sup>38</sup>

Засгийн газрын 2020 оны 5 сарын 22-ны өдрийн хуралдаанаар баталсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх” журмыг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйл буюу хүүхдийн эрхийн талаар хүлээх Засгийн газрын үүрэг, оролцоо хэсэгт “...онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах..” гэж заасны дагуу боловсруулсан бөгөөд онцгой нөхцөл байдлын үед буюу Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, ослын үед болон олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон салбар дундын харилцааг зохицуулж байна.

<sup>38</sup> Коронавируст цар тахлын үр нөлөөний түргэвчилсэн үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2020

## Тэгш бус байдал

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2018 онд улсын дундаж 0.33 байгаа бол хотод 0.34, хөдөө 0.29 буюу хотод тэгш бус байдал хөдөөгөөс өндөр байна<sup>39</sup>. Монгол Улсын хүний хөгжлийн индекс 0.74 буюу 177 орноос 92-р байранд, ур чадварын индексээр дэлхийн 140 орноос 99-р байр, бизнесийн орчны индексээр дэлхийн 190 орноос 74-р байр, авлигын индексээр 93-р байранд жагсаж байна.<sup>40</sup>



Ядуурал, тэгш бус байдлаас шалтгаалан хүн амын зарим бүлгүүд нийгмийн хөгжлийн үр шимийг тэгш хүртэж чадахгүй байна.

### Хүснэгт 3. Хүний хөгжлийн индекс

Бүс, байршил	2015	2016	2017	2018
Улсын дүн	0.736	0.733	0.734	0.74
Баруун бүс	0.667	0.661	0.659	0.664
Хангайн бүс	0.677	0.673	0.68	0.682
Төвийн бүс	0.695	0.692	0.69	0.693
Зүүн бүс	0.689	0.688	0.691	0.695
Улаанбаатар	0.813	0.812	0.814	0.822

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Эдийн засгийн төрөлжилт бага, бүс нутгийг жигд бус хөгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь хүн амын зарим бүлэг орхигдох, тэгш бус байдал, ядуурал нэмэгдэх гол шалтгаан болж байна.<sup>41</sup> Ядуурал, тэгш бус байдлаас шалтгаалан хүн амын зарим бүлгүүд нийгмийн хөгжлийн үр шимийг тэгш хүртэж чадахгүй байна. Ялангуяа, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, малчид, хот суурин газар руу шилжигчид зэрэг хүн амын бүлгүүд нь хөгжлийн үр шимийг хүртэх боломжоор хязгаарлагдмал, хөгжлөөс орхигдох эрсдэлтэй байгаа тул төр засгийн нийгмийн бодлогыг нэн тэргүүнд эдгээр хүмүүс рүү чиглүүлэх нь чухал юм.<sup>42</sup>

39 УСХ, Ядуурлын дүр төрх, 2018

40 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний хөгжлийн үзүүлэлт, 2018

41 МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 74-р тал

42 МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 19-р тал

Хүн амын үе үеийн эрх тэгш тэгш байдлыг хангасан тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг бий болгох, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чадварыг сайжруулах нь нэн чухал байна. Тэгш эрхийг хуульчилсан хэдий ч тэгш боломжийг бодитойгоор олгоход анхаарах шаардлагатай байна.

## Жендэрийн эрх тэгш байдал

Дэлхийн эдийн засгийн форумын гаргадаг жендэрийн ялгаатай байдлын индексээр 2018 онд нийт 149 орноос 58-р байранд жагсаж байсан бол 2020 оны тайланд 153 орноос 79-р байранд буюу 21 байраар ухарсан үзүүлэлттэй байна.<sup>43</sup>

### Хүснэгт 4. Монгол Улсын жендэрийн ялгаатай байдлын индексийг 4 дэд индексээр гаргасан байдал

Дэд индекс	Монгол Улсын эрэмбэ (153 орноос)	Оноо*
Эдийн засгийн оролцоон дахь жендэрийн ялгаатай байдал	29	0.751
Боловсролын амжилтын ялгаатай байдлын индекс	71	0.993
Эрүүл мэнд болон амьдрах чадварын индекс	1 (39 орны хамт)	0.98
Улс төрийн эрх мэдэлжүүлэлтийн индекс	120	0.102

\*0 рүү дөхөх тусам тэгш бус байдлыг илэрхийлдэг бол 1 нь тэгш бус байдлыг илэрхийлнэ.

Эх сурвалж: The global gender gap index 2020

Жендэрийн ялгаатай байдлын дээрх тайланд Монгол Улс эрүүл мэнд болон амьдрах чадварын индексээрээ тэргүүлж байгаа бол улс төрийн эрх мэдэлжүүлэлтийн индексээрээ дэлхийн 153 орноос 120-р байранд жагссан байна. Үүний тод илрэл нь парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 2019 оны байдлаар 17.1 хувь байгаа юм.<sup>44</sup> Бүс нутгаар авч үзвэл жендэрийн тэгш бус байдал зүүн бүсэд хамгийн өндөр

43 World economic forum, The global gender gap index 2020, 9-р тал

44 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл, 2020, 59-р тал



Монгол Улс төрийн эрх мэдэлжүүлэлтийн индексээрээ дэлхийн 153 орноос 120-р байранд жагссан байна.

буюу 0.833, хангайн бүсэд 0.341, төвийн бүсэд 0.289, баруун бүсэд 0.279 байгаа бол Улаанбаатар хотод хамгийн бага буюу 0.276 байна.<sup>45</sup> Монгол Улс 2017 оны 4 дүгээр сарын 26-нд 129 дүгээр тогтоол баталж, Монгол Улсад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 9 жил өнгөрч байгаа боловч тухайн хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байна.<sup>46</sup>

Монгол Улсын хувьд дундаж наслалт 1992 оноос 2018 онд 70.2 болж 26 жилийн хугацаанд 7.4 жилээр нэмэгдсэн бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 26 жилийн хугацаанд 60.7-оос 66.1 болж 5.4 жилээр, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 64.9-өөс 75.8 болж 10.9 жилээр нэмэгдсэн байна. Монгол Улсын хэмжээнд дундаж наслалтыг нэмэгдүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр үндэсний хэмжээний 4 бодлого, 9 хөтөлбөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг арилгах чиглэлээр тодорхой бодлого, үйл ажиллагаа байхгүй байна.<sup>47</sup>

Жендэрийн эрх тэгш байдал хэрхэн хангагдаж байгааг жишээ болгон, боловсролын салбар дээр авч үзье. Бүрэн дунд сургуульд хүйсийн харьцаа тэнцүү байсан хэрнээ дээд сургуульд суралцахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү их болж байна.<sup>48</sup> ЕБС-ийн хувьд 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй ногдож байгаа бол их дээд сургуулийн (мөн коллеж) хувьд 100 эрэгтэй оюутан тутамд ногдож буй эмэгтэй оюутнуудын тоо 146 байгаа юм.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид 2008-2009 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 6.0 мянга (49.2 %) нь эрэгтэй суралцагчид байсан бол 10 жилийн дараа буюу 2018-2019 оны хичээлийн жилд эрэгтэй суралцагчид 22.5 мянга (60.8 %) болсон байна (МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, 2019). 2018-2019 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдын 14,589 нь эмэгтэй бол 22,450

45 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

46 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл, 2020, 2-р тал

47 Суурь судалгааны тайлан, ЖҮХ, ҮСХ, 2020, 7-9-р тал

48 ҮСХ-ны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018. 212 дахь нүүр.



**Их дээд сургуулийн 100 эрэгтэй оюутан тутамд ногдож буй эмэгтэй оюутнуудын тоо 146 байна.**



**Боловсролын бүх салбарт үйлчилгээний ажлыг дийлэнх нь эмэгтэйчүүд хийж байгаа бол шийдвэр гаргах бодлогын ажлыг дийлэнх нь эрэгтэйчүүд хийж байна.**

нь эрэгтэй суралцагчид байна. Эндээс үзэхэд 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 65 байна.

2018-2019 оны хугацаанд ЕБС-иудын үндсэн багшийг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд 82% бол эрэгтэйчүүд 18%-ийг эзэлж байна. МСҮТ-ийн багшийн хүйс ч мөн адилаар эмэгтэй 63%, эрэгтэй 37%-г эзэлснээр эмэгтэй багш нар олон байна. Их дээд сургууль, коллежийн хувьд ч 60% нь эмэгтэй, 40% нь эрэгтэй багш нар байна. Харин Их дээд сургууль, коллежуудын захирлуудын 42% нь эмэгтэй, 58% нь эрэгтэй байна.<sup>49</sup> Тэгэхээр боловсролын бүх салбарт үйлчилгээний ажлыг дийлэнх нь эмэгтэйчүүд хийж байгаа бол шийдвэр гаргах бодлогын ажлыг дийлэнх нь эрэгтэйчүүд хийж байна.

Монгол Улсад нийт 798 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас 770 сургуулийг судалгаанд хамруулж үзэхэд, 54 хувь нь төвлөрсөн ус, ариун цэврийн байгууламжид холбогдсон, 11 хувь нь ундны баталгаат бус эх үүсвэр ашиглаж байна (Монгол Улсын Засгийн Газар, 2019).<sup>50</sup> Ариун цэврийн асуудлын хувьд хотын болон хотын бус талбар дахь сургуулиуд эрэгтэй болон эмэгтэйчүүдийн тусдаа ариун цэврийн өрөөнүүдтэй байна (Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, 2016).<sup>51</sup>

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа сарын тэмдгийн эрүүл ахуйд анхаарал хандуулж байна. Энэ нь сарын тэмдгийн эрүүл ахуйн асуудал, охидын эрүүл мэнд, сэтгэл санааны байдал болон тэдний сурах, хөгжих эрх, төлөвшил, тэдний амьдарч, сурч буй орчны байдалд урт хугацааны турш нөлөөлөх хүчин зүйл болдогтой холбоотой юм (НҮБ-ын Хүүхдийн Сан, 2017).<sup>52</sup> Өсвөр насны охидод сарын тэмдэг анх удаа гэнэтээр ирэх нь сэтгэл зүйн дарамт, амьдралын турш ичилт, эрэгтэй хүнтэй харьцах эмгэг зэргийг үүсгэхүйц нөхцөл байдлаас сэргийлэхийн тулд охидод сарын тэмдэг ирэхэд нийгэм болон сэтгэл зүйн дарамтад орохгүйн тулд

49 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, мета мэдээллийн сан, 2019

50 МУ-ын ЗГ, Монгол Улсын Үндэсний Сайн Дурын Илтгэл, 2019. 23 дахь нүүр.

51 Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, "Бага дунд боловсролын жендерийн дүн шинжилгээ," Швейцарийн Хөгжлийн Агентлаг, 2016. 31 дахь нүүр.

52 НҮБ-ын Хүүхдийн Сан, "Өсвөр насны охидын сарын тэмдгийн эрүүл ахуй," Улаанбаатар, 2017. 2 дахь нүүр.



сургууль дээр үнэ төлбөргүй ариун цэврийн хэрэглэл эмчийн өрөөнд байх нь зайлшгүй.

Өмнөх жилүүдийг бодвол сүүлийн жилүүдэд төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонгоход зориулсан ажлуудыг зохион байгуулах болжээ. Боловсролын жендэрийн дүн шинжилгээ судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй эмэгтэй багшийн 90 гаруй хувь нь сурагчдад зөвлөхдөө эмэгтэй хүнд багшийн ажил тохиромжтой, эрэгтэй хүнд барилгын ажил тохиромжтой гэх зэргээр жендэрийн өрөөсгөл үзэл, хандлага гаргадаггүй байгаагаас үзэхэд мэргэжлийн чиг баримжаа олгох тал дээр багш нарт жендэрийн үзэл санаа төлөвшиж байгааг харууллаа (Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, 2016).<sup>53</sup>

Сургуулийн боловсролын тогтолцоо мэдлэг олгохоос гадна сэтгэл зүйн болоод ёс суртахууны боловсролд анхаарах шаардлагатай. Яагаад гэвэл боловсролын институтын ил чиг үүргээс гадна далд чиг үүрэг нь нийгмийн зөв зохистой

<sup>53</sup> Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, “Бага дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ,” Швейцарийн Хөгжлийн Агентлаг, 2016. 36 дэх нүүр.



**Тэгш хамран сургах ойлголтыг багш өөрөө сайн ойлгох хэрэгтэй бөгөөд тэгснээр бусдад ойлгуулах болно.**

харилцааг үүсгэх байдаг. Боловсрол зөвхөн мэдлэгээс гадна бас ёс зүй, харилцаа, соёл, энэрэх сэтгэлийг багтаасан ойлголт. Тиймээс сургуулийн чиг үүрэг зөвхөн мэдлэгийг бус ёс зүй болоод сэтгэл зүйн боловсролыг олгоход чиглэх хэрэгтэй. Боловсролын реформ хөдөлгөөн нь сэтгэл зүйд суурилсан боловсролыг дэмжихийг гол зарчмаа болгож байгаа нь сайшаалтай.

Жендэрийн хэвшмэл үзэл, ойлголт нь ялгаварлан гадуурхалт хийгээд жендэрт суурилсан хүчирхийллийн үндэс болдог. Энэ утгаараа сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургуулиуд дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийн асуудлаар туршлага солилцож, сургалтын агуулга, нэр томъёо, ойлголтын зөрүүг нэгтгэх ажлыг хийх хэрэгтэй (Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2019).<sup>54</sup>

Үүний тулд хүүхдүүдийг нийтээр тэгш хамран сургах ойлголтыг багш өөрөө сайн ойлгох хэрэгтэй бөгөөд

<sup>54</sup> Хүний Эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улсын Хүний Эрхий Үндэсний Комиссын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан,” Улаанбаатар, 2019. 19 дэх нүүр.



тэгснээр бусдад ойлгуулах болно. Багшийг бэлтгэхдээ жендэрийн ойлголттой болоход нь онцлон анхаарснаар хүүхдүүдийн харилцан бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх үндэс болно.

Их дээд сургуулиудын бакалаврын ерөнхий суурийн хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан жендэрийн эрх тэгш байдлын тухай судалгааны дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд, иргэний боловсролын чиглэлийн хичээлүүдийн хөтөлбөрийн агуулга, тэдгээрт ашиглаж буй үндсэн сурах бичгүүдийг ерөнхийд нь жендэрийн мэдрэмжгүй гэж дүгнэжээ (Монгол Улсын Их Сургууль: Социологи, Нийгмийн ажлын тэнхим, 2019).<sup>55</sup> 2019 онд их дээд сургуульд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын (цаашид ЭЭШ гэх) дүнг хүйсээр авч үзвэл охид үндсэн хичээлүүд болох математик, монгол хэл, нийгмийн ухаан, гадаад хэл, физикийн хичээлүүд дээр хөвгүүдээс өндөр оноо авсан байгааг Боловсролын Үнэлгээний Төвөөс мэдээлсэн.

Боловсролын салбарын хүрээнд багшийн үнэлгээ нийгмийн хүйсийн нөлөөтэй байна. Их дээд сургуулиудын бакалаврын ерөнхий суурийн хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан жендэрийн эрх тэгш байдлын тухай судалгааны дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд, нийт оюутнуудын дундаж дүнгээс эмэгтэй оюутны дундаж дүн өндөр, харин эрэгтэй оюутнуудын дундаж дүн доогуур байна. Нийт оюутнуудаас эрэгтэй оюутнуудын амжилт доогуур байна гэжээ (Монгол Улсын Их Сургууль: Социологи, Нийгмийн ажлын тэнхим, 2019). Түүнчлэн эрэгтэй багш нар эмэгтэй багш нартай харьцуулахад оюутанд илүү өндөр үнэлгээ өгдөг нийтлэг хандлага шинжлэх ухааны бүх чиглэлд ажиглагджээ.<sup>56</sup>

Жендэрийн тэгш байдлын асуудлууд нь эрүүл мэнд, боловсролын хүртээмжтэй байдал, дотоод шилжилт хөдөлгөөн, ажил эрхлэлт, ядуурал зэрэгт амь бөхтэй байсаар байна.

55 Монгол Улсын Их Сургууль: Социологи, Нийгмийн ажлын тэнхим, "Н.Болдмаа: Дээд боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага," Социологи, pp. 162-171, 2019.

56 Н.Болдмаа, Дээд боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага, 2019, МУИС-ийн Нийгмийн Ухааны Сургууль, Социологи сэтгүүл. 171 дэх нүүр.



**Нийт оюутнуудаас эрэгтэй оюутнуудын амжилт доогуур байна.**



**Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9,7 жил.**

Эрүүл мэндийн хувьд авч үзье. Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.2.6 -д "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа" явуулахаар төлөвлөсөн. ҮСХ-ны 2018 оны мэдээллээр эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс 1,5 дахин их буюу нас барж буй 10 хүн тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна. Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9,7 жил байгаа нь дэлхийн дунджаас хоёр дахин их байна. ДЭМБ-ын 2016 оны статистикаас харахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү хамгийн өндөр улсуудаас 12-рт, Ази, Номхон далайн бүсийн хувьд 2-рт жагсаж байна. Монгол Улсын хувьд дундаж наслалт 1992 оноос 2018 онд 70.2 болж 26 жилийн хугацаанд 7.4 жилээр нэмэгдсэн бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 26 жилийн хугацаанд 60.7-оос 66.1 болж 5.4 жилээр, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 64.9-өөс 75.8 болж 10.9 жилээр нэмэгдсэн байна. Монгол Улсын хэмжээнд дундаж наслалтыг нэмэгдүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр үндэсний хэмжээний 4 бодлого, 9 хөтөлбөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг арилгах чиглэлээр тодорхой бодлого, үйл ажиллагаа байхгүй байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 91.5 хувь нь хэвийн жинтэй, 2.3 хувь нь жингийн дутагдалтай, 4.4 хувь нь жингийн илүүдэлтэй байгаа бол 1.8 хувь нь I, II болон III зэргийн таргалалттай байна. Байршлаар авч үзвэл сумын төв, хөдөөд жингийн дутагдалтай залуучуудын хувь өндөр, нийслэл, аймгийн төв, тосгонд эсрэгээрээ жингийн илүүдэлтэй залуучуудын хувь өндөр байна. Эрэгтэйчүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах нь зөв гэж мэддэг ч урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах дадал хэвшил муу байна. Арван эрэгтэй тутмын ес нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх хэрэгтэй гэж үзсэн ч гурван эрэгтэй тутмын нэг нь урьдчилан сэргийлэх үзлэгт огт хамрагдаагүй байна. Насны бүлэг, боловсролын түвшин дээшлэх тусам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх хэрэгтэй гэж үзсэн хувь нэмэгдсэн байна.



**Нийт залуучуудын гуравны нэг нь буюу 30.3 хувь нь тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг байна.**

Бүлгийн ярилцлагаас эрэгтэйчүүд эмнэлэгт очоод үзүүлэх эрэгтэйчүүдэд зориулсан кабинет байдаггүй, хэнд үзүүлэхээ мэддэггүй. Мөн уламжлалт зан үйлээр эрэгтэйчүүд гэр орноо авч явна, хүчтэй байна гэдэг шалтгаанаар нэрэлхүү, зангаасаа болоод эрүүл мэнддээ анхаарахгүй байна. Иймд гэр бүлийн хүрээнд эцэг эхийн үлгэр дууриаллаар эхнэрүүд нөхөртэйгөө урт удаан хамт амьдрахын тулд нөхрөө эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг байх, эцэг эхчүүд хөвгүүддээ эрүүл мэндийн үзлэгт хамрагдах дадал хэвшил суутал эмнэлэгт цуг явах хэрэгтэй байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн ихэнх (96.6 хувь нь) зөв хооллолт эрүүл мэндэд чухал гэж үзсэн хэдий ч дөрвөн эрэгтэй тутмын нэг нь л зөв хооллож байна. Мөн эрэгтэйчүүдийн 96.9 хувь нь дасгал хөдөлгөөн хийх нь эрүүл мэндэд чухал гэж үзсэн бөгөөд нийт залуучуудын гуравны нэг нь буюу 30.3 хувь нь тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг байна. Эрэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэхэд зөв хооллодог хувь, дасгал хөдөлгөөн чухал гэж үзэх хувь, дасгал хөдөлгөөн тогтмол хийдэг хувь нэмэгдэж байгаа ч бакалавр, түүнээс дээш зэрэгтэй эрэгтэйчүүдийн 25.1 хувь нь тогтмол зөв хооллодог, 35.6 хувь нь дасгал хөдөлгөөн тогтмол хийж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн дунджаар 16.4 насандаа тамхи татаж үзсэн бөгөөд 24-26 насны бүлгийнхэн 17.5 насандаа тамхи татаж үзсэн бол 18-20 насанд 15.9 насандаа тамхи татаж үзсэн байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 45.0 хувь нь одоо тамхи татдаг байна. 18-26 насны эрэгтэйчүүд дунджаар 18.2 насандаа согтууруулах ундаа хэрэглэж үзсэн бөгөөд 24-26 насанд анх согтууруулах ундаа уусан дундаж нас нь 19.4 байгаа бол 18-20 насанд анх согтууруулах ундаа уусан дундаж нас нь 17.4 байгаа нь залуучууд архи, тамхи хэрэглэж эхэлсэн нас эртэсч байгаа буюу залуучууд илүү багаасаа хорт зуршилд автаж байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 3 эрэгтэй тутмын нэг нь сүүлийн 1 сард дунджаар 4 өдөр согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Хоёр эрэгтэй тутмын нэг нь бага байхдаа хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд дөрвөн эрэгтэй тутмын нэг нь багадаа хүнд ажил хийж байсан байна. Бага байхдаа хүнд ажил хийх нь осол гэмтэлд өртөх эрсдэлтэй. Үүнээс үзэхэд, эрэгтэйчүүдийг багаас нь эрүүл мэндийн мэдлэг, дадал



**Эмнэлгүүдийг эрэгтэйчүүдийн кабинет, эрэгтэйчүүдийн эмчтэй болгох шаардлагатай.**

суулгах шаардлагатай тул боловсролын систем анхаарах, хүүхэд байхаас нь эхлээд эрэгтэйчүүдийг эрүүл мэнддээ анхаардаг болгох шаардлагатай байна. Мөн эмнэлгүүдийг эрэгтэйчүүдийн кабинет, эрэгтэйчүүдийн эмчтэй болгох шаардлагатай. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрэгтэй хүүхдүүдийг сургууль, гэр бүлийн орчинд эрүүл мэнддээ анхаарах асуудлаар тусгайлан арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролоос эхлэн муу зуршлын хор нөлөөг сайн таниулах, зөв хооллолт, амьдралын зөв хэв маягийн талаар таниулах хичээл оруулах;
- Эрэгтэй хүүхдийг сэтгэл санааны хүнд, гутранги байдлаа даван туулах болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадварыг олгох мэдээллийг хүртээмжтэйгээр хүргэх;
- Эрэгтэйчүүдийн таргалалтаас үүдэлтэй эрүүл мэндэд нь учирч буй эрсдлийг бууруулах чиглэлээр мэдээлэл, мэдлэгийг насны бүлгийн онцлогт нь нийцүүлэн тогтвортой хүргэх;
- Сургуулиудад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллуулах;
- Үлгэрлэн таниулах аргыг аав, ээж, багш сурган хүмүүжүүлэгчид ухуулан таниулах шаардлагатай байна.<sup>57</sup>

<sup>57</sup> ҮСХ, ЖҮХ 2020 Суурь судалгааны тайлан

## Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2018 онд 105,730 байгаа бөгөөд өмнөх оноос 2,100-аар өссөн үзүүлэлттэй байна<sup>58</sup>. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хэлнэ<sup>59</sup> хэмээн Үндэсний Статистикийн Хороо (цаашид ҮСХ гэх) тодорхойлон жил бүрийн тайланг гаргаж байна.

### Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо

Бүс байршил	2015	2016	2017	2018
Улсын дүн	101,730	100,993	103,630	105,730
Баруун бүс	17,544	17,272	17,294	17,848
Хангайн бүс	22,524	21,940	23,115	22,935
Төвийн бүс	18,051	18,788	19,215	19,227
Зүүн бүс	9,668	9,280	9,760	10,131
Улаанбаатар	33,943	33,713	34,246	35,589

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны хүн амын дөнгөж 20 гаруй хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ажил олгогчдын ойлголт, хандлага сөрөг байна. Дэд бүтцийн хүртээмжээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт төдийлөн нэмэгдэхгүй байна.<sup>60</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан боловсролын хөтөлбөрийг 2018 онд баталж, тэдний чанартай боловсрол эзэмших эрхийг хангах, ердийн сургуульд суралцах боломжийг бүрдүүлэх талаар зарим ахиц гарч байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого, хандлага хараахан өөрчлөгдөөгүй байгаа бөгөөд шинэчлэл хийхэд цаг хугацаа, хөрөнгө оруулалт шаардлагатай хэвээр байна.<sup>61</sup>

58 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

59 ҮСХ-ны тодорхойлолт

60 МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 11-р тал

61 Мөн тэнд, 32-р тал




Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны хүн амын дөнгөж 20 гаруй хувь нь хөдөлмөр эрхэлдэг.

## Хүснэгт 6. ЕБС болон СӨБ-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бүсийн дүнгээр

Бүс байршил	ЕБС		СӨБ	
	2018	2019	2018	2019
Улсын дүн	6,518	6,053	1,087	1,076
Баруун бүс	983	853	94	90
Хангайн бүс	1,409	1,261	170	169
Төвийн бүс	835	759	178	172
Зүүн бүс	505	488	61	90
Улаанбаатар	2,784	2,692	584	555

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80% орчим нь эдийн засгийн идэвхгүй байна.

2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 1076 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа бол, 6053 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтцийн болон бусад бүхий л төрлийн нийгмийн үйлчилгээний хүртээмж нь мэдээлэл авах, оролцох эрхээ эдлэхэд нэн чухал бөгөөд, зорилтот дэмжлэг хангалтгүй байгаагийн зэрэгцээ тэднийг нийгэмд ялгаварлан гадуурхах нь түгээмэл байгааг энэхүү үнэлгээг хийх үед уулзсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эх илэрхийлсэн байдаг. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бараг тал хувь нь бичиг үсэг тайлагдаагүй, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80% орчим нь эдийн засгийн идэвхгүй байгаа учраас тэд ядууралд өртөж, амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой амьдарч байна.

Монгол Улсын парламентын түүхэнд анх удаа 2020 оны УИХ-ын сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвшив. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2019 оноос эхлэн сонгуулийн санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүртээмжтэй байлгах, сонгуулийн сурталчилгаа, нэр дэвшигчийн танилцуулга, санал өгөх талаарх зааврыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой хэлбэрээр буюу дохионы хэл, брайл үсгээр хүргэх, тэргэнцэртэй иргэдэд зориулсан дэд бүтцийг санал авах байранд бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд квот олгохыг Сонгуулийн

тухай хуульд нэмэлтээр оруулж хуульчлах шаардлагатай гэсэн саналыг гаргаж байв.

Бие махбодын бэрхшээлээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлөөс хоцроохгүй байж, хөгжих эрхийг нь эдлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцох эрхийг хангахад тэдний мэдээлэлтэй байх, чанартай боловсрол эзэмших эрхийг эн тэргүүнд анхаарч, цахим засаглалыг хөгжүүлэх, бүх иргэнд ижил тэгш хүртээмжтэй дэд бүтцийг бий болгох, сонголттой оролцооны хувилбаруудыг бий болгох, дэмжих нэн шаардлагатай байна.

## Хотжилт, шилжин суурьшилт

2018 онд нийт хүн амын 67.9% нь хот суурин газар, үлдсэн 32.1% нь хөдөө амьдарч байна<sup>62</sup>. Шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан хот, хөдөө аль алинд хүндрэл бэрхшээлүүдийг бий болгож байгаа нь улсын бодлогын нэг гол тулгамдсан асуудал болж байна. Шилжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлийг харахад, шилжигч өрхүүдийн хувьд эдийн засгийн шинж чанартай хүндрэл, тэр дундаа, ажил олоход хүндрэлтэй байдаг гэсэн сорилт голлон зонхилж байна<sup>63</sup>. Байгалийн гамшиг, доройтол нь хөдөөнөөс сум, аймгийн төв, аймгийн төвөөс хот руу шилжих хөдөлгөөний урсгалыг улам бүр нэмэгдүүлж байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, шилжих хөдөлгөөнийг эсрэг чиглэлд өөрчлөх бодит хэрэгцээ байгаа бөгөөд орон нутгийн шийдвэр гаргах эрх мэдлийг өсгөх, хүний эрхийг дэмждэг засаглалыг бэхжүүлэх,



**Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, шилжих хөдөлгөөнийг эсрэг чиглэлд өөрчлөх бодит хэрэгцээ байна.**

болон хот, суурины зах зээлд холбох дэд бүтцийг барьж байгуулах, их дээд сургууль, эмнэлэг, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитойгоор сайжруулах, иргэдэд бизнес эрхлэх боломжийг дээшлүүлэх, түүхий эдийг орон нутагт нь боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэмжин орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх, орон нутгийн давуу талд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

62 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

63 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2018

**Хүснэгт 7. Хүн амын дотоод шилжин явсан (ирсэн) хөдөлгөөн**

Бүс, байршил	2016	2017	2018	2019
Баруун бүс	8985 (3907)	3587 (3406)	2443 (2635)	4059 (2036)
Хангайн бүс	11509 (6911)	6954 (7856)	6557 (7025)	8320 (5438)
Төвийн бүс	13469 (11875)	8759 (12458)	11616 (12095)	9665 (9404)
Зүүн бүс	3884 (2794)	2075 (3388)	2866 (3106)	2580 (2115)
Улаанбаатар	14342 (25196)	11431 (10335)	6328 (6568)	6595 (12373)

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт 5.6 хувьтай байна. Энэхүү шилжих хөдөлгөөн энэ хэвээр үргэлжлэх тохиолдолд хотын төвлөрөл, түүнийг дагасан асуудлууд нэмэгдэх, хөдөө орон нутгийн хөгжил улам хоцрогдож, эзэнгүйдэх эрсдэлтэй байна. Иймд хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, шилжих хөдөлгөөнийг эсрэг чиглэлд өөрчлөх бодит хэрэгцээ байна. Үүний тулд орон нутагт болон хот, суурины зах зээлд холбох дэд бүтцийг барьж байгуулах, их дээд сургууль, эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг болон бизнес эрхлэх боломжийг дээшлүүлэх, орон нутгийн давуу талд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна<sup>64</sup>.

**Хүснэгт 8. Хүн амын нягтрал<sup>65</sup>**

Бүс байршил	2016	2017	2018	2019
Улсын дүн	2	2	2.1	2.1
Баруун бүс	0.9	1	1	1
Хангайн бүс	1.5	1.5	1.6	1.6
Төвийн бүс	1	1.1	1.1	1.1
Зүүн бүс	0.7	0.8	0.8	0.8
Улаанбаатар	306.5	311.3	317.3	327.6

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Тус улсад нэг нэгж газарт 2.1 хүн ногдож байна. Харин Улаанбаатар хотод хүн амын нягтрал эрчимтэй нэмэгдэж 2019 оны байдлаар 327.6 хүн болсон байна. Хүн амын нягтрал нэмэгдэж буй үзэгдэл нь хүн амын хэт төвлөрлийг бий болгох болгох бөгөөд үүнээс үүдэн агаар, ус, хөрсний бохирдол, гэр хороолол болон хотын газар нутгийн зохицуулалтгүй тэлэлт, зүй ёсгүй ашиглалт, нийтийн тээврийн хангалтгүй

64 Алсын хараа 2050, 2020

65 Нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ. Жишээ нь нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам эсвэл тариалах боломжтой нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам



**Зах зээлийн эрэлт хэрэгцээ, хөгжлийг хангахад чиглэсэн замбараагүй хотжилт өрнөсөн ба энэ хүрээнд иргэн, нийтийн эрх ашгийг хангах асуудал, тэр дундаа хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах асуудлыг шийдвэрлэж чадаагүй.**

байдал, орон сууц нийгмийн дэд бүтцийн хангамжгүй байдал гэх мэт сөрөг үр дагаврууд гарч байгаа юм. Мөн алслагдсан дүүрэг, хорооны хүүхдүүд сургууль, цэцэрлэгт хамрагдах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хүндрэлтэй болж байна<sup>66</sup>.


Хотжилтын үйл явцад нийтийн эрх ашгийг хангах асуудлыг орхигдуулсан нь Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан хотжилт, хот төлөвлөлт, газрын харилцааны талаарх хуулийн төслүүдийн үндэслэл, танилцуулгаас мөн илэрхий байна. Үндсэндээ зах зээлийн эрэлт хэрэгцээ, хөгжлийг хангахад чиглэсэн замбараагүй хотжилт өрнөсөн ба энэ хүрээнд иргэн, нийтийн эрх ашгийг хангах асуудал, тэр дундаа хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах асуудлыг шийдвэрлэж чадаагүй.<sup>67</sup> Улаанбаатар хотод суурьших иргэдийн тоо хэт нэмэгдсэнээс алслагдсан дүүрэг, хорооны хүүхдүүд сургууль, цэцэрлэгт хамрагдах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хүндрэлтэй болж, мөн гэр хорооллын хэт тэлэлт, хог хаягдлыг боловсруулах асуудлыг зохистой шийдвэрлэхгүй байгаа зэрэг асуудал нь орчны бохирдлыг нэмэгдүүлж байна.<sup>68</sup> Түүнчлэн хотын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл нийт хүн амыг бүгдийг шингээж чадахгүй байгаа тул шилжин ирэгсэд болон ядуучууд нь ажилгүй, орлогогүй үлдэх магадлал өндөр хэвээр байна. Иймд орон нутгийн нөөц боломжид тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийг дэмжих шаардлагатай тулгарч байна.<sup>69</sup>

66 "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" танилцуулга

67 ХЗҮХ, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, 2016

68 Мөн тэнд, 34 дэх тал

69 Дэлхийн Банк, Дэлхийн Банк Монголд Тойм, 2018



**Монгол Улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх эрсдэлтэй.**

## Гамшигт үзэгдэл

Дэлхийн улс орны нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль орчин, гамшгийн үеийн хямралыг даван туулах нөөц, чадавхыг үнэлэн эрэмбэлдэг Эмзэг байдлын үзүүлэлтээр 2019 оны байдлаар Монгол Улс нийт 120 онооноос 54.1 оноо авч нийт 178 улсаас 128 дугаар байранд орсон нь илүү тогтвортой орны жагсаалтанд орсон байна<sup>70</sup>. Улс орнуудад учирч болох байгаль цаг уурын гамшгийн эрсдэлээр үнэлсэн Дэлхийн эрсдэлийн тайланд 2019 оны жагсаалтад 180 орноос 149-р байранд буюу эрсдэл багатай орнууды тоонд багтжээ<sup>71</sup>. Хэдий тийм боловч Монгол Улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх эрсдэлтэй нутагт ордог. Уур амьсгалын өөрчлөлтийн зэрэгцээ бэлчээрийн даац хэтрэлт, газар тариалан, уул уурхай, дэд бүтцийн салбарын үрэлгэн, хоцрогдсон технологи ашиглалт, олон салаа зам, хот суурины төлөвлөлтгүй тэлэлт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр цөлжилт, газрын доройтол эрчимжиж байна<sup>72</sup>.

### Хүснэгт 9. Гамшигт үзэгдэл, хохирол

Гамшигт үзэгдэл, хохирол	2018	2019
Гамшигт үзэгдлийн тохиодлын тоо	28964	34841
Ой, хээрийн түймэр /тоо/	465	822
Объектын түймэр /тоо/	25143	29718
Хүчтэй цасан болон шороон шуурга /тоо/	129	412
Аадар бороо, үерийн аюул /тоо/	395	227
Газар хөдлөлт	229	265
Хорогдсон, устгасан мал, амьтан /мян. толгой/	4.8	0
Гамшгийн улмаас нас барсан хүн /тоо/	1288	1360
Гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээ /тэрбум төг/	258.49	250.88

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, 2018 оны 327 дугаар

70 Fund for Peace, the Fragile States Index 2019

71 World risk report, 2019

72 Алсын хараа 2050, 2020



тогтоолоор батлагдсан “Гамшгийн зэрэглэл тогтоох журам”, 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам” болон бусад холбогдох дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалаар “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар”-ыг баталсан. 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар 6 аймгийн 17 суманд нийт 19 удаагийн ой, хээрийн гал түймэр гарсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ой, хээрийн гал түймрийн дуудлага 26.4 хувиар, хохирлын хэмжээ 40.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна<sup>73</sup>. 2019 онд Монголын нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт нийт 45,757 газар хөдлөлт бүртгэгдсэн. Үүнээс Монгол орны нутаг дэвсгэрт 30 гаруй мянга, хил орчмын бүсэд 15 мянган удаагийн газар хөдлөлт болсон байна. Үүнээс 4-4.9 магнитудын газар хөдлөлт 23, 5-5.9 магнитудын газар хөдлөлт дөрвөн удаа болжээ. 2020 оны байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгдүгээр сараас гуравдугаар сарын 27-ныг хүртэлх хугацаанд 17 мянга гаруй газар хөдлөлт болсон. Үүнээс 3.5 магнитудын газар хөдлөлт 21 удаа болсон байгаа. Эдгээр 21 тохиолдлоос найм нь Говь-Алтай аймгийн Тонхил суманд болсон байна.<sup>74</sup>

73 ОБЕГ, <https://nema.gov.mn/n/82513>

74 ОБЕГ, <https://nema.gov.mn/n/99812>



## Орчны бохирдол

Монгол Улс нь 2018 оны байдлаар агаарын гадаад орчны хамгийн их бохирдолтой дэлхийн 73 улсаас зургаадугаарт жагсаж байсан бол 2019 оны оны байдлаар дэлхийн 98 улсаас гуравдугаар байранд буюу хүн амын зүрх, амьсгалын замын эрхтэнд хортой нөлөөтэй бохирдолтой хотын ангилалд орсон байна.<sup>75</sup> Харин Улаанбаатар хотын хувьд 2018 оны хамгийн бохирдолтой хотуудын 5-р байранд (58.5) жагсаж байсан бол 2019 онд 3-р байранд (62) буюу агаарын бохирдлын чанар муудсан байна. Орчны агаарын бохирдол нэмэгдэж байгаа нь салбар дамнасан хөгжлийн тулгамдсан асуудал болж байна.<sup>76</sup> Агаарын бохирдол эхийн хэвлийд байгаа урагт нөлөөлж өсөлтгүй жирэмслэлт,

<sup>75</sup> IQAir, World air quality report, 2018, 2019

<sup>76</sup> МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 58-р тал



**Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлд хамгийн их буюу 20.2 хувийг хатгалгаа өвчин, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа 70.9 хувийг эзэлж байна.**

амьсгалын замын тогтолцоо, тархины хөгжилд нөлөөлж, зулбах, дутуу болон жин багатай төрөх, төрөлхийн гажиг үүсэх эрсдэлийг дагуулж байна.<sup>77</sup> Манай улсын агаарын бохирдол жилээс жилд нэмэгдсээр ирсэн. Агаарын бохирдол нь сүүлийн хэдхэн жилд бий болсон асуудал биш юм. Бүс нутгийн жигд бус хөгжил, байгалийн гамшгийн давтамж нэмэгдсэнээс хот сууринд хүн амын төвлөрөл үүссэн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж агаарын бохирдлын түвшин нэмэгдэж байна.<sup>78</sup> 2018 онд “Агаарын бохирдлыг бууруулахад авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолыг тус тус гарган хэрэгжүүлсэн бөгөөд тогтоол гарсны дараах буюу шахмал түлш хэрэглэснээс хойшхи агаарын бохирдлыг харьцуулсан судалгаа одоогоор хийгдээгүй байна. Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлд хамгийн их буюу 20.2 хувийг хатгалгаа өвчин, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа 70.9 хувийг эзэлж байна.<sup>79</sup> ҮСХ-ны гаргасан 2018 оны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-нд 9,903 хүнийг хамруулснаас 19.7 хувь нь өрхийн ундны усанд гэдэсний савханцар (Е.колигаар бохирдсон) илэрсэн буюу ялгадсаар бохирдсон өрхөд амьдарч байна<sup>80</sup>. Улаанбаатар хотын нийт гэр хорооллын 180 гаруй мянган айл өрх төвлөрсөн усан, ариун цэвэр, дулаан хангамжид холбогдоогүй байгаа бөгөөд тэдний 90% гаруй нь энгийн, шаардлага хангаагүй нүхэн жорлон ашиглаж байна.<sup>81</sup>

<sup>77</sup> Эмэгтэйчүүдийн нүдээр Агаарын бохирдол ба эх, хүүхдийн эрүүл мэнд XIII чуулган <https://www.nso.mn/content/2211#.XsjCOBMzbs0>

<sup>78</sup> МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, 57-р тал

<sup>79</sup> ҮСХ, Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд, 2019

<sup>80</sup> Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018, 261-р тал

<sup>81</sup> Б.Зориггоо, Д.Сувд, Хотжилт, цаг уурын дулаарал ба халдварт өвчин, НЭМХ, 2016; НҮБ-ын Хүүхдийн Сан, “Хүйтэн уур амьсгалтай орнуудын ариун цэврийн байгууламжийн шийдэл” олон улсын зөвлөлдөх уулзалт, 2017, 77 дахь тал

Энгийн нүхэн жорлонгоос шууд хамааралтайгаар хөрс, ус, орчны бохирдол нэмэгдэж, улмаар 5 хүртэлх насны хүүхдийн дундах суулгалт өвчний тархалт буурахгүй байна.<sup>82</sup> Улаанбаатар хотоос авсан бүх хөрсний дээж, Дархан хотоос авсан дээжийн 72.2%, Эрдэнэт хотоос авсан дээжийн 54.5% нь их бохирдолтой түвшинд хамрагдаж байгаа ба ялангуяа Улаанбаатар хотын үнэлгээнд хамруулсан хөрсний дээжийн 88%-д нь нян, хөгц, мөөгөнцөр илэрчээ.<sup>83</sup>

Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн асуудал жилээс жилд хүндэрсээр байгаа ба Засгийн газрын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хөтөлбөр хэрэгжсэн ч гэсэн 2030 он гэхэд 400 гаруй мянган иргэн бохирын шугамд холбогдоогүй байхаар байна.<sup>84</sup>

82 Мөн тэнд

83 Мөн тэнд, 155 дахь тал

84 Мөн тэнд, 53 дахь тал

Хотын хүн амын 66%, хөдөөгийн хүн амын 59% нь баталгаат ундны усаар хангагдсан байна.<sup>85</sup> Улаанбаатар хотын хүн амын ундны усны эх үүсвэрийн сав газрын хамгаалалтын бүс дотор хууль бусаар айл буух, хашаа барих зэрэг байгууламжийг бий болгосон нь хөрсний бүтцийг эвдэж, гүний усны нөхөн тэжээгдлийг бууруулж, нөөцийг багасгах аюултай байгаа юм.<sup>86</sup>

Мөн аймаг, сумын төвлөрсөн ус хангамжийн уснаас авсан дээжийн 12.7%-д, төвлөрсөн бус усан хангамжийн уснаас авсан дээжийн 22%-д нянгийн тоо стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарсан байна.<sup>87</sup>

85 Мөн тэнд

86 НҮБ-ын Хүүхдийн Сан, “Хүйтэн уур амьсгалтай орнуудын ариун цэврийн байгууламжийн шийдэл” олон улсын зөвлөлдөх уулзалт, 2017, 112 дахь тал

87 Мөн тэнд, 131 дэх тал





## НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН БОЛОН БҮСИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭ КОНВЕНЦ

Монгол Улс 2020 оны 7 дугаар сарын байдлаар хүний эрхийн чиглэлээр олон улсын 36 гэрээнд нэгдэн орсон ба 2018 оноос хойш хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдэн ороогүй байна. Монгол Улс 1980 онд батлагдсан Олон улсын хэмжээнд хулгайлагдсан хүүхдийг орон гэрт нь буцаах иргэний талуудын тухай Гаагийн конвенцод нэгдэн ороогүй хэвээр байна.

Үнэлгээнд хамаарах хугацаанд 2019 оны 9-р сарын 17-ны өдөр НҮБ-ын Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах хорооноос 1966 онд нэгдэн орсон НҮБ-ын Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон улсын конвенцын хэрэгжилтийн тайланд дүгнэлт зөвлөмжөө Монгол Улсын Засгийн газарт илгээсэн байна. Түүнчлэн, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн Ажлын хэсэг Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлыг 2020 оны 11 сарын 3-ны өдөр гурав дахь удаагаа авч хэлэлцэх юм.

Нэгдэн орсон гэрээний албан ёсны орчуулгыг хийх, НҮБ-аас ирүүлж байгаа дүгнэлт зөвлөмжийг олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, төрийн болон төрийн бус байгууллага (цаашид ТББ гэх), хууль сахиулах байгууллага, шүүхэд тэдгээрийг хэрэглэх мэдлэг чадавхыг бэхжүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (цаашид НҮБ гэх) Хүүхдийн Эрхийн Хорооноос Монгол Улсын Засгийн газарт 2017 онд илгээсэн зөвлөмжид хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай хүний, техникийн



**Монгол Улс хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд хөрөнгө нөөцийн хуваарилалт, хүүхдийн эрх ба бизнесийн салбар, ялгаварлан гадуурхахгүй байх, гэр бүлийн орчин, байгаль орчин ба эрүүл мэндийн асуудал болон хүүхдээр морь унуулах, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг эдийн засгийн мөлжлөгийн эсрэг шаардлагатай бүх арга хэмжээг яаралтай авах шаардлагатай.**

болон санхүүгийн нөөцийг гаргах, хуваарилахыг зөвлөсөн юм. Тус зөвлөмжид хөрөнгө нөөцийн хуваарилалт, хүүхдийн эрх ба бизнесийн салбар, ялгаварлан гадуурхахгүй байх, гэр бүлийн орчин, байгаль орчин ба эрүүл мэнд болон хүүхдээр морь унуулах, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг эдийн засгийн мөлжлөгийн эсрэг шаардлагатай бүх арга хэмжээг яаралтай авахыг шаардсан юм.

Хороо нь Конвенц, түүний гурван нэмэлт протокол, сэдэвчилсэн ерөнхий зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийг Монгол Улсад мөн сануулсан. Түүнчлэн Хүний Эрхийн Үндэсний Комисс (цаашид ХЭҮК гэх) дээр хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, гомдол хүлээж авах механизмыг бүрдүүлэх, хүүхдийг өөрсдийг нь гомдол гаргах эрхтэй, чадвартай болгох талаар шаардлагатай бүх арга хэмжээг авахыг уриалсан. Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн зургаа ба долоодугаар тайлангуудаа хамтатган 2022 оны 9-р сарын 1-ний дотор НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх үүрэгтэй бөгөөд энэхүү тайланд өмнөх дүгнэлт зөвлөмжүүдээр хүлээсэн үүргийн биелэлтийг мөн илтгэх юм. Үндсэндээ нэгдэн орсон хүүхдийн эрхийн талаарх гэрээ конвенцын хүрээнд хууль тогтоомжийг сайжруулах, хэрэгжилтийг хангах олон ажил хийгдэж байгааг хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, тогтолцооны шинэчлэлийн талаарх дараах хэсгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ.



2B

## ЭРХ ЗҮЙН БОЛОН УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦОО

### Улс төрийн нөхцөл байдал

1992 оны Үндсэн хуульд Монгол Улс нь парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс бөгөөд хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их Хурал, гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн газар, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллага нь Дээд шүүх юм гэж заасан. Монгол Улс засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд; аймаг нь сумдад, сум нь багт; нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдана. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас бүрэлдэнэ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг баримтлана. 2019 оны байдлаар Монгол Улс 21 аймаг, 330 сум, 1639 баг, нийслэл Улаанбаатар хотдоо 9 дүүрэг,



169 хороотой.<sup>88</sup> Бүх түвшний засаг захиргаа нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулдаг. Иймд орон нутгийн гүйцэтгэх засаглал нь нэг талаас дээд шатны захиргааны байгууллага, нөгөө талаас иргэний нийтийн хурлын өмнө хариуцлага хүлээдэг боловч санхүүжилтийн хувьд дээд шатны байгууллагаас хамааралтай тул дээд шатны байгууллагуудтай илүүтэй хамтран ажилладаг.<sup>89</sup> Мөн Засаг захиргааны тухай хууль тогтоомжтой хэдий ч сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын хариуцлага, хамтын ажиллагаа, хяналт тэнцвэрийн зохицуулалт тодорхой биш байдаг.<sup>90</sup>

Эрх зүйн тогтолцооны тухайд хэдийгээр Монгол Улс нь иргэний эрх зүйн тогтолцоотой оронд тооцогддог ч судлаачид Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн тогтолцооны холимог шинж чанар ажиглагддаг гэж үздэг.<sup>91</sup>

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19

88 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

89 Эшлэл 7, мөн тэнд, 5 дахь тал

90 Мөн тэнд, 5 дахь тал; Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006

91 Д.Баярсайхан, Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал, 2012

зүйл, 30 гаруй хэсэгт өөрчлөлт оруулахыг дэмжин баталсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс мөрдөж байна.

Монгол Улсын Дээд Шүүхэд 2019 оны 4 сарын байдлаар 36 бүртгэлтэй улс төрийн нам байна. Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2019 судалгаараар улс төрийн оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, намын санхүүжилт ба ил тод байдал гэсэн 4 үзүүлэлтээр Монголын улс төрийн намуудын ардчиллын индексийг гаргадсан бөгөөд томоохон 2 нам буюу Ардчилсан нам 65 оноогоор “ардчилсан”, улс төрийн олонхи буюу Монгол ардын нам 55 оноогоор “хагас ардчилсан” ангилалд багтаж байна. Сонгуулийн үйл явц, засгийн газрын үйл ажиллагаа, улс төрийн оролцоо, иргэний эрх чөлөөний индексээр тооцдог дэлхийн ардчиллын индексээр Монгол Улс 10 онооноос 6.5 оноо аван, 167 орноос 62-р байранд жагссан байна.

Монгол Улс Авлигын төсөөллийн индексээр 2018 онд 180 орноос 93-р байранд (100 онооноос 37 оноо) жагсаж байсан бол 2019 оны байдлаар 106-р (35 оноо) байранд буюу 13 байр ухарсан үзүүлэлттэй байна<sup>92</sup>. Засаглалын суурь

92 Транспэрэнси Интернэшнл, Авлигын төсөөллийн индекс, 2019

үзүүлэлтүүдийг хангаж буй байдлаар дэлхийн улс орнуудыг үнэлдэг Дэлхийн Банкны шалгуураас харахад төрийн зохицуулалт, Засгийн газрын ажиллагаа зэрэг үзүүлэлтүүд нэлээд сайжирсан байгаа боловч эрх зүйт төр, авилгын нөхцөл байдал эсрэгээрээ муудсан байна.<sup>93</sup>

**Зураг 1. Засаглалын үзүүлэлтүүд**



Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд 2018

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлсэн улс төрийн 13 нам, 4 эвслийг бүртгэж батламж олгосон болно. УИХ-ын сонгуульд нийт 606 хүнийг бүртгэж нэр дэвшигчийн үнэмлэх олгосноос 19.9 хувь нь буюу 121 нь бие даан нэр дэвшигч, 24.9 хувь нь буюу 151 нь эмэгтэй нэр дэвшигч байв. Сонгуулийн дүнгээр Монгол Ардын Намаас - 62, Ардчилсан Намаас - 11, “Та бидний эвсэл”-ээс /МАХН-ИЗНН-МҮАН/ - 1, “Зөв хүн электорат” эвслээс - 1, бие даан нэр дэвшигч - 1 хүн тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдлоо. Улсын Их Хурлын гишүүдийн 13 нь буюу 17.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Үнэлгээнд хамаарах хугацаанд Төрийн албаны тухай хуульд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

93 World Bank, Worldwide governance Indicators, 2018



## Иргэний нийгмийн оролцоо

Дэлхийн банкны засаглалын судалгааны иргэдийн дуу хоолой ба хариуцлага гэсэн үнэлгээнд Монгол Улсын индекс 57.124 байгаа бөгөөд 204 орноос 88-д эрэмбэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл бодлого тодорхойлох үйл явц дахь иргэдийн оролцоо дундаас ялимгүй дээгүүр байгаа юм. 2019 оны 4 дүгээр сарын байдлаар тус улсад Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт 22,416 төрийн бус байгууллага (цаашид ТББ гэх) байна. Үүнээс үйл ажиллагаагаа явуулж байгаа 10795, үйл ажиллагаа эрхлээгүй 7997, үйл ажиллагаагаа түр зогсоосон 3233, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон 302, олдохгүй байгаа болон бусад 89 ТББ байна. Төрөөс иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог үндэсний хөгжлийн нэгээхэн хэсэг гэдэг байр сууринаас дэмжин ажиллах асуудал удаашралтай байгаа боловч уг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэхээр Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, батлахаар ажиллаж байна. Төрийн бус байгууллагын тухай хуульд 1997 оноос хойш нийт 6 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд



**Олон нийтийн  
бүлэг, нийгмийн  
хөдөлгөөнүүд  
улсын бүртгэлд  
бүртгүүлэхгүйгээр  
үйл ажиллагаа  
явуулж болдог.**

төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 онд өргөн барьсан бөгөөд 2020 оны 7-р сарын байдлаар батлагдаагүй байна. 1997 онд батлагдсан ТББ-ын тухай хуулинд зааснаар төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ. ИНБ гэдэг нь холбоо, судалгааны байгууллага, олон нийтийн бүлэг, нийтлэг ашиг сонирхлын бүлэг, улс төрийн хөдөлгөөн, сонирхлын клуб гэх мэт байгууллагуудыг хэлж байна. ИНБ-ууд нь хуулийн этгээдээр бүртгүүлснээр албан ёсоор санхүүжилт авах болон тайлагнах боломж бүрдэж, орон тооны ажилтан ажиллуулах, үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд явуулах боломжтой. Түүнчлэн олон нийтийн бүлэг, нийгмийн хөдөлгөөнүүд улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулж болдог. ИНБ гэдэг нь ТББ-уудыг багтаасан нэр томъёо юм. Бүртгэлтэй ИНБ-уудын тоо хэдий олон ч тогтмол, системтэй үйл ажиллагаа явуулдаг ИНБ нь харьцангуй цөөн байна. Санхүүгийн боломж, хүний нөөцийн тогтвортой байдал болон удирдлагын чадавхи зэрэг нь ИНБ-ын оршин тогтнох болон амжилттай ажиллахад гол нөлөө үзүүлдэг. ИНБ-уудын 80 гаруй хувь нь нийслэл хотод, үлдсэн хувь нь орон нутагт бүртгэлтэй байна. Орон нутагт ажилладаг ИНБ-уудын тоо болон чадавхи жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллагууд нь ихэнхдээ жижиг хэмжээтэй, орон тооны ажилтангүй байх бөгөөд ихэвчлэн сайн дурын үндсэн дээр ажилладаг. Дунд хэмжээний ИНБ-ууд нь 2–5 орон тооны болон сайн дурын ажилтантай. Гишүүнчлэл болон удирдлагын аль ч түвшинд эмэгтэйчүүд ажиллах нь нийтлэг бөгөөд нийт ажилчдын 80-аас дээш хувийг эзэлдэг. Туршлагатай,





томоохон ИНБ-ууд бусад жижиг байгууллага, бүлгүүдэд сургалт явуулж, зөвлөгөө өгдөг. Улсын бүртгэлийн ерөнхий газар ИНБ-ын бүртгэлийн статистик тоо баримтыг сар бүр шинэчилэн гаргадаг боловч ИНБ-ын үйл ажиллагаа, холбоо барих хаяг, жилийн тайлан зэрэг иргэдэд өгөх мэдээллүүдийг нийтэлдэггүй байна. Зөвхөн цөөн тооны ИНБ-ууд цахим хуудас болон нийтийн сүлжээний сувгаар олон нийтэд үйл ажиллагааныхаа мэдээллийг ил болгодог. Мөн ИНБ-ууд үр дүнтэй ажиллаж буй эсэхийг хэмжих, чиг үүргийнхээ дагуу ажиллаж буй эсэхийг тодорхойлох механизм байхгүй байна. ИНБ-уудын үйл ажиллагааны тухай мэдээлэл дутмаг байгаа нь иргэний нийгмийн хөгжилд олон нийтийн оролцоог бий болгох, тэдний санаачлагыг дэмжих боломжийг хязгаарлаж байгаа юм.

ИНБ-уудад тулгамдаад буй томоохон асуудлуудын нэг нь дотоодын болон олон улсын түвшинд санхүүжилт авах туршлага дутмаг байгаа явдал юм. ИНБ-ын санхүүжилтийн гол эх үүсвэр нь гишүүнчлэлийн хураамж, хандив болон донор байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрүүд болоод байна. Үүний зэрэгцээ, ИНБ-ууд нь дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүжиж болдог. Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээлснээр ИНБ-ууд нь олон улсын донор байгууллагуудаас 59.5%, хувь хүнээс хандиваар 27.9%, өөрийн үйл ажиллагааны орлогоос 12.6%-ийн санхүүжилт тус тус бүрдүүлсэн байна. Үндэсний болон орон нутгийн ИНБ-уудад үндсэн санхүүжилт байхгүй бөгөөд ихэнхдээ олон улсын байгууллагын зарласан өрсөлдөөнт төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг. Төслийн санхүүжилт нь тогтмол биш учир ИНБ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд зарим тохиолдолд үндсэн чиглэлээсээ огт өөр үйл ажиллагаа эрхэлдэг байна. Орон нутгийн ТББ-уудад зөвхөн төслийн үр дүн төдийгүй ТББ-ын чадавхийг бэхжүүлэх, үндсэн нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн эх үүсвэрийг олговол тустай. Үйл ажиллагааны санхүүжилтийг бэхжүүлж, тогтвортой байдлыг хангаж ажиллах нь ИНБ-уудын хувьд тулгамдсан асуудлын нэг болж байна. Одоогоор ихэнх туршлагатай, томоохон ИНБ-ууд бусад жижиг байгууллага, бүлгүүдэд нэн



**ИНБ-ын  
санхүүгийн  
тогтвортой  
байдал,  
байгууллагын  
чадавхид гарч  
буй ахиц дэвшил  
хязгаарлагдмал  
байна.**

ялангуяа орон нутгийн ИНБ болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллага (ОНОТБ)-уудад сургалт явуулж, зөвлөгөө өгч байна. Зарим ИНБ-ууд хэвлэл мэдээлэл болон засгийн газрын байгууллагууд зэрэг оролцогч талуудад мэдлэг олгох, тэдний чадавхийг бэхжүүлэхэд анхааран бодлогын судалгааны төв хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Судалгааны төвтэй ИНБ-ууд нь техник эдийн засгийн үндэслэлд суурь судалгаа хийх, донор байгууллагуудаас санхүүжилт авсан төсөл, хөтөлбөрүүдийг хянах, үнэлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.<sup>94</sup> Үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн болон иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа хөгжиж байгаа хэдий ч хамтран ажиллах цар хүрээ, түншлэлийн түвшин харилцан адилгүй байна.

Бодлого боловсруулах, үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд ИНБ-уудын гүйцэтгэх үүрэг нь холбогдох төрийн албан тушаалтнуудын ойлголтоос ихээхэн хамаарч байна. ИНБ нь салбарын тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг Засгийн газар, олон улсын ИНБ болон бусад оролцогч талуудад илүү үр дүнтэй хүргэхийн тулд эвсэл, холбоо үүсгэн ажиллаж байна. Гэвч ИНБ-ын санхүүгийн тогтвортой байдал, байгууллагын чадавхид гарч буй ахиц дэвшил хязгаарлагдмал байна. Хүний эрхийн асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд дотооддоо болон олон улсад тэр дундаа Ази, Номхон далайн орнууд, Хойд Америк, баруун Европын орнуудтай нягт уялдаа холбоотой ажилладаг. Монголын иргэний нийгмийн манлайлагч байгууллагууд бүс нутгийн төдийгүй олон улсын түвшинд хувь нэмрээ оруулж байна. Монгол Улсад сүүлийн хорин жилийн хугацаанд ИНБ-ууд өөр өөр гарал үүсэл, итгэл үнэмшилтэй нийгмийн бүлгүүд болон иргэдийн хүсэл сонирхол, үзэл бодлыг төлөөлсөн «гуравдагч» хүчин болон хөгжиж байна. ИНБ-ууд нь улс орныг хөгжүүлэх үйл явцад оролцох ёстой нэн чухал түнш бөгөөд тэд туршлага хуримтлуулан мэргэшсээр байна.<sup>95</sup>

Төрийн бус байгууллага болон Иргэний нийгмийн бусад байгууллагын нийтлэг байдал, тэдгээрийн онцлог ялгааг

<sup>94</sup> Азийн Хөгжлийн Банк, Иргэний нийгмийн танилцуулга: Монгол Улс, 2019

<sup>95</sup> Азийн Хөгжлийн Банк, Иргэний нийгмийн танилцуулга: Монгол Улс, 2019



харгалзсан зохицуулалтгүй байдал нь “ТББ” нэрийн дор улс төр, шашны төдийгүй ашгийн төлөөх байгууллага, боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд хүртэлх өргөн хүрээг хамарсан байгууллагууд үйл ажиллагаа явуулж, хуулийг зөрчиж, хуулийн агуулгатай зөрчилдсөн хуулийн этгээд ТББ-д хамаарч, улмаар бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болгосон. Хуулийн этгээдийн бүртгэлийг Иргэний хуулийн агуулгатай нийцүүлэх, улмаар төрийн бус байгууллагын олон хэлбэрүүд нь хуулийн этгээдийн бүртгэлтэй зөрүүгүй байх, иргэний нийгмийн байгууллага гэх ойлголтод багтах сайн дурынханы үйл ажиллагаа, иргэний нийгмийн үүсэл санаачлагыг нийтэд тустай үйл ажиллагаа гэдгийг тодорхойлох, улмаар энэ үйл ажиллагааг дэмжих зохицуулалтыг ТББ-ын тухай хуульд тусгайлан зохицуулах шаардлагатай байна.<sup>96</sup>

Төрийн бус байгууллагын тухай хуульд төрийн бус байгууллагыг нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага гэж зорилгоор хамааруулан ангилдаг бөгөөд үйл ажиллагааных нь чиглэлээр нарийвчлан ангилсан статистик одоогоор байхгүй байна. Сүүлийн хорин жилд төрөл бүрийн салбар, чиглэлийн ИНБ-ууд олноор үүсч байгаа хэдий ч хууль эрх зүйн орчин ИНБ-ын хөгжлийн өнөөгийн хэрэгцээг хангахгүй байна.<sup>97</sup>

<sup>96</sup> Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын гандан судалгаа, ХЗДХЯ, ШХА, Баасанжав Консалтинг, Иргэдийн оролцоо II төсөл, 2017

<sup>97</sup> Азийн Хөгжлийн Банк, Иргэний нийгмийн танилцуулга: Монгол Улс, 2019


## Хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг тодорхойлдог Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзүүлэлтээр Монгол Улс 2018 онд 180 орноос 71-р байранд жагсаж байсан бол 2019 онд 70-р байранд жагсаж өмнөх оноос нэг байраар урагшилжээ. Харин хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөв байдлын тухайд, улс төрийн эрх 40 онооноос 36, иргэний эрх 60 онооноос 49 оноо авч, нийт 100 онооноос 84 оноо авснаар Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөв байдал “эрх чөлөөтэй” гэж үнэлэгджээ. Монголын хэвлэлийн хүрээлэнгийн “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр-2019” судалгааны тайланг хэлэлцүүлэхдээ “Томоохон мэдээллийн байгууллагуудын 70-аас дээш хувийг улс төрийн өндөр албан тушаалтан эзэмшиж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд нийт хэвлэл мэдээддийн хэрэгслийн 11 хувь нь төрийн мэдлийнх бөгөөд үүнд тухайлсан салбарын болон мэргэжлийн сонин, сэтгүүл багтаж байна.” гэж мэдэгдсэн байна. Харилцаа холбооны тухай хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд тус хуулийн 4.1-т заасан УИХ харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлно гэсэн заалтыг хүчингүй болгож, 5.1-т засгийн газар төрөөс баримтлах бодлогыг батлах, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах эрхтэй болсон.

Гэсэн хэдий ч хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагуудад мэдээллийг өргөн түгээх явдлыг үүрэг болгож ногдуулах биш харин бие даасан олон төрлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Төрийн нууцад хамаарах мэдээлэл 2017-2019 онд 565 болж нэмэгджээ. 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийг баталсан бөгөөд үүгээр Төрийн болон албаны нууцыг Засгийн газар жагсаалтаар батлах боломж бүрдсэн юм. Энэ нь хэвлэл мэдээлэл болон иргэдийн мэдээлэл авах эрхийг зөрчиж болзошгүй үйлдэл гэдгийг эрхзүйн салбарын зарим мэргэжилтнүүд онцолж байв.

Төрийн байгууллагуудын цахим хуудсаас иргэд шаардлагатай мэдээллээ олж авахад бэрхшээлтэй хэвээр



**Томоохон мэдээллийн байгууллагуудын 70-аас дээш хувийг улс төрийн өндөр албан тушаалтан эзэмшиж байна.**

байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрт тохиромжит хэрэгслээр мэдээлэл авах боломжийг хөгжүүлэх хэрэгтэй байна.

## Дэд хэсгийн дүгнэлт

Хүүхдийн эрхийг ханган ажиллахад улс орны онцлогтой холбоотой олон бэрхшээл тулгарч байна. Үүнд:

- Монгол Улс тогтмол эдийн засгийн өсөлттэй байгаа ч коронавирусын цар тахал болон Засгийн газрын өртэй холбоотой эдийн засгийн бодлого журам одоог хүртэл батлагдаагүй байгаа нь энэ оноос эхлэн хүүхдийн суурь хэрэгцээ багасах, хүүхдэд зориулагдсан төсвийг танах эрсдэл учирч болзошгүй байна.
- Ядуурлын түвшин хөдөө орон нутагт буурч байгаа хэдий ч хүн амынх нь гуравны нэг нь амьдарч буй Улаанбаатар хотод өсч байгаа нь хүүхдүүдэд чанартай төрийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулж, сургуульд хамрагдах, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхүүдийг хязгаарлаж, орчны бохирдол, тэгш бус байдал зэргийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй.
- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, шилжих хөдөлгөөнийг эсрэг чиглэлд өөрчлөх бодит хэрэгцээ байгаа бөгөөд орон нутгийн шийдвэр гаргах эрх мэдлийг өсгөх, хүний эрхийг дэмждэг засаглалыг бэхжүүлэх, болон хот, суурины зах зээлд холбох дэд бүтцийг барьж байгуулах, их дээд сургууль, эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитойгоор сайжруулах, иргэдэд бизнес эрхлэх боломжийг дээшлүүлэх, түүхий эдийг орон нутагт нь боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэмжин орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх, орон нутгийн давуу талд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.
- Эрс тэс уур амьсгал, цөлжилт, бэлчээрийн зохисгүй хэрэглээ, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа зэргээс үүдэлтэй байгалийн тэнцвэр алдагдах, энэ нь малчин ардын аж ахуй болон нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлөх бөгөөд энэ нь хүн амын Улаанбаатар хот руу шилжин ирэх хөдөлгөөнийг нэмэгдүүлж, нийгмийн зарим үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөхөд хүрч байна.
- Улс төр болон боловсролын салбарт жендэрийн ялгаатай байдал өндөр байгаагаас хамааралтайгаар эмэгтэйчүүдийн улс төрийн түвшинд оролцох оролцоо сул, авлигыг нэмэгдүүлж, эрх зүйт төрийн системийг сулруулж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж байгаа нь хүүхэд рүү чиглэсэн урт хугацааны бодлогын хэрэгжилтэнд сөрөг нөлөөлж байна.
- Хүний эрхийг хэрэгжүүлэх төрийн үйл ажиллагаанд хяналт тавих хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудын хараат бус үйл ажиллагааг дэмжих нь сайн засаглалын суурь элемент гэдгийг мартаж болохгүй.





  
Save the  
Children

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

# 3.НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

3А

## САЛБАР ДАМНАСАН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАРЧИМ, ТОГТОЛЦОО

### ХЭРЭГЖИЛТИЙН ЕРӨНХИЙ АРГА ХЭМЖЭЭ

#### Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хууль ТОГТООМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны үнэлгээний тайланд дараах хүүхдийн эрхтэй холбоотой гүйцэтгэлүүд тэмдэглэгдсэнээс онцлон дурдвал, Монгол Улсын хэмжээнд 2-5 насны СӨБ-ын 312,802 хүүхэд байгаагаас 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1,439 цэцэрлэгт 263,333 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 84.1 хувьд хүрсэн байна. 2019 онд барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 84 цэцэрлэг байна. 2.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгө оруулалтаар 275 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга гадны тусламжаар ашиглалтад оржээ. 2019 онд нийт Улсын хэмжээнд 3 ээлжээр хичээллэж байгаа байгаа сургуулиуд 2 ээлжид бүрэн шилжсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг боловсролд хамруулах нь зэрэг сургалтууд зохион байгуулагдсан байна. Стандарт хэмжил зүйн газрын даргын С/58 тоот тушаалаар “Монгол брайль бичгийн стандарт” MNS6800:2019 батлагдсан байна. ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS2019:6782



стандарт, ЕБС-д суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ ерөнхий шаардлага MNS2019:6781 батлагдаж, 29, 116 дугаар сургууль Дэлхийн банкны санхүүжилтээр 120 мянган ам долларын сургалтын хэрэглэгдэхүүний санхүүжилт хийгдсэн, 25, 55, 63, 70, 116 дугаар сургуулийн сургалтын орчныг сайжруулахад 30,000 ам долларын санхүүжилт хийгдсэн байна. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхийн төв болон салбар комиссыг байгуулан, үйл ажиллах зорилтын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд 21 аймаг, 9 дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс” байгуулагдан ажиллаж байна. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл” байгуулсан байна.

Үнэлгээний хугацаанд Монгол Улсад хүүхдийн эрхийг хангах чиглэлээр дараах бодлого, хөтөлбөрүүд хэрэгжсэн болон хэрэгжилт нь үргэлжилж байна.

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016
- Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016
- Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2016-2020, 2016
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2017
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017-2026), 2017
- “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021), 2010
- Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр (2016-2025 он), 2015
- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2018-2022), 2017
- Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
- Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025), 2016
- Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр (2019-2022), 2019 (15-34 нас)
- Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр, (2018-2023), 2018
- “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2020), 2017
- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2017-2025), 2017
- Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
- Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, (2017-2021), 2017
- “Осол, гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөр, (2018-2022), 2018
- “Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр, (2019-2023), 2019
- “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2015-2020), 2019
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2019-2024), 2019
- Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2024), 2016
- Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2011-2020), 2011 г.м.

**Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр** 2017-2021 оны хугацаанд хэрэгжиж буй ба хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах; хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх; хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлэх; нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах; тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулахад зорих ба эдгээрийг хэрэгжүүлэхдээ хүүхдийн оролцоог дэмжин, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахаар заасан байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, хот хөдөөгийн алслагдсан, ядуу болон бусад нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн хүүхдүүдэд эрүүл мэнд, боловсрол, хамгаалал болон нийгмийн бусад үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилтуудыг уг хөтөлбөрт тусгажээ.



**Хүснэгт 10.** Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд<sup>98</sup>

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин			
		Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
<b>Үр нөлөөний шалгуур үзүүлэлт</b>							
<b>Зорилго: Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.</b>							
Сэргийлэх боломжтой өвчлөлөөс шалтгаалсан хүүхдийн эндэгдэл	Нийт эндэгдлийн дотор эзлэх хувь	2016	16 (1625 тохиолдол)	2019	14	2021	13
Хүүхдийн өсөлтийн хоцрогдол	Түвшин	2013	10.1	2019	8	2021	7
Боловсролын хамран сургалтын цэвэр жин	СӨБ-ын хамран сургалт ЕБС-ийн хамран сургалт	2015/2016 Хич. жил	80.9 91.2	2019	84.0	2021	85.6 94.3
Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-Бага нас:18 болон 36 сар -Өсвөр үеийн-хэн: 11 болон 15 нас	2017	Шинээр тооцно.	2019	Тооцсон үзүүлэлтээс нэмэгдсэн байна.	2021	Тооцсон үзүүлэлтээс нэмэгдсэн байна.

98 Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин			
		Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн мэдээлэл Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд	тоо Хувь	2016	76 3.5	2019	76< 5.5	2021	76< 7.5
Хүүхдийн ядуурал	Ядуурлын шугам-аас доогуур орлоготой өрхөд амьдарч байгаа 0-17 насны хүүхдийн хувь	2016	28.9	2019	25	2021	20
5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлээс шалтгаалсан эндэгдэл	түвшин	2016	12.7 (207 тохиолдол)	2019	11	2020	10
Хүүхдэд ээлтэй байгууллага	-Хүүхдэд ээлтэй эмнэлгийн эзлэх хувь -Өсвөр үеийн-хэнд ээлтэй клиник	2016	75 (189 эмнэлэг) 28	2019	78 28<	2021	80
Боловсролын хувьд гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	хувь	2016	14.9 (6-14 насны хүүхдийн дунд); 6.3 (15-17 насны хүүхдийн дунд)	2019	13.0 5.8	2021	10 5
Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн хувь	хувь	2018	Шинээр тооцно	2019	Тооцсон үзүүлэлтээс нэмэгдсэн байна.	2021	Тооцсон үзүүлэлтээс нэмэгдсэн байна.

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин			
		Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Бага боловсролын төгсөлтийн бохир жин	хувь	2015/2016 хич. жил	95.8	2019	112	2021	123.9
Суурь боловсролын төгсөлтийн бохир жин	хувь	2015/2016 хич. жил	118.9	2019	128	2021	133.5
Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад хамрагдаж байгаа хүүхдийн эзлэх хувь	хувь	2015	74.4 (давхардсан тоогоор)	2019	78	2021	80
Хүүхдийн саналыг шийдвэртээ тусгасан нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн хувь	Хувь	2015	4.6	2019	8	2021	10
Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	-Хүүхдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	2015	86.7	2019	92	2021	95
Хүүхэд хамгааллын үйлчилгээнд төсвөөс олгож байгаа санхүүжилт	Улсын төсвөөс олгосон хөрөнгө (сая төгрөгөөр)	2016	12.8	2019	236.0	2021	300.0
Сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл	-сэтгэл зүйн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн эзлэх хувь -бие махбодийн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхэд	2013	40.3 27.8	2019	35.3 22.8	2021	30.3 17.8

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин			
		Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Орон байр гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	0-2 нас 3-5 нас 6-14 нас 5-17 нас	2016	32 78 38 15	2019	27 67 32 13.5	2021	24 60 29 11
Ариун цэврийн байгууламж гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	0-2 нас 3-5 нас 6-14 нас 15-17 нас	2016	77 76 13 12	2019	67 67 11.8 10.8	2021	58 57 10 9
Хүүхдэд ээлтэй нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь	хувь	2014	3.4	2019	4.1	2021	4.4

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2018-2022) нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх зорилготойгоор хэрэгжиж байна. Тус хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний алдагдсан чадварыг боломжит хэмжээнд хүртэл эргэн сэргээх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох, нийгмийн бүх орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралд нөлөөлөх аливаа асуудлаар тэдний оролцоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гамшгийн болзошгүй

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хангах чадвартай болгох зорилтуудтай. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2016-2025 онд хэрэгжүүлж байгаа бөгөөд 4.1.15-д хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх зорилтын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 сарын 15-ны өдрийн А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ыг боловсруулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх зааврыг боловсруулсан байна.



### **Эрүүл мэнд, хоол тэжээл, эрүүл ахуйн байгууламжийн талаарх хууль тогтоомж**

Үнэлгээнд хамаарах хугацаанд 2019 оны 5 сарын 30-нд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийг баталсан ба 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ. Суралцагчийн оюуны болон бие бялдрын өсөлт хөгжлийг дэмжих, хооллох зөв дадал төлөвшүүлэхэд чиглэсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлага, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулинд суралцагчийг тэгш хамруулах, эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хоол, хүнсээр хүртээмжтэй хангах, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог хангах, стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг зүй зохистой зохион байгуулах, орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх зэрэг заалтууд орсон.

### **Боловсролын талаарх хууль тогтоомж**

Үнэлгээнд хамаарах хугацаанд Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсан. Тус хуулийн 8.4-т ерөнхий боловсролын сургуулийн (цаашид ЕБС гэх) 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байх заалт тусгагдсан байна. БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газраас 2018 онд 21 баримт бичиг, 3 тушаал, 2019 онд 31 баримт бичиг үүнээс 4 нь стандарт мөн 3 тушаалыг баталжээ. Үүнд: ХБХ-ийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний жишиг шаардлага, үлгэрчилсэн загвар, хэрэглэх зөвлөмж А/155 2018.03.29, Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам А/239 2018.05.01, Сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөө А/398 2018.06.22, ЕБС-ийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого А476 2018.7.31, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам А612 2018.10.01, Нийслэлийн анги



дүүргэлт хэт өндөртэй хүүхдийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжээр хичээллэж буй ЕБС-ийг 2 ээлжид шилжүүлэх аргачилсан заавар А/323 2019.05.23, Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай “Иргэний ёс зүйн боловсрол сургалтын хөтөлбөр” А/390 2019.06.13 Монгол Улсын стандарт “ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин аюулгүй байдал ерөнхий шаардлага” MNS6781:2019 2019.10.16, Монгол Улсын стандарт “ЕБС-ийн сурагчдын сургуулийн орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага” MNS6782:2019 2019.10.16, Монгол Улсын стандарт “Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага Ерөнхий шаардлага” MNS6799:2019 2019.12.23, Монгол Улсын стандарт “Монгол брайль үсгийн тэмдэглэгээ” MNS6782:2019 2019.12.13 (133) тус тус батлагдав.

### **Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хууль тогтоомж**

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу 6 дүрэм, журам, стандарт батлагдахаас 5 батлагдаж, 1 батлагдаагүй; Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу 6 журам батлагдахаас 4 батлагдаж, 2 батлагдаагүй; Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу нийт 33 стандарт, журам тусгагдсанаас 22 батлагдаж, 11 нь батлагдаагүй байна. Тухайлбал<sup>99</sup>, Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу дараах журмууд батлагдаад байна. Үүнд: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам; Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам; Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын

<sup>99</sup> Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхтэй холбоотой хууль эрхзүйн баримт бичиг эмхэтгэл, УИХ, ХНХЯ, 2019



бодлого; Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг; Эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж зэрэг болно. Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу дараах журмууд батлагдаад байна. Үүнд: Хүүхдийн элчийг сонгох журам; Монголын нийгмийн ажилтын мэргэжлийн ёсзүйн дүрэм; Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам; Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журам батлагдан хэрэгжиж байгаа бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам; Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам; Хохирогчид үйлчилгээ үзүүлэх Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам; Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам; Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам; Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам; Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам; Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх журам; Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам; Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журам; Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам; Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам; Хохирогчид эмнэлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам; Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам; Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлэгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам; Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл, хөтөлж мэдээллийн сан бүрдүүлэх журам; Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам; Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам; Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрхзүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх журам; Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам; Аюулын зэргийн үнэлгээ хийх журам; Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам тус тус хэрэгжиж байна.



**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааны зорилго нь 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих юм. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхийн төв болон салбар комиссыг байгуулан, үйл ажиллах зорилтын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд 21 аймаг, 9 дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс” ажиллаж байна. Мөн сургуулиудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих баг” байгуулсан байна. Үнэлгээний хугацаанд хамаарах тус комиссын тайлан олдоогүй бөгөөд цаашид салбар комиссын чадавхыг бэхжүүлэх, иргэдийн мэдээлэл авах эрхийг дэмжсэн үйл ажиллагааг нь жигдрүүлэх хэрэгцээ шаардлага байна.



### Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байр

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөж болзошгүй хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалан байрлуулах, эсхүл эмнэлгийн тусламж, сэтгэл зүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, эрх зүйн тусалцаа, холбон зуучлах үйлчилгээг нэг цэгээс үзүүлэхээр хуульчилжээ. 2019 оны байдлаар улсын хэмжээнд түр хамгаалах байр 14, нэг цэгийн үйлчилгээний төв 15 тус тус ажиллаж байна. Үүнээс төрийн харьяаны 13 түр хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв, төрийн бус байгууллагын харьяаны түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв тус бүр 1 байна<sup>100</sup>.

**Хүснэгт 11.** Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн статистик мэдээлэл. (2018, 2019 он)<sup>101</sup>

Д/д		Иргэн		Үүнээс малчин	
		2018 он	2019 он	2018 он	2019 он
1	Түр хамгаалах байр	529	596	23	45
2	Нэг цэгийн үйлчилгээний төв	1210	1821	6	6

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйлчилгээ үзүүлэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байрыг 2017 онд байгуулж, тухайн жилд 0-18 хүртэлх насны 285 хүүхдэд, 2018 онд 945 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн байна. 2019 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 2,020 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ<sup>102</sup>.

100 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 29 дэх тал.

101 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 30 дах тал.

102 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104 дэх тал.



### Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т зааснаар “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг ойлгодог. Тус хуулийн 15 дугаар зүйлд заасанчлан Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох



**Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 1356 (7.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд байсан.**

сургалт, хөтөлбөрт хамруулах, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй юм. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу аймаг, дүүрэгт хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2017 онд байгуулагдан ажиллаж байна. Уг хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилласны үр дүнд хороогоор үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2017 онд 618, 2018 онд 902 болж өссөн үзүүлэлттэй байна. Тус хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтын гарын авлага номыг боловсруулан, 2019 онд хорооны төрийн албаны 270 гишүүдийг сургалтад хамруулсан байна. Энэ нь нийт гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас хохирсон зэрэг Хүүхдийн эрхийн хорооны үйл ажиллагаа шаардлагатай хүүхдийн тоотой харьцуулахад маш бага үзүүлэлт тул Хүүхдийн эрхийн хорооны хүртээмж муу, зорилтот хүүхэд бүрт хүрч ажиллаж чадахгүй байгаа харуулж байна. 2019 онд гэмт хэргийн улмаас хохирсон 18 хүртэлх насны 1598 хүүхэд байна. Өмнөх онд гэмт хэргийн улмаас хохирсон 18 хүртэлх насны хүүхдийн тоо 1688 байсан. Харин хүүхэд оролцсон хэрэг 1068 болж, өмнөх оноос 327 (44.1%)-оор өссөн байна. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид 2019 онд 17.1 мянга болж, өмнөх оноос 721 (4.4%)-ээр өссөн байна. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 1356 (7.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд байсан. Энэхүү тоо баримтаас харвал гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон зэрэг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа шаардлагатай 3000 орчим хүүхдийн тэн хагаст ч Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа хүрч ажиллаж чаддаггүйг харуулж байна. Тиймээс цаашид Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сурталчилах, зорилтот хүүхдүүдэд заавал санал болгох, хүүхдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## Хамтарсан баг

2018 онд Монгол Улсын хэмжээнд 609 хамтарсан багийн 4634 гишүүнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан ба хамтарсан багууд гэр бүлийн хүчирхийлэлтэй 1,298 гэр бүлтэй ажиллаж, 945 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн нь эрсдэлт нөхцөлд амьдарч буй нийт хүүхдийн 4.5% байсан байна.<sup>103</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу хамтарсан багууд улс даяар байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч практик дээр үр дүнтэй ажиллахад бодлогын, санхүүгийн, хүний нөөцийн тогтвортой байдлын, үйл ажиллагааны хүрээнд асуудал бэрхшээл тулгарсаар байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудын дагуу хамтарсан багийн гишүүд нь өөрсдийн үндсэн чиг үүргээс гадна гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, мөн бусад хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа нь ачааллыг нэмэгдүүлж хүүхдийн эрхийг хангах үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.<sup>104</sup> Түүнчлэн, анхан шатны нэгжид ажиллаж байгаа хамтарсан багуудын ажиллаж чадахгүй байгаа, мухардалд орсон кейсийг аймаг/дүүргийн түвшинд шилжүүлэх дүрэм, журмыг тодорхой болгох; хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, урамшууллын механизмыг тодорхой болгох; нууцлалын гэрээний загварыг боловсруулах; хамгааллын үйлчилгээний жагсаалт, стандартыг бий болгох; хамтарсан баг хооронд харилцан туршлага солилцох механизмыг бүрдүүлэх; хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах механизмыг бий болгох зэрэг олон асуудлыг нарийвчлан тодорхойлох, журамлах шаардлага тулгарч байна.<sup>105</sup> Үүнээс гадна, бодлогын, орон нутгийн мөн хамтарсан багийн түвшинд тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн олон санал зөвлөмжийг “Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөгөөн болон

103 С.Мөнгөнчимэг, “Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөгөөн, 2018, Нээлтийн үг

104 Мөн тэнд; Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв, “Хамтарсан багийн өнөөгийн байдал, ололт, амжилт, тулгамдсан асуудал” судалгаа, 2018, 78-86 дахь тал

105 Мөн тэнд; ХНХЯ, ГБХЗХГ, ЖАЙКА, ХИС, “Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөгөөн, 2018



“Хамтарсан багийн өнөөгийн байдал, ололт, амжилт, тулгамдсан асуудал” судалгаагаар тогтоосныг хамтран ажил хэрэг болгох нь чухал байна. Хамтарсан багийн гишүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал хурцаар хөндөгдөж байна. Тухайлбал, хамтарсан багийг чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулагдсанаас хойш нийт гишүүдийн 19,1%, нийслэлийн хэмжээнд 50% нь өөрчлөгдсөн.<sup>106</sup> Үндсэндээ хамтарсан багийн гишүүдийг цаашид чадавхжуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн арга хэмжээ авах, сайн туршлагыг нэвтрүүлэх, ялангуяа урьдчилан сэргийлэх, кейс илрүүлэх, кейс менежментийн үйлчилгээг сайжруулах нь цаг үеийн шаардлага болжээ.<sup>107</sup>

Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, холбогдох дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр 2019 онд нийт 18 үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг 181,890 хүүхдэд, хариу үйлчилгээг

106 Мөн тэнд; П.Мягмаржав, НХГБХГ-ын Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтсийн үйл ажиллагааны танилцуулга, 2018

107 Мөн тэнд

9,662 хүүхдэд үзүүлсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйлчилгээ үзүүлэх хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байрыг 2017 онд байгуулж, тухайн жилд 0-18 хүртэлх насны 285 хүүхдэд, 2018 онд 945 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн байна. 2019 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 2,020 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ<sup>108</sup>

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүний санаачилгаар нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг шинээр нэвтрүүлж, 2019 оны 8 дугаар сараас ажиллуулж эхэлжээ. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, Дорноговь, Хэнтий аймагт 13,308 иргэн, 20,580 хүүхдэд хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээ үзүүлж, 43 хамтарсан багийн 276 мэргэжилтнийг ажлын байранд нь чадавхжуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн 111 цэгт эрсдэлийн үнэлгээ хийж, цахим хуудсаар дамжуулан 113,000 хүнд мэдээлэл хүргэжээ<sup>109</sup>. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг магадлан итгэмжлэгдсэн 19 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж 2019 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 586 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, түүнд шаардагдах 490 гаруй сая төгрөгийг хүүхдийн хөгжил, хамгааллын зардлаас олгосон байна. Тогтоолын энэ заалтын хүрээнд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрүүл мэндийн болон хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээний зардлыг төр бүрэн хариуцах талаар олон чухал алхмууд хийсэн боловч

108 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104-105 дах тал.

109 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104-105 дах тал.





хоширогчийг дэмжих сан байгуулсан эсэх нь тодорхойгүй байна<sup>110</sup>. 2019 онд ГБХЗХГ-аас хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг хөдөлгөөнт явуулын хэлбэрээр анх удаа зохион байгуулсан байна. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг автобустай, хөдөлгөөнт, явуулын хэлбэрээр газар дээр нь шуурхай үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг санаачилж, “Хөөрхөн зүрхнүүдийн аян” ТББ-тай гэрээлэн гүйцэтгэжээ. “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ” нь Олон нийтийг мэдлэгжүүлэх (I), Үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг ажлын байранд нь чадавхжуулах (II), Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах (III), Эрсдэлт орчинг илрүүлэх (IV) нийт 4 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулсан. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч болон сэтгүүлч, жолооч зэрэг 8 мэргэжилтэн, 20 гаруй сайн дурын ажилтан, 15 гаруй эксперт Улаанбаатар хотын 9 дүүрэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Хэнтий аймгийн

110 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 106 дах тал.

Чингис хот, Төв аймгийн Зуун мод, Баянчандмань сумууд зэрэг 3 аймагт автобустайгаа хүрч очиж, Монгол Улсын хэмжээнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевиз, сайт, албан ёсны цахим хуудсаар дамжуулан шууд бус байдлаар нийт 567,973 гаруй хүнд, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх мэдээллийг шууд буюу сургалт, сурталчилгааны аргаар нийт 95,673 хүн ам (19,125 гэр бүл, 76,548 хүүхэд), 9 дүүргийн 82 хамтарсан багийн 492 хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд, 186 цэгт хүрч ажилласан байна<sup>111</sup>.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийг аргазүйгээр дэмжих нь Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн стратегийн нэгэн зорилт юм. Хүүхэд хамгааллын тогтолцоог хамтарсан багийг чадавхжуулан бэхжүүлэхийг зорьж ажилладаг ХИС-гаас хамтарсан багийн чадавх бэхжүүлэхэд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд: Нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтуудыг үе шаттай, практикт суурилан зохион байгуулах, 2016, 2017 онуудад маягтууд шинэчлэгдсэнээс шинэ ба хуучин, дэлгэрэнгүй ба хураангуй маягтыг бөглөхөд хүндрэлтэй талууд нийтлэг ажиглагдсан тул энэ чиглэлээр сургалт явуулах, маягтуудыг тогтмол хэрэглэн, үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад хамтарсан багаараа хамтран ажиллах мөн энэхүү нөхцлийг бүрдүүлэхэд анхаарахыг зөвлөж байна. Мөн Хамтарсан багийн кейс илрүүлэлтийг сайжруулах чиглэлээр, хамтарсан багаас орон нутгийн онцлогт тохируулан хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, хүчирхийлэл, гэмт хэрэг, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах нь нэн чухал байгааг зөвлөж байна. Түүнчлэн, Үндэсний түвшний бодлогын хүрээнд, хамтарсан багийн гишүүдэд хамгаалал шаардлагатай хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээнүүдийг хэрхэн үр дүнтэй хүргэх талаар мэргэжлийн байгууллагуудаас арга зүйгээр хангаж ажиллахад анхаарах, хамтарсан багийн төсөв, санхүүжилтийг улсын төсөвт суулгах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт суулгасан

111 ГБХЗХГ-ын мэдээллийн сан- <http://www.fcy.gov.mn/news/124>

шилдэг туршлагыг баримтжуулах, түгээх шаардлагатай юм. Салбар дундын хамтын ажиллагаанд хүрээнд, кейс хуралдааныг зохион байгуулахтай холбоотой зөвлөмж боловсруулж, үйлчилгээнд нэвтрүүлэх, салбар дундын зохицуулалтыг сайжруулах үүднээс хамтарсан багийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг жил бүрийн эхэнд гаргаж яам, агентлаг, орон нутгийн түвшинд хамтарсан тушаалаар батлах, хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр чадавх бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг боловсронгуй болгоход чухал алхмууд болохыг зөвлөж байна.

### Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн төсөв, санхүүжилт

Улсын төсвийн гүйцэтгэл 2019 онд 9,091.9 тэрбум төгрөг байсан бөгөөд эрүүл мэндийн салбар нийт төсвийн гүйцэтгэлийн 9.1% байгаа бол боловсролын салбар 19.2 хувь байна. Боловсролын салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 3.8 бол эрүүл мэндийн салбарынх 1.8 хувь байна<sup>112</sup>. 2019 онд нийгмийн халамжийн сангийн 34.1 хувийг хүүхдэд мөнгөн тэтгэмж олгох буюу “Хүүхдийн мөнгө хөтөлбөр”-т хамрагдах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр 20,000 төгрөг олгосон<sup>113</sup>. 2019 онд 21,420 суудлын хүчин чадал бүхий 48 сургууль, 13,140 ор бүхий 93 цэцэрлэг баригдахаар төлөвлөгдсөн байснаас 48 сургууль буюу бүгд, 81 цэцэрлэг буюу 87 хувь нь баригдсан байна<sup>114</sup>. Улмаар “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2019 оны үнэлгээний тайланд Улсын хэмжээнд 3 ээлжээр хичээллэж байгаа байгаа сургуулиуд 2 ээлжид бүрэн шилжсэн хэмээн тайлагнасан байна<sup>115</sup>.

Хүүхдийн хөгжил хамгааллын тусгай зориулалтын шилжүүлэг 2019 онд 7822.9 сая, 2020 онд 10676.8 сая

112 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

113 2019 оны төсвийн гүйцэтгэл

114 Мөн тэнд,

115 “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2019 оны үнэлгээний тайланд



төгрөг байна.

**Хүснэгт 12.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв

Төсвийн ерөнхийлөн захирагч, дүн (сая төгрөгөөр)	2018	2019	2020
Эрүүл мэндийн сайд	766,306.1	839,948.9	964,554.8
Урсгал зардал	632,972.2	735,710.9	830,798.6
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,267,659.9	1,619,397.5	1,547,593.0
Урсгал зардал	1,201,772.2	1,585,502.1	1,522,136.1
БСШУСЯ сайд	1,632,349.00	1,863,563.9	2,173,161.9
Урсгал зардал	1,136,445.00	1,192,310.2	1,510,740.4

Эх сурвалж: Монгол Улсын 2018, 2019, 2020 оны Төсвийн тухай хууль

Гэсэн хэдий ч Эрүүл мэнд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын төсвийн багцад урсгал зардал дийлэнх хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. НҮБ-ын Хүүхдийн Сангийн тооцоолсноор Монгол Улсад Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын хуулиудыг бүрэн хэрэгжүүлэхэд 22, хамгийн багадаа 11 тэрбум төгрөг шаардлагатай тул хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна. Төсөв санхүүтэй холбоотой асуудлыг боломжтой асуудал бүрийн тухайд цаашид дэлгэрэнгүй авч үзэх болно.

## Ерөнхий зарчмууд

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод заасан хүүхдийн эрхийн үндсэн зарчмууд болох эсэн мэнд амьдрах, хөгжих, үл ялгаварлагдах, хүүхдийн дээд ашиг сонирхол, хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэн оролцох эрх зэргийг Хүүхдийн эрхийн, Хүүхэд хамгааллын, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Эрүүгийн, Зөрчлийн зэрэг шинээр найруулсан, шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт хуульчлан баталгаажуулсан. Гэсэн хэдий ч хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын, санхүүгийн, хүний нөөцийн, иргэдийн мэдлэг хандлагын хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй олон бэрхшээл тулгарч байгааг хүүхдийн төлөө байгууллагуудын хэсэгт авч үзсэн ба дараах хэсгүүдэд хүүхдийн эрхийн асуудал бүрийн тухайд дэлгэрэнгүй авч үзэх болно.

## Хүүхдийн тодорхойлолт

Хүүхдийн эрхийн тухай хуульд 18 нас хүрээгүй хүнийг хүүхэд гэж тодорхойлсон. Гэсэн хэдий ч хүүхэд 14-15 насандаа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд орж, 16-17 насандаа мэргэжил эзэмшиж, 18 нас хүрээгүй байхдаа ажил эрхлэх болж байгаа учраас хууль эрхзүйн орчинд хүүхдийн дээд эрхийг хамгаалах, шинэчлэх шаардлагатай байна гэж Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцын хэрэгжилтийн талаарх үндэсний тавдугаар тайланд дурдсан байдаг. Түүнчлэн Эрүүгийн хуульд "... хүчиндэх гэмт хэргийн улмаас арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон ..."; "...бэлгийн мөлжлөгийн улмаас арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон ..." гэж заасан нь 16-18 насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эрхзүйн хамгаалалт хангалтгүй болохыг харуулж байна.

## Дэд хэсгийн дүгнэлт

Хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн нөр их ажил хууль тогтоомж, бодлого, институцийн болон хэрэгжүүлэх түвшинд богино хугацаанд хийгдсэн/хийгдэж байна. Гэвч хууль тогтоомж, журамд заасан чиг үүргийг засаг захиргааны анхан шатны нэгж дээр хэрэгжүүлэхэд хэт ачаалалтай байх, хүний нөөц хангагдаагүй байх, санхүүжилт хангалтгүй байх, үнэлгээ, урамшуулал, ажил үүрэг, үйлчилгээний нэр төрөл тодорхойгүй эсхүл хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байх зэрэг олон асуудал хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог бий болгоход тулгарч байна.



## 3Б ХҮҮХДИЙН ЭРХИЙН ҮНДСЭН СЭДВҮҮД

### БОЛОВСРОЛ

Монгол Улс дахь хүүхдийн хөгжих, сурах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар юун түрүүнд тоон мэдээллийг ерөнхийлөн тоймлов. Энд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын салбар дахь хүүхдийн асуудлыг дэлгэрэнгүй авч үзэх болно.

**Хүснэгт 13.** 2018-2019 оны боловсролын салбарын статистик тойм

Үзүүлэлт	2018 оны байдлаар
Боловсролын хамран сургалтын цэвэр жин	96,3%
Бага боловсролын хамран сургалтын бохир жин	98,6%
Боловсролын хувьд гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	13,0% (6-14 насны хүүхдийн дунд); 5,8% (15-17 насны хүүхдийн дунд)
Хамран сургалтын бохир жин (Суурь буюу 1-9 дүгээр анги)	97,1%
Сургуульд орох албан ёсны насанд хүрэхээс нэг жилийн өмнө зохион байгуулалттай сургалтад хамрагдагсдын эзлэх хувь	64,6%
Боловсрол эзэмшээгүй, хөдөлмөр эрхлээгүй болон сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь	19,8%
Сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоо	682

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, БСШУЯ, Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүд, Боловсролын салбарын тайлан 2018





### 1 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ (ЦААШИД СӨБ ГЭХ)

- ▶ Цэцэрлэгийн тоо: 1439
  - Эдгээрээс 48% нь (685 сургууль) Улаанбаатарт
  - 62% нь төрийн өмчийн, 38% нь хувийн өмчийн цэцэрлэг байна.
- ▶ СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо: 263,333
  - Эдгээрээс 46% нь Улаанбаатарт
  - 51% нь эрэгтэй, 49% нь эмэгтэй байна.
- ▶ СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд: 1087 (2018 оны байдлаар)
  - Эдгээрээс 53% нь (576 хүүхэд) Улаанбаатарт
  - 39% нь (428 хүүхэд) эмэгтэй байна.
  - Эдгээр хүүхдүүд нь нийт суралцагчдын 0,4 хувийг эзэлж байна.



### 2 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ (ЦААШИД ЕБС ГЭХ)

- ▶ Бага, дунд, ахлах сургуулийн тоо: 820
  - Эдгээрээс 257 сургууль нь Улаанбаатарт
  - Төрийн өмчийн 656, хувийн өмчийн 147 ЕБС байна.



### 3 ТЕХНИК БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

- ▶ Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн тоо: 86
  - Төрийн өмчийн 51, хувийн өмчийн 35 МСҮТ байна.
- ▶ Нийт суралцагчдын тоо: 37,039
  - Эдгээрээс 61% нь эрэгтэй, 39% нь эмэгтэй байна.



### 4 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ

- ▶ Их, дээд сургуулийн тоо: 95
  - Төрийн өмчийн 21, хувийн өмчийн 71, гадаадын 3 сургууль байна.
- ▶ Нийт суралцагчдын тоо: 148,446
  - Эдгээрээс 39% нь эрэгтэй, 61% нь эмэгтэй байна.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж боловсролын зорилгыг тодорхойлжээ.<sup>116</sup> Боловсролын институтын байгууллага болох сургууль нь гагцхүү мэдлэгийг үнэлэх бус ёс суртахууныг төлөвшүүлэх үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх нь чухал.

116 <https://www.legalinfo.mn/law/details/9020>



## Сургуулийн өмнөх боловсрол

Бага, дунд боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын зорилгыг тодорхойлохдоо хүүхдийн авьяас чадвар болон насан туршийн ур чадварыг хөгжүүлэх орчныг бүрдүүлснээр тэдний оюун санаа, бие махбод болон хувь хүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм гэж тодорхойлжээ (World Bank (IBRD; IDA), 2016).<sup>117</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамын (цаашид БСШУСЯ гэх) мэдээлснээр Монгол Улсад 2018-2019 оны хичээлийн жилд нийт 1435 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, үүнд 261.4 мянган хүүхэд хамрагдаж байна (МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, 2019).<sup>118</sup> Цэцэрлэгүүд хүчин чадлынхаа аль болох дээд хэмжээнд хүрч ажиллаж байгаа ба даац хэтэрсэн цэцэрлэгүүд сугалаа явуулдаг.

1 дүгээр ангид элсэн ороход 6 настай байх болсон нь цэцэрлэгийн ачааллыг бууруулж буй гол хүчин зүйл болдог. Түүнчлэн ялангуяа хотын бус талбар дахь цэцэрлэг-сургуулийн аж байдлын байр суурийг орхигдуулж үл болно. ХНХСИ-аас хийсэн Малчдын судалгаанд сургуульд сурах насны доод хязгаарыг 6 насаар хязгаарлаж байгааг малчдын 48.5 хувь нь зөв, 51.5 хувь нь буруу гэж хариулсан бөгөөд ЕБС-д хүүхдийг 6 наснаас сургуульд хамруулж байгааг буруу гэж үзсэн ч эцэг эхчүүд хүүхдээ бусдаас хоцроохгүй, дутуу явуулахгүй гэсэн хандлага давамгайлдаг учир албан шахалтаар сургуульд хамруулж, үүнд нийцүүлэн гэр бүлийн амьдралыг зохицуулдаг гэжээ (Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, 2018).<sup>119</sup>

117 Дэлхийн Банк, "Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн," Улаанбаатар, 2016. 18 дэх нүүр.

118 МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, "Боловсрол, Шинжлэх Ухаан 2018: Монгол Улсын Боловсролын салбарын 2018 оны танилцуулга," Улаанбаатар, 2019. 14 дэх нүүр.

119 Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, "Малчдын аж байдлын судалгаа," Улаанбаатар, 2018. 63 дэх нүүр.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд хамгийн бага буюу 1087 байсан ба үүнээс 428 нь эмэгтэй хүүхдүүд байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд хамгийн их буюу 1597-д хүрсэн байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл 2018 онд СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 30.2 хувь нь 5 настай хүүхдүүд эзэлж байна (ҮСХ, 2019).

Хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэм-шихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэн оруулахад бэлтгэх сургалтын байгууллага юм.<sup>120</sup> 2018-2019 оны хичээлийн жилд 1-р ангид шинээр нийт 72.2 мянган хүүхэд элссэний 70.5 хувь нь СӨБ-д хамрагдсан байна (Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, 2019).<sup>121</sup> Сургуульд бэлтгэгдсэн байдлыг авч үзвэл 1-р ангид сурч байгаа хүүхдүүдээс өмнөх жил нь СӨБ-д хамрагдагсан хүүхдүүдийн өрхийн аж байдлын түвшин дундаж болон дээгүүр байна. Өөрөөр хэлбэл өрхийн аж байдлын доогуур түвшинтэй өрхийн хүүхдүүд СӨБ-д хамрагдалгүйгээр 1-р ангид элсэн орцгоох нь түгээмэл байна (ҮСХ, 2019).<sup>122</sup>

СӨБ нь суурь боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос социал шинжээрээ ялгаатай. Эдгээр нь нийгмийн бодлогын (ялангуяа боловсролын бодлогын)

<sup>120</sup> СӨБ-ын танилцуулга, <https://mecss.gov.mn/page/29/>

<sup>121</sup> Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, "Боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн товч танилцуулга," Улаанбаатар, 2019. 25 дахь нүүр.

<sup>122</sup> ҮСХ, "Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018," Улаанбаатар, 2019. 202 дэх нүүр.



**Өрхийн аж  
байдлын доогуур  
түвшинтэй өрхийн  
хүүхдүүд СӨБ-д  
хамрагдалгүйгээр  
1-р ангид элсэн  
орцгоох нь  
түгээмэл байна.**

хувьд гагцхүү боловсролын институтын шинжид хамаардаг бол харин зөвхөн СӨБ нь боловсролын болоод гэр бүлийн институтын дундын шинжид хамаардаг. Социологич Мишел Фуко "Сургуулийн тогтолцоо бол хүмүүжүүлэх хүч мөн" гэж үзсэн. Тэрбээр, эдүгээчлэгдсэн бидний амьдарч буй нийгэмд сахилга бат, эмх цэгц, дэг жаяг, дүрэм журам бол байх ёстой гэж үздэг, үүнийгээ ч орчин үед хүмүүс соёлжсон хөгжсөн гэж үзэж зүй ёсоор хүлээн зөвшөөрч бусдад тулган хүлээлгэдэг болсон гэжээ (Foucault, 2012).<sup>123</sup> Гэртээ байхдаа хүссэн цагтаа бие засдаг байсан хүүхэд сургуулийн орчинд ороод ав адилхан олон хүүхэд дунд хэм хэмжээнд орж, бие засахдаа дураараа биш харин багшаас зөвшөөрөл авч байх болдог. Ийм орчин солигдолтыг гэнэтээр биш харин дасгаж даван туулахын тулд ЕБС-д элсэхэд сургуулийн өмнөх боловсрол хэрэгтэй.

<sup>123</sup> M. Foucault, Discipline and Punish: The Birth of the Prison, Knopf Doubleday Publishing Group, 2012.



**“СӨБ-оор бэлтгэгдсэн” болон “гэрийн хүмүүжлээр өссөн” хүүхдүүдийн ялгааг сэтгэл зүйн талаас судалсан дорвитой судалгаа хийгдээгүй байна.**

Фукогийн онолоор, хүмүүжүүлэх хүч ба сахилга батжуулах институтын санаанаас үүдэж бие хүний нийгэмшлийн томоохон агент болох сургуульд элсэн ороход “СӨБ-оор бэлтгэгдсэн” болон “гэрийн хүмүүжлээр өссөн” хүүхдүүдийн ялгааг сэтгэл зүйн талаас судалсан дорвитой судалгаа хийгдээгүй байна. Дэлхийн Банкны “Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн” судалгааны тайланд СӨБ-д удаан хугацааны турш хамрагдсанаар илүү сайн үр дүн гардаг болох нь нотлогдож, үүний тоо үзүүлэлтийг магадлан харвал тоо тоолол, унших ба бичихэд бэлтгэх, нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийн үзүүлэлтүүд нь сайн буюу өндөр байна (World Bank (IBRD; IDA), 2016).<sup>124</sup> Гэхдээ зөвхөн СӨБ-д бэлтгэгдсэнээр сургуульд амжилт гаргах нь хамаарахгүй ба харин ар гэрийн нөхцөл байдал, нийгэм-эдийн засаг, угсаатны байр сууриас нөхцөлддөг. ЕБС-д элсэн орох нь хүүхдийн хувьд маш том орчны солигдолт мөн.

## Ерөнхий боловсрол

Ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд хамгийн бага буюу 6518 байсан ба үүнээс 2948 нь эмэгтэй хүүхдүүд байсан бол 2013-2014 оны хичээлийн жилд хамгийн их буюу 11.2 мянгад хүрсэн байна. 2018 онд ЕБС-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 47.7 хувь нь Улаанбаатар хотод, 7.8 хувь нь Хөвсгөл аймагт суралцаж байна (ҮСХ, 2019).

Сургуульд хамрагдаагүй хүүхдийн хувьд 2018-2019 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдүүдийн 5.5 хувь буюу 15.3 мянган

<sup>124</sup> Дэлхийн Банк, “Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн,” Улаанбаатар, 2016. 60 дахь нүүр.



**Бага ангид элсэхийн өмнө хүүхэд СӨБ-ын байгууллагад хамрагдсанаар наад захын биеэ авч явах, хувцсаа өмсөх тайлах, жагсах, суух, үзэг барих, дэвтэр номоо эмхлэх, багштай харилцах зэрэг чадвартай болсон байдаг. Нээлттэй нийгэмшсэн, хийсвэр сэтгэлгээ хөгжсөн байдаг. (ЕБС-ийн 1-р ангийн багш)**

хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдүүдийн 7.4 хувь буюу 13.8 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд хамрагдаж чадаагүй хүүхдүүд сургалтын чанарыг хүртэж чадахгүйтэй адил хэдийгээр сургуульд хамрагдсан ч сургалтын чанарыг хүртэж чадахгүй байх асуудал гардаг. Энэ утгаараа сургалтын хөгжлийг дэмжихийн тулд БСШУЯ Сайдын болон Засгийн газрын тушаалаар сургуулийн орчинд гар утас хэрэглэхийг хориглох шийдвэрийг сургуулийн захиргаанд хүргүүлдэг. Зөвхөн хүүхдүүд гар утас ашиглахгүйгээс гадна багш нарын ч гар утасны хэрэглээ хязгаарладаг.<sup>125</sup>

Бүх төрийн өмчит сургуульд “Ухаалаг гар утас ашиглах журам”-ыг баримталдаг. Сургууль,

<sup>125</sup> Монгол Улсын БСШУСЯ-ын Сайдын тушаал, 2018 <http://sbd.edu.mn/Data/uploads/docs/juram%20yam20180928-a-608.pdf>

цэцэрлэгийн орчинд хичээл, сургалтын үеэр сурагч, хүүхдүүдэд ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглахыг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хязгаарласан Засгийн газрын тогтоол батлагдсан.<sup>126</sup> Хичээл, сургалтын цагаар гар утсыг хязгаарласнаар суралцагч цагийг зөвхөн сурч боловсрохдоо зарцуулж, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй шалтгаануудыг бууруулж, бүх шатны сургалтын чанарыг сайжруулах боломж бүрджээ.

Ерөнхий боловсролын сурах бичгийн агуулгыг хянах нь иргэний эрхийн хэрэгжилтийн гол зүйл болно. Иймд ЕБС-ийн бүх сурах бичгийг хүний эрхийн боловсролд суурилсан болгохын тулд хөндлөнгийн шинжээчдийн баг үүсгэж түүгээр хянан оруулдаг болох системийг бүрдүүлэх шаардлагатай. Хүчирхийллийн бус, жендэрийн тэгш байдал, хайр болон хүн байх тухай чухалчлагдсан агуулгыг сурах бичигт тусгах нь зүйн хэрэг. Сурах бичгийг боловсруулахад хүний эрхийн суурь зарчим, ардчиллын үнэт зүйлст тулгуурлаж, хөгжлийн бодлого зорилттой уялдуулсан байдлаар ажиллах ёстой ба шинжлэх ухааны болон хүний эрхийн хөндлөнгийн шинжээчдийн баг ажиллуулах шаардлагатай байна.

Нийт ЕБС-ийн 18 хувийг эзэлж буй хувийн сургуулиуд боловсролын зах зээлийн ачааллыг хуваалцаж, өрсөлдөөнийг бий болгож буй боловч бүх хүүхдэд амьдралын гарааны тэгш боломжийг бий болгох учиртай боловсролын гол үүргийг эргэн харахыг сануулж, нийгэмд ялгаатай байдлыг үүсгэж байгаа талаар иргэний нийгмийн байгууллагууд тэмдэглэж байлаа.

<sup>126</sup> ЗГ-ын тогтоол, Сургалтын орчинд авах арга хэмжээний тухай, <https://www.legalinfo.mn/law/details/13638>



**Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд орлогын ядууралд өртсөөр байна.**

Монгол Улсын Үндэсний Сайн Дурын Илтгэл- 2019-д улсын болон хувийн сургуулиудын боловсролын чанар нь ялгаатай байна гэжээ (Монгол Улсын Засгийн Газар, 2019).<sup>127</sup> Ядуурлын дүр төрх судалгааны тайланд амьжиргаа сайтай өрхийн хүүхдүүд бага наснаасаа хувийн сургуульд илүү хамрагдах хандлагатай байна хэмээн дүгнэгджээ (Үндэсний Статистикийн Хороо, 2020).<sup>128</sup> Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзэхэд хүүхдүүд орлогын ядууралд өртсөөр байгаа бөгөөд нийт хүүхдийн 28.9 хувь нь ядуу өрхөд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүмүүсийн 46 хувийг бүрдүүлж байна.<sup>129</sup> Монгол Улсад хамгийн өндөр төлбөртэй хувийн ЕБС-ийн нэг жилийн сургалтын дээд төлбөр 100 сая төгрөг байна.

<sup>127</sup> Монгол Улсын Засгийн Газар, “Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл,” Улаанбаатар, 2019. 23 дахь нүүр.

<sup>128</sup> Үндэсний Статистикийн Хороо, “Ядуурлын дүр төрх 2018,” Дэлхийн Банк, Улаанбаатар, 2020. 39 дэх нүүр.

<sup>129</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



**Монгол Улсад боловсролын салбарын дундаж цалин 903,000 төгрөг байна.**

Өндөр төлбөр бүхий хувийн сургуулиудад төр хувьсах зардал олгож буюу төрийн бус өмчит сургуулиуд ашигтай ажиллахынхаа сацуу татаас авч байгаа нь татвар төлөгчдийн хөлсийг нийтэд хүртээлгүй зарцуулж буй хэрэг болж байна. Энэ асуудлыг 2014 оноос эхлэн улсын парламентэд хөндсөөр байгаа боловч дорвитой хэлэлцсэн удаагүй юм. Жил бүр төсвийн зардал нь орлогоосоо давж алдагдалтай ажилладаг Засгийн газар аль болох төсвийг танах бодлого баримталдаг ч өндөр төлбөртэй хувийн сургуулиудад татаас олгож, хувьсах зардал өгсөөр байгаа нь төсвийн алдагдалтай бодлогыг үүсгэх гол хүчин зүйл болсоор байна.

Монгол Улсад дундаж цалин 2019 оны 4-рулирлын байдлаар 1.124,000 төгрөг байгаа бол боловсролын салбарын дундаж цалин 903,000 төгрөг байна.<sup>130</sup> Боловсролын салбарынхан

<sup>130</sup> Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

улсын дундаж цалингаас доогуур дундаж цалинтай байгаа нь боловсролын салбарынхныг бодитой дэмжиж үл чадаж байгааг харуулж байна. Ажлын гүйцэтгэл болон цалин хөлсний хооронд уялдаа байх бөгөөд солилцооны онолоор цалин урамшуулал нэмэгдэх тусам ажил гүйцэтгэл сайжирдаг. Тиймээс сурагчдын боловсролыг чанаржуулахын тулд бусдад хөрөнгө оруулах шаардлага гардаг ба энэ тухай дэлгэрүүлэн Боловсролын санхүүжилт бүлэгт авч үзнэ.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрх

2018-2019 онд ерөнхий боловсролын сургуульд нийт 6.5 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаагаас 45 хувь нь охид, 55 хувь нь хөвгүүд байна (ҮСХ, 2019). Монгол Улсад 2008-2009 онд 23,969 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсан бол 10 жилийн дараа буюу 2018-2019 онд 6,518 болж буурчээ. Хүйсийн харьцааг авч үзвэл, 2008-2009 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 52 хувь нь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэй байсан бол 2018-2019 онд 45 хувь эмэгтэй болж, 55 хувь нь эрэгтэй болж өөрчлөгджээ.



**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2019 онд 107.1 мянга болж, нийт хүн амын 3.4 хувийг эзэлж байна.**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2019 онд 107.1 мянга болж, нийт хүн амын 3.4 хувийг эзэлж байна. Эдгээрийн 11,610 нь 0-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл, төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн эзлэх хувь олдмолоос илүү байна. 2019 байдлаар СӨБ-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийт 1076 байгаагаас 52% (555 хүүхэд) нь нийслэл хотод суралцдаг бол ЕБС-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийт 6053 байгаагаас 44% (2692 хүүхэд) нь нийслэл хотод байна.<sup>131</sup>

**Хүснэгт 14.** 2018-2019 оны СӨБ болон ЕБС-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

Хэлбэр	Хүүхдийн тоо	Үүнээс								
		Харааны	Ярианы	Сонголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Оюуны	Аугтэм	Дауны хам шинж	Хавсарсан
СӨБ	1,087	110	106	54	270	47	27	93	38	342
ЕБС	6,518	1,638	712	958	931	956	1,323			

Эх сурвалж: Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, 2019.

СӨБ-ын түвшинд ч, ЕБС-ийн түвшинд ч хөгжлийн бэрхшээлийн төрөл дундаас харааны бэрхшээлтэй хүүхэд хамгийн их байна (Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, 2019). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд суралцах хүсэл, эрмэлзэл байвч манай улсад эдгээр иргэд саадгүй чөлөөтэй зорчих гудамж талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, сургалтын материаллаг орчин хангалтгүй байгаа явдал нь тэдний суралцах эрхийг хязгаарлаж, нийгэмд боловсролгүй, “үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцлийг бүрдүүлсээр байна (Монгол Улсын Засгийн газар, 2017-2020).<sup>132</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 1-р ангид элсэж буй тооноос 12-р

<sup>131</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>132</sup> Монгол Улсын Засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр,” Улаанбаатар, 2017-2020. 7 дахь нүүр.



анги төгсөж буй тоо нь эрс бага байгаа (Хүүхдийг Ивээх Сан, 2018)<sup>133</sup> ба энэ нь ичиж зовох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцохоос айж эмээх гэх мэт шалтгаант холбоотой байгаа тул тоон мэдээллийг цаашид гүнзгийрүүлэн чанарын аргаар судлах бодит шаардлага тулгарч байна.

Стигматизац буюу шошго наах онолоор социал буюу хамтын амьдралд гажууд (хэвийн биш мэт) эсэх тухай эргэцүүлэл нь түүний шинж онцлогоор, бусад хүмүүс түүнийг хэрхэн үнэлж байна гэдгээр нөхцөлддөг (Smelser, 1988).<sup>134</sup> Үндсэн хуулийн хүрээнд хэнийг ч ялгаварлан гадуурхаж харилцаж болохгүй гэсэн төрийн зохицуулалт бас бий.

Сургуульд хамрагдалтын түвшин нь хүний биеийн сул тал, чадвар алдагдсанаасаа шалтгаалж харилцан адилгүй байдаг. ДЭМБ-ын дүгнэлтэд хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд оюун ухааны хомсдол эсвэл мэдрэмжийн сул талтай хүүхдүүдээс илүү сургуульд хамрагдах нь их байдаг гэжээ.<sup>135</sup> Иймд хөдөлгөөний бэрхшээлтэйгээс гадна оюун ухааны болон мэдрэмжийн сул талтай хүүхдүүдэд тусгай хэрэгцээ илүү шаардлагатай болж байна.

Сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжихээр сурах бичгийн шинэчлэл хийж, сургалтын хэрэглэгдэхүүний хувьд 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бага ангийн 4 нэр төрлийн сурах бичгийг шинэчлэн хэвлэжээ.<sup>136</sup> Үүнд:

1. Дүрслэх урлаг, технологи I-V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/
2. Математик IV /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/
3. Монгол хэл V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/

133 Хүүхдийг Ивээх Сан, "Хүүхдийн Эрхийн Нөхцөл Байдлын Үнэлгээ," Улаанбаатар, 2018. 97 дахь нүүр.

134 N. Smelser, Sociology, New Jersey: Prentice Hall, 1988.

135 ДЭМБ, Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан, 8 дэх нүүр. [https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO\\_NMH\\_VIP\\_11.01\\_mon.pdf;jsessionid=271CEC82724724B29DF51BF2AB46D2BD?sequence=61](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO_NMH_VIP_11.01_mon.pdf;jsessionid=271CEC82724724B29DF51BF2AB46D2BD?sequence=61)

136 Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа", Улаанбаатар, 2017. 37 дахь нүүр. [http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514\\_02.pdf](http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514_02.pdf)

#### 4. Монгол хэл V /Сонголын бэрхшээлтэй сурагчдын/ Харин сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих

Чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 26 насан туршийн боловсролын төв, 326 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 9291 хүүхэд суралцаж байгаагийн 18,5 хувь буюу 1716 нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Тэдний 30,9 хувь нь оюун ухааны бэрхшээлтэй, 4,5 хувь нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй суралцагчид байна. Тэдний 39,8 хувь буюу 683 нь бага боловсрол, 41,6 хувь буюу 714 суурь боловсрол, 18,6 хувь буюу 319 нь бүрэн дунд боловсрол эзэмших түвшний ангид суралцаж байна (Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, 2017).<sup>137</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс доогуур орлоготой, доогуур боловсролтой болдог гэсэн байгалийн примитив загвар нийгэмд үйлчлэх ёсгүй. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээл нь хүний сурч хөгжих гол саад болж болохгүй. Тиймээс ялангуяа эдгээр хүүхдэд тусгай хэрэгцээг л зориулах болохоос эдгээр хүүхдийг нийгмээс тусгай хүүхдүүд мэт хандах "шошго" байдлыг үгүйсгэх хэрэгтэй байна.

Үзэл бодлоо илэрхийлэх суурь нөхцөл бол хэл харилцаа байдаг тул, дохионы хэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний төрөлх хэл мөн ч өөрийгөө илэрхийлэх нэгэн арга юм, цаашлаад нийгэмтэй харилцахад, суралцахад, өөртөө тусламж авахад чанартай боловсролоор олж авсан бичгийн хэл мөн чухал юм.

137 Мөн тэнд, 38 дэх нүүр.

## Хэлний цөөнх хүүхдийн сурах эрх

### 7-14 насны хүүхдийн сурах суурь чадвар

Баян-Өлгий аймаг 2019 оны эцсийн байдлаар 103,870 хүн амтай ба 24,310 өрхтэй байна.<sup>138</sup> Эдгээрээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1,344 байна.<sup>139</sup> Энгийн эхийг уншиж ойлгох чадвар бол хүүхдийн сурч чадах хамгийн чухал үндсэн суурь чадваруудын нэг юм. Мөн бага ангидаа хүүхэд дөрвөн аргын тоонд суралцаж, сууриа сайтар тавих нь цаашдаа математикт амжилт гаргахад нь ихээхэн чухал байдаг байна (МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, 2019). Үндэстний цөөнх хүүхдүүдэд монгол хэл сурах сурах бичиг хангалтгүй түгээгддэг хэвээр байна. 2018 оны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны үр дүнд, 7-14 насны нийт хүүхдүүдийн 61.6 хувь нь унших суурь чадвар эзэмшсэн, 51.5 хувь нь тоо бодох суурь чадвар эзэмшсэн байна. Унших суурь чадвар баруун бүсэд 37.4 хувь, тоо бодох суурь чадвар Улаанбаатар хотод 43.9 хувь гарсан нь хамгийн бага байна. Баруун бүсэд унших суурь чадвар бага гарсан нь уг үзүүлэлт Баян-Өлгий аймагт 10.0 хувь гарснаас шалтгаалсан байна (Үндэсний Статистикийн Хороо, 2019). Үүнээс харахад хэлний цөөнхийн асуудлаас шалтгаалж цаашдын суралцах амжилт буурдаг байна.

Зөвхөн бусад үндэстний дунд буй Тува, Казах зэрэг үндэстнүүд нь хэлний цөөнх болдоггүй, Тува, Казах үндэстний хүүхдийн дунд байгаа бусад үндэстний хүүхдүүд ч бас хэлний цөөнх болж байдаг. Гадаадаас, хотын төвөөс болон бусад аймгуудаас Баян-Өлгийд шилжин амьдарч буй гэр бүл дэх хүүхдэд хэлний цөөнх болж буй асуудал тулгарах нь бий. Тиймээс хэлний цөөнхийн асуудал нь зөвхөн үндэстний цөөнхийн асуудал биш ба үндэстний олонхын ч асуудал болдог нь нөхцөл байдлаасаа шалтгаалж байна.

138 Баян-Өлгий аймаг засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, Хүн ам, өрхийн тоо 2019, <http://www.bayan-ulgii.nso.mn/>

139 Баян-Өлгий аймаг засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, Нийгмийн зарим үзүүлэлтүүд 2019



Баян-Өлгий аймаг нь Монгол Улсын хувьд газар нутгийн хувьд захын хийгээд соёлын өвөрмөц онцлогтой үндэстний ба хэлний цөөнх болдог хүн амтай аймаг юм. Тус аймгийн зарим боловсролын байгууллага төсвийг хууль бус зарцуулалсан нь Үндэсний Аудитын Газар-ын “Санхүүгийн тайлан”-д дурдагдсан байна. Тухайлбал, “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” журмыг зөрчиж дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормативыг хэтрүүлж, төсвөөс илүү зарцуулсан, нэгэн цэцэрлэг ажилтнуудын урамшуулалт цалингийн төсвөөс шүүхийн шийдвэрээр хоёр ажилтны ажилгүй байсан хугацааны цалинд төсөв олгож төсвийг зориулалт бус зарцуулснаас оны эцэст нэлээдгүй өртэй гарсан, үнэ бүхий үндсэн хөрөнгийн акталж данснаас хассан боловч устгалтын комисс томилоогүй, хөрөнгийг акталж устгасан талаар тушаал шийдвэр, нотлох баримтуудыг бүрдүүлж баримтжуулаагүй гэхчлэн баримтуудаас үзвэл<sup>140</sup> хууль бусаар зарцуулдаг санхүүг хуулийн хүрээнд оруулах цаашилбал төсөв батлахдаа санхүүгийн тодотголыг сайтар тооцож хийх шаардлагатай байна. Төсвийн хууль бус зарцуулалтыг хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийн хүрээнд зүй зохистойгоор зарцуулах хэрэгтэй.

140 Үндэсний Аудитын Газар, “Баян-Өлгий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан,” Өлгий хот, 2019.



Хэлний цөөнхийн асуудлаас шалтгаалж цаашдын суралцах амжилт буурдаг байна.

## Малчдын хүүхэд

2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-д малчдын 114.2 мянган хүүхэд суралцаж байна. Нийт малчин өрхийн хүүхдүүдийн 28.7 мянга (25.1 %) нь дотуур байранд амьдарч байна (Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, 2019).

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институтаас “Малчдын аж байдлын судалгаа”-г 2018 онд хийжээ. 8 аймаг 24 сум болон нийслэлийн мал аж ахуй эрхэлдэг өрхөөс авсан уг судалгаанд 1050 өрхийг буюу 4080 гишүүнийг хамруулжээ. Энэ нь дунджаар эцэг эх, хоёр хүүхэд гээд 4 ам бүлтэй амьдардаг байгаагаас хүүхдүүд болон өсвөр үеийнхний боловсролын үйлчилгээний хамрагдалтыг авч үзье (Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, 2018).

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 6-15 насны 425 хүүхдийн 98% нь сургуульд хамрагдсан бол 2% нь сургуульд хамрагдаагүй байна. Энэ үзүүлэлтийг байршлаар авч үзэхэд нийслэлээс судалгаанд хамрагдсан малчдын хүүхдүүд 100% дунд сургуульд хамрагдсан байгаа бол аймгийн болон сумын төвийн малчдын хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Өөрөөр бол хөдөөгийн малчдын 98% нь хүүхдээ сургуульд хамруулсан бол 2% нь сургуульд хамруулаагүй аж. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл бүгд эрэгтэй хүүхдүүд байна. 6-15 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 25% нь өвчний улмаас юмуу хөгжлийн бэрхшээлтэй учраас, 16.7% нь өрхийн аж ахуйд туслахаар, 16.7% нь өөрөө суралцах хүсэлгүй, 16.7% нь сургуульд орох насанд хүрээгүй (сар дутуу), 8.3% нь эцэг эх сургах хүсэлгүй, 8.3% нь санхүүгийн боломжгүй, 8.3% нь бусад шалтгаанаар сургуульд хамрагдаагүй байна.



## Боловсролын байгууллага дахь хүүхэд хамгаалал

Үнэлгээний хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого батлагдсан нь сайшаалтай. Түүнчлэн, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу Нийслэлийн Цагдаагийн Газар, Нийслэлийн Боловсролын Газар нарын хамтрах ажиллах төлөвлөгөөг үндэслээд “School Police” буюу Сургуулийн Эргүүл хийж байгаа нь үр дүнгээ үзүүлж байна. Сургуулийн ойр орчимд хөвгүүд зодолдох, гэмт хэрэгт холбогдох болон физик утгаар ямар нэг хүүхдийн эрх ашигт хор хөнөөлтэй үйлдлүүдийг хянаж чадаж байна. Цэцэрлэг болон ЕБС-иас хэрэв эцэг эхийн эргүүл гаргаагүй бол хариуцлагын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн School Police болон сургуулийн дотоод журмаар зохицуулагддаггүй нэгэн орчны аюулгүй байдлыг анхаарах зүйл бол ойр орчмын бизнес эрхлэлт юм. Сургуулийн ойр орчимд байрлалтай гоймон бэлэн хоолны үйлчилгээ, импортын чихэр чавга худалдаалах, ил гар дээр шошгогүй хүнсний зүйл зарах зэрэгт хүүхдийн эрүүл мэндийг анхаарч үйл ажиллагаанд нь хяналт тавих шаардлага тулгарсаар байна.

Суралцагчид бие махбодын дарамт, дээрэлхэлтээс гадна цахим орчин дахь кибер дарамт, нийтэд зарласан дүнгийн үнэлгээний дарамт, мөн стигма буюу бусдаар “шошголох” байдлаар тэгш бус харьцах байдалд өртөх болсон байна.





**Сургуулийн сургалтын үнэлэх тогтолцооны өөр нэгэн асуудал бол “улаан шугам”.**

Хүүхдийн сурлагыг үнэлэх үнэлгээ субъектив үнэлэмж дээр суурилах биш объектив ур чадвар дээр үндэслэгдэх чухал. Зөвхөн дүрмийн дагуу хатуурхан шалгуулж буйг үнэлэх биш ёс зүй гаргаж, багаар хамтарч чадаж буйг ч гэсэн үнэлэх чухал. Багшийн үнэлгээ нь анги хамт олны зүгээс тухайн хүүхдийг үнэлэх үнэлгээ болдог тул ямар дүн авсныг нь зөвхөн тухайн сурагч ба түүний эцэг эх мэддэг байхаар нууцлах нь ялгаварлан гадуурхагдах хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх бас нэгэн арга арга зам болно.

Сургуулийн сургалтын үнэлэх тогтолцооны өөр нэгэн асуудал бол “Улаан шугам”. Сурагчид 9-р анги төгсөхөд “Улаан шугам”-ын доогуур орсон бол нэг бол МСҮТ-д элсэх, ажил хийх эсвэл өөр ЕБС руу шилжих сонголт үлддэг. Энэ нь техник мэргэжлийн боловсролоос холдон хөндийрөх хандлагыг үүсгэжээ. Энэ хандлагын эсрэг төрөөс МСҮТ-ийг дэмжих зарим арга хэмжээг авч байна. Тухайлбал “Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг” зэрэгт тэтгэлэгт хамрагдах оюутнуудын тоонд заавал МСҮТ-өөс тодорхой оюутныг багтаасан байх бодлого барьдаг. Тэдэнд өндөр шаардлага тавилгүйгээр бусдаас бага үзүүлэлтийг шаардан (зөвхөн дүнгээрээ гэх мэт) тэнцүүлдэг. Энэ мэтчилэн төрөөс МСҮТ-ийг зарим талаараа их дээд сургуулиас ч илүү дэмжиж ажилладаг. 2020 оны төсвийн мэдээллээр Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагсдын тэтгэлгийг 2 дахин нэмж, сар бүр 200,000 төгрөг олгоно гэжээ (Сангийн Яам, 2020).<sup>141</sup> 9-р анги төгсөхөд муу дүнтэй буюу Улаан шугам-ын доор орвол МСҮТ рүү шилжүүлдэг механизм нь нийгэмд боловсролын ялгаварласан тэгш бус байдлыг өдөөсөн тогтолцоог бий болгожээ. Энэ нь МСҮТ-ийн нэр хүндийг унагаж, муу хүүхдүүд л ордог гэсэн стигма буюу шошгыг зүүх шалтгаан болжээ.

141 Сангийн Яам, “Иргэдийн Төсөв 2020: Монгол Улсын Нэгдсэн Төсвийн Төсөл,” Улаанбаатар, 2020. 36 дэх нүүр.



**Өвлийн морин уралдаанд хүүхдээр морь унуулахыг зогсооход сургууль, багш нарын үүрэг их бий.**

Сургууль нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанаас гадна мөн хүүхдийг хамгаалах функцтэй. Социологич Иван Иллич “Сургууль нь нэг ёсны асрамжлагч байгууллагын үүрэгтэй ба сургуульд заавал суралцах ёстой бөгөөд ингэснээр хүүхдүүд эрт наснаас эхлэн хөдөлмөрийн үйл ажиллагааны эхэн үе хүртэл “гудамжны нөлөөллөөс” (эсэн мэнд байдал алдагдахаас) хамгаалагдах болно” гэжээ (Illich, 1973).<sup>142</sup> Гэтэл Монгол Улсад уламжлал, соёл, ёс заншлын дагуу хүүхдээр хурдан морь унуулдаг нь сургуулиас завсардуулах, түүнчлэн тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлж буй хэрэг юм. 2019 оны 7-р сард буюу улсын их баяр наадмаар хурдан морины уралдаанд 9 насны 651 унаач хүүхэд оролцсон байна. Тэдний ердөө хагасыг нь буюу “Номин” “Миг” даатгалтай хамтран ажиллаж 300 гаруй хүүхдийг л даатгуулжээ. Уралдааны явцад нийт 9 насанд 36 хүүхэд мориноосоо унасан ба 15 хүүхэд хөнгөн гэмтэл авч, гэмтлийн зэргийг түргэн шуурхай тодорхойлон, уяач болон асран хамгаалагчид 35 хүүхдийг хүлээлгэн өгч, 1 хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчтай нь Гэмтэл согог судлалын үндэсний төв рүү хүргүүлжээ (Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, 2020).<sup>143</sup> Тиймээс ялангуяа хүйтний улирал хүүхдээр хурдан морь унуулахыг хориглож, эсэн мэнд байдлын сөрөг нөлөөллөөс хамгаалах бүхий сургуулиас завсардуулалгүй байх нь зүйтэй. Өвлийн морин уралдаанд хүүхдээр морь унуулахыг зогсооход сургууль, багш нарын үүрэг их байна.

COVID-19 вирусын гамшиг дэлхийд нүүрлэсэн тул олон улсын жишгийн дагуу 2020 оны эхний улирлаас Монгол Улс сургууль, үйлчилгээний байгууллагуудад хөл хорио тогтоосон билээ. Гэтэл гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн тоо 2020 оны 1-р улиралд 2019 оны 1-р улиралтай харьцуулахад 46.92% -иар өссөн байна.<sup>144</sup> Энэ нь сургууль бол боловсролын үйлчилгээний байгууллагаас гадна хамгаалах чиг үүрэгтэй гэдгийг улам нотолж байна.

142 I. Illich, Deschooling Society, Harmondsworth, 1973.

143 Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, “2019 оны үйл ажиллагааны тайлан,” Улаанбаатар, 2020. 16 дэх нүүр.

144 Protection Cluster Situation Report (16 April 2020)



## Боловсролын санхүүжилт

Монгол Улс 2000 онд боловсролын салбарын нийт зардалд 91.5 тэрбум төгрөг, 2010 онд 522.0 тэрбум төгрөг зарцуулж байсан буюу дараагийн 10 жилд санхүүжилт даруй 5.7 дахин өсөв. Боловсролын салбарт зарцуулж буй зардлын хэмжээ 2014 оноос хойш 1.0 их наяд төгрөгөөс давсаар 2018-2019 оны хичээлийн жилд 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна (Үндэсний Статистикийн Хороо, 2019). Төсвөөс олгосон санхүүжилтийг нарийвчлан авч үзвэл, 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 322.1 тэрбум төгрөгийг, ерөнхий боловсролд 651.0 тэрбум төгрөгийг, техникийн болон мэргэжлийн боловсролд 76.0 тэрбум төгрөгийг, дээд боловсролд 135.3 тэрбум төгрөг (дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй дотоодын оюутнуудад 99.9 тэрбум төгрөгийг, Монголд суралцаж буй гадаад оюутнуудад 0.9 тэрбум төгрөгийг, харин гадаадад суралцаж буй Монгол оюутнуудад 25.7 тэрбум төгрөг)-ийг тус тус зарцуулсан байна.<sup>145</sup>

“Боловсролын салбарын тойм судалгаа”-нд боловсролын санхүүжилтын бодлого нь тэгш байдлыг хангахад биш, тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлж байна гэж дүгнэжээ. Энэ нь нэгдүгээрт улсын төсвөөс 31 тусгай сургуулийг илүү хэмжээгээр санхүүжүүлж байгаагаар, хоёрдугаарт улсын төсвөөс хувийн сургуулиудын хувьсах зардлыг санхүүжүүлж байгаагаар тус тус холбоотой. Кембрижийн хөтөлбөрт багтсан 31 сургууль нь Ерөнхий боловсролын нийт сургуулиас илүү стандарттай (жишээлбэл хос хэл дээр хичээл явагдах, сургалтын хэрэглэгдэхүүн материал хангамжтай байх гэх мэт). Мөн эдгээр сургуулиудад багшилж байгаа багшийн цалин бусад сургуулийн багш нарын цалингаас 30 хувиар өндөр, хичээл сургалтын материал, лабораторийн сургалтын тоног төхөөрөмж илүү их хангамжтай байгаа нь нийт суралцагчдад ногдож буй дундаж зардлыг тэгш биш болгож байна. Өөрөөр хэлбэл, эдгээр 31 сургуульд илүү хэмжээгээр санхүүжилт зарцуулагдаж байгаа нь үлдсэн

<sup>145</sup> Үндэсний Статистикийн Хороо, “Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ,” Улаанбаатар, 2019. 20 дэх нүүр.



**ЭЕШ-ын  
оноогоор үзэхэд  
хөдөөгийн  
сурагчид хотын  
сурагчдаас  
доогуур  
оноотой байдаг.**

төрийн өмчийн нийт сургуулиудад ногдох санхүүжилтээс танаж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна (Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, 2013).<sup>146</sup> Кембриж хөтөлбөрт нийт суралцагчдын 2 орчим хувийг эзлэх бөгөөд илүү боломжид суурилсан эдгээр нь нэмэлт хөрөнгө оруулалт бус бусад 98 хувийг эзэлж буй хүүхдийн боломжоос танаж байна. Түүнчлэн ЭЕШ-ын оноогоор үзэхэд хөдөөгийн сурагчид хотын сурагчдаас доогуур оноотой байдаг ба энэ нь эдийн засгийн байдал, зардлын зарцуулалтыг хөдөөд нэмэгдүүлэхийг харуулж байна гэжээ.

Ослогийн тунхаглалын дагуу Монгол Улс боловсролын санхүүжилтэд улсын төсвийн 20-иос доошгүй хувийг зарцуулдаг. 2019 онд улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь 15.3% бөгөөд нэг хүнд ногдох боловсролын зардал 547 мянган төгрөг байна.<sup>147</sup> Энэ нь хөгжингүй орнуудтай харьцуулахад доогуур ч, хөгжиж буй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт байна. Жил ирэх бүр хүн ам өссөөр байгаа тул боловсролын салбарт тусгах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байх хэрэгцээ гарч байна.

### **Дэд хэсгийн дүгнэлт**

Эдийн засгийн нийгмийн давхаргын зөрүү нь хүүхдүүдийн боловсролыг тэгш бус байдалд хүргэж байна. Тиймээс СӨБ болон ЕБС-ийн боловсрол олгох институтууд нийтийн хүртээлд хүрэх ёстой болж харин хувийн цэцэрлэг, сургуульд өндөр төлбөртэй суралцдаг байдлыг Үндсэн хуулийн тэгш эрхийн хүрээнд хязгаарлах хэрэгтэй. Яагаад гэвэл эдийн засгийн капиталын ялгаатай байдал нь соёлын капиталын тэгш бус байдалд хүргэж байна. Тиймээс нийгмийн хуваарилалт болоод өмчийн асуудалд хянуур хандах шаардлага урган гарч байна. Өрхүүд амжиргааны түвшнээсээ хамааран хүүхдийнхээ боловсролд эрс ялгаатай хөрөнгө оруулалт хийж байна.

<sup>146</sup> Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, “Боловсролын салбарын тойм судалгаа,” Улаанбаатар, 2013. 20 дэх нүүр.

<sup>147</sup> YCX, Боловсролын салбарын зардал, 2019  
[http://1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_2002\\_055V1&A1\\_select\\_all=1&A1SingleSelect=&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2019\\_2018\\_2017\\_2016\\_2015\\_2014\\_2013\\_2012&viewtype=table](http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2002_055V1&A1_select_all=1&A1SingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012&viewtype=table)



Боловсролыг хүртээгчид буюу багш нар хувийн хэвшлийг илүүд үзэх хандлагатай байгаа бол боловсролыг хүртэгчид буюу хүүхдүүд, олон нийт (хүүхдүүдийн ар гэрийнхэн) төрийн хэвшлийг илүүд үзэх хандлага ажиглагдаж байна. Энэ нь санхүүгийн нөөц бололцоотой шууд холбоотойн улмаас ийн хандлага үүсч байгаа бөгөөд санхүү, мөнгө бололцоо нь хүүхдийн сурч хөгжих эрхийн хэвийн байдлыг алдагдуулж болохгүй юм. Ялангуяа цэцэрлэг болон их дээд сургууль нь хувийн өмчийнх байх нь хэвийн үзэгдэл ч ерөнхий боловсролыг ерөнхий биш ялгаатайгаар олгож болохгүй. Яагаад гэвэл хүний эрхтэй холбоотой олон улсын баримт бичгүүдэд дээд боловсролыг заавал эзэмшүүлэх албагүй ч ерөнхий боловсролыг хүн бүрт заавал эзэмшүүлбэл зохино гээд иймд ерөнхий боловсролыг төр үнэ төлбөргүй бүх хүнд олгоно гэсэн байдаг. Гэтэл маш өндөр төлбөртэй хувийн ЕБС-ууд нийгэмд өрхийн аж байдлын түвшнээс хамаарч боловсролын харилцан адилгүй байдлыг үүсгэсээр байна. Тиймээс баян, ядуугаас үл хамаараад хүүхэд бүрийн “сайн сайхан байдал”-д бодитой өөрчлөлт хэрэгтэй болж байна.

Боловсролын талаар статистик судалгаанаас гадна чанарын судалгааг хийх дутуу орон зайг судалгааны байгууллагууд, судлаачид нөхөх ажлууд хэрэгтэй ба энэ талаар тулгамдаж буй асуудлуудыг шийдтэй судлахад нь хөндлөнгөөс дэмжих тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй болжээ. Ингэснээр макро түвшин дэх боловсон хүчин, нийгмийн эрхийн хэрэгжилт зэргээс гадна микро түвшин дэх бие хүний нийгэмшил, нийгмийн харилцаа зэргийг цогцлоон тодорхойлоход жинтэй хувь нэмэр болох ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч хөгжих эрх нь тэдний цаашдын нийгэмд өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх сайн сайхан байдлыг бий болгоход туслах арга зам болдог. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зөвхөн нийгмийн тодорхой нэг хэсгийнхний л анхаарах ёстой үзэгдэл мэт хандах хандлага ажиглагдаж байна. Тэгснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боломжийг хуваарилаж буй мэдэлтнүүд үр ашиггүй үйл ажиллагаа явуулж байгаад хяналт тавих боломжгүй болж байгаа юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх нь олон нийтийн оролцоон дээр тулгуурлаж, олон талт хамтын ажиллагааны дэмжлэгийг шаардаж байна.

## ЭРҮҮЛ МЭНД

Үндэсний статистикийн хорооны “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018” оны үзүүлэлтэд тусгаснаар хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг, арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 5 хүртэлх, 5-9, 10-14, 15-19 насны бүлэг тус бүрд нэмэгдсэн байна. Тав хүртэлх насны 10,000 хүүхдэд ногдох өвчлөлд халдварт бус суулгалт 422.7, шүдний цооролт 305.0, шүд ба дайврын эмгэг 171.6 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна. Харин 5-9 насны хүүхдийн өвчлөлд тухайн насны 10,000 хүүхдэд шүдний цооролт өвчин 625.1, шүд ба дайврын эмгэгийн өвчин 622.4 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна<sup>148</sup>.

148 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”





## Эх хүүхдийн эрүүл мэнд ба эндэгдэл

2020 оны эхний 3 сарын байдлаар улсын хэмжээнд 18,663 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 311 хүүхдээр буюу 1.7 хувиар өсжээ. Төрөлтийн төвшин 1000 хүн амд 5.9 байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 889 нярай буюу 4.8 хувь нь 2500 граммаас доош жинтэй, 163 тохиолдол буюу 0.9 хувь нь төрөлхийн гажигтай төржээ. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 96.4 байна. Дутуу төрөлтийн төвшин 1000 амьд төрөлтөд 64.5 байна. Амьгүй төрөлтийн төвшин 1000 нийт төрөлтөд 5.4 байна. 2019 оныг бүтэн жилээр авч үзвэл 78,223 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 696 тохиолдлоор их байсан ба 0.8 хувиар нэмэгджээ. Нийт амьд төрсөн хүүхдийн 3415 нь буюу 4.3 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ.

**Хүснэгт 15.** Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт

Он	Амаржсан эхийн тоо	Амьд төрсөн хүүхэд	Амьгүй төрөлт	Эхийн эндэгдэл	Төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд	2500 граммаас бага жинтэй төрсөн хүүхэд
2017	73,884	74,328	451	20	433	3,437
2018	77,058	77,527	438	21	533	3,421
2019	77,734	78,223	405	21	620	3,415
2020 оны эхний 3 сар	18,830	18,663	101	11	163	889

## Жирэмсний хяналт ба төрөх үе<sup>149</sup>

Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 20,981 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 88.8 хувь нь эхний 3 сартайд, 10.3 хувь нь 4-6 сартайд, 0.9 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.6 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 3.7 хувь нь цус багадалттай нь илэрчээ. Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сарын байдлаар 18,530 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 295 төрөлтөөр буюу 1.6 хувиар өсжээ. Төрсөн

149 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

эхчүүдийн 13,839 нь буюу 74.7 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Мэс заслын аргаар төрсөн эхчүүд 26.5 хувийг эзэлж байгаа ба 33.1 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 66.9 хувь нь хүндрэлгүй төрсөн байна.

## Жирэмсний үеийн ургийн гажиг

Шинжлэх Ухаан Технологийн Санд бүртгэгдсэн Ш.Алтантуяагийн докторын диссертацийн ажил болох 2018 онд хийгдсэн “Жирэмсний эхний гурван сард ургийн зүрхний хүнд гажгийг илрүүлсэн судалгаа” нь 2015-2017 онд 19-44 насны, 110-136 долоо хоногтой 381 жирэмсэн эхчүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хийгдсэн. Судалгааны үр дүнгээр жирэмсний эхний гурван сарын төгсгөлд шилэн хүзүүний арын шингэний зузаан, венийн цорго болон гурван хавтаст хавхлаганы хэт авиан оношилгооны өнгөт Допплерын шинжилгээнд тулгуурлан зүрхний хүнд гажиг хөгжил 2.0%-д илэрсэн бөгөөд зүрхний хүнд гажиг хөгжил жирэмсний тээлтийн 20-24 долоо хоногтойд ургийн зүрхний хэт авиан шинжилгээгээр 7(87.5%), төрсний дараа зүрхний хэт авиан шинжилгээгээр 2(25%), эмгэг судлалын шинжилгээгээр 3(37.5%) онош тус тус батлагдсан байна (Ш.Алтантуяа, 2018).



## Жирэмсэн эхийн өвчлөл

**Тэмбүү** өвчнийг илрүүлэхээр 2019 онд жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 77,584 жирэмсэн эх хамрагдсанаас 1528 буюу 1.9 хувьд нь тэмбүү өвчин илэрчээ<sup>150</sup>. **Заг хүйтэн** илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 71839 нь хамрагдсан ба 305 буюу 0.4 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ<sup>151</sup>. **Трихомониаз** илрүүлэх шинжилгээнд 2019 онд жирэмсэн эмэгтэйчүүдийн 72,200 эмэгтэй хамрагдсанаас 1,300 буюу 1.8 хувьд нь илэрсэн байна<sup>152</sup>. **Сүрьеэ** өвчний шилжилгээнд 2018 онд жирэмсэн эхчүүдийн 50.9 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхтэй сүрьеэгийн 31 тохиолдол буюу 0.07 хувьд эерэг гарчээ.<sup>153</sup>

## Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж

2019 онд улсын хэмжээнд 77,601 эх амаржсан нь 2018 онтой харьцуулахад төрөлт 543 тохиолдлоор буюу 0.6 хувиар өссөн. 2019 оны жилийн эцсийн байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 25.9 хувийг эзэлж байгаа ба 31.4 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 68.6 хувь нь хүндрэлгүй төрсөн байна. 2019 оны нийт төрөлтийн 31.3 хувь нь Улаанбаатарын амаржих газруудад төрсөн бол аймгийн нэгдсэн эмнэлэг 27.5, ЭХЭМҮТ 16.5, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 12.6, сум, сум дундын эмнэлэг 4.8, дүүргийн нэгдсэн эмнэлэг 1.8, гэрийн төрөлт 0.3 хувийг эзэлж байна<sup>154</sup>. Нийт төрөлтийн дийлэнх хувь нь эмнэлгийн байгууллагад төрж байна. Гэвч 0.3 нь гэртээ төрж байгаа нь нялхсын эндэгдлийг үүсгэх аюултай.

150 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.12

151 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.12

152 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.12

153 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018

154 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.4



## Төрөлтийн давтамж

2018 онд төрсөн нийт эхчүүдийн 26.9 хувь нь анхны төрөлт, 50.8 хувь нь 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн байна. Нийт төрөлтийн 99.8 хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан байна. Насны хувьд 4.7 хувь нь 20 хүртэлх насны, 16.7 хувь нь 35-ээс дээш насны төрөлт эзэлж байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцон үзвэл 2018 онд нөхөн үржихүйн насны 1,000 эмэгтэй тутмын 92 нь хүүхэд төрүүлсэн байна<sup>155</sup>.

## Төрсний дараах асуудлууд

2018 онд хяналтад байж төрсөн эхчүүдийн 87.5 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхтэй хяналтад хамрагджээ мөн жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 65,064 тохиолдол бүртгэгдэж 1,000 амьд төрөлтөд 844 ногдож байна. 2018 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 49 тохиолдол бүртгэгджээ. Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 25.2 хувь, манас таталт 0.1 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 31.4 хувь, төрсний дараах хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 75.3 хувьтай тэргүүлж байна<sup>156</sup>.

155 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.40

156 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.43

## Эхийн эндэгдэл

2020 оны эхний 3 сарын байдлаар эхийн эндэгдэл 11 бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор их байна<sup>157</sup>. 2019 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 100,000 амьд төрөлтөд 23.0 байна. 2018 онтой харьцуулбал 3 тохиолдлоор буюу 100,000 амьд төрөлтөд 4.1-оор буурсан байна. Эхийн эндэгдэл Архангай, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд аймаг, ЭХЭМҮТ, Хүрээ амаржих газар, ШШҮХ-нд тус тус 1 тохиолдол, Өргөө амаржих газар, Хөвсгөл аймагт 2 тохиолдол, УГТЭ-т 5 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна<sup>158</sup>.

## Өсвөр насны охидын төрөлт

“Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” судалгаанд тусгаснаар улсын хэмжээнд 15-19 насны 1000 охид тутмын 40 нь төрдөг ба хот болон хөдөөгөөр авч үзвэл хотод 1000 охид тутмын 35 нь төрдөг бол хөдөө 1000 охид тутмын 70 нь төрдөг байна<sup>159</sup>.

## Нялхсын эрүүл мэнд

2018 онд нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 84.7, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 69.3 байна. Нярай хүүхдийн өвчлөлийн 25,874 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 33.3 хувийг эзэлж байна. Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор төрөхөд ураг бүтэх 5.6 хувь, нярайн шарлалт 52.2 хувийг эзэлжээ. Нэг хүртэлх насны хүүхдэд бүртгэгдсэн төрөлхийн гажгийн 3,868 тохиолдлоос зүрх, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг 26.4 хувь, шээс ялгаруулах тогтолцооны төрөлхийн гажиг 10.6 хувь, сэтэрхий уруул ба тагнай 9.8 хувь, хоол боловсруулах тогтолцооны төрөлхийн гажиг 4.4 хувь, түнхний төрөлхийн гажиг 6.0 хувьтай тэргүүлэх байрыг эзэлж байна<sup>160</sup>.

## Нялхсын эндэгдэл

Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 1041 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.3 ногдож 2018 онтой харьцуулахад 4 тохиолдлоор нэмэгдсэн хэдий ч 1,000 амьд төрөлтөд харьцуулахад 0.1-оор буурсан

157 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2020 оны эхний 3 сарын байдлаар” тал.3

158 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.3

159 Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018 инфографик”, тал.18

160 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”




үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 56.0 хувь нь эрэгтэй, 44.0 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 2018 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн 1,037 тохиолдол бүртгэгдэж, 1,000 амьд төрөлтөд 13.4 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 64.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1,000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.7 юм. Нярайн эндэгдлийн нийт 672 тохиолдол бүртгэгдсэний 486 буюу 72.3 хувь нь нярайн эрт үед /амьдралын эхний 0-6 хоногт/, 186 буюу 27.7 хувь нь нярайн хожуу үед /амьдралын эхний 7-28 хоногт/ эндсэн байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 58.0 хувь нь эрэгтэй, 42.0 хувь нь эмэгтэй хүүхэд байна<sup>161</sup>.

## Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

Эрүүл мэндийн яамны захиалгаар хийгдсэн “Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс 2019” судалгаанд тусгагдсанаар 2018 онд нялхсын эндэгдлийн 19.7%-ийг гэрийн буюу эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл эзэлж байгаа ба эдгээрийн 26.5%-ийг амьсгалын тогтолцооны өвчин, 24.5%-ийг осол гэмтэл эзэлжээ. Мөн төрөлхийн хөгжлийн гажгийн улмаас эндсэн нярайн 55.1% нь 37 ба түүнээс дээш долоо хоногтойдоо эндсэн байна<sup>162</sup>.

161 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2019 оны жилийн эцсийн байдлаар”, тал.7  
162 Ц.Амаржаргал “Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс 2019”

**Зураг 2.** 29 хоногтойгоос 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан 2018



Эх сурвалж: Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс 2019”

### Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 278 тохиолдол бүртгэгдэж, 1,000 амьд төрөлтөд 14.9 ногдож байгаань өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 2.4-оор буурсан байна. Нийт эндэгдлийн 87.7 хувь нь өвчнөөр, 12.3 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 40.4 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 14.1 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 16.2 хувь, 12.3 хувийг осол, гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлж байна<sup>163</sup>.

### Агаарын бохирдлын асуудал

2018 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлд хамгийн их буюу 20.2 хувийг хатгалгаа өвчин, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа 70.9 хувийг эзэлж байна. Мөн цочмог бронхит (acute bronchitis) ба цочмог бронхиолит (acute bronchiolitis) өвчин нь амьсгалын

<sup>163</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2020 оны эхний 3 сарын байдлаар”, тал.9



тогтолцооны өвчлөлийн 15.0 хувь, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 77.6 хувийг эзэлж байна<sup>164</sup>. 2018 онд 0-15 насны 326 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн байна.

Үндэсний статистикийн хорооны(ҮСХ) “Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд” 2019 оны тайланд тусгаснаар сүүлийн 10 жилийн байдлаар Улаанбаатар хотын 10000 хүүхдэд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчин өссөн бөгөөд 2018 оны байдлаар 1808 болж, 5 жилийн өмнөхөөс 1.4 дахин, 10 жилийн өмнөхөөс 1.9 дахин өссөн байна. 10000 хүүхдэд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчин 2018 онд хамгийн их буюу 1808, хамгийн бага нь 2009 онд 692 байна<sup>165</sup>. Харин нас баралтын хувьд сүүлийн 10 жилээр авч үзвэл хатгалгаа өвчнөөр 10000 хүн амд ногдох нас барсан хүн амын тоо 1-2 байгаа бол 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчнөөр нас барч буй тохиолдол 3-8 буюу өнөдөр байна гэж үзжээ. 5 хүртэлх насны 10 000 хүүхдэд ногдох хатгалгаагаар нас баралт 2011 онд хамгийн их буюу 8 байсан бол үүнээс хойш буурч 2018 онд 3 болж, 5 жилийн өмнөхөөс 1-ээр, 10 жилийн өмнөхөөс 2-оор тус тус буурсан байна (ҮСХ, 2019).

<sup>164</sup> Үндэсний Статистикийн Хороо “Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд”, 2019 он

<sup>165</sup> [http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=UB\\_health\\_airpolution\\_2019.pdf&ln=Mn](http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=UB_health_airpolution_2019.pdf&ln=Mn)

Агаарын бохирдлоос үүдэн гарч буй нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөл буюу 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлт 2018 онд 81 байсан бол 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай хүүхэд 2018 онд 6 төржээ (хороо, 2019).

### Халдварт өвчний асуудал



**Нийт өвчлөлийн 68.3 хувь нь сургууль, цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн өвчлөл эзэлжээ.**

2018 онд улсын хэмжээнд гар хөл, амны өвчний нийт 2 876 тохиолдол буюу 10 000 хүн амд 9.1 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд нийт өвчлөлийн 80.4 хувийг 5 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаа ба 29.2 хувь нь цэцэрлэгт, 64.5 хувь нь гэртээ байдаг хүүхдүүд байна. Хүйсийн хувьд 57.1 хувийг эрэгтэй, 42.9 хувийг эмэгтэй тус тус эзэлж байна<sup>166</sup>. Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 319 тохиолдол буюу 10 000 хүн амд 1.0 бүртгэгдсэн гахай хавдрын өвчлөл бүх насныханд бүртгэгдсэний 63.6 хувь-ийг 1-9 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Нийт өвчлөлийн 44.5 хувь нь сургуульд явдаг, 21.9 хувь нь цэцэрлэгт явдаг аж<sup>167</sup>. Салхинцэцэг өвчнөөр 8 130 тохиолдол буюу 10,000 хүн амд 25.6 бүртгэгдсэн бол үүний 78.6 хувь нь 0-9 нас, үүнээс 54 хувь нь 2-4 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Нийт өвчлөлийн 68.3 хувь нь сургууль, цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн өвчлөл эзэлжээ<sup>168</sup>. 2018 онд улаанэсэргэнэ өвчний нийт 992 тохиолдол буюу 10,000 хүн амд 2.9 тохиолдол байгаа бөгөөд үүнээс 0-9 насны хүүхдүүд 87.2 хувийг эзэлж байна. Нийт өвчлөгсдийн 41.7 хувь нь цэцэрлэгт, 23.6 хувь сургуульд, 31.1 хувь нь гэртээ байдаг хүүхдүүд эзэлж байна<sup>169</sup>. “Сургуулийн насны хүүхдүүдийг сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэхэд Д аминдэмийн нөлөө судалгаа” нь 2015-2019 оны хооронд хийгдсэн байна.

166 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.72

167 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.75

168 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.77

169 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.78

### Сэтгэцийн эрүүл мэнд



**2019 онд 3,231 дуудлага хүлээн авсны 243 нь хүүхдээс ирсэн дуудлага байжээ.**

Эрүүл мэндийн яам сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал (уур бухимдал, нойргүйдэл, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, амиа хорлолт, донтолт, мансуурал, хүчирхийлэлтэй холбоотой сэтгэл санааны хямралд өртсөн)-тай үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх 24 цагийн 1800-2000 дуудлагын утсыг ажиллуулж, 2019 онд 3,231 дуудлага хүлээн авсны 243 нь хүүхдээс ирсэн дуудлага байжээ. Дээрх утсыг нээн ажлуулснаар уур бухимдал, нойргүйдэл, стресс, сэтгэл зүйн асуудалтай хүмүүс мэдээлэл авах боломж бүрдсэн. Мөн ГССҮТ-ийн дэргэдэх Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээ болон ЭХЭМҮТ-ийн Өсвөр үеийн клиникээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн 16 хүртэлх насны 128 хүүхэд эмнэлгийн болон сэтгэл зүй, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээ үзүүлсэн<sup>170</sup>.

### Хорт хавдрын өвчлөл

2018 онд улсын хэмжээнд 109 хүүхэд хорт хавдраар өвчилсний 55.9/61/ хувь нь хөвгүүд, 44.1/48/ хувь нь охид юм. Тухайн насны 100,000 хүүхдэд харьцуулахад 5 хүртэлх насны хүүхдэд 11, 5-9 насанд 6, 10-14 насанд 10, 15-19 насанд 8 тохиолдол тус тус ногдож байна. Хүүхдүүдийн дунд лимфойд лейкеми болон тархи, мэдрэлийн хорт хавдрууд тэргүүлж байна. Хорт хавдрын улмаас нийт 59 хүүхэд нас барснаас 0-4 насны 28.8 хувь, 5-9 насны 28.8 хувь, 10-14 насны 23.7 хувь, 15-19 насны хүүхдүүд 18.6 хувийг тус тус эзэлж байна<sup>171</sup>.

170 Эрүүл мэндийн яамнаас 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1А/805 дугаар албан бичиг

171 Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн үзүүлэлт 2018”, тал.87

## Осол, гэмтэл

Гэмтэл согог судлалын жил тутам гаргадаг “Осол гэмтлийн тандалтын тайлан”-д тусгаснаар Монгол Улсын хэмжээнд гэмтсэн 3 хүн тутмын 1 нь 0-15 насны хүүхэд байдаг. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 2,920 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 375 нь 0-19 насны хүүхэд юм. Хүүхдийн нас барж буй шалтгааныг авч үзвэл:

### Хүснэгт 16. Осол гэмтлээс үүдсэн нас баралт<sup>172</sup>

Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх шалтгаан – 2018 он				
	I	II	III	IV	V
0-4 нас /n=178/	Амьсгал боогдох - 55	Зам тээврийн осол – 30	Түлэгдэлт - 25	Усанд живэх - 25	Уналт - 11
5-9 нас /n=48/	Зам тээврийн осол - 12	Усанд живэх – 11	Түлэгдэлт - 8	Уналт - 5	Хордох - 4
10-14 нас /n=46/	Амиа хорлох – 11	Зам тээврийн осол – 10	Усанд живэх - 6	Амьгүй механик хүчинд өртөх - 5	Түлэгдэлт – 2
15-19 нас /n=103/	Амиа хорлох – 42	Зам тээврийн осол – 25	Хордох - 12	Усанд живэх - 6	Хүчирхийлэл - 5

## Хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл

Монгол Улсын хэмжээнд 2018 онд хүчирхийллийн шалтгаант өвчлөл 17,844 бүртгэгдсэн нь нийт осол гэмтлийн 12.5 хувийг эзэлж байгаа ба 10,000 хүн ам тутамд 57.2 хүн хүчирхийллийн улмаас гэмтэж эмнэлэгт хандсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үүний 486 буюу 4.5 хувь нь 0-15 насны хүүхэд байна.

172 Осол гэмтлийн тандалтын тайлан



## ХООЛ ТЭЖЭЭЛИЙН АСУУДАЛ

### Иод дутал

Иод нь хүний бие махбодын бодисын солилцоог зохицуулах, ураг, нялх хүүхдийн хэвийн өсөлт, тархины хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй бамбай булчирхайн дааврын нийлэгжилтэд нэн шаардлагатай эрдэс юм (НҮБ-ын Хүүхдийн сан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн яам, 2017). Иод нь далайн загас, замаг зэрэг далайн гаралтай хүнсэнд их хэмжээгээр агуулагддаг бол цагаан идээ, үр тариа, өндгөнд өчүүхэн бага хэмжээгээр агуулагддаг байна. “Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” оролцсон 13,798 өрхийн иоджуулсан давсны хэрэглээг шалгасан бөгөөд үүнээс 75.1 хувь нь иоджуулсан давстай байсан бол давсгүй 0.7, Иоджуулагүй (0 мг/кг) 24.2, Иоджуулсан ( $1 < \text{мг/кг} < 15$ ) 16.9, Иоджуулсан ( $15 + \text{мг/кг}$ ) 58.2 хувьтай байсан<sup>173</sup>.

### Илүүдэл жин ба таргалалт

Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2018 онд хамтран гаргасан “Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” нь 13,798 өрх хамрагдсан ба түүнээс тав хүртэлх насны хүүхэд 6,091, 5-17 насны хүүхэд 7,427 хамрагдсан. Үүнээс тав хүртэлх насны нийт хүүхдийн 10.5 хувь нь өндөртөө тохирсон жингээс хэт их жинтэй байсан<sup>174</sup>.

### Өсөлт хөгжилт

2020 оны эхний 3 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 513,183 хүүхэд хамрагдсанаас 0.25 хувь нь туранхай, 0.19 хувь нь тураалтай, 0.27 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2020).

173 Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018”, тал.192

174 Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018 инфографик”, тал.11

“Монгол хүүхдийн биеийн хэмжээ” судалгаа нь 2017-2019 оны хооронд хүүхдийн биеийн хэмжээний стандартыг боловсруулан үйлдвэрлэлд ашиглах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, ХХААХҮЯ-ны захиалгаар Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Хувцас судлалын төв хийж гүйцэтгэсэн. Тус төслийн хүрээнд түүвэр судалгааны аргаар Төв, Ховд, Дорноговь, Орхон, Дорнод, Сүхбаатар аймаг, Нийслэл Улаанбаатар хотын нийт 9012 сурагчаас биеийн 63 төрлийн хэмжээг антропометрийн хүрэлцэх болон үл хүрэлцэх 3D бодискайнер ашиглан хэмжилт хийжээ. Судалгааны үр дүнг боловсруулан матемакик статистик тооцоолол хийн биеийн хэмжээ”, MNS 2019”, “06-18 насны хөвгүүдийн биеийн хэв шинжит галбирын ангилал. Биеийн хэмжээ. MNS 2019” стандартуудыг боловсруулан батлуулжээ.

**Хүснэгт 17.** Монгол хүүхдийн биеийн дундаж хэмжээ, см<sup>175</sup>

Нас	Өндөр-цээжний бүслүүр-бүсэлхийн бүслүүр, см	
	Хөвгүүд	Охид
6 нас	116-56-51	116-56-48
7 нас	122-60-54	122-60-51
8 нас	128-64-57	128-60-54
9 нас	134-64-57	134-64-57
10 нас	140-68-60	140-68-57
11 нас	146-72-63	146-72-60
12 нас	152-76-63	152-76-63
13 нас	158-76-66	158-80-63
14 нас	164-80-66	158-80-66
15 нас	164-80-66	158-80-92*
16 нас	170-84-69	158-84-92*
17 нас	170-84-72	164-88-92*

Судалгааны үр дүнгээр гарсан онцлох үр дүнгүүдийг дурдвал:

- Эрэгтэй сурагчдын биеийн өндрөөс хамаарч 15 ангилал, эмэгтэй сурагчдын 12 ангилал үүсгэн биеийн дундаж хэлбэрийг тогтоосон.
- Хөвгүүд хамгийн өндөр нь 190-197 см бөгөөд Улаанбаатар хот, Орхон аймгийн хөвгүүд, охид хамгийн өндөр нь 170-176 см бөгөөд Улаанбаатар хот болон Төв аймгийн охид байна.
- Охидын хувьд 1-р ангид хамгийн намхан нь Улаанбаатар хотын сурагчид, хамгийн өндөр нь Төв аймгийн сурагчид байна. 3 ангиас эхлэн охидод нурууны бөхийлт ажиглагдаж байгаа бөгөөд 3-5 ангид ойролцоо өндөртэй болж байна. 5-8 ангид өсөлт огцом явагдаж 9-11 ангид жигдхэн өссөн. Ахлах ангид Дорноговь, Орхон аймгийн охид илүү өсгөлүүн болсон байна.
- Хөвгүүдийн хувьд Ховд аймгийн хөвгүүд намхан, Улаанбаатар хот, Орхон, Төв аймгийн хөвгүүд өндөр байна. 1-5 ангид жигд өсөлттэй байгаа ба 7-9 ангид огцом өсөлт байна. 3 ангиас эхлэн бөгтийлт

175 ХХААХҮЯ “Монгол Хүүхдийн биеийн хэмжээ тодорхойлох судалгааг танилцуулав” 2019 он





ажиглагдаж байгаа бөгөөд 6-7 ангиас биеийн хэлбэрийн өөрчлөлт эхэлж байна. Ахлах ангиас нурууны бөгтийлт багасч байгаа нь бие бялдар, булчин томорч байгаатай холбоотой гэж үзэж байна<sup>176</sup>.

## Дархлаажуулалт

ДЭМБ-ын Хүүхдийн Дархлаажуулалтын талаарх зөвлөмжид хүүхэд бүрийг сүрьеэ, сахуу, татран, хөхүүл ханиад, саа, улаан бурхан, гепатит В, хемофилюс инфлюэнза В, пневмококийн нян, ротавирус, улаануудын эсрэг зэрэг өвчлөлийн эсрэг вакцинжуулалтад хамрагдахыг зөвлөжээ. Нэг хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтыг 2018 оны байдлаар төрсний дараа 24 цагийн дотор хийдэг сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцины хамралт 98.4 хувь, халдварт саагийн эсрэг вакциных 98.6 хувь, гепатит В-ийн эсрэг вакцины хамралт 98.6 хувь байх бөгөөд тавт вакцины тархалт 99.5 хувьтай байна (ҮСХ, 2019). Үүнээс харахад эцэг эхчүүд хүүхдийн дархлааг дэмжих вакцинжуулалтад сайн хамрагдаж байгаа нь харагдаж байна.

## Нөхөн үржихүйн эрүүл мэнд

“Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” судалгааны үр дүнгээр 15-24 насны эмэгтэйчүүд 2390 байсан бөгөөд бэлгийн хавьталд орж байсан нийт 48.7 үүнээс 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон 0.7 хувь, 15-24 насны нийт 1042 байсны бэлгийн хавьталд 58.8 хувь нь орсон бөгөөд үүнээс 4.9 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд оржээ. Нийт судалгаанд оролцогчдын 1 хувь нь 15-19 насандаа эцэг болсон бол 0.3 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө эцэг болсон нийт 586 тохиолдол байна. Нийт 15-49 насны 10,794 эмэгтэй, 4,447 эрэгтэй оролцсон ба ХДХВ-ын талаарх мэдлэгээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн 23.3 хувь, эрэгтэйчүүдийн 23.1 хувь нь цогц мэдээлэлтэй байжээ<sup>177</sup>.

<sup>176</sup> ХХААХҮЯ “Монгол Хүүхдийн биеийн хэмжээ тодорхойлох судалгааг танилцуулав” 2019 он

<sup>177</sup> Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018”, тал.121-122



## Цэвэр ус, усан хангамж

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллерын Монгол Улсад хийсэн 2018 оны айлчлалын дүгнэлтэд тусгаснаар Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах Газрын (УСУГ) харьяаны нийт 600 худаг гэр хорооллуудад үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн хүн амын бараг 60 хувь буюу 200,000 гаруй өрх гэр хорооллуудад оршин суудаг байхад дунджаар 300 өрх тутамд нэг худаг ногдож байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм (Хеллер, 2018). “Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” судалгаанд оролцогчдын 82.5 хувь нь сайжруулсан ундны усны эх үүсвэр ашигладаг бөгөөд усны эх үүсвэр нь сууц/ хашаанд нь байдаг эсвэл усанд явж ирэхэд 30 хүртэлх минут зарцуулдаг дэд бүтэцтэй холбогджээ. Орон нутаг болон нийслэлээр харьцуулж үзвэл нийслэлийн 95.4 хувь, аймгийн төвийн 93.4 хувь, сумын төвийн 74 хувь, хөдөө 47.2 хувьтай байна. 100 мл хүртэлх усан дахь гэдэсний савханцарын тоогоор нь авч үзвэл бага (100 мл-т 1-ээс бага) 84.0, дунд (100 мл-т 1-10) 6.0, их (100 мл-т 11-100) 5.1, маш их (100 мл-т 100-аас их) 4.9 хувьтай гарчээ<sup>178</sup>.

<sup>178</sup> Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018 инфографик”, тал.5



Нийт судалгаанд оролцогчдын 1 хувь нь 15-19 насандаа эцэг болсон.



### Ариун цэврийн байгууламжийн асуудал

“Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” судалгаанд оролцсон нийт өрхийн 69 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг бөгөөд ариун цэврийн байгууламжаа дангаараа хэрэглэдэг. Нийслэл болон орон нутгаар харьцуулж үзвэл нийслэлийн 78.1 хувь, аймгийн төвийн 78.5 хувь, сумын төвийн 62.8 хувь, хөдөө 40.7 хувьтай байна<sup>179</sup>.


### Орчны аюулгүй байдлын асуудал

Нийслэлийн засаг даргын захирамжаар 2018 онд нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хэрэгжиж буй стандартыг мөрдүүлэх зорилтын хүрээнд орчны тохижилт, инженерийн шугам сүлжээ, авто замын засвар үйлчилгээний нөхцөл байдал

<sup>179</sup> Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018 инфографик”, тал.5

зэрэгт нэгдсэн үзлэг шалгалт, судалгаа хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий 54 хүний бүрэлдэхүүнтэй есөн дүүргийн 152 хороонд 14 хоног үзлэг, судалгаа хийгдсэн. Нийт 5423 орчны аюулгүй байдлыг алдагдуулж байгаа асуудал бүртгэгджээ<sup>180</sup>.

**Зураг 3.** Нийслэлд орчны аюулгүй байдлыг алдагдуулж байгаа асуудал, тоогоор



Эх сурвалж: Ulaanbaatar.mn

**Зураг 4.** Нийслэлд орчны аюулгүй байдлыг алдагдуулж байгаа асуудлууд, төрлийн давтамжаар




<sup>180</sup> Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл байдлыг зөрчсөн 5423 асуудал байна - <http://www.ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=41562>

### Нэгээс тав хүртэлх насны хүүхэд

2018 оны байдлаар хүүхдийн хамгийн түгээмэл өвчлөл нь амьсгалын тогтолцооны өвчлөл 49.8 хувиар тэргүүлж байгаа бөгөөд бусад өвчлөлийг авч үзвэл хоол боловсруулах тогтолцооны өвчин 10.4, Перинаталь үед үүссэн зарим эмгэг 8.4, мэдрэлийн тогтолцооны өвчин 6.1, арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 6 хувь байна.


**Зураг 5.** Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл



Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1263 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.1 ногдож 2018 онтой харьцуулахад 47 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 0.8-оор буурсан байна. Нийт эндэгдлийн 87.7 хувь нь өвчнөөр, 12.3 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 43.2 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 13.2 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 14.8 хувь, 12.3 хувийг осол, гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлсэн<sup>181</sup>.

181 Эрүүл мэндийн хөгжлийн төв "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2020 оны эхний 3 сарын байдлаар", тал.9

**Зураг 6.** Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаан



### 5-19 насны хүүхдийн өвчлөл нас баралтын шалтгаан

Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар амбулаторийн үзлэгээр 5-19 насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь хоол боловсруулах тогтолцооны өвчин болж байгаа бөгөөд дундажлан үзвэл 24.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 22.4 хувь, арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 11.3 хувийг эзлэн тэргүүлж байна. 5-19 насны хүүхдийн хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд шүд ба дайвар бүтцийн бусад эмгэг 35.9 хувь, шүд цоорох өвчин 34.0, амьсгалын тогтолцооны өвчинд цочмог тонзиллит буюу гүйлсэн булчирхайн үрэвсэлт өвчин 20.1 хувь, цочмог бронхит 13.4 хувийг эзэлж байна. Гүйлсэн булчирхайн үрэвсэл нь хүний биеийн эсэргүүцэл, дархлааг дарангуйлдаг өвчин юм. 5-19 насны хүүхдийн өвчлөлийн 3 дахь шалтгаан болсон арьс ба барьсан доорх эслэгийн өвчинд арьсны идээт өвчин 29.1 хувь, арьсны харшлын төрлийн өвчин 16.7 хувийг эзэлж байна<sup>182</sup>.

182 Үндэсний Статистикийн Хороо "Эрүүл мэндийн салбарын танилцуулга", тал.26

**Хүснэгт 18. 5-19 насны хүүхдийн өвчлөл**

Өвчний шалтгаан	5-9	10-14	15-19
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	28.8	24.2	21.0
Амьсгалын тогтолцооны өвчин	28.6	23.7	14.8
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	9.5	11.8	12.6
Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин	7.4	10.9	11.1
Нүд ба түүний дайврын өвчин	4.6	5.2	4.1
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	4.2	3.6	2.5
Шээс, бэлгэсийн тогтолцооны өвчин	4.1	5.5	9.9
Халдварт ба шимэгчит зарим өвчин	3.2	2.0	3.7
Мэдрэлийн тогтолцооны өвчин	2.5	4.2	5.8
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	0.8	1.7	2.3



**Амиа хорлох тохиолдол 30.2 хувь ба үүнээс 69.0 хувь нь эрэгтэй хүүхэд.**

Хүүхэд, өсвөр үеийнхний нас баралтын тэргүүлэх шалтгаанд 2018 оны байдлаар гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг дунджаар 50.2 хувийг, мэдрэлийн тогтолцооны өвчин 17.3 хувь, хавдар 11.3 хувиар эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна. Гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэгийн дотор амиа хорлох тохиолдол 30.2 хувь ба үүнээс 69.0 хувь нь эрэгтэй хүүхэд, 24.0 хувийг зам, тээврийн осол, үүний дотор 76.6 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна (ҮСХ, 2019)<sup>183</sup>.

**Эрүүл мэндийн хууль эрх зүйн орчин ба үндэсний хөтөлбөрүүд**

1. “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрт нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхэд, эмэгтэйчүүдийг баяжуулсан хүнс, эсхүл олон найрлага бичил тэжээлийн холимгоор хангах тухай тусгажээ (Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр, 2015).
2. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрт агаарын

<sup>183</sup> Үндэсний Статистикийн Хороо “Эрүүл мэндийн салбарын танилцуулга”, тал.27

бохирдол ихтэй бүс нутгийн 1 хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулах; 5 хүртэлх насны хүүхдийн уушгины хатгалгааг бууруулах зорилт тавьжээ (Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, 2017).

3. Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхдэд олгох харааны шилний төлбөрийг нийгмийн халамжийн сангаас хөнгөлөх, эсхүл үнэ төлбөргүй олгох асуудлыг судлан шийдвэрлэх тухай тусгажээ (Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017).
4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрт эх, хүүхдийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн асуудлыг чухалчлан авч үзэн хүүхдийг эндэгдлээс сэргийлэх, нэн шаардлагатай эрүүл хүнсээр хангах зэрэг ажлуудыг төлөвлөжээ. Мөн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, эмчлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох тухай тусгажээ (“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, 2017).
5. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 2018-2020 он хүртэл 900 хоног хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “сургууль, цэцэрлэгийн хүүхдийн сүү” төслийг хэрэгжүүлэх, хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эрх, эрүүл мэндийг бүх шатанд хамгаалах, компьютер болон дэлгэцэнд донтолтоос ангижруулах, хүүхдийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээ авах; хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энэ талаарх гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг шинэчлэн боловсруулж батлуулах тухай тусгайжээ (“Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлах тухай, 2018).

6. Эрүүл мэндийн сайдын А/503 тушаалаар Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлэгийн болон эмнэлэгийн бус эндсэн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлал хэлэлцэх тухай журамд
7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 20.1, 20.2-р зүйлд төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх тухай заажээ. (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016)
8. Эрүүл мэндийн сайдын А/512 тушаалын дагуу 2017 оны 12-р сарын 14-нд “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага”-ын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар баталсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлж, алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд сэргээн засах тогтолцоог бүрдүүлэх зорилготой юм. (тушаал, 2017)
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааварт хүүхдийн эрт илрүүлэг, оношилгоо үйлчилгээ, хөгжлийн дэмжлэгт хамруулах шийдвэр, хөгжлийн дэмжлэг оролцооны үүргийн уялдаа холбоог тусгажээ. (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018)

Монгол Улс хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн салбарыг амжилттай хөгжүүлсээр ирсэн. Монгол Улс нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д нэгдэж, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ыг боловсруулан хэрэгжүүлж байна. Тус үзэл баримтлал нь үндэсний тогтвортой хөгжлийн, үүнд хүн амын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх зорилт, хангах шалгуур үзүүлэлтийг тодорхой зааж өгсөн. Монгол Улсын Засгийн газар улсын нэгдсэн төсөвт эзлэх эрүүл мэндийн



**Эхийн  
эндэгдлийн  
түвшин 100,000  
амьд төрөлтөд  
27.1 байна.**

зардал, үүнд эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Тодруулбал, 2015 онд улсын нэгдсэн төсөвт эзлэх эрүүл мэндийн зардлын хэмжээ 580,679.65 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 2.51%-ийг эзэлж байсан бол 2020 онд 1,173,410.50 тэрбум төгрөгт (ДНБ-ний 3.19%) хүрч, үүний 681.41 тэрбум төгрөг нь улсын төсвөөс, 458.0 тэрбум төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас төсөвлөгджээ.<sup>184</sup>

Эрүүл мэндийн үзүүлэлтэд ч эерэг өөрчлөлт гарч байна.<sup>185</sup> Тухайлбал, 2015 онд 69.11 байсан төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2018 онд 70.19 (эрэгтэй 66.11, эмэгтэй 75.78)-д хүрчээ. Монгол Улс эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр тавьсан Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлж, 2015 он гэхэд шалгуур үзүүлэлтийг нь хангасан цөөн улс орны нэг болсон. Энэхүү эерэг хандлага одоо ч үргэлжилж, 2018 оны байдлаар 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тус тус 13.4 ба 16.9 хүртэл буурч, харин эхийн эндэгдлийн түвшин 100,000 амьд төрөлтөд 27.1 байна.

**Халдварт болон халдварт бус өвчин** - Зүрх судасны өвчин, хорт хавдар, гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт нь нийт нас баралтын шалтгаан дотор зонхилж, 76%-ийг нь бүрдүүлж байна. Зүрхний ишеми өвчин, тархины цус харвалт, элэгний хатуурал, элэгний хавдар, зам тээврийн осол нь цагаас өмнөх нас баралт болон амьдралын алдагдсан жилийн хавсарсан шалтгаан дотор голлож байна. Зохисгүй хооллолт, таргалалт, тамхи болон согтууруулах ундааны хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлс нь хөгжлийн бэрхшээл болон нас баралтын хавсарсан шалтгаан дотор зонхилсоор байна. Хотжилт, түүнтэй холбоотой амьдралын хэв маягийн өөрчлөлт, мөн өсөн нэмэгдэж буй хүн амын насжилт нь халдварт бус өвчлөл болон түүний эрсдэл, ялангуяа эрэгтэйчүүдийн дунд нэмэгдэхэд нөлөөлж байна.

Халдварт өвчний тухайд хэдийгээр буурч байгаа ч сүрьеэ (100,000 хүн амд ногдох өвчлөл 2006 онд 186, 2018 онд 110.7), мөн вирус гепатит В болон С тулгамдсан асуудал болсоор

<sup>184</sup> 2020 оны Төсвийн тухай хууль.

<sup>185</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт 2018. Улаанбаатар.



**Товлолын дархлаажуулалтын хамралт өндөр буюу 2018 оны байдлаар 98.8%-д хүрсэн байна.**

байна. Засгийн газраас вирүст гепатит В, С-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр үр дүн өгч, 2018 оны байдлаар 10,000 хүн амд ногдох вирүст гепатит В-ийн өвчлөл 8.5, вирүст гепатит С-ийн өвчлөл 1.5 болсон байна. ХДХВ/ДОХ-ын хувьд Монгол Улс бага тархалттай (0.1-ээс хувиас бага) ангилалд багтсаар байгаа боловч бэлгийн замаар дамжих бусад халдвар, үүнд тэмбүү, заг хүйтэн, трихомониазийн (10,000 хүн амд тус тус 19.4, 17.2, 14.1) өвчлөл өндөр байна. Товлолын дархлаажуулалтын хамралт өндөр буюу 2018 оны байдлаар 98.8%-д хүрсэн байна.

### **Анхан ба лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас эрүүл мэндийн зардлын хэмжээг ДНБ-ний 5 ба түүнээс дээш хувь хэмжээнд байлгахыг зөвлөдөг. Монгол Улсын нэгдсэн төсөвт эзлэх эрүүл мэндийн зардлын хэмжээ үүнээс бага буюу 3.19%-ийг<sup>186</sup> эзэлж байгаа нь эрүүл мэндийн салбарын бодит хэрэгцээг хангахгүй, улмаар тулгамдсан асуудал болсоор байна. 2020 оны байдлаар эрүүл мэндийн зардалд

<sup>186</sup> Өмнөх 10 жилийн хугацаанд ДНБ-ий 3%-иас бага хэмжээнд байсан.



**Төрийн өмчит эмнэлгүүдэд нийт орны 76%, хэвтүүлэн эмчилсэн тохиолдлын 80% ногдож байна.**

эзлэх анхан шатлалын тусламж, үйлчилгээний<sup>187</sup> хувь (17%) лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ногдох хэмжээнээс (66.7%) ихээхэн доогуур байна. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар хангалтгүй, өрхийн эрүүл мэндийн төвийн оношлогооны чадавхи сул, нэн шаардлагатай эм, хэрэгсэл дутагдалтай байна. Анхан шатлалд энгийн лабораторийн шинжилгээ болон дүрс оношлогоо, яаралтай тусламж, өдрийн тусламж, үйлчилгээ, үүнд жижиг хэмжээний мэс ажилбар, нөхөн сэргээх, гэрээр үзүүлэх болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг хангалттай түвшинд үзүүлж чадахгүй байна. Ингэснээр үйлчлүүлэгчид анхан шатлалыг алгасан шууд өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хандах нь түгээмэл байна. Үүнд хүн амын дунд уламжлал болсон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг, мөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг илүүд үздэг хандлага ч нөлөөлж байна.

Монгол Улсад хэвтүүлэн эмчлэх орны тоо 10,000 хүн амд 78.8 байгаа нь хүн амын бодит хэрэгцээ, мөн өндөр хөгжсөн улс орны дундажтай (10,000 хүн амд 35) харьцуулахад ихээхэн илүүдэлтэй байна. Төрийн өмчит эмнэлгүүдэд нийт орны 76%, хэвтүүлэн эмчилсэн тохиолдлын 80% ногдож байна. Гэвч төрийн өмчит эмнэлгүүд бие даан шийдвэр гаргах эрх мэдэл дутагдалтай байгаа нь удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэл, мөн тусламж, үйлчилгээний чанарт нь сөргөөр нөлөөлж байна. Төрөөс тавибал зохих зохицуулалт, хяналт хангалтгүйгээс хувийн эрүүл мэндийн байгууллага олноор нэмэгдсээр ирсэн. Өдрийн тусламж, үйлчилгээ, дурангийн мэс засал зэрэг дэвшилтэт арга барил төрийн өмчит болон хувийн эмнэлгийн аль алинд нь бүрэн хөгжөөгүй байна. Урт хугацааны нөхөн сэргээх, сувилахуйн болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ хангалттай түвшинд хөгжөөгүй нь эмнэлгийн “хурц” орыг архаг өвчтний тусламж, үйлчилгээнд үндэслэлгүйгээр ашиглахад хүргэж байна. Анхан ба лавлагаа шатлалд хүний нөөцийн хөгжил, хангамж дутагдалтай, төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн тасралтгүй

<sup>187</sup> Хувь хүн, гэр бүл, олон нийтийн эрэлт, хэрэгцээнд төвлөрсөн, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалахад нийгэмд суурилсан хандлагыг хэрэгжүүлэгчийг эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ гэж тодорхойлдог. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийг цогцоор нь авч үзэж, бие махбод, оюун санаа болон нийгмийн эрүүл мэнд, сайн сайхан байдал хоорондын уялдаа холбоо бүхий цогц асуудалд төвлөрдөг. (ДЭМБ)

боловсрол олгох түвшин хангалтгүй, эмч, сувилагчийн харьцаа алдагдаж, сувилагч дутагдалтай, эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн нөхцөл, цалин хангамж хангалтгүй байна. Өвчтнийг шилжүүлэх тогтолцоонд анхан шатлалын тусламж, үйлчилгээг дэмжсэн зохицуулалт нэвтрээгүй байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалттай үзүүлэх тогтолцоо бүрдээгүй, улмаар анхан ба лавлагаа шатлал хоорондын зохицуулалт, уялдаа холбоо хангалтгүй байгаа нь шилжүүлгийн тогтолцоо үр дүнтэй ажиллаж чадахгүй байгаад давхар нөлөөлж байна.

### Ядуу, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж

Монгол Улсад хотжилт эрчимтэй явагдаж, хот сууринд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ачааллыг эрс нэмэгдүүлж байна. Хөдөөгөөс шилжин суурьшигчдыг ихэнхийг нийслэл Улаанбаатар хот хүлээн авч, тус хотод



### Өндөр үнэ өртөг, зохисгүй хэрэглээнээс хамааран өрхийн зарлагын гуравны нэгийг эмийн зардал эзэлж байна.

Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувь нь оршин сууж байна. Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь төвлөрсөн халаалт, усан хангамжид холбогдоогүй, ариун цэврийн нөхцөл тааруу, нийгмийн тусламж, үйлчилгээ дутагдалтай гэр хороололд амьдарч байна. Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, нэн ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдэд хангалтгүй түвшинд байна. Хүн амын амьжиргааны дунд, дээгүүр түвшний иргэдтэй харьцуулахад ядуу, эмзэг бүлгийн иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг 2.5 дахин бага авдаг ажээ.<sup>188</sup> Иргэдээс шууд төлөгдөх зардал эрүүл мэндийн нийт зардлын 41%-ийг эзэлж байна.<sup>189</sup> Өндөр үнэ өртөг, зохисгүй хэрэглээнээс хамааран өрхийн зарлагын гуравны нэгийг эмийн зардал эзэлж байна. Судалгаагаар зах зээлд стандартын бус (10.1%), бүртгэлгүй (4.3%), дуураймал (0.8%) эмийн хувь өндөр гарчээ.<sup>190</sup> Эмийн нэгдсэн зохицуулалтын байгууллага, тогтолцоо байхгүй нь эмийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөөр байна. Засгийн газар ойр орхон солигдсоноор эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, хэрэгжилтийн залгамж халаа алдагдаж байна.

### Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг тусгасан байна.

Гэвч өнөөг хүртэл манай улсад хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтийн талаар хийсэн цогц судалгаа, оношлогооны систем байхгүй байна.

ХНХЯ-ны харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, БНСУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хүрээлэн хамтран 2015 оны дөрөвдүгээр сараас 2018

188 ЭМЯ. НҮБ-ын Хүүхдийн сан. 2017. Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал: Үндэсний тав дахь судалгааны тайлан. Улаанбаатар.

189 J.Dorjdagva et al. 2016. Catastrophic Health Expenditure and Impoverishment in Mongolia. International Journal for Equity in Health. 15(105).

190 ЭМЯ. АХБ. 2018. Монгол Улс дахь стандартын бус, бүртгэлгүй, дуураймал эмийн тархалтын судалгаа. Төслийн эцсийн тайлан. Улаанбаатар.



оны долоодугаар сарыг дуустал нийт гурван жилийн хугацаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн илрүүлэлт, оролцоо” төслийг хэрэгжүүлж байсан. Төслийн хүрээнд 2016-2018 онд боловсруулсан ном гарын авлага, хийгдсэн судалгааны ажлын хүрээнд 21 аймаг, есөн дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн илрүүлэлт, оролцоо” сургалтыг эцэг эх, асран хамгаалагч, өрхийн эмч, сувилагч, СӨБ-ын бага ангийн багш болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдэд зохион байгуулсан байна. Сургалтад нийт 3,200 гаруй хүн хамрагджээ. Төслийн багийнхны үзэж байгаагаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, эрт арга хэмжээ авснаар хөгжлийн бэрхшээлийг 30 хүртэл хувиар бууруулах боломжтой байна. Дээр дурдсанчлан манайд эрт илрүүлэх тогтсон систем байхгүй учраас статистик мэдээлэл бодитой гарахгүй байгааг төслийн багийнхан дурджээ<sup>191</sup>.

191 Төслийн тайлант үйл ажиллагааны үеэр төслийн багийнхнаас өгсөн ярилцлагаас дурдав. <https://ikon.mn/n/1dyo>



**Хүүхдийг эхийн хэвлийд байх үед болон нярай, бага насанд зохистой арга хэмжээ авснаар хөгжлийн бэрхшээл үүсэхээс 70 хувь сэргийлэх боломжтой.**


ДЭМБ-аас хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн ирт илрүүлэлтийн талаар хийгдсэн судалгаанд дурдсанчлан ургийн үеийн шинжилгээ хийх боломж бүрдсэн газар хөгжлийн бэрхшээл үүсгэх магадлалтай эрүүл мэндийн зарим нөхцөл байдлыг ургийн үед нь илрүүлж байгаа бол зарим хөгжлийн бэрхшээлийг төрөх үед, төрсний дараа оношилж болдог. Цаашилбал, хүүхдийн хөгжлийн явцыг ажиглах, хянах ажлыг өрхийн эмчийн товлот үзлэгийн үеэр юмуу Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвөөр үйлчлүүлж байх үеэр хийж болно. Эрүүл мэндийн юмуу боловсролын байгууллага дээр, эсвэл вакцинжуулалт зэрэг нийгмийн эрүүл мэндийн кампанит ажлын үеэр бага насны хүүхдийн хараа, сонсголын согогыг илрүүлэх гэх мэт зорилтот үзлэг хийж байхаар зохицуулж болно. Эдгээр хүчин чармайлт нь хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг бага насанд нь эрт илрүүлэхэд тус болох юм<sup>192</sup>.

Мөн хүүхдийг эхийн хэвлийд байх үед болон нярай, бага насанд зохистой арга хэмжээ авснаар хөгжлийн бэрхшээл үүсэхээс 70 хувь сэргийлэх боломжтой, гэвч хөгжлийн хоцрогдолтой 9 сартай хүүхдүүдийн 9 хувь, 24 сартай хүүхдүүдийн дөнгөж 12 хувь нь шаардлагатай үйлчилгээг авч байна гэсэн судалгаа байдаг. Хөгжлийн хоцрогдлын илт эрсдэлтэй хүүхдэд цаг алдалгүй хөгжлийн дэмжлэг үзүүлэх, чадвар алдалтыг багасгах, эцэг эхийн оролцоог сайжруулахад эрт илрүүлэх тогтолцоо зайлшгүй шаардлагатай<sup>193</sup>.

192 ДЭМБ-Нээлттэй нийгэм форум-“Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл” асуудал дэвшүүлсэн тайлан-[https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028\\_mon.pdf?sequence=9&isAllowed=y](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y)

193 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, / <https://mlsp.gov.mn/uploads/news/files/3b7c0cd4a89b-54380c5f1bea0787488c24c58abd.pdf>





**Засгийн газрын тооцоолсноор хүн амын 20 орчим хувь COVID-19-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй.**

## COVID-19 -ийн нөхцөл байдал

2020 оны 1 дүгээр сарын дунд үеэс эхэлсэн Ковид 19-ийн цар тахал эрүүл мэндийн салбарын ачааллыг огцом, эрс нэмэгдүүлж байна. Монгол Улсын Засгийн газар тус вирусийн халдвар нэвтрэн тархахаас сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч чадсан. Үүнд олон улсын болон дотоодын тээвэр, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, нэн чухал бус үйлдвэрлэл, үйлчилгээг хаах, олон нийтэд халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг хүргэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон нийтээр нэг дор цуглахыг цуцлан хязгаарлах, цэцэрлэг, сургуулийг завсарлуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ингэснээр халдварын тархалтаас сэргийлж, 2020 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар COVID-19-ийн батлагдсан тохиолдлын тоо 140, тусгаарлалтад байгаа хүний тоо 1,224, мөн нас барсан тохиолдол байхгүй байгаа тухай Эрүүл мэндийн яам (ЭМЯ) мэдээлсэн. Одоогийн байдлаар COVID-19 дотоодод дамжин халдварласан тохиолдолд байхгүй байна. Гэвч Засгийн газрын тооцоолсноор хүн амын 20 орчим хувь COVID-19-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй, мөн халдвар тархаж, өвчтэй хүмүүсийн тоо огцом нэмэгдвэл шаардагдах эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тусгарлах байр болон бусад нөөц дутагдалтай байна.

ДЭМБ-аас хийсэн үнэлгээгээр нийгмийн эрүүл мэндийн ноцтой нөхцөл үүсэхэд бэлэн байдал хангалтгүй байгааг тогтоожээ. Үүнд үүсч болох эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэн тогтоох, шаардагдах нөөц, тухайлбал яаралтай үед ашиглах тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлон төлөвлөх, бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, мөн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэхэд хариу арга хэмжээ авах чадавхи анхан ба дунд шатанд сул байгааг дурдаж байсны мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлага бий.<sup>194</sup> Монгол Улс гамшгаас хамгаалах арга хэмжээг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд ОБЕГ хэрэгжилтийг нь удирдан зохион байгуулдаг.

<sup>194</sup> World Health Organization. 2017. Joint External Evaluation of International Health Regulation Core Capacities of Mongolia. Geneva.



**Монгол Улсын  
Их хурал 2016  
онд Тогтвортой  
хөгжлийн үзэл  
баримтлал  
2030-ыг  
баталсан.**

Түүнчлэн салбар бүр өөрийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, холбогдох яам хэрэгжилтийг нь удирдан зохион байгуулдаг. Гэвч эдгээр төлөвлөгөөнд салбар тус бүрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тов тодорхой болгоогүй байгаа тухай үнэлгээнд дурджээ. Мөн Монгол Улс шинэ болон шинээр сэргэж буй халдвар тархах, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд эмзэг байдалтай бөгөөд хариу арга хэмжээ авах үндэсний тогтолцоонд нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд байна гэж үнэлгээгээр дүгнэжээ.

Монгол Улсын Их хурал 2016 онд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ыг баталсан. Тус үзэл баримтлалд тогтвортой хөгжлийн үндэсний зорилтыг тодорхойлж, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 78 насанд хүргэх, Монгол Улсыг хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 улс орны эгнээнд багтаана гэж тооцжээ.<sup>195</sup> Үзэл баримтлал дахь нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн зарчмын нэгийг “эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалсан байх” хэмээн тодорхойлжээ. Мөн эрүүл мэндтэй холбоотой дараах дөрвөн зорилтыг дэвшүүлсэн байна: (i) урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношлогоо, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, (ii) эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, (iii) зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах, (iv) халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлэх.

<sup>195</sup> 2019 оны байдлаар Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 0.735 байна. Тус үзүүлэлтээр Монгол Улс хүний хөгжил өндөртэй улс орны ангилалд буюу 92 дугаарт бичигдэж байна. Эх сурвалж: UNDP. 2019. Overview of the Human Development Report 2019. Beyond income, beyond averages, beyond today: Inequalities in human development in the 21st century. New York.

## Эрүүл мэндийн бодлого

2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, салбар хоорондын болон салбар доторх бодлогын уялдаа холбоог сайжруулах, мөн сонгуулийн дөрвөн жилийн мөчлөгийн хүрээнд засгийн газар солигдоход бодлогын залгамжийг хангах зорилготой юм. Тус хууль хэрэгжсэнээр эрүүл мэндийн салбарт мөрдөж байсан янз бүрийн түвшний бодлогын баримт бичгийг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017)-д нэгтгэж, мөн АХБ-ны дэмжлэгтэйгээр Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө 2020-2026)-г боловсруулж, 2020 онд батлаад байна.

Эдгээр баримт бичиг нь эрүүл мэндийн салбар ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга замыг үндсэн найман чиглэл буюу нийгмийн эрүүл мэнд,



эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хүний нөөц, эрүүл мэндийн санхүүжилт, эрүүл мэндийн технологи, эм зүйн тусламж, үйлчилгээ, мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага, эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын хүрээнд тодорхойлжээ. Бодлогын зорилтод агаар, ус, хөрсний бохирдол, хүсний аюулгүй байдал, зонхилон тохиолдох өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг зэрэг нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, мөн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал тохиолдоход бэлэн байх, зохистой хариу арга хэмжээ авахад салбар хоорондын хамтын ажиллагааг ханган ажиллахаар тусгажээ. Үүний зэрэгцээ анхан ба лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, урт хугацааны тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, эрүүл мэндийн ажилтны сургалтын тогтоолцоог салбарын хэрэгцээтэй нийцүүлэх, эрүүл мэндийн, нэн ялангуяа анхан шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх, иргэдээс шууд гарч байгаа төлбөрийн хэмжээг багасгах, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой болгох, эрүүл мэндийн байгууллагын дэд бүтцийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, эмийн зохицуулалтыг сайжруулах, эмийн үнийг бууруулах, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн өмчит эмнэлгийг бие даалгах, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохицуулалтыг сайжруулахаар төлөвлөжээ.

Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөг (2020-2026) эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөх аргачлалаар хангах тусламж, үйлчилгээний төлөвлөлтийн хүрээ, дунд хугацааны зардал болон хөрөнгө оруулалтын хүрээ, мөн тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ дагалдаж байгаа. Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө 2020-2026 болон түүний дагалдах баримт бичиг нь тус салбарын нийт оролцогч талын үйл ажиллагааг уялдуулах, улмаар төрийн, хувийн хэвшлийн болон олон улсын хөрөнгө оруулалтыг үр дүнтэй зохицуулж ашиглах үндэс суурь нь болох зорилготой.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016) нь төрийн өмчит эмнэлгийн засаглал, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохицуулалтыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. ЭМЯ тус хуулийн хэрэгжилтийг эхлүүлж, хагас бие даасан засаглалыг эхний ээлжинд төрийн өмчит гурван эмнэлэгт АХБ-ны тусламжтайгаар нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүний зэрэгцээ ЭМЯ хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохицуулалтыг хангах журам, гэрээний загварыг боловсруулах, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх үйл явцыг боловсронгуй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. ЭМЯ нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Монгол Улсын Их хуралд 2019 онд өргөн барьсан. Хуулийн шинэчилсэн найруулгад ДЭМБ-аас зөвлөмж болгосон эмийн зохицуулалтын үндсэн үйл ажиллагааг төвлөрүүлсэн эмийн нэгдсэн зохицуулалтын бие даасан байгууллагыг бий болгох, эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх, эмийн үнийн зохицуулалтыг сайжруулах зэрэг чухал асуудал тусчээ.

## Дэд хэсгийн дүгнэлт

Эх, үрсийн эрүүл мэндийн асуудал нь нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинтой холбоотой олон янзын хүчин зүйлээс шалтгаалан нийгэмд тулгамдсан асуудал болжээ. Үндсэндээ эх, нярай, хүүхдийн эндэгдлийн дийлэнх нь урьдчилан сэргийлэх боломжтой эндэгдэл байгаа нь шинэлэг бодлого, арга, үйлчилгээний төрлөөр эрүүл мэндийн тогтолцоог зорилтот бүлэгт хүртээмжтэй чанартай болгох төдийгүй гэр бүл, хувь хүний мэдлэг, ухамсар хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх онцгой шаардлагатайг харуулж байна.

Орчны бохирдол, иргэдийн эрүүл мэндийн хомс мэдлэг, хоол тэжээлийн дутал, халдварт болон халдварт бус өвчлөл, осол гэмтэл, олон төрлийн эрсдэлт зан үйлийн өндөр тархалт, болон өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудал зэрэг олон асуудал нийгэмд тулгамдаж байгаатай холбоотойгоор олон төрлийн хууль, үндэсний хэмжээний хөтөлбөр, бодлого баталж улмаар төрийн нэлээд оролцоотой, урьдчилан сэргийлэх чиг баримжаа бүхий эрүүл мэндийн бодлого хэрэгжих хандлагатай байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн иргэд, ялангуяа бага насны хүүхдүүдийн мэдлэг, хандлага, эрсдэлт зан үйлийг үр дүнтэй сайжруулах зорилгоор нийгмийн эрүүл мэндийн ажлыг шинэ шатанд гаргаж, алслагдсан, нэн ядуу, бусад зорилтот бүлэгт чиглэсэн шинэлэг төсөл, хөтөлбөрүүдийг онцгой анхаарч хэрэгжүүлэхээр зорьж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, нийгмийн эрүүл мэнд, мэдээлэл сурталчилгааны ажлыг шинэ шатанд гаргах, агаарын бохирдол, тогтолцооны шинэчлэл, урьдчилан сэргийлэх зэрэг ажиллагааг өргөнөөр хэрэгжүүлэх шаардлагатай холбоотойгоор эрүүл мэндийн салбарын зардал ойрын ирээдүйд огцом өсөхөөр байгаа боловч Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн орчинд энэ бүгдийг төсвөөс санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал гэж үзэж байна.<sup>196</sup> Эцэст нь Монгол Улс ямар арга хэмжээг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн салбарын орлогыг буюу тус салбарын ДНБ-д оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх талаар огтоос дурдахгүй, шинийг санаачлахгүй байгааг анхаарах нь зүйтэй юм.

<sup>196</sup> Мөн тэнд, 8 дахь тал



## ИРГЭНИЙ ЭРХ БА ЭРХ ЧӨЛӨӨ

### Ялгаварлан гадуурхалт

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар, 15-49 насны хүмүүсийн ялгаварлан гадуурхалтад өртсөн хамгийн нийтлэг шалтгаан нь “амьжиргааны түвшин буюу баян, ядуугийн ялгаа”-наас болжээ. Харин 15-19 насны хүүхдүүдийн ялгаварлан гадуурхалтад өртсөн хамгийн нийтлэг шалтгаан нь “нас” байна (Үндэсний Статистикийн Хороо, 2019).

Өөрөөр хэлбэл хүүхдүүд нийгмийн харилцаанд ороход тэднийг насаар ялгаварлаж балчир, юм ойлгохгүй хэмээн дүгнэж, шударга болон тэгш байдлаар харилцдаггүй аж. Энэ нь ялангуяа манай орны уламжлал, хэвшсэн соёлтой холбоотойгоор “ах нь сургаж, дүү нь сонсдог” нийгмийн үнэлэмжийг ноёрхуулж байна. Ингэснээр хүүхэд өөртөө итгэлгүй, хүлцсэн болох хандлага ажиглагдаж байна.

Английн философич Жон Локк хүн бүрт жам ёсны эрх буйг онцолсон нь дараах 3 эрх:

- Амьдрах буюу амьдралтай байх (Live-life)
- Чөлөөт буюу эрх чөлөөтэй байх (Liberty)
- Өмчлөх буюу өмчтэй байх (Property)

гэж томъёолсон нь манай улсад "амьдрах эрх" гэж биш "амьд явах эрх" гэж орчуулагдаж, алхам бүртээ хүний эрхийн төлөө үйлдэл хийх учиртай төрийг энэ үүргээс нь холдуулж байна.<sup>197</sup> Иргэдийн сонголттой амьдрах боломжит хувилбаруудыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, аливаа эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.



**Төр нь иргэдийнхээ гарааг зүй ёсны болгон бэлдэхэд гойд үүрэг гүйцэтгэж, түүнээс хойш хүн гарааны тэгш байдлаас өөрсдийн сонголттой амьдрах эрхээ эдлэх нь олон улс дахь хөгжингүй хүмүүнлэг орнуудын жишиг байдаг.**

<sup>197</sup> А. Хишигтөгс, Социоаналитик: Ерөнхийллийн онол, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2018. 75-76 дэх нүүр.



**Асран хамгаалагчдын зүгээс хүүхэдтэй хэрхэн харилцаж, хайр халамж тавьж байгаа нь тэдний хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл болдог.**

## Хайр халамж

Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцид хүүхдийн хөгжлийг цогц, нийцтэй байлгахын тулд тэд аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Монголд 2018 оны байдлаар 0-17 насны хагас, бүтэн өнчин 18,794 хүүхдийн 74% нь эцэг эсвэл эхтэйгээ хамт амьдардаг байна.<sup>198</sup> Гэвч харин ч эсрэгээр элэг бүтэн гэр бүл боловч хүүхдэдээ цаг гарган, ном уншиж өгч, хамт тоглохын оронд саатуулах маягаар смарт таблет эсвэл гар утсаа өгөх болжээ. Хүүхдэд бага байхаас нь л ухаалаг үйлдэлтэй гар утас, таблет хэрэглүүлж, интернэтээр зочлуулдаг нь тэдний бие бялдар, танин мэдэхүй, сэтгэхүйн болоод нийгмийн сайн сайхан байдалд эерэг болон сөрөг нөлөөтэй. Хүүхдийн амьдралын эхний жилүүдэд тархи нь маш хурдацтай хөгждөг бөгөөд энэ үед гэр орных нь нөхцөл, асран хамгаалагчдын зүгээс хүүхэдтэй хэрхэн харилцаж, хайр халамж тавьж байгаа нь тэдний хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл болдог.<sup>199</sup>

Нийгмийн Үзүүлэлтийн Түүвэр Судалгаагаанаас харахад 5 хүртэлх насны 6,091 хүүхдээс сүүлийн 7 хоногт насанд хүрэгчид хүүхдээ хараа хяналтгүй үлдээсэн байдал 12.5% нь байна. Эндээс дээд боловсролтой эхийг бодвол боловсролгүй эхчүүд; дээгүүр давхаргынхныг бодвол доогуур давхаргынхан хараа хяналтгүйгээр хүүхдээ үлдээдэг байна (Үндэсний Статистикийн Хороо, 2019). Хүүхдээ цоожлоод гарах эсвэл хүүхдээ бага насны хүүхдээрээ харуулж хамтад нь орхиж гарснаар галд шатаж, ус-тогонд цохиулах зэргээр хүүхдийн амь нас эндэгдэж байгаа тохиолдлууд гарсаар байгаа<sup>200</sup> тул хүүхдийг хараа хяналтгүй үлдээх хандлагыг таслан зогсоох арга хэмжээг авах хэрэгтэй.

198 НҮТС-ны үзүүлэлт SR.19 - Хагас, бүтэн өнчин хүүхэд. 77 дахь нүүр.

199 М. Блэк нар. "Бага Насны Хүүхдийн Хөгжилд Анхаарах нь: Амьдралын Мөчлөгүүдээр Ангилсан Шинжлэх Ухаанч Нотолгоо." Ланцет 389, дугаар. 10064 (2016): 77-90. doi:10.1016/s0140-6736(16)31389-7; Ж, Шонкофф нар. "Бага Насны Хүүхдүүдэд Учирч Буй Саад Бэрхшээл, Хөнөөлт Сэтгэл Зовнилын Насан Туршийн Нөлөө." Педиатрикс 129, дугаар. 1 (2011): 232-46. doi:10.1542/peds.2011-2663.

200 Цагдаагийн Ерөнхий Газрын цахим мэдээллийн сан



Энэнгшихийн онолын үүднээс авч үзэхэд сэтгэл зүйч Жон Боулби ээнэгшилтийн анхны онол болох хүмүүсийн хоорондох урт хугацааны сэтгэл зүйн холбоог тодорхойлсон. Түүнийхээр хүүхэд насанд нь үүсэх холбоо харилцаа тухайлбал хүүхэд асрагчтайгаа үүсгэх холбоо нь цаашдын амьдралд нь онцгой нөлөө үзүүлдэг гэжээ (Cassidy, 1999).<sup>201</sup> Араатан амьтан үр төл рүү нь дайрахад эх нь дан ганц тэжээх үүргээсээ гадна хамгаалалтын үүргийг давхар гүйцэтгэдэг шиг хүүхдийн хувьд эсэн мэнд амьдрахад хайрлаж хамгаалах хэрэгцээ гардаг. Ялангуяа ээжтэйгээ ойр байснаар бага насны хүүхдүүд хамгаалалтаа сайтар мэдэрч чаддаг (Ainsworth, 1978). Хэрэв ээнэгшсэн хүнээс салвал (ихэнхдээ эхээс хагацах) хүүхдийн нийгэмшилд сэтгэл зүйн хүндрэл учирдаг.

201 J. Cassidy, "The Nature of a Child's Ties," in Handbook of Attachment: Theory, Research and Clinical Applications, New York, Guilford Press, 1999, pp. 3-20.

Хүүхдийг “ээжийн” дүр төрхөөс салган итгэл, хайр энэрэлийг нь алдах тусам дараа дараагийн дүрүүдэд ээнэгших нь улам багасч, улам хаагдмал болдог бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам өөрийн дотоод хүсэл, сэтгэл гэхээс илүүтэй чихэр жимс, тоглоом наадгай зэрэг материаллаг зүйл рүү анхаарлаа хандуулдаг болдог. Боулби эхээсээ салах нь хүүхэд насандаа амссан тэр зовлон нас бие гүйцсэн хойно нь ч дахин илрэх үйл явцыг бий болгож болзошгүй хэмээн дүгнэсэн байна.

Эцэг эхийн хайр халамж нь хүүхдийг төрснөөс хойш биш тээлтийн үед ч илрэх ёстой. Хайр халамж нь хүүхэд гарч ирснээс эхэлнэ гэж үзвэл шинэ хүн угтан авах бэлтгэлгүй болох тул тээгдэж эхэлсэн цагаас болоод аль хэдийн өмнө нь анхаарал халамж тусах хэрэгтэй болдог. Тээх явцад стресс, уур уцаар, сэтгэлийн дарамт, муу зуршлын оронд хайр халамжаар энэрснээр ургийг зүй зохиостой хэлбэржүүлэх нь чухал.



**Эцэг эхийн хайр халамж нь хүүхдийг төрснөөс хойш биш тээлтийн үед ч илрэх ёстой.**

Хайр халамжийн тухай сэдвийг нийгмийн харилцаанд суралцахуйн онол ч авч үзсэн байдаг. Хүмүүс бусдын хийж буй үйлдлийг харж даган дуурайх замаар өөртөө зан үйлийг төлөвшүүлдэг (Bandura, 1973).<sup>202</sup> Өөрөөр хэлбэл хүчирхийллийг харсан хүмүүс үүнийг өөрсдийн харилцаанд хэрэглэх магадлал өндөр гэсэн үг. Эсрэгээр хүүхэд үедээ хайр халамжаар хангалттай өссөн бол тэд өөрсдийн хүүхдээ ч хайр халамжаар дүүргэхээр хичээнэ. Тиймээс хэдийгээр бага балчиртаа үл хайхрагдаж өссөн байлаа ч насанд хүрсэн хойноо түүнийхээ эсрэгээр зорьж харин ч бусдад болон хүүхдэдээ илүүтэйгээр анхаарал халамж тавихаар хичээх хүмүүс байдаг учраас гэр бүлийн институтын бодлогыг үргэлж сайжруулах хэрэгтэй болдог.

Хайр халамж нь хүүхдийг нийгэмд зүй ёсоор оролцуулахад буюу нийгэмшүүлэхэд гол хүчин зүйл болдог. Хүүхдийн ертөнцийн хувьд өөрийн гэсэн тоглоомуудаас авахуулаад бие засаж сурах, цоожлолтгүй өрөөнд торних, санаа бодлыг сонсох гэхчлэн өргөн хүрээнд анхаарал бэлтгэл шаардагддаг. Хүүхдийн хариу үйлдэл болох уйлаан ба инээмсэглэлд томчууд хариу үйлдэл хийцгээдэг. Хүүхдийн уйлаан нь балчир хүүхэд анхаарал шаардаж буй дохио болдог. Тэгэхээр уйлах нь хүүхдийн хамгийн сайн хэл юм. Хүүхдийн хөгжлийн гол элемент болох асран хамгаалагч, хүүхдийн хоорондын дотносолт нь анхаарал, халамжгүйгээр боломжгүй. Дотносолгүй өссөн хүүхдүүд хожим харилцааны хүндрэлтэй болж, зан ашид нь гүнзгий өөрчлөлт гардаг аж (Ainsworth, 1978).<sup>203</sup> Хүүхдийн ирээдүйн сайн сайхан байдалд бага насан дахь сэтгэлийн тогтвортой дотносолт чухал.

Хүүхэд өөрийгөө бие хүн шүү гэдгээ ухамсарлах шалтгаан нь өөрийгөө бусдын анхааралд байна гэдгээ мэдрэх явдал юм. Үл хайхрал нь хүүхэд өөртөө итгэл үнэмшилгүй, харилцаанаас эмээсэн шинжтэй болгодог. Тиймээс бусдын зүгээс анхаарах халамж нь хүүхдийн “би” бүрэлдэх гол нөхцөл болно. Психоаналитикч Зигмунд Фройдныхоор, балчир хүүхдэд идэх уухаас гадна хайрын хэрэгцээ байдаг

202 Bandura, Aggression: A social learning analysis, Englewood Cliffs, NJ: Prentice Hall, 1973.

203 Ainsworth, Patterns of Attachment: A Psychological Study of the Strange Situation, Hillsdale: Lawrence Erlbaum, 1978.

(Giddens, 2009).<sup>204</sup> Энэ утгаар Фройд хүүхдийн бие боловсрох хүртэл бэлгийн дур хүслийг хойш тавьсан ба гэвч хүүхэд өөрийн дотоод ухамсартаа туулсан сэтгэлийн байдлаа хадгалдаг байна. Хайрлаж халамжлах, анхаарал тавихыг ердөө хорьж цагдах, хязгаарлах зэргээр уламжлалт ойлголт болгохоос зайлсхийх нь орчин үеийн шаардлага болсоор байна. Ялангуяа хүүхэд өсвөр насанд хүрэхэд анхаарал тавихыгаа хувийн орон зайгүй болгож, эрх чөлөөнд нь хүндэтгэлгүй хандах байдалтай хутгаж боломгүй.

### Шашин шүтэх эрх чөлөө

Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 14 дүгээр зүйлд хүүхдийн чөлөөтэй бодож сэтгэх, сүсэглэх, шашин шүтлэгтэй байх хүүхдийн эрхийг хүндэтгэн үзнэ гэж заасан ба Үндсэн хуулийн дагуу бүх иргэд шашин шүтэх эрх чөлөөтэй. Монгол Улсад 2018 онд 364 сүм хийд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 193 нь Улаанбаатар хотод байна. Нийт сүм хийдийн байгууллагын шашны төрлөөс хамгийн их үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Христийн шашинд хамаарч байна.<sup>205</sup> Хүүхдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг эдлүүлэхийг дэмжихдээ, утга чанарыг нь ойлгоод шүтэж буй болон амьдралын нөхцөлөөс хамаарч шууд болон шууд бусаар татагдан орсон хоёр ялгаатай болохыг бодолцон энэ асуудлыг судлах шаардлагатай. Сүм хийдүүд ялангуяа хотын зах хэсгээр болон гэр хорооллын дунд тархсан ба үнэ төлбөргүй хоол унд, чихэр, дэвтэр үзэг зэргийг хүүхдүүдэд өглөг болгон өгдөг. Энэ нь хүүхдүүд найзуудаа уриалан дуудан сүм рүү дахин зүглэх замаар гишүүнчлэл тэлэгддэг. Тиймээс хүүхдийн шашин шүтэх эрхийг хамгаалахын сацуу хэрхэн шашин шүтэх болсон шалтгаан хийгээд таталтыг онцлон судалж байх хэрэгтэй.



Монгол Улсад  
2019 оны  
байдлаар  
**453** сүм хийд  
бүртгэлтэй  
үйл ажиллагаа  
явуулж байна.

<sup>204</sup> A. Giddens, *Sociology*, Cambridge: Polity Press, 2009.

<sup>205</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан







**Хүүхдүүд лам болж шавилан сууснаар ерөнхий боловсрол тасалдаж холддог.**

**Хүснэгт 19. Сүм хийдийн тоо**

Шашин	2010	2013	2016	2019
Бүгд	234	322	350	453
Будда	127	146	136	177
Христ	96	151	183	233
Ислам	6	20	22	30
Бусад	5	5	9	13

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүд нь сүм хийдийн дотуур байр, лам багшийн дэргэд шавилан сууж, шашны сургууль төгстөлөө тэндээ амьдарч амралтаараа ар гэртээ харьдаг (НҮБ-ын Хүүхдийн Сан; Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, 2014).<sup>206</sup> Тиймээс 18-аас доош насныхан буюу хүүхдүүд лам болж шавилан сууснаар ерөнхий боловсрол тасалдаж холддог. Монгол Улсын Иргэний хуулинд иргэний эрхзүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно гэж заасан.<sup>207</sup> Эрх зүйн бүрэн чадамжгүй учраас түүнийг асран хамгаалагч болон эцэг эх нь зарим талаар мэдэх эрх, үүрэг хүлээдэг. Тиймээс хүүхэд өөрөө шашин шүтэх эсхүл ламд шавилан суухыг сонгон шийдэхээс илүү тухайн хүүхдийн гэр бүлийн сонгосон шийдвэр байх нь олонтаа. Энэ утгаараа шашны сургуульд сурах насны хязгаарыг заах шаардлагатай эсэхэд салбар дундын судалгаа хэрэг болно.

Хүүхдийн үндсэн эрхийн нэг болох сурч хөгжих эрх нь сургуульд сурах байдлаар буюу албан боловсролоор биелэгддэг. Тиймээс хийдэд шавилан суусан ч ерөнхий боловсролыг заавал эзэмшүүлэх шаардлагатай (Save the Children; Child for Child; World Vision (Дэлхийн Зөн Монгол), 2015).<sup>208</sup> Монгол Улсад 2018-2019 оны хичээлийн

206 НҮБ-ын Хүүхдийн Сан; Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, "Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн сүм хийдэд татагдаж буй шалтгаан: Түргэвчилсэн үнэлгээний тайлан," Улаанбаатар, 2014. 5 дахь нүүр.

207 Иргэний хууль, Гурав дугаар бүлэг, 15 дугаар зүйл, <https://www.legalinfo.mn/law/details/299>

208 Save the Children; Child for Child; World Vision (Дэлхийн Зөн Монгол), "Бүх хүүхдийн эрхийн төлөө: НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх Хүүхдийн илтгэл - Монгол Улс," Улаанбаатар, 2015. 7 дахь нүүр.



**Клиникийн сэтгэл зүй хөгжөөгүй оронд шашин хөгждөг үзэгдэл ажиглагддаг тул сэтгэл зүйн төвүүдийг чанаржуулж олшруулах хэрэгтэй.**

жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 600.4 мянган хүүхэд суралцсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдүүдийн 5.5 хувь буюу 15.3 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдүүдийн 7.4 хувь буюу 13.8 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна (МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, 2019). Шашны сургуульд суралцаж ЕБС-иас гарсан тохиолдлууд эдгээр тооны нэгээхэн эзлэх хувь болох бөгөөд энэ талаар бүртгэлтэй мэдээллийг тодруулж бүртгэх системийг сайжруулах хэрэгтэй.

Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар-аас хийсэн судалгаанд сүмийн үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг болон хийдэд шавилан сууж буй хүүхэд 164 байгаа бол өдрөөр үйлчилгээнд хамрагддаг 1177 хүүхэд байна гэжээ. Мөн зарим хийдэд шавилан суудаг хүүхдүүд нэг өрөөнд хэт олуулаа байрладаг зэрэг зөрчил илэрсэн байна. Сүмээр очих үед мэдээ, мэдээлэл хариуцсан хүн нь байхгүй байх, хүлээлгэх, дахин очих зэргээр хүндрэлтэй асуудлууд гарч байсныг илрүүлэн зөвлөмж гаргаж хүргүүлсэн байна (Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, 2020).<sup>209</sup>

Телевизээр (ялангуяа үндэсний телевиз) аль нэг шашныг сурталчлан үзүүлэхийн оронд аль нэг сувгийг зөвхөн шашны тухай өгүүлдэг болгох хувилбар бий. Түүнчлэн боловсролоор шашны тухай зөв ойлголт өгөхгүй бол олон нийтийн дунд шашныг хүсэл биелүүлдэг мэт ойлгох нь түгээмэлжлээ. Шашинд хандах хандлагын талаар зохистой ойлголт өгөх ёстой ба тэрхүү өгөгч нь мөн шашны зөрчилгүй эсхүл давамгайлалгүй байх шаардлагатай болно. Шашны хүч түрэлт хийгээд дэлгэрэлт нь сүмийн санхүүжилтаас гадна өргөл барьцтай уялдах нь байдаг тул энэ талаар жичтэй судалгааг хийх хэрэгцээ байна. Мөн клиникийн сэтгэл зүй хөгжөөгүй оронд шашин хөгждөг үзэгдэл ажиглагддаг тул сүм хийдээс илүү сэтгэл зүйн төвүүдийг чанаржуулж олшруулах хэрэгтэй гэж судалгааны баг үзэж байна.

209 Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, "2019 оны үйл ажиллагааны тайлан," Улаанбаатар, 2020. 20 дахь нүүр.



**Нийт гэмт хэрэг үйлдэгчдээс харвал дээд боловсролгүй иргэд нь дээд боловсролтой иргэдээс их гэмт хэрэг үйлдсэн байна.**

## Гэмт хэрэг

2019 онд улсын хэмжээнд 31,524 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 15 хүртэлх насныхан 596 гэмт хэрэг, 16-17 хүртэлх насныхан 761 гэмт хэргийг үйлджээ.<sup>210</sup> Үүнээс тооцоход 18-аас доош насныхан буюу хүүхдүүд улсад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн зөрчлийн 4.3%-ийг (1357 хэрэг) эзэлж байна. Харин нийслэлийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 495 нь (5.6%) хүүхэд байна (Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Статистикийн газар, 2018).<sup>211</sup> Хийсэн буруу хэргээс үүдэж эрхийг нь хязгаарлах хүртэл арга хэмжээ авах нь хууль ёсных бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд хүрсэн шалтгааныг тодруулснаар ялангуяа хүүхдийн эрхийн хязгаарлалтын тоог бууруулж болох юм.

Нийт гэмт хэрэг үйлдэгчдээс харвал дээд боловсролгүй иргэд нь дээд боловсролтой иргэдээс их гэмт хэрэг үйлдсэн байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг нь боловсролын түвшнээс шууд бус хамааралтай байна. Харин шууд хамаарлын хувьсах хэмжигдэхүүн нь ядуурал байх хүчин зүйл ажиглагдаж байна. Ядууралд өртөхүйц эмзэг бүлгүүдийн нэг нь өрх толгойлсон өрх байдаг. Монгол Улсад 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо 2018 онд 36.3 мянга байна.

Нийт ядуу хүн амын 42 хувь нь 15 хүртэлх насны хүүхдүүд байна (Үндэсний Статистикийн Хороо, 2020). Эдгээрт 5 хүртэлх насны буюу СӨБ-ын хүүхэдтэй, олон хүүхэдтэй, өрх тэргүүлсэн хүүхэдтэй, залуу өрхийн тэргүүнтэй хүүхэдтэй өрхүүд багтаж байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2020 оны эхний 2 сарын байдлаар гэхэд нийт 6,517 иргэд байгаагаас 264 нь (4.1%) 18 хүртэлх насны хүүхдүүд байна (Үндэсний Статистикийн Хороо, 2020). Түүнчлэн 1619 (24.8%) нь 18-29 насных буюу өсвөр насныхан болон залуучууд гэмт хэргийн хохирогчдын дийлэнх хувийг эзэлж байна.<sup>212</sup> Ядуурлын дүр төрх судалгаанд, хөдөлмөрийн насны хүн

210 Цагдаагийн Ерөнхий Газар, 2019 оны улсын нийт дүн

211 Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Статистикийн газар, "Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал," Улаабаатар, 2018. 70 дахь нүүр.

212 УХС, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020. 43-47 дахь нүүр.



амд ногдох тэжээгдэгчдийн тоо болон хүүхдийн тоо ихсэх тусам ядуурал нэмэгдэж байна гэж дүгнэжээ (Үндэсний Статистикийн Хороо, 2020).

## Бүртгэл, шилжилт хөдөлгөөн



**Монгол Улсад  
2019 онд 79,580  
хүүхэд төрсөн.**

Хүүхдийн эрхийн тухай конвенц, олон улсын бусад гэрээ конвенцоор хүүхэд бүр нэр авах, иргэний харьяалалтай болох эрхийг баталгаажуулсан байдаг. Хүүхдийг төрмөгц бүртгэх нь тэднийг хуулиар хүлээн зөвшөөрч, эрхийг нь хамгаалах, уг эрхийн эсрэг ямар нэгэн хүчирхийллийг нуун дарагдуулахгүй байхыг баталгаажуулж буй эхний алхам юм.<sup>213</sup> Монгол Улсад эцэг, эх, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эрх бүхий байгууллагын төлөөлөгч хүүхэд төрснөөс хойш 30 хоногийн дотор харьяа дүүрэг, сумынхаа иргэний бүртгэлийн албанд бүртгүүлж төрсний гэрчилгээ авах үүрэг хүлээдэг.<sup>214</sup> Монгол Улсад 2019 онд 79,580 хүүхэд төрсөн гэж бүртгэгджээ.<sup>215</sup>

213 НҮБ-ын Хүүхдийн Сан. Хүүхэд бүр төрснөө бүртгүүлэх эрхтэй: Төрсний бүртгэлийн тэгш бус байдал болон хандлага. Нью-Йорк: НҮБ-ын Хүүхдийн Сан, 2013. [https://www.unicef.org/publications/files/Birth\\_Registration\\_11\\_Dec\\_13.pdf](https://www.unicef.org/publications/files/Birth_Registration_11_Dec_13.pdf)

214 Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/13540?lawid=13540>

215 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



**Дотоод шилжин суурьшил нь хүүхдийн эрхийн зөрчлийн үндэс болсоор байна.**

Дотоод шилжилт хөдөлгөөнөөс үүдэж хороо дүүргийн хуваарилалт, бодлогын шийдэл гаргах баримтууд алдагдаж байгаа тул хөдөлгөөнт хүн амаа бүртгэх системийг бий болгох хэрэгтэй. Тэгснээр оршин суугаа газартаа үйлчилгээ болоод хамрагдвал зохих оролцооноос хоцрогдохгүй болно. Байр түрээслэн амьдардаг өрхүүд гэрээний хугацаа дуусмагц өөр түрээсийн газар луу шилжин суурьшдаг байдлыг бүртгэхгүйгээс болж иргэдийн оролцох эрхэд асуудал үүссээр байна.

Дотоод шилжин суурьшил нь хүүхдийн эрхийн зөрчлийн үндэс болсоор байна. Монголын нийгмийн гэр бүл нь уламжлалт хэв маягаас (ахмадууд болон эцэг эх бүгдийг шийдэх) орчин үеийн хэв маяг руу (хүүхдийн санал бодлыг оролцуулан шийдэх) шилжих шилжилтийн шинжтэй байдаг. Өөрсдийн тогтсон орон сууцгүй айл өрх болон түрээслэгчид нүүдэл суудал хийцгээж байна. Энэ нь нэгэнт томчуудын хэрэг болж, хүүхдийн үзэл бодлоос хамааралгүй шийдэгддэг. Тиймээс хүүхдийн эцэг эх болон залуу хосуудын ажлын газар нь аль болох орон сууцжуулахыг дэмжиж туслах хэрэгтэй тэгснээр нийгмийн хариуцлагын хүрээнд ажилчдынхаа болон хүүхдийн сайн сайхан байдлыг тогтворжуулж чадах юм. Цаашилбал энэ үйл ажиллагаа банк болон төрийн, хувийн бүх хэвшлүүдийн бодлогод тусгагдах хэрэгтэй байна.

Хүүхэдтэйгээ ярилцаж санаа бодлыг нь тусгалгүйгээр зөвхөн эцэг эх дур мэдэн шийдэл гарган нүүдэг байдал нь хүүхдийн орчныг үгүй хийх суурь нөхцөл болдог. Энэ нь ядууралтай холбоотой ба ихэвчлэн өөрийн гэсэн өмчийн орон сууцгүй өрхүүд байнга шилжин нүүх болдог. Байр түрээслэх маягаар байнгын нүүж суурьшнаар тухайн гэр бүлийн хүүхдийн орчныг өөрчилж, найз нөхдийн хэлхээ холбооны хүрээлэлгүй болгох эрсдэл тулгарна.

Хогийн цэг дээр амьдрагсдын зарим бүртгэлгүй, бичиг баримтгүй байх нь тохиолдол гардаг. Тэр тусмаа хүүхдийн эрүүл мэнд болон боловсролын эрх зөрчигдөх асуудал наад захын үзэгдэл болдог. Иймд Улаанчулуут дахь хогийн цэгт амьдардаг айл өрхийн хүүхдүүдийг халуун дулаан



**Улаанчулуутын хогийн цэгт дунджаар өдөрт 400 гаруй иргэн ажиллаж амьдардаг.**

орчинд өсч, сурч хүмүүжих нөхцөлөөр хангах зорилгоор “Нарны хүүхдүүд-2” цэцэрлэг 2019 оны 1 сард нээгджээ.<sup>216</sup> Сонгинохайрхан дүүрэг дэх тус хогийн цэгийн байршилд 150-200 хүүхэд хүлээн авах бололцоотой юм. Улаанчулуутын хогийн цэг нь 8 км үргэлжилдэг бөгөөд зүүн хойд хэсэгт нь “Нарны хүүхдүүд-1” цэцэрлэг байрладаг. Иймд хогийн цэгийн баруун захаар амьдарч буй хүүхдүүдэд зориулж “Нарны хүүхдүүд-2” цэцэрлэгийг барьжээ. Улаанчулуутын хогийн цэгт дунджаар өдөрт 400 гаруй иргэн ажиллаж амьдардаг бөгөөд 200 орчим хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байна. Харин энэхүү цэцэрлэг нээгдсэнээр хүүхдүүд бүрэн хамрагдах боломжтой болжээ.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг аймгаар авч үзвэл, 2018-2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 146.0 мянга (92.6 %) нь Улаанбаатар хотод (МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, 2019). Эндээс боловсрол эзэмшихийн тулд хот руу шилжин нүүдэллэж байдаг зүй тогтол харагдаж байна.

Социологич Адна Вебер хотын өсөлт нь 4 янзын нийгмийн шалтгаантай гэсний нэг нь “Хүүхдийн боловсролын төлөө хот бараадах” гэжээ (Weber, 2012).<sup>217</sup> Нийт их дээд сургуулийн тоо 2018-2019 онд 94 байсны 86 нь (91%) Улаанбаатар хотод байна. Хүүхдээ хот руу оюутан болгож сургуульд сургахаар явуулж, дараагаар төд удалгүй эцэг эх нь өөрсдөө хот руу шилжин ирэх үзэгдэл статистикаас ажиглагдаж байна. Монголд 2018 оны байдлаар 67% нь хотын, 33% нь хөдөөгийн хүн ам эзэлж байна. 2020 онд Монгол Улсын хүн амын тоо 3.3 сая болжээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтаас хүн амын хэтийн тооцооллыг гаргасан ба үүнд 2034 онд 4 сая хүн амд хүрнэ гэжээ (Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, 2018).<sup>218</sup> Хэрэв дэд бүтцийг хөгжүүлж өөрөөр хэлбэл чанартай боловсролын байгууллагыг хотын бус талбарт байгуулахгүй бол хүн ам улам л хотод нягтаршихаар байна. Хотын нягтаршил даацаасаа хэтрэх тусам утаа,

216 <https://www.n24.mn/a/1465>

217 A.F.Weber, The Growth of Cities in the Nineteenth Century: A Study in Statistics, HardPress Publishing, 2012.

218 Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, “Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын статистик,” ХНХЯ, Улаанбаатар, 2018. 9-10 дахь нүүр.

бохирдол, түгжрэл, үнийн өсөлт гэх мэт ялангуяа хүүхдийн эрхийн зөрчигдөх асуудал болж хувирна. Тиймээс Монгол орны онцлог болох нэг хүнд ногдох газрын хэмжээг зөв зохистой ашиглаж чадахын тулд ажил хэргүүдийг эхлэх шаардлагатай болжээ.

Иргэний эрх, эрх чөлөөний дагуу гэр бүл болох гэр бүл цуцлах эрх нээлттэй байдаг. 2019 онд 20,043 гэрлэлтийг бүртгэсэн бөгөөд мөн 4,262 гэр бүлийг цуцалжээ. Гэр бүл салалтаас гадна хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, эцэг эх байх эрх хасах, хүүхдийн нийгэмшлийн өөрчлөлт гэх мэт хүүхдийн эрхийн олон асуудал үүсддэг. Түүнчлэн хүүхэд эцэг эхийн байдлаас шууд хамаарч хэн болох нь төлөвшин тогтож, орчин нь бүрэлддэг. Дэлхийн Банкны судалгаагаар, архинд донтсон эцэг эхтэй хүүхдүүд ихэвчлэн сургуульд явдаггүй ба хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгт өртөх (хог түүх, зах дээр ачаа зөөх, машин угаах, гутал тослох гм) юмуу гудамжид гуйлга гуйдаг аж (Дэлхийн Банк, 2016).<sup>219</sup>

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөнд оролцох эрх**

Нийтийн тээврийн автобусанд аль зогсоол дээр явж байгааг мэдээлдэг болсон. Бүх иргэдэд зориулж ажлыг нь хөнгөвчилж туслахаас гадна сонсголгүй зогсоолыг нэрийг спикерээр хэлэх нь харааны бэрхшээлтэй иргэдэд; урсдаг бичгээр харуулдаг нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулагдаж үйл ажиллагаанд нь тусладаг болжээ. Цаашид дэд бүтцийн бүгдэд тохиромжтой технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх шаардлагатай.

<sup>219</sup> Дэлхийн Банк, "Улаанбаатар хотын ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь" Улаанбаатар, 2016. 69 дэх нүүр.



## Мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэн оролцох эрх

БСШУСЯ-ын мэдээлснээр, энэ нь хүүхдүүдийг цахим гадуурхал, халдлага, донтолтоос сэргийлэх, эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, сурах идэвхийг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх, нийгмийн бодит харилцаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилготой авч буй арга хэмжээ юм. Жишээлбэл, чөлөөт цагаараа номын санд сууж байгаа хүүхдүүд гар утсанд ирсэн сошиал мэдээлэлдээ сатаарахгүй байж болно.

Нөгөөтэйгүүр цахим орчин буюу сошиал сүлжээн дэх хандлагаар төрийн үйлдэл хийгддэг шинэ үзэгдэл сүүлийн үед ажиглагдах болов. Тухайлбал, 2019 онд “Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” хуулийн төслөөр жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 14-нд хурдан морины уралдаан зохион байгуулж, хүүхдээр морь унуулах заалтыг оруулахаар хэлэлцэж байсныг тус оны 12 сард Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хүүхдийн эрхийн зөрчилтэй байгаа хүсэлт хүргүүлжээ. Хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулж буй энэ хуулийн төслийг ард иргэд үй олноороо сошиал сүлжээг ашиглан эсэргүүцэж байв. Хүүхдийн эрхийг хамгаалахын төлөө дуу хоолойгоо өргөсөн ард иргэдийн сошиал сүлжээний “давалгаа” эрх баригчдад олон нийтийн санаа бодол гэдгээр хүчтэй нөлөөлж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн тухай мэдээлэл сэтгүүл зүйн салбарын зүгээс цацагдсаны улмаас сошиал сүлжээгээр гэмт этгээдийг нийтээрээ жигшиж, энэ талаар дор бүрнээ өөрсдийн байр суурийг илэрхийлцгээж, ард иргэд механик эв нэгдэлд орох болов. Улмаар 108 хүүхдийн түргэн тусламжийн утасны үйлчилгээ илүү сайжирч, цаашилбал урлаг соёлынхон хүртэл хүүхдийн хүчирхийллийн эсрэг дуу хийж олон нийтэд түгээжээ. Эдгээрээс харахад сошиал сүлжээ нь олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх талбар болохоос гадна мэдээлэл авах



**Дэлхийд  
сошиал медиа  
хэрэглээгээр  
тэргүүлж буй  
орнуудад нүүр  
тулсан харилцаа  
багассаар байна.**

болон үзэл бодол, байр сууриа илэрхийлж болох талбар болж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн үг хэлэх эрх чөлөөг сошиал сүлжээд илүү боломжжуулж байна.

Сошиал сүлжээг ашиглан хүүхдүүд дуу клип хийж, авьяас чадвараа нээж, өөрийгөө сорьж, үнэ төлбөргүйгээр youtube дээр байршуулж, олон нийтэд түгээж байна. Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хамгийн түгээмэл орон зай болох сошиал сүлжээ нь хязгаарлагдахын аргагүй шинжтэй тул тэнд буй мэдээ мэдээллийн үнэн зөв эсэхийг, цацагдсан контент үзвэрүүд нь хүүхэд үзэж болохооргүй сэдвүүд байх зэргийг хянах бололцоогүй байгаа нь хүүхдэд тавих анхаарлыг улам ихэсгэх шаардлагыг үүсгэж байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь өөртөө зөвхөн “илэрхийлэх” гэсэн ойлголтыг багтаахгүй бөгөөд “сонсох” үзэл хандлагыг орхигдуулж болохгүй. Дэлхийд сошиал медиа хэрэглээгээр тэргүүлж буй орнуудад нүүр тулсан харилцаа багассаар байгааг хүмүүнлэгийн салбарынхан (жүжиг, зураг, богино хэмжээний кино гэх мэт) шүүмжилсээр байна. Сошиал медиа хэрэглээ нь дотны гишүүдээс бүрдсэн гэр бүлийн уур амьсгалыг ч өөрчилсөөр байна. Нүүр тулсан харилцаагаар ч, сошиал медиагаар ч үзэл бодлоо илэрхийлэх ихсэх бүр үзэл бодлоо илэрхийлж чадахгүй хүмүүсийг орхих хандлага үүсэв. Жишээ нь интернэт худалдаж авах чадамжгүй өрх, түүнчлэн хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх асуудалд орлоо. Хүүхдийг гэхэд хэлд орсон цагаас өөрийгөө илэрхийлэхийг нь дэмжих бодит харилцаа чухал болжээ.

Орчин үед сошиал сүлжээ нь нэгэнт бүх хүмүүсийн мэдээлэл авах эх үүсвэр болсон байна. Эцэг эхчүүд хүүхдээ төрүүлэх хүртлээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болно гэж төсөөлөөгүй байдаг тул цочирч хямрах явдал гардаг. Энэ байдалд хариу арга хэмжээ авах үүднээс анхаарвал зохих мэдээллийг мэдээлэл авах тухай эрхийн хүрээнд сошиал сүлжээг ашиглан өргөжүүлэх боломжтой.

## Дэд хэсгийн дүгнэлт

Эцэг эхийн хайр халамж, анхаарал нь хүүхдийн хувьд бие бялдар, танин мэдэхүй түүнчлэн сэтгэл зүйн хөгжилд нь нөлөөлдөг тул нүүр тулсан харилцаанаас зайлсхийсэн (гар утас өгөх, интернэт орчинд үлдээх гэхчлэн) хандлагыг бууруулах хэрэгтэй. Хараа хяналтгүй үлдээх эсхүл бага насны хүүхдээр балчир насны хүүхэд харуулж үлдээх зэргээс үүдээд хүүхдийн эсэн мэнд хийгээд амь насанд халтай тохиолдлууд учирсаар байгаа тул хүүхдийг хараа хяналтгүй үлдээж буй цаад шалтгаануудад (дарга нь ажилчныг гэнэт дуудах эсхүл орлогогүйдэх гэх мэт) анхаарах шаардлагатай. Хүүхэд ээнэгшин дасах мэдрэмж өндөр тул дотно харилцаа үүсгэгч хүн (ихэнх тохиолдолд ээж) гэнэт холдохгүй байх нөхцөл байдалд анхаарах нь чухал. Хүүхэд суралцан дуурайх хандлагатай тул үл хайхарсан эсвэл хүчирхийлэл үзүүлсэн дүр зургийг хүүхдийнхээ нүдэнд харуулахгүй байх нь цаашдын амьдралд нь тустай.

Хүүхдийн шашин шүтэх эрхийг хязгаарлаж болохгүй ч түүний шашинд автагдах болсон шалтгааныг ярилцаж, эрсдэл буй эсэхийг судлах хэрэгтэй болжээ. Учир нь хотын захуудаар, хот, аймаг, сумын төвүүдээр болон жижиг бэлэг сэлтээр хүүхдийг татах байдалд хяналт байхгүй нь хэрэв хор хөнөөл учрах бол түүнийг тооцоолох аргагүй болгох юм.

Өрх байнгын шилжин суурьших нь түрээсийн байр болон өмчийн орон сууцгүйгээс үүдэж байгаа ба ийм дотоод шилжилт хөдөлгөөн нь хүүхдийн орчин алдагдах, нийгэмшилд нь ганцаардал давамгайлах байдлыг төрүүлж байна. Шилжин суурьших нь хүүхдийн санаа бодлоос илүү санхүүгийн бололцоонд үндэслэгдсээр байна.

Сошиал сүлжээ нь мэдээлэл авах үндсэн эх сурвалж болох хандлага орчин үед давамгайлж байна. Гэвч мэдээллийн үнэн зөв байдлыг хянах бололцоо сошиал сүлжээнд байдаггүй. Түүнчлэн илэрхийлэх, дуугарах эрх чөлөөг хангаж буй талбар нь сошиал сүлжээ болсон ба төрийн үйлдэл зарим талаар сошиал сүлжээний хандлагыг хүлээх болжээ.



## ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

### Тусгай хамгааллын арга хэмжээ: Хүүхдийн эсрэг гэмт хэрэг

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-ийг хуульчилж өгсөн байдаг бөгөөд үүнд; “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах”, “Хүүхдийг согтууруулах, мансууруулах, донтох байдалд татан оруулах”, “Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх”, “Хүүхдээр гуйлга гуйлгах”, “Хүүхэд солих”, “Хүүхэд худалдах”, “Хүүхэдтэй хэрцгий харьцах”, “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах”, “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах”, “Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх”, “Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх”<sup>220</sup> гэмт хэргүүд энэхүү бүлэгт хамаарна. “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг” нь 2018 онд улсын хэмжээнд нийт 21 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2019 онд 31 гэмт хэрэг бүртгэгдэж энэ төрлийн гэмт хэрэг нь өмнөх оноос 47.6%-иар өссөн байна. Үүнээс “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах” гэмт хэрэг нь 2019 онд өмнөх оноос 2 дахин өссөн /2019 онд 16, 2018 онд 8/ бөгөөд нийслэлийн хэмжээнд 15 гарсан нь /2019 оны гарсан 16 гэмт хэргээс/ энэ төрлийн гэмт хэргийн өсөлтөнд түлхүү нөлөөлсөн байна. Харин он гарсаар эхний 2 сарын байдлаар энэ төрлийн гэмт хэргийн 5 тохиолдол бүртгэгдээд байна<sup>221</sup>.

<sup>220</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он.

<sup>221</sup> ЦЕГ, Улсын хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 6 дах тал ; ЦЕГ, Улсын хэмжээнд 2020 оны 02 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 6 дах тал.

**Хүснэгт 20.** Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Бүртгэгдсэн гэмт хэрэг	2018 он	2019 он
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах /16.1/	2	0
Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх /16.3/	6	9
Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах /16.8/	8	16
Бусад /16.4 , 16.5 , 16.6 , 16.7 , 16.9 , 16.10 , 16.11/	5	6
Нийт	21	31

Эх сурвалж: Улсын хэмжээнд 2018 болон 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, ЦЕГ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-үүдээс тус зүйлийн 16.8-д заасан “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах” гэмт хэрэг нь тус бүлгийн гэмт хэргүүдээс хамгийн их үйлдэгдэж, тоон үзүүлэлтэнд өндөр хувь эзэлж байна. Ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн гаралт нь 2019 онд өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа учраас тус төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, насанд хүрэгчдэд хүүхдийг садар самуунд уруу татах, сурталчлахгүй байхыг сануулах, энэ нь гэмт үйлдэл болохыг мэдээлэх шаардлагатай байна.

**Гэр бүлийн хүчирхийлэл**

Хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд хүн бүр амьдарч буй орчин, гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг баталгаажуулсан болно<sup>222</sup>.

Монгол Улсын Эрүүгийн хуулинд тусгагдсан бас нэгэн хүүхдийн ашиг сонирхол хөндөгддөг гэмт хэрэг нь тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг юм. “Гэр бүлийн

<sup>222</sup> ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 23 дах тал.



хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг бусад гэмт хэргээс ялгаатай нь гэр бүлийн ашиг сонирхол хөндөгддөг бөгөөд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний<sup>223</sup> байнга хохирогч болгодог.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд заахдаа зөрчлөөс “байнга”<sup>224</sup> гэж ялган тэмдэглэсэн бөгөөд ийнхүү зөрчил нь байнга үйлдэгдэн гэмт хэрэг болоход тухайн зөрчлийг тухайн үед нь мэдэгдээгүй мөн гэр бүлийн хамаарал, харилцаа холбоо зэргээс шалтгаалж байна.<sup>225</sup>

<sup>223</sup> ЭХ-ийн 10.4-ийн тайлбар-Энэ хуульд заасан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаа” гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжинд байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.

<sup>224</sup> “байнга зодсон” гэж гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний бие махбодид 3 ба түүнээс дээш удаа халдсан байхыг ойлгоно.- “Гантулга С. Энхболд-Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг. УБ. 2018, 48 дах тал”

<sup>225</sup> ГБХЗХГ-ын Гэр бүлийн хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Л.Бадамцэцэг-ийн ярилцлагаас дурдав. /http://fcy.gov.mn/news/133usmr7iir?fbclid=IwAR2n8uJoO-JH4z2ji9j\_tlWfMjvp3ShSRMcowr8eqlxqTIVN2EjOmv38sk7k/



Цагдаагийн байгууллагад 2019 онд 2,175,825 зөрчил бүртгэгдсэний 8,962 нь буюу 0.4 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байна. Ийнхүү зөрчил гаргасан 6,634 хүнд 29,735,000 төгрөгөөр торгох, 6,400 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ. Мөн онд цагдаагийн алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шалгахдаа хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн 10,238 үнэлгээг хийсэн байна<sup>226</sup>.

2020 оны эхний улирлын цаг үеийн байдалтай холбогдон ЦЕГ-ын мэдээллээр ахуйн хүрээний архидалт өмнөх мөн үетэй харьцуулахад 30-40 хувиар нэмэгдэж, зөрчил 3131 бүртгэгдэн 61,6 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн зөрчлөөр баривчлагдсан этгээдийн тоо 2194 болж, 98.7 хувиар тус тус өссөн байна. Мөн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирж байгаа гэр бүлийн харилцааны зөрчлийн талаар зөвлөгөө авахыг хүссэн дуудлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108,8 хувь өсч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны ачаалал 115 хувиар нэмэгджээ<sup>227</sup>.

2020 оны 3-р сард хүүхдийн эсрэг бие махбодийн хүчирхийлэл өмнөх сарынхаас 32.9%, 2019 оны 2-р сартай харьцуулахад 46.8% -иар өссөн дүнгээр бүртгэгдсэн байна. Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл 2020 оны 2-р сард 2019 оны 2-р сартай харьцуулахад 57.6% -иар нэмэгдэж бүртгэгдсэн. Хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийллийн дуудлага 2020 оны 2-р сард 2019 оны 2-р сартай харьцуулахад 22.5% -иар өссөн бүртгэл байна<sup>228</sup>. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл тэр дундаа хүүхдэд бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлсэн байдал нь өмнөх оноос дандаа өссөн үзүүлэлттэй байгаа нь харамсалтай байна.

Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэл гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгааг 2017 онд улсын хэмжээнд хийсэн бөгөөд уг судалгаагаар эмэгтэйчүүдийн

226 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 27 дох тал.

227 ГБХЗХГ-ын мэдээллийн сан- <http://www.fcy.gov.mn/news/125>

228 Хүүхэд хамгааллын кластерын 2020 оны эхний улирлын тайлан.

эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшинг тогтоосон ба судалгааны дүнд үндэслэн Гэр бүлийн хүчирхийлэл их гардаг, хохирогч хамгаалал шаардлагатай Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт хохирогчдоо тусламж, үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулсан. Уг ажлыг зохион байгуулахад орон нутгаас 623 сая төгрөг, олон улсын байгууллагаас 764,5 сая төгрөг тус тус зарцуулсан<sup>229</sup>.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Хамтарсан багийн гишүүд болох сум, дүүргийн Засаг дарга, өрхийн эмч, хэсгийн төлөөлөгч, сургуулийн нийгмийн ажилтан болон нийгмийн ажилтныг сургах, дахин сургах зорилгоор Хамтарсан багийн үндэсний сургагч бэлтгэх сургалтыг 2017, 2019 онуудад зохион байгуулж, үндэсний сургагч нараар 21 аймаг, 9 дүүргийн бүх Хамтарсан баг /2017 онд 609 хамтарсан багийн 4634 гишүүд, 2019 онд 676 хамтарсан багийн 4714 гишүүд/-ийн бүх гишүүдийг сургалтад хамруулж, ур чадварыг нь нэмэгдүүлсэн<sup>230</sup> байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөж болзошгүй хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалан байрлуулах, эсхүл эмнэлгийн тусламж, сэтгэл зүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг нэг цэгээс үзүүлэхээр хуульчилжээ. 2019 оны байдлаар улсын хэмжээнд түр хамгаалах байр 14, нэг цэгийн үйлчилгээний төв 15 тус тус ажиллаж байна. Үүнээс төрийн харьяаны 13 түр хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв, төрийн бус байгууллагын харьяаны түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв тус бүр 1 байна<sup>231</sup>.

229 UPR- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 3 дах илтгэл (төсөл), 17 дох тал.

230 UPR- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 3 дах илтгэл (төсөл), эшлэл 8.

231 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 29 дэх тал.



**Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл 2020 оны 2-р сард 2019 оны 2-р сартай харьцуулахад 57.6%-иар нэмэгдэж бүртгэгдсэн.**

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн статистик мэдээлэл. (2018, 2019 он)-г Хүснэгт 11-ээс үзнэ үү.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйлчилгээ үзүүлэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байрыг 2017 онд байгуулж, тухайн жилд 0-18 хүртэлх насны 285 хүүхдэд, 2018 онд 945 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн байна. 2019 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 2,020 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ<sup>232</sup>.

ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэлд дурдсанаар гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн харилцааны сөрөг хандлага, хүчирхийлэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Ойлгоё, Хүндэлье” урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан тухай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна<sup>233</sup>.

Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийнхээ

232 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104 дэх тал.

233 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 107 дох тал.

хүрээнд Салбар зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах зэрэгт анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдах эрсдлийг буруулах, алслагдмал хөдөө, орон нутагт амьдарч байгаа болон мэдээлэл авах боломжгүй, бичиг, үсэг мэдэхгүй мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны тодорхой ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна. Бүх шатны Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт цогцоор нь тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна<sup>234</sup>.

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн этгээдийг баривчлахаас гадна албадан сургалтад хамруулахаар<sup>235</sup> заасан бол Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахгүйгээр, эсхүл ял дээр нэмж, зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээг шүүхээс хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт оногдуулахаар<sup>236</sup> заажээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд<sup>237</sup> заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ял шийтгүүлсэн этгээдэд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллага нь баривчлах, албадан сургалтад хамруулах, шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг тус тус зохион байгуулахаар байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73

234 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 33 дах тал.

235 Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл.

236 Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг.

237 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг.

дугаар тушаалаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”-ыг баталснаар зан үйлд нөлөөлөх сургалтын загвар хөтөлбөр, сургалтын гарын авлагатай болж, багш нарыг бэлтгэж байгаа ч бодит байдалд багш нар болон сургалтын байр, танхим, хэрэглэгдэхүүний хүртээмж хангалтгүй байна<sup>238</sup>.

## Хүн худалдаалах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаадах” гэмт хэргийн улмаас 2018 онд 10 хүн хохирсны 4 нь 14-17 насны хүүхэд байсан бол 2019 онд тус гэмт хэргийн улмаас 9 хүн хохирсны 5 нь мөн 14-17 насны хүүхэд байсан байна<sup>239</sup>. 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурдсанчлан Монгол Улсын Засгийн газар хүний наймааг таслан зогсооход тавигдах наад захын шаардлагыг бүрэн хангахгүй байгаа ч энэ талаар мэдэгдэхүйц чармайлт гаргаж байна. Өмнөх жилтэй харьцуулахад хүний наймааг таслан зогсоох төрийн хүчин чармайлт нэмэгдсэн<sup>240</sup> учраас Монгол Улсын зэрэглэлийг ахиулж 2-р шатлалд оруулсан байна. Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас дурдвал, хүний наймааны гэмт хэргээс хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд тодорхой хэмжээний санхүүжилт олгож эхэлсэн<sup>241</sup>, илүү олон хохирогчдыг илрүүлж, хилийн чанадаас эх оронд нь авчирсан, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулинд гэмт

238 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 33 дах тал. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт” мониторингийн тайлан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Швейцарын Хөгжлийн Агентлаг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, УБ, 2018 он/

239 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

240 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурдсанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1-р зүйлд прокурор хүний наймаа үйлдсэн хэмээн буруутгагдсан этгээдийн эсрэг хэрэг үүсгэхээс нааш хохирогч хамгаалах үйлчилгээ авах боломжгүй утга бүхий хэллэг байсан нь 2017 онд зарим хохирогчдыг хамгаалах үйлчилгээ авахад саад болсон. 2018 онд энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд ХЗДХЯ ажлын хэсэг байгуулж, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар засгийн газар хоорондын санал солилцох ажлыг эхлүүлсэн. Тайлангийн хугацааны төгсгөлд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичиг хуулийн төслийн шатандаа явж байсан.

241 Засгийн газраас 2018 онд хохирогч хамгаалах үйлчилгээний дийлэнхийг үзүүлдэг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцдэг ТББ-уудад 95 сая төгрөгийн (35,950 ам.доллар) санхүүжилт өгсөн байна. “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2017-2021) болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Өмнөх жилүүдийг бодвол энэ тайлангийн хугацаанд төрөөс тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 709 сая төгрөг (268,260 ам.доллар) төсөвлөсөн байна (2017 онд төсөв байгаагүй).

этгээдэд ял шийтгэл оногдуулах тодорхой заалтуудыг оновчтой тусгасан, улмаар нийгмийн сүлжээгээр дамжуулан хүний наймааны зорилгоор бусдыг залилан мэхлэх явдлыг таслан зогсоох зорилготой хууль сахиулах шинэ кампанит ажлыг<sup>242</sup> санаачилсан зэрэг ажлуудыг дурдаж болно. Гэвч, тайлант хугацаанд /2018-2019 он/ хэд хэдэн гол асуудлын хүрээнд төрийн зүгээс хүний наймааг таслан зогсоход тавигдах наад захын шаардлагыг хангаагүй хэвээр байна. Энэ нь эрх бүхий төрийн албан хаагч, байгууллагууд шинэ Эрүүгийн хуулийг хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш 2017 онд зохих ял шийтгэл оногдуулалгүй хэрэгсэхгүй болгосон хүний наймааны гэмт хэргүүдийн алийг нь ч дахиж нээгээгүй бөгөөд зарим хууль сахиулах албан хаагчид хохирогчдод хүний наймааны хэргээс хохирсны улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулсан хэвээр байна<sup>243</sup>.

НҮБ-аас хүн худалдаалах гэмт хэрэгтэй шууд холбоотой 8 зөвлөмж<sup>244</sup> өгснөөс зургаа нь эрх зүйн зохицуулалтад хамаарах, хоёр нь хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээ, нөхөн төлбөр болон төсөв санхүүтэй холбоотой зөвлөмж байсан. “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хууль байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалахтай тэмцэх төрийн үйл ажиллагаа нь “зөвхөн хурал, цуглаан хийх байдлаар хязгаарлагдаж” байна<sup>245</sup>. Мөн ЕАБХАБ-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Мадина Ярбуссинова<sup>246</sup> дүгнэхдээ “Хүн худалдаалахтай тэмцэх” асуудлыг “Засгийн газрын оролцоотой хийхгүй бол

242 Өмнөх тайлангуудаас ялгаатай нь энэ удаа хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, биеэ үнэлэгчдийг худалдан авах хэрэгцээг багасгах талаар төр засгаас арга хэмжээ авсан байна. Олон улсын байгууллагатай хамтран ХЗДХЯ болон ЦЕГ нь бэлгийн мөжлөгийн зорилго бүхий хүн худалдаалах гэмт хэрэг болон хүчээр хөдөлмөр эрхлүүлэхэд хүргэж болох цахим орчин дахь залилангийн талаар олон нийтийн ойлголтыг дээшлүүлж, тухайн хэргүүдийг мөрдөн шалгаж, таслан зогсоохын тулд кампанит ажлыг санаачилж, хамтран санхүүжүүлж, улмаар хэрэгжүүлсэн.

243 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2019 оны 6-р сарын 20-ны өдөр, /<https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-trafficking-in-persons-report-mn/>

244 Зөвлөмжийн 5.116-5.123 хүртэл

245 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагын хамтарсан “Иргэний оролцоо 2” төслийн хүрээнд “МУ-ын хуулиуд дахь иргэний оролцооны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ судалгааны үр дүнгийн тайлан”-д дурдсанаар

246 Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Д.Нямгэрэлийн 2018 оны 7/1726 тоот албан бичгээс хэсэгчлэн тусгав.

үр дүн гарахгүй бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн асуудлыг “Хүн худалдаалахтай тэмцэх” болгох шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэсэн. Монгол Улс хүн худалдаалахтай тэмцэх тал дээр ажиллаж буй бөгөөд 2008 онд НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэж, 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуультай болсон. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасны дагуу 2017 онд 4 жилийн хугацаатайгаар хэрэгжих Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, дээрх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, улмаар Засгийн газрын агентлаг хоорондын хүчин чармайлтыг зохицуулах чиг үүрэгтэй Хүний наймаатай тэмцэх ажлыг зохицуулах үндэсний дэд зөвлөлийг ажиллуулж байна. Гэхдээ Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл буурахгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой бус, албан хаагчид нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нэгдмэл ойлголтгүй, байгууллага хоорондын хамтын ажиллагаа байхгүй, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн байдал дутмаг байгаатай холбоотой байна. Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар үндэстэн дамнан үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэргээс урьчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоосны үндсэн дээр уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна<sup>247</sup>.

247 Монгол Улсын Засгийн газар 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”.

## Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

Эрүүгийн хуульд заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2019 онд 624 хүн хохирсны 359 (57.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд байсан байна. Үүнээс 253 (70.5%) нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч болжээ<sup>248</sup>.

**Хүснэгт 21.** Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо

Бүртгэгдсэн гэмт хэрэг	2018 он	2019 он
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүн	579	624
Үүнээс 0-18 хүртэлх насны хүүхэд	312	359
Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүн	487	492
Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон 0-18 хүртэлх насны хүүхэд	238	253

Source: YCX, Хохирсон хүн хүйс, насны ангилал, гэмт хэргийн төрлөөр-2018, 2019 он.

Эрүүгийн хуульд заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан Хүчиндэх гэмт хэрэгт 2018 онд улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 24 эмэгтэй хохирогчоор тогтоогдсоны 7 нь насанд хүрээгүй охид, 17 нь насанд хүрсэн эмэгтэйчүүд байна Энэ төрлийн гэмт хэрэгт орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү хохирчээ. Тухайлбал орон нутагт насанд хүрээгүй 6, насанд хүрсэн 11 эмэгтэй хохирогчоор тогтоогдсон байна<sup>249</sup>.

248 Мөн тэнд, YCX, Хохирсон хүн хүйс, насны ангилал, гэмт хэргийн төрлөөр-2018, 2019 он.

249 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, 52-р тал.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг багц хуулийн төслийг боловсруулсныг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан байна. Энэ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Эрүүгийн хуулийн Арван зургадугаар бүлэгт болон Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Тухайлбал Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүчиндэх (12.1 дүгээр зүйл) гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн бол хоёроос найман жил хүртэл хорих ялтай байсныг таваас арван хоёр жил хүртэл хорих ялтай болгож, арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгож үйлдсэн бол таваас арван жил хүртэл хорих ялтай байсныг наймаас арван таван жил хүртэл хорих ялтай болгож ялын бодлогыг чангатгажээ. Мөн Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2 дугаар зүйл) гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож хоёр жил хүртэл хорих ялтай байсныг 8 хүртэл жил болгож ялыг нэмэгдүүлсэн байна. Биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон бөгөөд энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар зохицуулалт тусгасан байна<sup>250</sup>. Энэ нь хүүхдийн бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг үйлдсэн гэмт хэрэгт насанд хүрэгчдийн бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг үйлдсэн гэмт хэргээс илүү хүнд хариуцлага хүлээлгэх буюу хүндрүүлэх бүрэлдэхүүн лүү оруулж өгсөн нь нэгэнт хүүхдийн зөрчигдсөн эрхэнд тохирсон ялыг ногдуулахад чиглэсэн байна гэж харж байна. Хүүхэд нь насанд хүрэгчдийг бодох юм бол бусдаас биеэ хамгаалах чадвар бага, биеийн хөгжил гүйцээгүй байдгаас хүүхдийн бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг үйлдсэн гэмт

250 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 118 дах тал.

хэрэг нь хүүхдэд сэтгэл санаа болон бие махбодын хувьд насанд хүрэгчдээс илүү их хохирлыг бий болгож байдаг.

### Хууль зөрчсөн болон гэрч, хохирогч хүүхэд

Өмнөх онд гэмт хэргийн улмаас хохирсон 18 хүртэлх насны хүүхдийн тоо 1688<sup>251</sup> байсан бол энэ онд 90 (5.3%) өөр буурчээ.

Харин хүүхэд оролцсон хэрэг 1068 болж, өмнөх оноос 327 (44.1%) оор өссөн байна. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид 2019 онд 17.1 мянга болж, өмнөх оноос 721 (4.4%) эер өссөн байна. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн<sup>252</sup> 1356 (7.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна<sup>253</sup>. Харин шүүхээр ял шийтгүүлсэн 18 хүртэлх насны хүүхдийн тоо 2018 онд 295 байсан бол 2019 онд 360 болон 65 (18%) аар өссөн байна<sup>254</sup>.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд 2019 онд гэмт хэргийн улмаас 111 хүүхэд нас барсан гэж бүртгэгдсэн бөгөөд эдгээр хүүхдийн нас барсан шалтгааныг судлахад гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсны улмаас сэтгэлзүйн гүн хямралд орж амиа хорлосон тохиолдол бүртгэгдээгүй хэдий ч ийм болзошгүй эрсдэл байгааг онцгойлон анхаарч гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх арга хэмжээг авч байгаа ажээ. “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-д гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тараахгүй

251 YCX, Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, хүйс, насны ангилал, сумаар, жилээр-2018 он. /[https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_2300\\_011V1&13999001\\_select\\_all=0&13999001SingleSelect=\\_12&SOUM\\_select\\_all=0&SOUMSingleSelect=\\_0&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2018\\_2019&viewtype=table/](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_011V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_12&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2018_2019&viewtype=table/)

252 Яллагдагч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

253 Мөн тэнд, YCX, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2019 он, 46 дах тал.

254 YCX, Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо хүйс, насны ангилал, жилээр-2018, 2019 он. / [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_2300\\_008V1&CR008\\_select\\_all=0&CR008SingleSelect=\\_2&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2019\\_2018&viewtype=table/](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_008V1&CR008_select_all=0&CR008SingleSelect=_2&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019_2018&viewtype=table/)

байх талаар сэтгүүлчид, алба хаагчдад чиглэсэн сургалтын агуулгад тусгуулахаар сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж байгааг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ХЭҮК-д мэдээлсэн байна<sup>255</sup>.

### Хохирогч хамгаалалт

ЦЕГ-ын ажилтнууд бэлгийн мөлжлөгт өртсөн 8 хохирогч хүүхдийг сэтгэлзүйн, нийгмийн болон эмнэлгийн халамж үйлчилгээнд зуучилсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) нь 12 хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээгээр хангахын тулд хэд хэдэн ТББ-тай гэрээлж ажилласан байна. ХТЭТ ТББ хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогч болсон 1 хүнд, бэлгийн мөлжлөгийн 38 хохирогчид тусалцаа үзүүлжээ (2017 онд нийт 29 хүнд тусалсан). Тэднээс насанд хүрсэн хохирогчид нь бүгд эмэгтэй байсан бөгөөд насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөгийн хохирогч нийт 6 хүүхэд байсны 1 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй хүүхэд байсан байна<sup>256</sup>.


Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж 2019 онд нийслэлийн хэмжээнд хохирогч 19 хүүхдэд өмгөөллийн, 48 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, 56 хүүхдэд хууль эрхзүйн зөвлөгөө өгч, 32 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 30 хүүхдэд өмгөөлөгч авахад нь зуучилжээ<sup>257</sup>.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/263, А/406, 321 дүгээр тушаалаар “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ын 3 дугаар

255 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 116 дах тал.

256 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2019 оны 6-р сарын 20-ны өдөр, /<https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-trafficking-in-persons-report-mn/>

257 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 105 дах тал.



Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд 2019 онд гэмт хэргийн улмаас 111 хүүхэд нас барсан гэж бүртгэгдсэн



**Монголын  
Хуульчдын  
холбоотой  
хамтран 2016-  
2019 онд  
хуульчийн багц  
цаг хангах  
сургалтыг  
амжилттай  
зохион  
байгуулсан.**

зүйлд “Насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна” гэж, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Шүүх эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний Цогцост хийх шинжилгээний хэсгийн 5-д “цогцост хийх шинжилгээ (0-18 насны) 30,000 төгрөг” гэснийг хүчингүй болгосугай.” гэж тус тус өөрчлөлт оруулжээ. Мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн болон яаралтай тусламж үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, дараалал харгалзахгүй, үнэ төлбөргүй үзүүлж байна<sup>258</sup>.

Хууль зүйн үнэгүй туслалцааны хувьд төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх Хууль зүйн туслалцааны төв нь улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, хүн ам ихээр суурьшсан 2 сум, нийт 31 салбарт 52 улсын өмгөөлөгч, 7 өмгөөлөгчийн туслах ажиллаж байна. 2016-2019 онд шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн нийт 6019 хэргийн 6689 холбогдогчийн 846 нь насанд хүрээгүй хүүхэд, 1253 нь бичиг үсэг тайлагдаагүй, 309 нь хөгжлийн бэрхшээлтэй, оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын иргэн 14, гадаадын иргэн 13 байна. Улсын өмгөөлөгчдийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмыг таниулах, шүүхийн практикт ач холбогдол бүхий хуульчийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор Монголын Хуульчдын холбоотой хамтран 2016-2019 онд хуульчийн багц цаг хангах сургалтыг амжилттай зохион байгуулж, 177 улсын өмгөөлөгчийг хамруулсан<sup>259</sup>.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд уг төсөлд Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн арван найман насанд хүрээгүй хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэл гаргасан иргэн төлбөрийн чадваргүй бол газар өмчлөх эрх нь зөрчигдсөн иргэн төлбөрийн чадваргүй бол,

<sup>258</sup> Дээр дурдсан бүтээл, 106 дах тал.

<sup>259</sup> UPR- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 3 дах илтгэл (төсөл), 25 дах тал.

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг/эх хууль зүйн туслалцаа авах, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарахаар тусгагдаад байна<sup>260</sup>.

Гэвч төлбөрийн чадваргүй яллагдагч хууль зүйн туслалцаа аван улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлж, явагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэдэн хувьд нь яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэж, өмгөөлөгч өмгөөлөх чиг үүргээ амжилттай хэрэгжүүлсэн, эсхүл хэдэн хувь нь яллагдагчид ашиггүйгээр шийдвэрлэж, эрх, ашиг сонирхлыг нь хөндсөн буюу улсын өмгөөлөгч өөрийн өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлж чадаагүй талаар судалгаа, мэдээлэл хараахан алга байна. Тиймээс хэдийгээр төлбөрийн чадваргүй иргэд өмгөөлөгчтэй болж байгаа нь сайн талтай хэдий ч үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлыг хамгаалж байгаа эсэх дээр үнэлгээ хийж, хяналт тавих шаардлагатай байна.

Мөн цаашид Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, тэдгээрийн харьяа байгууллагуудаас хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд ихээхэн анхаарч байгаа ч олон улсын жишигт нийцсэн цогц үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, одоо ажиллаж буй ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг ХЭҮК нь Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлд дурджээ.

<sup>260</sup> Мөн тэнд- UPR- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 3 дах илтгэл (төсөл), 25 дах тал.

## Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль ба хэрэгжилт

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар гэрч, хохирогч гэдэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч<sup>261</sup>, хохирогч<sup>262</sup> бөгөөд тус хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох явдал юм. Гэрч хохирогчийг хамгаалахын тулд аюулгүй байдлын болон сэтгэлзүйн гэсэн 2 төрлийн хамгаалалтын арга хэмжээг авдаг.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг сар, улирал, жилээр нь Цагдаагийн ерөнхий газрын цахим сайтад Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс мэдээлж байгаа нь тус хуулийн хэрэгжилттэй олон нийт танилцах, хэрэгжилтийг үнэлэх зэрэг боломжийг бий болгосон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь 2016 онд Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байгуулагдаж, Цагдаагийн албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Тус хэлтэс нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалах тухай прокурор, шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, туслалцаа үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд мөн иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх 92020606, 92120606 дугаарын утсыг 24 цагаар ажиллуулдаг<sup>263</sup> байна.

261 ЭХХШТХуулийн 9.6 дугаар зүйлийн 9.6.1-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг

262 ЭХХШТХуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.1.1-Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд

263 ЦЕГ, цахим сайт, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ш.Шинэбаярын ярилцлагаас дурдав. / <http://police.gov.mn/p/3791/>

Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс мэдээлж байгаагаар Цагдаагийн байгууллагаас 2018 онд гэрч хохирогчийг хамгаалах 51 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулснаас Урьдчилан сануулах 31, Тодорхой үйлдлийг хязгаарлах 3, Биечилсэн хамгаалалт 9, Мэдээллийн нууцлалыг хангах 1, Тусгай техник хэрэгслээр хангах 4, аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээ 3-ыг тус тус хэрэгжүүлж, шүүгч 1, прокурор 2, гэрч 6, хохирогч 39, хамаарал бүхий этгээд 17, нийт 65 иргэний аюулгүй байдлыг эрсдэлгүй хамгаалж ажилласан байна. Хамгаалалтад авагдсан 5, зөвлөгөө мэдээлэл авахыг хүссэн 2, нийт 7 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, 8 иргэнд хууль зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлж, сэтгэл зүйн хамгаалалтад 1 иргэнийг авч, хамгаалалтанд байгаа хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх ажлыг 2 удаа, хамгаалалтанд авагдсан иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг тухай бүр, хохирогчийг шүүх хуралдаанд оролцох үед сэтгэл зүйчийг байлцуулах арга хэмжээг 2 удаа тус тус хэрэгжүүлж ажилласан талаар мэдээлсэн байна<sup>264</sup>.

2019 онд Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8-д заасан чиг үүргийн хүрээнд Цагдаагийн байгууллагаас эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр 144 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж, 134 гэрч, хохирогч, иргэний амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалж ажилласан талаар мэдээлжээ. Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс цагдаагийн байгууллагын алба хаагчдаас гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 26 удаагийн 78 цагийн сургалтыг зохион байгуулж 938 алба хаагчийг хамруулсан байна<sup>265</sup>.

Мөн Цагдаагийн албанаас 2020 оны Нэгдүгээр улиралд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан 41 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж, 30 хүнийг хамгаалалтад авч, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна<sup>266</sup> хэмээн мэдээлсэн байна.

264 ЦЕГ, цахим сайтын мэдээлэл - <http://police.gov.mn/p/3783>

265 ЦЕГ, цахим сайтын мэдээлэл - <http://police.gov.mn/p/3802>

266 ЦЕГ, цахим сайтын мэдээлэл - <http://police.gov.mn/p/3812>



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 210 дугаар тогтоолын 2 дахь заалтад хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн хүрээнд хэрэгжүүлэх салбар дундын ажлын төлөвлөгөөг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад, салбар бүрт дэд ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгожээ. Улмаар Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын 2019-2020 оны салбар дундын ажлын төлөвлөгөөг баталжээ. Уг төлөвлөгөөнд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсронгуй болгох, эрүүл мэнд, сэтгэл зүйн нөхөн сэргээх урт хугацааны эмчилгээ, үйлчилгээний хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг 2020 оны I-IV улиралд хийх, хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам хариуцан ажиллахаар тусгасан байна<sup>267</sup>.

Тогтоолын дээрх заалтын хэрэгжилтийн тухай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүний сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг батлах субъектыг тодорхой болгохоор тусгасан байна. Энэ аргачлалд хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг тусгайлан зааж болно” гэжээ<sup>268</sup>.

Хууль зүй, дотоод хэргийн яам Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2019 оны 9 дүгээр сард өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандартыг бий болгох, тэдний суралцах хэрэгцээг хангах талаар төрөөс

267 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104 дэх тал.

268 Мөн тэнд, ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 104 дэх тал.

үзүүлэх тусламж үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг тусгасан тухай мэдээллийг ХЭҮК-д ирүүлсэн талаар Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэлд дурджээ.

Хүүхдэд гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх, тооцох аргачлалыг бий болгож, хохирлыг арилгах тал дээр Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Сэтгэл санааны хохирол тооцох журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална” гэж тусгаснаас өөрөөр гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлсэн эсэх талаар мэдээлэл байхгүй байна<sup>269</sup>.

Хууль зөрчсөн хүүхдийн талаар хүүхэд, насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэргийн сүүлийн 3 жилийн судалгаанд үндэслэн “Хүүхэд хамгаалагч” төслийг 2019 онд нийслэлийн 152 хороо, 21 аймгийн сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв болох 702.3 сая төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санхүүжүүлж, төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна<sup>270</sup>. Уг төслийн хүрээнд Улсын хэмжээнд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч болзошгүй эмзэг цэгүүдийн судалгааг гарган, “Хүүхэд хамгаалагч” эргүүлийн ажиллах цаг, чиглэлийг хороо, баг бүрээр тооцон, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсгийн байцаагч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд зөвлөмж, зааварчилгаа өгч, нийт 454 дунд сургуулийн 123,200 сурагч, 20,900 эцэг эх, 3,400 багш, ажилтнуудад мэдээлэл хүргүүлжээ. Хүүхэд хамгаалагч ажилтанд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах мэдлэг олгох 8 цагийн багц сургалтыг үе шаттай зохион байгуулж 40 нэгжийн 194 ажилтныг хамруулсан байна. Хүүхэд хамгаалагч эргүүл 2019 оны 5-12 дугаар сард давхардсан тоогоор 1,550 чиглэлд ажиллаж,

269 Дээр дурдсан бүтээл, 135 дах тал.

270 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 107 дох тал.



**Хэт бага наснаасаа ажил хийх, эсвэл бие бялдар, оюун санаа, нийгмийн болон боловсролын хөгжилд нь саад учруулж буй үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үздэг.**

150,259 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүчирхийлэлд өртсөн 12 хүүхдийн мэдээллийг хамтарсан багт мэдээлж, төөрсөн 79, цасан болон шороон шуурганы үеэр хараа хяналтгүй явсан бага насны 183 хүүхдийг гэрт нь хүргэн, хүүхэд шууд эрсдэж болзошгүй 128 тохиолдлоос урьдчилан сэргийлж, зөвшөөрөлгүй газар тамхи татсан, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан зэрэг 161 зөрчлийг таслан зогсоожээ. Мөн зөвшөөрөлгүй цахим тоглоомын үйл ажиллагаа явуулсан, гудамжинд архи дан согтуурсан зэрэг зөрчлийн 188 дуудлага, мэдээллийг хүргэж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлжээ<sup>271</sup>.

### Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Хэт бага наснаасаа ажил хийх, эсвэл бие бялдар, оюун санаа, нийгмийн болон боловсролын хөгжилд нь саад учруулж буй үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үздэг<sup>272</sup>.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн бүртгэл, судалгаа хомс мөн сүүлийн жилүүдэд хийгдээгүйн улмаас сүүлийн жилд хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн талаарх тоон судалгаа, мэдээлэл алга байна. Жишээлбэл, ҮСХ-ны Статистикийн мэдээллийн нэгдсэн санд хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн зөвхөн 2011, 2006, 2002 оны тоон мэдээллүүд байгаа юм<sup>273</sup>. Энэ нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тогтмол судалгаа хийдэггүй, нөхцөл байдлыг тогтоодоггүй болохыг харуулж байна. Хамгийн сүүлийн үед хийгдсэн нэгдсэн судалгаа болох “Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт”-ийн 2016 оны судалгаагаар Монгол Улсад 5-17 насны хүүхдийн 10 хувь буюу 56,000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь хөдөө аж ахуй (хурдны морь унаж уралдах зэрэг), уул уурхай, барилгын салбарт ажиллаж байна. Барилга, уул уурхайн салбарт аюултай ажлын байр нийтлэг байдаг бөгөөд энэ салбарт ажил эрхэлж буй 15-17

271 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 107-108 дах тал.

272 НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018-нэгдсэн тайлан, 228 дах тал.

273 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



насны хүүхдийн талаас илүү нь аюултай, хортой нөхцөлд ажиллаж байна. Хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт ядуу өрх олон байхын хэрээр хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь элбэг байна. Боловсрол дахь гендэрийн тэгш бус байдлын улмаас охидтой харьцуулахад хөвгүүд хөдөлмөр эрхлэх илүү эрсдэлтэй, харин охидын хувьд гэрийн ажил хийх нь их байдаг. Ажил олгогчид нь 18-аас доош насны ажилчдыг бүртгэлжүүлэх үүрэг хуулиар хүлээгээгүй тул хүүхдийн хөдөлмөрийн талаар мэдээлэл цуглуулах, хяналт-шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдаг<sup>274</sup> талаар дурджээ.

274 Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2016 он, 1 дэх тал. / [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_508366.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508366.pdf)



**Гэр бүлийн  
гишүүдийн  
зүгээс хүүхдийг  
хүчээр хөдөлмөр  
эрхлүүлж  
бэлгийн  
мөлжлөгт  
оруулахад  
хамсаатан болж  
байна.**

2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурдсанаар зарим хүүхэд хүчээр гуйлга гуйх, хулгай хийх болон хурдан морь унах, мал маллах, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга зэрэг эдийн засгийн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна. Зарим тохиолдолд гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг хүчээр хөдөлмөр эрхлүүлж бэлгийн мөлжлөгт оруулахад хамсаатан болж байна. Эцэг эхийнх нь гарын үсэг зурж байгуулсан гэрээний дагуу ажиллаж буй уран нугараач Монгол охидыг гол төлөв Монгол, Турк, мөн цөөн тоогоор Хонконг, Сингапурт албадан хөдөлмөр эрхлүүлж байна. Монгол хөвгүүд Хятад улсын хилийн боомт дээр хурдан морь унаач болон циркийн жүжигчнээр тодорхойгүй хугацаагаар ажиллаж, 6 сар тутам хүн дагуулж гэрт нь очуулах гэсэн нөхцөлтэйгөөр ажиллуулдаг нь хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд хүргэж байна<sup>275</sup>. Гэвч энэ талаар хийсэн хяналт, шалтгалт, судалгаа байхгүйн улмаас хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, албадан хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймааны хохирогч болж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах чадахгүй байх нөхцөл байдал бий болж байна. Тиймээс энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зайлшгүй шаардлагатай болоод байна. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөгийн хяналт, шалгалтыг улирал бүр тогтмол явуулж, зөрчлийг арилгах, гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагат мэдээлэх, хохирогч болсон хүүхдийн эрхийг сэргээх, хамгаалах шаардлагатай байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд 15 хүртэлх насны хүүхэд ажил эрхлэхийг зөвшөөрөхгүй<sup>276</sup>, 15 настай хүүхдүүд эцэг эх асран хамгаалагч болон төрийн байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр мэргэжлийн чиг баримжаа эзэмших, тодорхой чадвартай болох зорилгоор гэрээ байгуулан ажиллаж болох<sup>277</sup> ба 16 нас хүрсэн хүүхдүүд

275 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2019 оны 6-р сарын 20-ны өдөр, /<https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-trafficking-in-persons-report-mn/>

276 Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6- Энэ хуулийн 109.1, 109.3-т зааснаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно.

277 Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3- Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын

ямарваа нэгэн зөвшөөрөл шаардахгүйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болохоор<sup>278</sup> заажээ. Гэтэл Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд “Ажлын цагийг богиносгох”-той холбоотой харилцааг зохицуулахдаа тус зүйлийн 71.1-д<sup>279</sup> ажилтны насыг 14 наснаас эхэлсэн нь хуулийг нэг мөр ойлгоход хүндрэл учруулж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хууль нь хүүхдийн насны байдалд харгалзуулан ажлын цагийг хязгаарлаж илүү цагаар болон олон нийтийн баяр, амралтын өдрүүдэд ажиллахыг хориглосон байна. 2016 оны 2-р сард Хөдөлмөрийн сайд Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон Ажлын байрны жагсаалтыг А36 тоот тушаалаараа шинэчлэн баталжээ. Энэ тушаал нь албан ба албан бус хэвшлийн алинд нь ч хамаарах бөгөөд 18 нас хүрээгүй хүнийг тэдний амьдрал, эрүүл мэнд, зан суртахуун, аюулгүй байдал, хөгжилд сөрөг нөлөө бүхий ажлын байранд ажиллуулахыг хоригложээ. Мөн химийн бодис, шатах, дэлбэрэх бодис зэрэг тодорхой материалуудтай харьцаж ажиллахыг хориглосон бөгөөд (нас, хүйсээс хамааран) өргөж болох ачааны дээд хэмжээг тогтоон зарим нэг ажил хөдөлмөр эрхлэхийг бүрэн хоригложээ<sup>280</sup>.

Хүүхдийн хөдөлмөр нь богино хугацаанд өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг боловч хүний капиталын хуримтлалыг бууруулдаг тул урт хугацаанд ядууралд хүргэдэг хүчин зүйл юм. Сургууль завсардалт өндөр байгаа нь хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, ялангуяа орон нутагт түгээмэл байна. Хөдөө орон нутагт сургуулиас гадуур буй хүүхдийн тоо хот суурин газартай харьцуулахад хэд дахин өндөр. Хүүхдүүд ажиллахын зэрэгцээ сургуулиа орхихгүйг хичээж байгаа боловч хөдөлмөр эрхлэснээр гэртээ бие даан судлах, чөлөөт цагаа өнгөрүүлэх хугацаа бага болдог тул боловсролын чанарт сөргөөр нөлөөлдөг. Үүнээс гадна хөдөө аж ахуйгаас бусад салбарт хүүхдүүд мэдлэг

зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

278 Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1- 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.

279 Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1- 71.1.Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байна.

280 Дээр дурдсан бүтээл, Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2016 он, 2-3 дах тал. / [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/--ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_508366.pdf/](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/--ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508366.pdf/)

чадвар шаардахгүй ажил эрхэлдэг. Эдгээр ажил нь хүүхдийн мэдлэг, чадварыг хөгжүүлдэггүй, ирээдүйд олох орлогыг нь нэмэгдүүлдэггүй байна. Хүний капитал хөгжихгүй байх нь зөвхөн хувь хүн, өрхийн түвшинд нөлөөлөөд зогсохгүй, үндэсний хэмжээнд нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлнө. Мөн боловсролын салбар дахь жендэрийн тэгш бус байдалд хүүхдийн хөдөлмөр сөргөөр нөлөөлдөг байна<sup>281</sup>.

Харин хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тулгамдаж буй асуудал болдог Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэдэгт «Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай» Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэдэгт дараах ажлын төрлийг багтаана:

(а) боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа (б) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох; (в) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох; (г) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил<sup>282</sup> зэрэг багтдаг.

281 Дээр дурдсан бүтээл, Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2016 он, 5 дах тал. / [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_508366.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508366.pdf)

282 “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийн 2 дох тал. /<http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2015/06/21-huuhiin-hudulmuriin-tevchishgiu-helber.pdf>

Хөдөлмөрийн сайдын тушаалаар 2016 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-анд гар аргаар алт олборлох, өнгөт болон хагас үнэт чулуу олборлох болон бусад төрлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, уул уурхайн туслах үйл ажиллагаанд хүүхэд хөдөлмөр эрхлэхийг хориглосон. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны —Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам-д Бичил уурхай эрхлэгч этгээд нь 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх гэсэн заалтыг тусган хэрэгжүүлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 138, 182 дугаар конвенцийн заалтад нийцүүлэн насанд хүрээгүй ажилтны хөдөлмөрийн насыг суурь боловсрол эзэмших насанд уялдуулж, хөнгөн ажил эрхэлж болох насыг 13-15 нас болгож, урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд хүүхэд оролцуулахаар бол хүүхдийн эрхийн байцаагчаас тухай бүр зөвшөөрөл авах зохицуулалтыг оруулаа<sup>283</sup>.



283 UPR, Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын 3 дахь илтгэл /төсөл/, 2020, 19 дэх тал.

## Хурдан морины уралдаанч хүүхэд

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 2006 онд «Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг 2016 он гэхэд устгах дэлхийн үйл ажиллагааны хөтөлбөр»-ийг батлахдаа гишүүн орнуудын Засгийн газарт Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хугацаат хөтөлбөрийг ажил олгогч, ажилчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэхийг уриалсан<sup>284</sup> байдаг. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолоор «Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай» Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийн үзэл санааг үндэслэл болгон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, хязгаарлах, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг бүх салбарт эрчимжүүлэх замаар 2016 он гэхэд Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг бүрэн устгах зорилго бүхий үндэсний хөтөлбөрийг боловсруулсан нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад ахиц болсон хэдий ч бүрэн үр дүнд хүрч хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг өнөөг хүртэл устгаж чадаагүй байна. 2016 онд баталсан Хөдөлмөрийн сайд “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-анд<sup>285</sup> хамгийн сүүлд хийсэн нэмэлтээр жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаанд хүүхэд оролцохыг хоригложээ. Энэ нь цаг агаарын хувьд хамгийн аюултай цаг үе байдаг. Гэвч зун наадмын үеэр хамгийн доод тал нь 7 настай хүүхэд хурдан морь унаж уралдах боломжтой хэвээр байна<sup>286</sup>.

2018 онд Стандартын Үндэсний Зөвлөлөөс өмнөх MNS 6264:2011 стандартыг шинэчилж “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018

284 Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралт “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”./<https://www.legalinfo.mn/annex/details/2937?lawid=7722/>

285 <https://www.legalinfo.mn/annex/details/7183?lawid=11791>

286 Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2016 он, 3 дах тал. / [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_508366.pdf/](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508366.pdf/)



стандарт"-ыг баталжээ. Гэвч МХЕГ-ын 2017-2018 оны хяналт шалгалтын дүнгээс үзэхэд нийтдээ 121450 морийг 71121 хүүхэд унаж уралдсанаас 942 хүүхэд мориноос унаж, 22 хүүхэд хүнд гэмтэл авч, 1 хүүхэд тахир дутуу болсон гэсэн харамсалтай тоон мэдээ байна. 2018 оны наадмаар хамгаалалтын дуулгагүй 336, хамгаалах хувцас хэрэгсэлгүй 183, морины хэрэгсэлгүй 330, гурвалсан гэрээ байгуулаагүй 4771, даатгуулаагүй 1174 хүүхэд уралдаанд оролцуулсан зөрчил илэрсэн. Мөн 07 нас хүрээгүй 52 хүүхдийг уралдаанд оролцуулах гэж байсныг зогсоосон байна. 2018 оны дүн мэдээг 2017 онтой харьцуулахад мориноос унаж, амь нас нь эрсэдсэн тохиолдол байхгүй, мориноос унасан хүүхдийн тоо 282-аар, хөнгөн гэмтэл авсан хүүхдийн тоо 39-өөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн тоо буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь хүүхдийн хамгаалах хувцас хэрэгслийг болон морины хамгаалах хэрэгслэлийг стандартын дагуу зөв, бүрэн хэрэглэсэнтэй холбоотой гэж үзсэн<sup>287</sup> байна.

287 МХЕГ-ын мэдээ мэдээлэл, МХЕГ-ын Нийгмийн хамгааллын хэлтсийн дарга П.Хорлоогийн ярилцлагаас дурдав /<http://home.inspection.gov.mn/news/247/single/1831/>

2019 онд морь унаач хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд нийт 10,235 хүүхдийг биосканаар бүртгэж, “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандарт”-ын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласны үр дүнд 2019 онд 172 удаагийн уралдаан зохион байгуулагдсан нь өмнөх оныхоос 2.8 дахин буурсан үзүүлэлт бөгөөд мориноос унасан хүүхдийн тоо 213 тохиолдлоор буурч 448 болсон байна. Унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэхээр даатгалын компаниудтай хамтран ажиллаж, нөхөн олговрын хэмжээ 5 сая хүртэлх төгрөг байсныг 20 сая хүртэлх төгрөг болгон нэмэгдүүлжээ. 2018 онд хурдан морины уралдааны үед мориноос унаж бэртсэн 86 хүүхэд 49.5 сая төгрөг, 2019 онд 121 хүүхэд 186.6 сая төгрөгийг гэнэтийн ослын даатгалын нөхөн олговорт авсан байна<sup>288</sup>.

Засгийн газрын 2018 оны 19 дүгээр тогтоолд<sup>289</sup> хаврын тэргүүн сарын шинийн 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний хүртэлх хугацаанд хурдан морины хуралдаанд 12 хүртэлх насны хүүхдийг хурдан морь унуулахыг хориглосон байсан бөгөөд энэхүү заалт нь 12-оос дээш насны хүүхдээр хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр эрхлүүлэх нөхцлийг зөвшөөрч, өвөл, хаврын морины уралдааныг бүрэн хориглоогүй нь хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалахгүй байгаа явдал хэмээн томоохон шүүмжлэлд өртөж байсан.

Тиймээс Засгийн газар нь 2019 оны 57 дугаар тогтоолоор<sup>290</sup> өмнөх 2018 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” баталсан бөгөөд үүнд жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ

288 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 117 дох тал.

289 <https://www.legalinfo.mn/law/details/13178>

290 <https://www.legalinfo.mn/law/details/14014?lawid=14014>

зохион байгуулахыг хориглосон. 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс энэхүү судалгааг хийсэн үе болох 2020 оны 4 дүгээр сарын сүүл хүртэл ямар нэг хурдан морины уралдаан зохион байгуулагдаагүй байна. Мөн одоогийн байдлаар 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 4 сарын сүүл хүртэл хурдан морины уралдаан зохион байгуулагдаагүй байна. Энэ нь өвөл, хаврын улиралд зохион байгуулагддаг хурдан морины уралдааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирох эрсдэлтэй хүүхдүүдийн эрх, ашиг сонирхлыг төрийн зүгээс хамгаалсан шийдвэр юм. Эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа болон бэртэл гэмтэлд хийгдсэн дүн шинжилгээгээр хурдан морины уралдаанч хүүхдэд Толгой болон мөчдийн гэмтэл, Ясны хугаралт, Хөлдөлт, осголт, Амьсгалын замын өвчин, Дотор эрхтэний доргилт, өвчлөлт, Нүдний эвэрлэг бүрхүүлийн гэмтэл зэрэг бэртэл гэмтэл авдаг байна<sup>291</sup>. Холын замд уралдах үед бөөр нь доргилт ихээр авсанаас бөөр унжих, ууцаар хөшиж өвдөх, цустай шээс гарах болон шээс ойр ойрхон хүрэх, эсвэл тасалдах, турах, хоолны дуршил буурах, ядрах зэрэг шинж тэмдгүүд илрэхээс гадна яваандаа бөөрний унжилт их болж, шинж тэмдгүүд даамжран хүндэрч улмаар бөөрний бусад эмгэгүүд, бөөрний архаг үрэвсэл, бөөр чулуужих хүртлээ хүндэрдэг. Хөвгүүдийн хувьд морь унах явцад төмсөгөө гэмтээх улмаар насанд хүрсэн үедээ үргүйдэлд хүрэх эрсдэлтэй. Охидын хувьд эмээлгүй морь унах явцад онгон хальсаа гэмтээх аюултай байдаг<sup>292</sup>.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенц, Зөвлөмжийн хэрэгжилтийн шинжээчдийн хорооноос Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн шууд хүсэлтэд уралдааны морь унах нь хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд аюултай буюу осолтой гэдгийг дурьдаад, Монгол Улсын Засгийн газрыг 18-аас доош насны хүүхдүүдийг морь уралдаанчаар ажиллуулахгүй байх тал дээр анхааран дорвитой арга хэмжээ авахыг хүссэн байна. Мөн тус Хороо дээр дурьдсан

291 “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 12 дах тал.

292 Дээр дурдсан бүтээл, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 22 дах тал.

хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийг хангах тал дээр Засгийн газар тодорхой арга хэмжээ авч, хөдөлмөрийн байцаагч нараар гэнэтийн шалгалт хийлгэж, 18-аас доош насны хүүхдүүд тэдний эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөлд морь уралдаан хийхийг нь хязгаарлаж, хамгаалан ажиллахыг уламжилжээ<sup>293</sup>.

Хурдан морь унаж байгаа хүүхдүүд нь 6-16 насны буюу бие даан бусадтай хэлцэл хийж, өөрийгөө бүрэн төлөөлөх чадамжгүй насан дээрээ байгаа бөгөөд тэднийг морь унах сонирхол дээр нь үндэслэн түүний эцэг эх, уяач нар хоорондоо тохиролцож, морь унасан хөлсөнд өгөх мөнгийг нь амьжиргааны түвшингээр дунд болон түүнээс доогуур орлоготой эцэг, эх нь авч амьжиргаагаа залгуулдаг. Харин хүүхдэд оногдох шан харамж нь ойр зуур чихэр, ундаа, хуушуур, бүр ихэдлээ гэхэд хичээлийн хувцас, хэрэгслээр нэг удааг хангах төдийхнөөр хэмжигдэж байгаа юм. Энэ нь хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж байгаа хэлбэр мөн<sup>294</sup>.

Уралдааны зохион байгуулалт сул, харилцан адилгүй байдаг нь уралдааны гараа болон уралдах явцад хүүхэд унаж бэртэн эрүүл мэндээр хохирох нөхцлийг бүрдүүлдэг. Гарааны төхөөрөмжийн нэгдсэн стандартгүй, аймаг сум тус бүр янз бүрийн байдлаар хийсэн гарааны төхөөрөмжтэй, төхөөрөмжийг ажиллуулах хүмүүсийг сайн дадлагажуулдаггүй зэрэг нь гараан дээр хүүхэд мориноос унах эрсдлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн, уралдааны зам зориулалтын бус, стандарт байхгүй, уралдааны зам хөлдөлттэй зэрэг нь уралдааны явцад морь халтирах, хүүхэд унах эрсдлийг бий болгож байна. Уралдааныг олон тооны машин дагалдах явдал нь маш их тоос босгож, үзэгдэх орчин хязгаарлагдан уралдаанч хүүхэд замын нөхцөл байдлаа харж морио удирдах боломжгүй болох, амьсгалын замаар үүсэх өвчинд нэрвэгдэх суурийг тавих, мөн тэрчилэн уралдаанч хүүхэд авто осолд орох өндөр магадлалыг бий болгож байна<sup>295</sup>.

293 Дээр дурдсан бүтээл, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 7 дах тал.

294 Дээр дурдсан бүтээл, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 32 дах тал.

295 Дээр дурдсан бүтээл, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 20 дах тал.

Хурдан морины уралдаанч хүүхэд эрүүл мэндээрээ хохироход уяач, эцэг эх нар хоорондоо тохиролцоод эмчилгээний зардлыг төлөх төдийгөөр өнгөрөх, амь насаа алдсан тохиолдолд хариуцлага хүлээх болон хүлээлгэх эзэнгүй, хэн нэгэн буруутай этгээдийг тогтоож хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил болж байна<sup>296</sup>.

### Хараа хяналтгүй, тэнэмэл хүүхэд

Улсын хэмжээнд тэнэмэл, хараа хяналтгүй байж болзошгүй 151 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд орон гэргүй 10 гэр бүлийг шинээр судалгаанд хамруулан, тэдгээр эрхийн 19 хүүхдийг нэг цэгийн үйлчилгээнд холбон зуучилж, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд 7 хоногоос 1 сарын хугацаатай байрлуулан сэтгэл зүй, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж, архины хамааралтай эцэг эхэд 48 цагийн сургалт зохион байгуулсан байна. Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, аймаг, дүүрэг дэх Цагдаагийн газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, бусад байгууллагууд хамтран улсын хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хараа хяналтгүй болон хараа хяналт сул, хөдөлмөр эрхэлдэг, гуйлга гуйдаг, хог түүдэг, тэнэмэл хүүхдүүд байж болох газар, цэгүүдэд хяналт шалгалт хийх, илэрсэн хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, зөрчил илэрсэн газруудад хариуцлага тооцох зорилгоор “Илрүүлэлт-2019” нэгдсэн арга хэмжээ, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852-2017 стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт 95 арга хэмжээ зохион байгуулсан байна. Арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүй байж болзошгүй 188, хараа хяналт сул 274, хөдөлмөр эрхлэгч 106, гар дээрээс худалдаа эрхэлдэг 16, гуйлга гуйдаг 20, орон гэргүй, тэнэмэл 11, нийт 623 хүүхдийг олж тогтоон, бүртгэлд оруулсны 457 нь эрэгтэй, 166 нь эмэгтэй байх бөгөөд 7 хүртэл насны 48, 8-13 насны 180, 14-17 насны 261 хүүхэд байна. Эдгээр хүүхдээс Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн

296 Дээр дурдсан бүтээл, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, 14 дах тал

тусгай цогцолборт 3, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст 62, эцэг эх, асран хамгаалагчид 296, Хүүхдийн тусламжийн утас- 108 төвийн дэргэдэх түр хамгаалах байранд 53, хамтарсан багийн хяналтад 2 хүүхдийг тус тус хүлээлгэн өгч, хамгаалан байршуулж, хариу үйлчилгээ үзүүлжээ. Тус арга хэмжээний хүрээнд Зөрчлийн тухай хуулиар насанд хүрээгүй хүнд цаг хэтрүүлэн үйлчилж байсан цахим тоглоомын 3 газарт тус бүр 350,000 төгрөг, хүүхдээ үл хайхарсан 5 эцэг, эхэд нийт 1,290,000 төгрөгийн торгууль тус тус ногдуулжээ<sup>297</sup>.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга нар Сонгинохайрхан дүүргийн Улаан чулуутын хогийн цэг, Нарантуул худалдааны төвд ажилладаг зорилтот бүлгийн хүүхдийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, улмаар «Зорилтот бүлгийн хүүхдийн эрхийг хамгаалах тухай» 2019 оны А/343, А/1207 хамтарсан тушаал, захирамж баталж, хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдийн эрхийг хамгаалах ажлыг нийслэлийн хэмжээнд улирал тутам зохион байгуулж, тэдний эрхийг хамгаалах, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулжээ. Цаашид хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн санг бий болгож, салбар бүрийн уялдаа холбоог хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Учир нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн мэдээлэлд “Илрүүлэлт-2019” арга хэмжээний хүрээнд илэрсэн хараа хяналтгүй хүүхдийн тоо зөрүүтэй, мэдээлэлд дурдсан үйл ажиллагааны ангилал өөр байгаагаас нэгдсэн мэдээллийг гаргахад хүндрэлтэй байв<sup>298</sup>.

297 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 113 дах тал.

298 Дээр дурдсан бүтээл, 114 дэх тал.



## Дэд хэсгийн дүгнэлт

Хүүхдийн эсрэг болон хүүхэд үйлдсэн гэмт хэргийн гаралт өмнөх онуудаас өссөн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт их байгааг харуулж байна. Тиймээс холбогдох асуудлаар ажиллах бүтцийг бэхжүүлэх, одоогийн ажиллаж байгаа тогтолцоо болох хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс зэрэг албан тушаалтнууд нь үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, боловсон хүчний тоог нэмэх, зорилтот хүүхэд бүрт хүрч ажиллах шаардлагатай байна. Мөн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тогтмол судалгаа хийх, цаг үеийн байдлыг үнэлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг анхаарах асуудал дутагдаж байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Хууль зөрчсөн хүүхэд, гэрч, хохирогч хүүхэд, хараа хяналтгүй хүүхэд, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг зорилтот бүлгийн хүүхдүүдийг үргэлжүүлэн анхаарах, зөв үлгэр дуурайлал, амьдралын зөв дадал, нийгэмд бие даан амьдрахад нь үр дүнтэй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа учраас энэ хүрээнд сайн туршлага нэвтрүүлэх, боловсролын болон төрийн идэвхтэй ажил олголтын бодлогоор дэмжих шаардлагатай байна.

## Гэр бүлийн орчин хүүхэд хамгаалал

Монгол Улсад 2019 оны байдлаар 897,850 өрх бүртгэгдсэн<sup>299</sup>. Үүний 291,085 буюу 32,4% нь орон нутагт, 606,765 буюу 67,6% нь хотод байгаа өрх байна. Энэ тоо 2018 онд 894496 байсан ба нэг өрхөд 3,5-6 хүн ногдож, нийт өрхийн 33% нь орон нутагт, 67% нь хотод, 54.4%-ийг шилжин суурьшсан өрх эзэлж байжээ.<sup>300</sup>

299 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

300 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл, 2018



**Хүснэгт 22.** Өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр

Байршил	2017	2018	2019
Хот	584520	590371	606765
Аймаг	301119	304125	291085
Нийт	885639	894496	897850

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

**Хүснэгт 23.** Өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр шилжилт хөдөлгөөний өсөлт/бууралт

Байршил	2017 Өсөлт/ бууралт	2018 Өсөлт/ бууралт	2019 Өсөлт/ бууралт
Хот	2761	5851	16394
Аймаг	13029	3006	-13040

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Монгол Улсад жил бүр 20500 орчим хос гэрлэлтээ бүртгүүлж байгаа ч 4000 орчим нь гэрлэлтээ цуцлуулж байгаа ба 2018 онд нийт 4201 гэр бүл цуцлалт бүртгэгдсэний 2528 нь буюу 60,2% нь хотод, 1673 нь буюу 39,8% нь орон нутагт байсан байна. Харин 2019 онд нийт 4262 гэр бүл цуцлалт бүртгэгдсэний 2713 нь буюу 63,7% нь хотод, 1549 нь буюу 36,3% нь орон нутагт байсан байна<sup>301</sup>. Энэ нь 2019 оны гэр бүл цуцлалт нь өмнөх 2018 оноос 61-ээр өссөн байна. Үүнээс үүдэлтэй нийлмэл гэр бүл, өрөөсгөл гэр бүл, өрх толгойлсон хүүхэд, эх, эцэг нэмэгдэх хандлагатай байна. Гэрлэлтээ цуцлуулагчид салалтын шалтгаанаа итгэл алдарсан (54%), санхүүгийн бэрхшээл (47.3%), гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг (41.3%) гэжээ.<sup>302</sup> Мөн гэр бүлийн боловсрол хангалтгүй, архидалт, гадаад болон дотоодод гэр бүлээсээ хол удаан хугацаагаар ажиллах зэрэг асуудал хамаарч байна.

Гэрлэлт цуцлалтын шалтгаанд хөдөлмөр эрхлэлт, санхүүтэй холбоотой шалтгаанаас гадна үзэл бодлын зөрчил, үл ойлголцол, хардалт зэрэг гэр бүлийн гишүүдийн хэвийн бус харилцаанаас үүдэлтэй шалтгаан орж байгаа нь иргэдэд

301 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

302 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл, 2018; Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, 2019

гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн харилцааны нарийн төвөгтэй асуудлыг шийдэхэд төрийн оновчтой зохицуулалтыг хийж, үйлчилгээг гэр бүлд хүргэх шаардлага байгааг харуулж байна.<sup>303</sup>

**Хүснэгт 24.** Гэрлэлт, цуцлалтын тоо

Гэр бүлийн байдал	2017	2018	2019
Гэрлэлт	20470	21020	20043
Цуцлалт	3945	4201	4262

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Гэрлэлт, цуцлалтын тоо

2019 оны 1-р улирлын байдлаар Гэр бүлийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн хэрэг нийт иргэний хэргийн 9.1 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн 877 хэргээс 61.5 хувь нь гэрлэлт цуцалсан, 25.9 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулсан хэрэг байна. Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо 596 байгаа ба сүүлийн жилүүдэд шүүхийн журмаар хүүхдийн тэтгэлэг тогтоолгох үзүүлэлт тогтмол нэмэгдэж байна.<sup>304</sup>

**Хүснэгт 25.** Монгол Улсад оршин суугаа хүүхдийн тоо, насны бүлгээр

Насны бүлэг	2017	2018	2019
0-4	380,751	380,751	383,557
5-9	335,472	355,993	367,100
10-14	230,263	250,032	273,230
15-19	232,063	224,539	216,153
нийт 0-18	1,178,549	1,211,315	1,240,040

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

“Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 онд “Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар” судалгааг Дэлхийн зөн Монгол ОУБ, Нийгмийн бодлогын судалгааны хүрээлэн ТББ-тай хамтран хийсэн.

303 Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай <http://www.mls.gov.mn/nnews/478>

304 Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан-2019 [https://drive.google.com/file/d/1vcgQDKYh3Bo-RNHJdWM3r91Izcybsf/\\_view](https://drive.google.com/file/d/1vcgQDKYh3Bo-RNHJdWM3r91Izcybsf/_view)



Судалгаанд нийт 42970 гэр бүл хамрагдсан бөгөөд 3000 гэр бүлийн мэдээллийг ашигласан. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн хэв маягаар нь авч үзвэл дан гэр бүл 42.8 хувь, нийлмэл гэр бүл 24.4 хувь, олон хүүхэдтэй гэр бүл 17.9 хувь, өрөөсгөл гэр бүл 7.2 хувь, ганц бие гэр бүл 2.2 хувь, хамтран амьдрагч гэр бүл 4.3 хувь, хүүхэдгүй гэр бүл 1.2 хувь байсан бол гэр бүлийн насны бүтцийн хувьд залуу гэр бүл 35.6 хувь, дунд насны гэр бүл 51.1 хувь, ахмад насны гэр бүл 13.3 хувь тус тус эзэлж байна.<sup>305</sup>

Дотоод хэргийн их сургуулийн, Цагдаагийн сургуулийн багш нар “Нээлттэй Нийгэм Форум” ТББ-тай хамтран хийсэн “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгаанаас үзэхэд, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, төрсөн хүүхдээ алсан тохиолдол 42.2 хувийг тус тус эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 15 хувь, төрөл, садангийн хүний

<sup>305</sup> Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар онд “Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар” судалгааны дүнгээс

хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг тус тус эзэлж байна.<sup>306</sup>

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна.<sup>307</sup> Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн профессор, багш нарын багийн хамтран 2019 онд гүйцэтгэсэн “Бага насны хүүхдийг хүчиндэх, алах гэмт хэргийн судалгаа”-аас үзэхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 16 буюу хохирогч зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад 2019 онд хандсан нийт иргэдийн 23,5 хувьтай байгаа анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь хохирогчдын 40.4 дарамтад өртсөн, 20.3 хувь хууртагдсан, 17 хувь гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон /ээж, дүү/, 19.1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй зэрэг байна. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотнын хүндээ шууд мэдэгддэг болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.<sup>308</sup> Эдгээр төрлийн гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт

<sup>306</sup> С.Гантулга: Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх шалтгаан болж байна. УБ, 2020 <http://www.zaluucom.mn/read/488c3f35c?fbclid=IwAR1nrVBoGCfpfaSHTGhRuS263yjUjUYLmmZ2TkXsW0e5OKT3E9CwrWfeMc>

<sup>307</sup> Мөн тэнд

<sup>308</sup> С.Гантулга: Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх шалтгаан болж байна. УБ, 2020 <http://www.zaluucom.mn/read/488c3f35c?fbclid=IwAR1nrVBoGCfpfaSHTGhRuS263yjUjUYLmmZ2TkXsW0e5OKT3E9CwrWfeMc>



хэргийн 38.2 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувь нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.<sup>309</sup>

Гэр бүлийн асуудал нь хувийн шинжтэй боловч нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийг төрөөс дэмжих, хамгаалах, иргэдэд гэр бүлийн боловсрол нэгдсэн зохицуулалтаар олгох, төрийн үйлчилгээг гэр бүлд оновчтой хүргэх гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагыг тогтвортой ажиллуулах, гэр бүл харилцаанд оролцогчдын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, хариуцлагажуулах, гэр бүл дэх хүүхдийн эрхийг хангах, хүүхэд үрчлэлт, асран хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох, гадаадын харьяат гэр бүлд монгол хүүхэд үрчлэх, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд оролцсон гэр бүлийн харилцааны асуудлыг хуулиар зохицуулах шаардлага байна.<sup>310</sup>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран “MNB гэр бүл” телевизийн шинэ сувгийг нээн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих, тэдэнд нэн шаардлагатай боловсрол, эрүүл мэнд, танин мэдэхүй, түүх уламжлал, соёл ёс заншил, хууль эрх зүй зэрэг бүхий л мэдээллийг дагнасан нэг сувгаар өгөх том төслийг хамтран хэрэгжүүлэхээр эхлүүлж буй юм.<sup>311</sup> Энэ нь гэр бүлийн боловсролыг нэгдсэн зохицуулалтаар олгох, өнгөрсөн жилүүдийн гашуун сургамжуудыг зассан үр дүнг харуулахыг л хүлээх үлдлээ.

<sup>309</sup> Мөн тэнд

<sup>310</sup> Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай <http://www.mlsp.gov.mn/nnews/478>

<sup>311</sup> Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Хүүхэд, гэр бүлд зориулсан телевизийн тусгай суваг удахгүй нээгдэнэ <http://www.mlsp.gov.mn/nnews/708>



**Хүүхдээ хаана, хэнтэй, юу хийж явааг, хүүхдээ юунд дуртай, дургүйг нь мэдэхгүй байгаа нь хүчирхийллийн нэг хэлбэр.**

Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2020 онд “Архидалтгүй Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү ажлын хүрээнд ахуйн хүрээний архидалт бусад байдлаар архидан согтуурч буй нөхцөл байдалд чиглэсэн арга хэмжээнүүдийг авах юм. Ингэснээр хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа хамгийн том асуудлыг шийднэ. Учир нь хүүхдийн эрхийн хамгийн том зөрчил архидан согтуурахтай холбоотой.<sup>312</sup> Мөн эцэг эхийн үүрэг, хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллаж байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг иргэд өнгөц ойлгодог. Хүүхдийн зүгээс маш хүндээр хүлээж авдаг асуудлуудад өөрийнхөө байр суурьнаас энгийн л нэг үзэгдэл мэт ханддаг. Хүүхэд хамгааллын хуульд, дөрвөн төрлийн хүчирхийллийг заасан байна. Тодруулбал, бэлгийн, бие махбодын, сэтгэл санааны, үл хайхрах хүчирхийлэл. Үүнээс үл хайхрах хүчирхийллийг бараг хүн бүр үйлддэг. Хүүхдээ хаана, хэнтэй, юу хийж явааг, хүүхдээ юунд дуртай, дургүйг нь мэдэхгүй байгаа нь хүчирхийллийн нэг хэлбэр.<sup>313</sup>

.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйл /Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүрэг/-ийн 25.2-т “Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно” хэмээх заалтын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/301дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг шинээр байгуулсан. Уг хэлтэс нь одоогоор дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Хэлтэс байгуулагдсанаар гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэг дээшлэх, гэмт хэргийн далд байдал үгүй болох, иргэд хүчирхийллээс өөрийгөө болоод хайртай хүмүүсээ хамгаалах боломжтой болох юм.<sup>314</sup>

312 Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Н.Мандуултай ярилцлаа. <https://montsame.mn/en/read/216311>

313 Мөн тэнд


314 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга, Цагдаагийн хошууч Э.Баярбаясгалангийн ярилцлага <http://police.gov.mn/a/5012>



Улсын хэмжээнд 2020 оны эхний хоёр сарын байдлаар хүчирхийллийн 170 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 45.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<sup>315</sup> Гэвч хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн мэдээлэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 34.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. “Ковид-19” халдварын үед сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаанд зогсоож, тодорхой хэмжээнд хүмүүс хөл хорионд байна. Хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагад дүгнэлт хийхэд ахуйн хүрээний архидалтаас үүдэлтэй гэр бүлийн орчин дахь хүчирхийлэл нэмэгдсэн, мөн хүүхдээ үл хайхарсан, хараа хяналтгүй байлгах, өдрийн цагаар ажилтай гээд хүүхдээ орхчихож байна. Цагдаагийн байгууллагаас ахуйн хүрээнд архидах явдал ихэссэн талаар мөн мэдээлсэн байна.<sup>316</sup>

315 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга, Цагдаагийн хошууч Э.Баярбаясгалангийн ярилцлага <http://police.gov.mn/a/5012>

316 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Азжаргалын ярилцлага



Жил бүрийн 4-р сарын 30-ны өдөр бол “хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр тохиодог. Энэ өдөр дэлхийн улс орнууд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”-уудыг эрэлхийлэхийг уриалдаг бөгөөд олон улсад 22, Монгол Улсад 16 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүлж байна. Тодруулбал, 1998 онд энэ өдрийг анх АНУ-д санаачилж, улмаар 2001 оноос бусад улс орнууд нэгдэж, дэлхий нийтээрээ тэмдэглэдэг болжээ. Харин Монгол Улсад Японы Хүүхдийг ивээх сангаас санаачлан 2006 оноос энэ өдрийг анх олон нийтэд таниулсан. Улмаар 2018 оноос Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх аяныг өрнүүлж өдгөө 3 дахь жилдээ үндэсний хэмжээнд зохион байгуулж байна.<sup>317</sup>

Хэдийгээр манай улс хүүхдийг зодож шийтгэхгүй байх олон улсын өдрийг 2006 оноос тэмдэглэж ирсэн ч хүүхдийн эсрэг

317 ГБХЗХГ, Хүүхдийн хөгжил, хамгааллын газар <http://www.fcy.gov.mn/news/136>



**2020 оны нэгдүгээр улирлын байдлаар 108 утасны үйлчилгээний төв нийтдээ 27.050 дуудлага мэдээлэл хүлээн авчээ.**

хүчирхийллийн тоо буурахгүй байна. Хамгийн сүүлийн үеийн буюу Ковид-19 вирусээс болж хөл хорио тогтоосон энэ үед гэр бүлийн хүчрхийлэл тэр дундаа хүүхдэд хүчирхийлэлд өртлөө гэсэн дуудлагын тоо нэмэгдсээр байна.<sup>318</sup>

Зөвхөн 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв л гэхэд нийтдээ 27.050 дуудлага мэдээлэл хүлээн авчээ.<sup>319</sup> Үүнээс:

1. Хүүхэд хамгааллын дуудлага 4456
2. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлага 157
3. Зөвлөгөө хүссэн дуудлага 1283
4. Мэдээлэл, лавлагаа хүссэн дуудлага 8177
5. Зорилтот бус дуудлага 241 (хаяг байршил, утасны лавлагаа, үзвэр үйлчилгээ, бусад) тус тус ирсэн байна.

Хүүхэд хамгааллын 4456 дуудлагаас хүүхдийн эрх зөрчигдсөн, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 1326 дуудлага буюу хэргийн тохиолдолд хувийн хэрэг нээж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж өнөөдрийн байдлаар 252 хэргийн тохиолдлыг амжилттай шийдвэрлэжээ. Үлдсэн 1074 хэргийн тохиолдолд хяналт тавин үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэж байна. Мөн 2020 оны нэгдүгээрдүгээр улирлын тоон мэдээллийг 2019 оны нэгдүгээр улирлын тоон мэдээлэлтэй харьцуулахад нийт дуудлагын тоо 25.8 хувиар буурсан ч хэргийн тохиолдлын тоо 13,8 хувиар, хяналтанд байгаа хэргийн тохиолдлын тоо 38.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<sup>320</sup>

318 Мөн тэнд <http://www.fcy.gov.mn/news/136>

319 Мөн тэнд <http://www.fcy.gov.mn/news/136>

320 Мөн тэнд <http://www.fcy.gov.mn/news/136>

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлийн орчин

Хөгжлийн бэрхшээл ямар ч гэр бүлд тохиолдож болох ч ядуурал болон хөгжлийн бэрхшээл хоорондоо хүчтэй харилцан холбоотой байдаг ажээ. Ядуурал нь хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг нэмэгдүүлж болохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлээс үүсэх үр дагавар ч болж болно. Ядуу амьдралтай жирэмсэн эмэгтэй эрүүл мэндийн доройтол, хоол тэжээлийн дутагдал, хортой бодисын нөлөө, орчны бохирдолтод өртөх магадлалтай бөгөөд энэ нь ургийн хөгжилд шууд нөлөөлнө. Ядуу амьдралтай хүүхдүүд олон янзын эрсдэлд өртөж байдаг тул нийгэм, эдийн засгийн илүү таатай нөхцөлд байгаа үе тэнгийнхнийгээ бодвол хөгжлийн хоцрогдолтой болох эрсдэл нь өндөр байдаг. Тэд хоол тэжээлийн дутагдалд орох, ариун цэвэр, эрүүл ахуйн таагүй нөхцөлд амьдрах, халдвар авах, өвчлөх нөхцөл үүсэх, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх, орон сууцны нөхцөл муу, зарим нь орон гэргүй, асрамж, арчилгаа дутагдах, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхралтад өртөх, сэтгэл санааны хямрал, дарамтын улмаас ээж нь хангалттай анхаарал халамж тавьж чадахгүй байх, асрамжийн газар өсөх, хөгжлийг нь дэмжиж өдөөх сэдэл, орчин дутагдах зэрэг эрсдэлд өртөж байдаг. Мөн бусадтай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлд нийгэм, эдийн засгийн хүндрэл, бэрхшээл тулгарах нь элбэг. Хөгжлийн бэрхшээл бол өрхийн түвшний ядуурлыг даамжруулах магадлалтай хүчин зүйл юм. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд асаргаа халамж үзүүлэхийн тулд эцэг эх нь орлого олоход зарцуулах цагаа багасгах, ах эгч, дүүг нь сургуулиас гаргах шаардлага тулгарч мэдэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлийн улмаас үүсэх эрүүл мэнд, тээврийн зэрэг нэмэлт зардлыг гэр бүл өөрөө зохицуулах шаардлагатай болдог.<sup>321</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийн амьжиргаа бусдаас доогуур байх хандлага хөгжиж буй орнуудад

<sup>321</sup> Нээлттэй нийгэм форум. Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл асуудал дэвшүүлсэн тайлан. [https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028\\_mon.pdf?sequence=9&isAllowed=y](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y)

нийтлэг ажиглагдаж байгааг судалгааны байгууллагууд зарлах боллоо. Энэ утгаараа ядуурал, өлсгөлөнг тэглэх, хүн бүрийг зохистой ажил хөдөлмөр эрхэлж, амьжиргааны эх үүсвэртэй байх боломжоор хангах, эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, бүх нийтийг бичиг үсэг, боловсролтой болгох зэрэг нь Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудалтай салшгүй холбоотой юм.<sup>322</sup>

## Эцэг, эхийн эрх хасах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд хүний эцэг, эх байх эрхийг дараах тохиолдолд хасахаар зохицуулсан. Үүнд:

1. Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан,
2. Бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан,
3. Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээ санаатайгаар зайлсхийсэн,
4. Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүн.

Эцэг, эх байх эрх хасуулах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага тухайн эцэг, эхийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй.

Шүүх эцэг, эх байх эрх хассан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад явуулна.<sup>323</sup>

<sup>322</sup> УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Конгрессын зохион байгуулах үндэсний хорооны дарга С.Чинзориг “Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын санаачилга, туршлага, сургамж” илтгэл

<sup>323</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

ГБХЗХГ-ын мэдээлснээр улсын хэмжээнд 2019 оны 11-р сарын байдлаар 1,067 хүүхэд 31 асрамжийн газар амьдарч байв. Энэ тоонд хүчирхийлэлд өртсөн болон өнчин хүүхдүүдийн аль алиныг багтаасан байх байдаг ба ГБХЗХГ уг мэдээллийг дотор нь ангилдаггүй.<sup>324</sup>

### Хүүхэд үрчлэлт

Монгол Улсын хэмжээнд жилдээ 1500-1600 орчим хүүхэд дотоодод үрчлэгддэг. Дотоодын үрчлэлийн асуудал дээр хяналт тавих талаар Гэр бүлийн тухай хуульд одоогоор тусгагдаагүй байгаа бөгөөд шинэчилсэн найруулгын төсөлд дотоод үрчлэлийг олон улсын зарчим, стандартад нийцүүлэх асуудлыг тусгаж байгаа нь сайшаалтай байна.<sup>325</sup>

Харин “Гадаад үрчлэл”-ийн асуудал олон улсын гэрээ конвенцын дагуу явдаг. 1993 онд батлагдсан «Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” Гаагийн конвенцид манай улс 1999 онд нэгдэн орсон. Энэ дагуу гадаад үрчлэлийн асуудал Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулинд туссан 1999 оноос гадаад үрчлэлийн асуудал явагдаж эхэлсэн. 2000 онд анхны хүүхэд гадаадад үрчлэгдсэн. Үүнээс хойш 2019 оны байдлаар 17 улсад 270 хүүхэд гадаадын улс оронд үрчлэгдсэн.<sup>326</sup>

#### Хүснэгт 26. ҮРЧЛҮҮЛСЭН ХҮҮХДИЙН ТОО, насны бүлгээр

Насны бүлэг	2018	2019
3 нас хүртэл	704	819
3-6	402	349
7-9	142	163
10 ба түүнээс дээш	301	336

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Үрчлэлийн зөвлөлийн журмын дагуу хүүхдийн эзэнэгшин дасалт, өсөлт хөгжлийн тайланг заавал ирүүлж байх ёстой.

324 МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ХҮНИЙ ЭРХИЙН ТАЙЛАН <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-human-rights-report/>

325 Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл-2019 <http://forum.parliament.mn/projects/561>

326 Хүүхэд үрчлэлийн асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээ 2019 <http://eagle.mn/r/65526>



2019 оны байдлаар 17 улсад 270 хүүхэд гадаадын улс оронд үрчлэгдсэн.

0-3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл 2 жил тутамд тайлан мэдээллийг тухайн гэр бүл болон эрх бүхий итгэмжлэл авсан байгууллагаараа дамжуулж ХНХЯ болон ГИХГ ирүүлдэг. 2019 оны байдлаар Монгол Улсаас үрчлэгдсэн хүүхдүүдэд хүүхдийн эрхийн зөрчил, элдэв гэр бүлийн зөрчилтэй холбоотой мэдээлэл, тайлан ирээгүй. Тайлан мэдээллээр тухайн гэр бүлүүд үрчилж авсан хүүхдүүд нь яаж хөгжиж, хэрхэн уралдаан тэмцээнд оролцон амжилт гаргасан, гэр бүлийн аяллаар хэрхэн явсан талаар зурагтай тайлан мэдээллүүдээ хугацаанд нь ирүүлдэг. Журмын дагуу гадаадад суугаа монголын дипломат төлөөлөгчийн газар тухайн улсад үрчлэгдсэн хүүхдийнхээ нөхцөл байдалд хяналт тавих үүрэгтэй. Үрчилсэн талаас гэрээний дагуу үрчилсэн хүүхдийнхээ эцэг эх, төрсөн эх орных нь талаар мэдүүлэх үүрэг хүлээсэн байдаг.<sup>327</sup>

### Асрамж халамжийн үйлчилгээ

Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг Хүүхдийн халамж асрамжийн 17 байгууллагын 28 төвд 864 хүүхэд амьдарч байна.<sup>328</sup>

#### Хүснэгт 27. Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдийн тоо

	Бүтэн өнчин хүүхдийн тоо		Хагас өнчин хүүхдийн тоо	
	2018	2019	2018	2019
Он	2018	2019	2018	2019
Улсын дүн	3122	3116	33322	33254
Улаанбаатар	1399	1424	11676	11670

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд

327 Хүүхэд үрчлэлийн асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа <http://eagle.mn/r/65526>

328 НХГБХГ-ын мэдээ 2020 <http://child.gov.mn/?p=35578>



ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчилнэ.<sup>329</sup>

А. Энэхүү хөнгөлөлтөд хөдөө орон нутгаас аймаг, нийслэлд ирж суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч тус бүрт ирж очих унааны зардлыг жилд нэг удаа орон нутгийн нийтийн тээврийн тарифт үнээр олгоно.

Б. Нийслэл болон аймгийн төвд СӨБ-ын байгууллага, ЕБС, МСҮТ, их дээд сургууль, коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургуульд нь хүргэж өгч авч байгаа иргэнд Засгын газраас тогтоосон хэмжээний мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно.

Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно.<sup>330</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгоно.<sup>331</sup>

**Хүснэгт 28.** Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг гэрээт байгууллагууд

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг гэрээт байгууллагууд		
1	Батгэрэлт ирээдүй ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн төв
2	Ачлалт хүүхдүүд ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн төв

Эх сурвалж: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар

329 Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын цахим хуудас <http://hudulmur-halamj.gov.mn/content/62>

330 Мөн тэнд

331 Мөн тэнд

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу дараах тусламж, хөнгөлөлтийг эдлэх эрхтэй.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан 9 төрлийн үйлчилгээний хамрагдах зорилтот бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байна.

### Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд харж хандах хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулан байршуулж, хооллон, асаргаа сувилгаа, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна.



## Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Дараах 3 төрлийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг. Үүнд:

1. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ / нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэн/
2. Боловсролыг дэмжих үйлчилгээ /сурах бичгийг үнэ төлбөргүй олгох/
3. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ /Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах/

Хөнгөлөлт, тусламж

- 1/ байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;
- 2/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;
- 3/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;
- 4/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын

сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;<sup>332</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн оролцоо, түншлэлд өөрсдийн эрх ашгийн төлөөх төрийн бус байгууллагаараа дамжуулан оролцох боломж нь илүү нээлттэй үр дүнтэйг олон улсын болон гадаад орнууд, дотоодын байгууллагуудын туршлага, үйл ажиллагаа харуулж байна. 2018 оны байдлаар манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр 600 гаруй төрийн бус байгууллага бүртгэлтэй байна. Энэ нь нэг талаас, хөгжлийн төлөөх түншлэл, хамтын ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд хэрхэн бэлтгэж байгааг харуулна. Нөгөө талаас энэ их хүчийг бид хэрхэн зөв ашиглаж өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулахыг шаардаж байна.<sup>333</sup>

Засгийн газрын ээлжит хуралдаан 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулахаар тогтоол баталсан байна. Шинэ агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт, салбар дундын зохицуулалтыг хангах, тэдгээр иргэний хөгжил, нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжих, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх, тэдний талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэхээр төлөвлөсөн байна.<sup>334</sup>

332 ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагаа [file:///C:/Users/User/Downloads/Documents/20180514\\_02.pdf](file:///C:/Users/User/Downloads/Documents/20180514_02.pdf)

333 ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд төр, засгаас анхаарал хандуулж буйн тод илрэл <http://www.mlsp.gov.mn/nnews/547>

334 ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд төр, засгаас анхаарал хандуулж буйн тод илрэл <http://www.mlsp.gov.mn/nnews/547>

2018 оны байдлаар манай улсад нийт хүн амын 3.3 хувь нь буюу 103.6 мянган иргэн хөгжлийн бэрхшээлтэй. Тэдгээрээс 15-59 насны иргэдийн 28 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Түүнчлэн ийм иргэдийн 42 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа тул өвчнийг нь эрт илрүүлэх чиглэлд үйл ажиллагаагаа хандуулах нь тус агентлагийн зорилго байх аж.<sup>335</sup>

Цагдаа дотоодын цэргийн Сургалтын нэгдсэн төвд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хүрээнд Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны харъяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах хөтөч цагдаа бэлтгэх нь” сэдэвт хоёрдугаар ээлжийн модуль сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтад орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэс, тасгийн 23 алба хаагч хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс мэдээ мэдээлэл, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлүүлэх, туслалцаа үзүүлэх, дохионы хэлээр ярих чадвартай болж төгсөх юм.<sup>336</sup>

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчилгээ үзүүлэх анхдагч нэгж нь “Хамтарсан баг” юм. Хамтарсан баг нь тухайн сум, хорооны Засаг даргаар ахлуулсан, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, мөн энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн салбар дундын оролцоог хангасан зохион байгуулалт юм. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд өөрт шаардлагатай тусламж, үйлчилгээг Хамтарсан багийн аль ч гишүүнд хандан авч болно. Жишээлбэл, хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн

335 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгууллаа <http://unuudur.mn/%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9-%D1%85%D2%AF%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B5%D1%80%D3%A9%D0%BD%D1%85%D0%B8%D0%B9-%D0%B3%D0%B0%D0%B7%D0%B0%D1%80-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D0%BB%D0%B0%D0%BF/>

336 “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХАРИЛЦАХ ХӨТӨЧ ЦАГДАА БЭЛТГЭХ НЬ” СУРГАЛТ БОЛЛОО <https://police.gov.mn/a/4340>



тусламж авах шаардлагатай бол өрхийн эмчдээ шууд хандаж болно, харин өрхийн эмч нь цааш Хамтарсан багтаа хэргийг уламжилж, багаараа үзүүлэх тусламж, үйлчилгээг тодорхойлдог.<sup>337</sup>

Хүүхдийн тусламжийн утас 108 дугаар утсанд өдөрт 380-480 дуудлага тогтмол ирж байна. Үүний дийлэнх нь асран хамгаалах хүнгүй 4-5 насны хүүхдүүд байна. Эцэг, эх нь архины хамааралтай болсон, мөн бага насны хүүхдээ зодсон гэх дуудлагууд давамгайлдаг. Харин өсвөр насны хүүхдүүдээс эцэх эх нь тоохгүй байна, анхаарал дутуу тавьж, үл тоомсорлодог, өөртэй нь ярихгүй, сонсохгүй байна, ганцаардаж байна, амиа хорлох бодол төрж байна гэдэг шалтгаан нөхцөлтэй дуудлагууд зонхилж байна. Бид дуудлага бүрт тохирох зөвлөмж, мэдээллийг өгч тухайн нөхцөл байдлыг үнэлэн шаардлагатай тохиолдолд хамтарсан багт мэдээлж, хариу арга хэмжээ авдаг.<sup>338</sup>

337 Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Л.Бадамцэцэг Хамтарсан багийн талаар <http://www.arслан.mn/608759/sitem>

338 Мөн тэнд <http://www.arслан.mn/608759/sitem>

Нийслэлийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хараа хяналтгүй болон хараа хяналт сул, хөдөлмөр эрхлэгч, гуйлга гуйдаг, хог түүдэг, тэнэмэл хүүхдүүдийн байж болох газар Сүм хийдүүд, ПС тоглоомын газрууд, Зочид буудал, дэн буудал, саун, сүлжээ хоолны газруудад хяналт шалгалт хийх, илэрсэн хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, зөрчил илэрсэн газруудад хариуцлага тооцох зорилгоор “Илрүүлэлт-2019” нэгдсэн арга хэмжээг Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн газрын хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсүүд хамтран 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллалаа.<sup>339</sup>

Илрүүлэлтээр нийт 188 хүүхэд илэрсэн. Үүнээс:

- Ар гэрт нь эргэн нэгтгэсэн-157
- Асрамж халамжийн төвд-3
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байранд-28

хүүхдийг тус тус байршуулж ажиллалаа гэж Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраас мэдээллээ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай асуудал эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэгдсэн ч тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд нээлттэй ил тод байх шаардлагатай байна.

## Үүргийн мөргөлдөөн

Социологич Роберт Мертон, хүн хэд хэдэн үүргийг зайлшгүй биелүүлэх нөхцөлд үүргийн мөргөлдөөн үүсдэг гэж үзсэн. (Merton, 1949). Хүнд ажил ба гэр бүлийн үүргийн мөргөлдөөн үүсэх нь элбэг. Хувь хүний үүрэг нь дарамт болох цагаас институцийн уналт эхэлдэг. Иймд институцийн ачааллыг

339 Монгол Улсын засгийн газар “Илрүүлэлт-2019” нэгдсэн арга хэмжээ <https://www.zasag.mn/m/ulaanbaatar/view/22114>



**Ажил хийснээрээ гэр бүлдээ цаг гаргах боломжгүйдэхээс сэргийлж гэр бүлийн болон хөдөлмөр зохицуулалтын зөв бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна.**

хуваалцахын тулд нийгмийн бодлого хэрэгждэгийн нэг нь ажилтныхаа гэр бүлийг тухайн байгууллага анхааралдаа авах явдал юм. Ажил олгогч ажилтныхаа гэр бүлийг дэмжинэ гэдэг өөрсдийн ажлын бүтээмжийг дэмжиж буй хөрөнгө оруулалт мөн.

Орлого нь өрхийн амжиргааг залгуулж хүрдэггүйгээс үүдэж эдийн засгийн цаг ихэсч, ажлын байран дээр ихэнх цагаа өнгөрөөснөөр гэр бүлдээ, ялангуяа хүүхэддээ зарцуулах цаг багассаар байна. Гадаад улс орон руу явж ажиллаж, ар гэр рүүгээ мөнгө явуулдаг нь хэдийгээр тэд гэр бүл, хүүхдүүдийнхээ төлөө ажиллаж буй мэт боловч үнэндээ гэр бүл хийгээд хүүхдээс нь холдуулж байна. Тэгш бус боломж олгож буй тогтолцоо дундаж гэр бүлийн гишүүдийг салгаж байна. Ажил хийснээрээ гэр бүлдээ цаг гаргах боломжгүйдэхээс сэргийлж гэр бүлийн болон хөдөлмөр зохицуулалтын зөв бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

### **Дэд хэсгийн дүгнэлт**

Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хангах нь тулгамдсан асуудал болжээ. Гэр бүлийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн суурь шалтгааныг шийдвэрлэх үр дүнтэй механизмгүйгээр хүүхэд хамгааллын томоохон тогтолцоог үндэсний хэмжээнд бэхжүүлэхээр ажиллаж байгаа нь эргээд тогтолцоо нь ачааллаа даахгүй болох, хүүхдийг эрсдэлд оруулах магадлалтай юм. Иймд үндэсний хэмжээнд хүчирхийлэгч этгээдийн хүчирхийлэл үйлдэж буй суурь шалтгаан, тархалтыг тогтоох судалгаа хийж, тэдний зан үйлийг өөрчлөх бусад суурь шалтгааныг арилгах хариу арга хэмжээний болон үйлчилгээний төрлийг тодорхойлох, сайн туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай тулгарч байна. Энэ хүрээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, эцэг эхийн эрх хасах, хязгаарлах асуудлыг хуулиар нарийвчлан, тодорхой зохицуулах ч шаардлагатай юм. Мөн асрамж халамжийн төвийн хүүхдийг нийгмийн амьдралд өрсөлдөх, бие даан амьдрах ухаан, ур чадвартай иргэн болгох асуудлыг онцгой анхааран, сайн туршлага, арга зүйг нутагшуулах туйлын шаардлагатай байна..



Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.т “Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ” гэж заасан. Гэтэл энэ зүйл заалт хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл/эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь/ хууль зөрчиж хүүхдийн эрхэд халдсаар байгааг Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээнүүдээс харж болно. Иймд цаашид “хүүхдийг хүмүүжүүлэх” хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга гэж юуг хэлэх үүнийг хүүхэдтэй харилцах хүмүүст хэрхэн таниулж эзэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг Монгол Улсын төрөөс “Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогод зайлшгүй тусгаж, анхаарч ажиллах шаардлагатай. Одоогийн

Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөлд хүүхдийн эсрэг аливаа төрлийн хүчирхийлэл үйлдсэн эцэг эхийг албадан сургалтад хамруулах асуудал тусгагдсан хэдий ч тэдэнтэй ажиллах цогц арга зүйн асуудал тухайлбал, эцэг эх ажилгүй, орлогогүй ядуу байгаа учраас хүүхэд үл хайхрах хүчирхийлэлд өртөж байгаа бол төрөөс эцэг эх байх эрх хязгаарлахаас бусад ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуульд "... боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэнэ" гэсэн бол Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад "... хүүхдийг эцэг эхэд нь буцааж өгөх нь түүний эрх, ашиг сонирхолд харшлахаар байгаа бол ..." гэж эцэг эхийн эрхийг хязгаарлах асуудлыг ерөнхий байдлаар тусгасан нь нэг талаас эцэг, эхэд тодорхойгүй байдлыг бий болгож байгаа бол нөгөө талаас шүүх болон бусад эрх бүхий бусад байгууллагын тухайд ч зарим тохиолдолд ил тод биш эргэлзээтэй байдлыг үүсгэж болох юм.

Гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, эцэг, эх асран хамгаалагчдын зүгээс хүүхдэд үзүүлэх хайр халамж, тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл эцэг, эхчүүд хүүхдээ үл хайхарснаас болж хүүхэд гэмт хэргийн хохирогч болж байна.

## САЛБАР ДАМНАСАН ХҮЧИН ЗҮЙЛС БА ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧИД

### Хүүхдийн эрхийн улсын байцаагч

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д зааснаар хүүхдийн эрхийн ажилтан гэж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг ойлгодог. Харин хүүхдийн эрхийн улсын байцаагчид ямар шаардлага тавигдах, ямар субъектүүд хүүхдийн эрхийн улсын байцаагч болох талаар Хүүхдийн эрхийн тухай хуулиар зохицуулсан байна. Тус хуулийн 20 дугаар зүйлд зааснаар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх бөгөөд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшиж, сургалтад хамрагдсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгоно. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна. Мөн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан нь хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах чиг үүрэг бүхий субъект болох талаар тусгажээ.

Тиймээс Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийн эрхийн улсын байцаагчид холбогдох эрх, үүргийн хуульчилжээ. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9-т Энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээлэл хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ гэжээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.26-т зааснаар хүүхдийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/, 10.23 дугаар зүйл /Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль зөрчих/, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт /Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь

саад учруулах/ заасан зөрчлийг харьяалан шийдвэрлэх эрх хэмжээтэй байна.

Үүнээс гадна Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийн эрхийн ажилтан буюу хүүхдийн эрхийн улсын байцаагч нь нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болох эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг, нийгмийн ажилтан гаргах бөгөөд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагын ажилтан, алба хаагч дэмжих, холбон зуучлах үйлчилгээг үзүүлээгүй, эсхүл шаардагдах үйлчилгээг үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол энэ тухай хүүхдийн эрхийн ажилтан тэмдэглэл үйлдэж, төрийн албаны салбар зөвлөл, мэргэжлийн ёс зүйн хороонд хүргүүлж шийдвэрлүүлэх, хүүхэд асрах хувилбарт болон төвлөрсөн асрамжийн үйлчилгээнээс хүүхдийг гэр бүлд нь нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих зэрэг хүүхдийн эрхийн хэрэгжилттэй холбоотой маш олон үйл ажиллагааг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий субъект юм.

### Хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх нь

Монгол Улсын хүүхдийн эрхийн зөрчлийг /гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөл гэх мэт/ төрийн байгууллагад мэдээллэхээс эхлээд түүнийг хянан шийдвэрлэх хүртэлх механизм болон чиг үүрэг бүхий төрийн албан хаагчдын эрх хэмжээ зэргийг Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиудаар голлон тусгасан байна.

Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар<sup>340</sup> хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг эх, асран хамгаалагч,

<sup>340</sup> Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл.

харгалзан дэмжигч, бусад иргэн байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжинд заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргахаар байна. Энэ нь хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх нь тухайн этгээд хэн байхаас үл хамааран иргэн бүрт нээлттэй гэсэн үг юм.

Харин Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар<sup>341</sup> мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах чиг үүрэг бүхий этгээд нь нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч байна<sup>342</sup>. Мөн тус хуульд зааснаар хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно гэсэн өнөөгийн 108 утас юм. 108 утас нь хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой мэдээллийг цаг алдалгүй 24 цаг хүлээн авах, дээр дурдсан холбогдох чиг үүрэг бүхий этгээдүүдэд дамжин мэдээлэх зорилготой юм.

Тус ирүүлсэн мэдээ, мэдээлэл хүүхдийн эрхийн зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан буюу хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ<sup>343</sup>. Харин гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллага нь өөрийн чиг үүргийн дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ<sup>344</sup>.

Тус ирүүлсэн мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бол тухайн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан дангаар болон багаар газар дээр нь, байгаа орчинд нь очиж үзэх зэргээр шийдвэрлэхээр байна<sup>345</sup>.

### Хүүхдийн ядууралд өртөж буй нөхцөл байдал

Монгол Улсын нийт хүүхдийн 28.9% нь ядуу өрхөд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүмүүсийн 46%-ийг бүрдүүлж байна.<sup>346</sup>

341 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйл.

342 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1

343 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9

344 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.10

345 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8

346 Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017

### Хүснэгт 29. Хүүхдийн орлогын болон олон хэмжээст ядуурлын нөхцөл байдал

	Орон байр гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	Ариун цэврийн байгууламж гачигдалтай хүүхдийн эзлэх хувь	Ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхөд амьдарч байгаа 0-17 насны хүүхдийн хувь
0-2 нас	32	77	28.9
3-5 нас	78	76	
6-14 нас	38	13	
5-17 нас	15	12	

Эх сурвалж: Хүүхдийн орлогын болон олон хэмжээст ядуурлын дүн шинжилгээ, 2016

Үндэсний статистикийн хорооноос 2016 онд хийсэн “Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын шинжилгээ”-ний дүнгээс харахад 0-23 сартай дөрвөн хүүхэд тутмын нэг нь (25.9%) нэгэн зэрэг гурван төрлийн гачигдалд өртөж, арван хүүхдийн нэгд эцэг эхийн анхаарал дутагдсан байна. Бага насны хүүхдийн хувьд давхацсан гачигдлын хамгийн түгээмэл хослол нь ус, эрүүл ахуй, орон байр, хоол тэжээлийн гачигдлууд байжээ. Гачигдлаар илэрхийлсэн хүүхдийн ядуурал нь ихэвчлэн сумын төв, хөдөө орон нутаг, ялангуяа Баруун болон Хангайн бүс нутагт харьцангуй өндөр байна. Улаанбаатар хотоос бусад газарт аливаа хүүхэд нэгэн зэрэг 4-5 төрлийн гачигдалд орсон байх нь нийтлэг байгааг тогтоожээ. Түүнчлэн эхийн боловсролын түвшин доогуур, олон ам бүлтэй эсвэл малчин өрхийн хүүхдүүд ядууралд илүү өртөж байна. Ядуу өрхийн 12-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 67% буюу маш бага байна.<sup>347</sup>

Иймд орлогын ядуурлыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэхээс гадна хүүхдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бусад шаардлагатай арга хэмжээ, бодлогыг давхар авч хэрэгжүүлэх нь хүүхдийг эрүүл саруул

347 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл, 2018



өсөж бойжин, өрсөлдөх чадвартай иргэн болж улмаар үе дамжсан ядуурлын мөчлөгт өртөхөөс сэргийлэхэд чухал гэж үзэж байна.<sup>348</sup>

## Уур амьсгалын өөрчлөлт

Монгол орон дөрвөн улирал ээлжилсэн эх газрын эрс тэс уур амьсгалтай. Хамгийн их салхи шуургатай үе дөрөв, тавдугаар сард тохиодог. Нэгдүгээр сард хамгийн их хүйтэн, долоодугаар сард хамгийн халуун байдаг. Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур 2.24 хэмээр дулаарч, ууршиц ихсэж, тал хээр, говь цөлийн бүсэд хуурайшил 3-10 хувь, ойт хээрийн бүс, өндөр уулын бүслүүрт 10-15 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн ган, зуд болон хүчтэй салхи, шороон ба цасан шуурга, ширүүн аадар, уруйн үер зэрэг ус, цаг агаарын аюулт үзэгдлийн давтагдал сүүлийн хорь гаруй жилд 2 дахин ихсэж, тэдгээрээс үүдсэн эдийн засгийн хохирол нэмэгдсэн. Уур амьсгалын дулааралт, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтол цаашид энэ хурдцаар үргэлжилбэл экологийн томоохон сүйрэлд хүргэж болохын дээр улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын эрүүл мэнд, амьжиргаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх магадлал улам бүр нэмэгдэх болно.

Тус улсын агаарын температурын жилийн дундаж XXI зууны дунд үе гэхэд дунджаар 2.1-3.00С, зууны сүүлээр 3.1-5.00С-аар дулаарч XX зууны дулааралтын эрчээс ойролцоогоор 2-3 дахин илүү байх, хур тунадас 2030 оноос хойш 6-15 хувь нэмэгдэх, харин өвлийн улиралд 2050 он хүртэл 7-15 хувь, түүнээс хойших хугацаанд ойролцоогоор 50 хувь өсөх урьдчилсан тооцоо гарч байна. Эрдэмтдийн тооцоогоор дулааралт нь хуурайшилт, цөлжилтийг улам идэвхжүүлж, гадаргын ууршилт нь хур тунадасны бага хэмжээний өсөлтөөс даруй 6-10 дахин их байхаар байна. Дулааралтын улмаас цэвдэг, өндөр уулын мөстөлийн хайлалт улам идэвжих болно. Цамбагарав уулын мөстлийн зузаан 2040 оны үед 50 м-ээр, 2050-2060 оны үед 100 м-ээр,

<sup>348</sup> НҮБ-ын Хүүхдийн сангийн Нийгмийн бодлогын хөтөлбөрийн ахлагч Н.Энхнасан, «Тав хүртэлх насны хүүхдүүдийн 70 хувь нь нэгэн зэрэг дөрвөн зүйлээр гачигдаж байна», 2016



2070-2080 оны орчимд 200 м-ээр тус тус хайлах төлөвтэй байна. Цэвдэгт мандлын элэгдлийн улмаас Алтай, Хангайн нурууны ар хажуугаас эх авдаг голуудын усны нөөц зууны эхний хагаст нэмэгдэх магадлалтай боловч цаашид багасах болно. Зундаа их халж хуурайшин жилийн хүйтэн улиралд ордог цасны хэмжээ нэмэгдсэнээр зудын эрсдэл улам нэмэгдэж, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх байгалийн нөхцөл нэн хүндэрч болзошгүй.

Газар тариалангийн төв бүсэд улаан буудайн ургац 2011-2030 онуудад дунджаар 15 хувиар буурч болзошгүй байна. Дулааралтын улмаас Монгол оронд урьд өмнө ажиглагдаж байгаагүй дулаан орны шинэ өвчин дамжуулагчид тархах, хүнсний аюулгүй байдал алдагдаж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байна.

Хуурайшилт эрчимтэй явагдаж байгаагаас олон зуун гол, горхи, булаг шанд, нуур, цөөрөм хатаж ширгэн, бэлчээрийн

ургамлын ургац буурч, зүйлийн бүрдэл нь хомсдож байна. Бэлчээр доройтож, хэт халуун өдрийн тоо нэмэгдсэнээс мал сүрэг зун, намар тарга хүчээ бүрэн авч чадахгүй давжаарч зудын гамшгийг тэсвэрлэх чадвар нь буурч байна. Уур амьсгалын дулаарах үед зарим нутагт дулаан бүсийн ургамал тарих, газар тариаланд өмнө нь ашиглах боломжгүй байсан хүйтэн уур амьсгалтай зарим нутгийг эзэмших, байшин барилгын халаалтын хугацааг богиносгох, ханын зузааныг нимгэлэх боломж бүрдэх, зарцуулах цахилгаан эрчим хүч, дулааныг хэмнэх, гол мөрөн, нуурын мөсөн бүрхүүлтэй байх хугацаа богиносгох зэрэг эерэг нөхцөл бүрдэх боловч манай орны хувьд сөрөг үр дагавар нь эрс давамгайлахаар байна.<sup>349</sup>

Монгол Улс 2011 онд Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг баталж 2011-2021 онд хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр заасан бөгөөд нэгдүгээр үе шат буюу 2011-2016 онд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлж, эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхээр, хоёрдугаар үе шат буюу 2017-2021 онд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгаралтын өсөлтийг сааруулах үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх эхлэл тавигдана.

2017-2021 онд Хойт мөсөн далайн ай сав болон мөстлийн усны нөөц хуримтлуулах сангуудыг байгуулж эхлэх; бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах ажлыг өргөжүүлэх; голын эх, сав газруудын нэгдсэн менежментийг томоохон голуудыг хамруулан хийх; ойн нөөцийг бүрэн хамгаалалтад авах, нөхөн сэргээх, мод үржүүлэх ажлыг өргөжүүлэн хүлэмжийн хийн шингээх чадавхийг нэмэгдүүлэх; газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээг өргөжүүлэх; уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг биологийн олон янз байдлыг хамгаалах, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт өргөжүүлэх; уур амьсгалын өөрчлөлтөд

349 Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011

зохицсон мал аж ахуйн менежментийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх; хуурайшилттай нөхцөлд зохицсон ус хэмнэх, хөрс хамгаалах технологид тулгуурласан усалгаатай газар тариаланг өргөтгөх; агаар мандлын гаралтай аюултай ба гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх; хот, сууринд үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг өргөжүүлэх, усыг дахин ашиглах технологийн шийдлийг боловсруулан хэрэгжүүлэх; байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, бүтээмжийг дээшүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулж, карбон багатай эдийн засагт шилжих эхлэлийг тавих зэрэг ажлууд хийгдсэн байх ёстой байна.<sup>350</sup>

### Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхдийн эрх, хамгаалал

Сүүлийн жилүүдэд гамшгийн төрөл, тоо, давтамж нэмэгдэж, гамшгийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноороо хорогдох нь түгээмэл болжээ. Гамшиг онцгой байдлын үед хүүхдэд бие махбодын гэмтэл учрах, нийгэм сэтгэл зүйн хямрал, эцэг эхээсээ хагацах, тусгаарлагдах, мөлжлөг, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх зэрэг эрсдэлүүд бий болдог.<sup>351</sup>

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндайн үйл ажиллагааны хүрээ, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын гэрээ, Тогтвортой хөгжлийн зорилт-2030, 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хууль, 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн баталж, хууль тогтоомжийг сайжруулсан. Гэсэн хэдий ч боловсролын салбар дахь гамшгийн бэлэн байдал болон аюул эрсдэлгүй хамгаалагдсан орчинд боловсролыг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөл байдал, зохицуулалт учир дутагдалтай байгаа юм.<sup>352</sup>

350 Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011

351 “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал” үндэсний бодлогын чуулган, 2016

352 ХИС, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа, 2017; ХИС, “Зудад өртсөн малчин өрхийн хүүхдэд боловсрол нөхөн олгох нь” төсөл, 2018



Үндэсний хэмжээнд 7 аймаг болон Улаанбаатар хотын 8 дүүргийн 96 төрийн өмчит ЕБС-ийг хамруулан 2018 онд хийсэн Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаагаар, сургуулийн 52%, дотуур байрны 26% нь стандарт хүчин чадал хэтэрсэн; зөвхөн 27% нь гамшигт тэсвэртэй хүчитгэл сайжруулалт хийсэн; сургуулийн 51%, дотуур байрны 60% хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орц гарцгүй; сургуулийн 80% ирж очих зам хүүхдүүдийн эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй; мөн гамшигын үед авч хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны талаарх багш, сурагчид, эцэг эхийн ойлголт, мэдлэг дөнгөж 50% байгаа нь тогтоогджээ.<sup>353</sup>

Дийлэнх сургууль гамшигын эсрэг бэлэн байдлын төлөвлөгөөг хийдэг боловч түүнийг хэрэгжүүлэх төсөв хомс байдаг төдийгүй гамшиг, онцгой байдлын үед боловсролын үйлчилгээг тасалдуулахгүй үргэлжлүүлэх төлөвлөгөө, төсөв байхгүй байна.<sup>354</sup> Гамшиг, онцгой байдлын үеийн боловсролыг нөхөн олгох, тасалдуулахгүй

<sup>353</sup> Мөн тэнд

<sup>354</sup> Мөн тэнд

байхад чиглэсэн механизмыг бүрдүүлэх нь цаашид хүүхэд хичээлээс хоцрохгүй байх, сургууль завсардахгүй байх, улмаар хүүхдийн ирээдүйн сайн сайханд онцгой ач холбогдолтой юм. Түүнчлэн эрсдэлийн үнэлгээ, бэлэн байдлыг хангах төлөвлөлтийг хийх явцад бүх насны хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төлөөллийг оролцуулах зайлшгүй шаардлагатай талаар хуульд заасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.<sup>355</sup> Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад "... Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна." гэж заасан нь мөн л орон нутгийн түвшинд бодит ажил хэрэг болгохгүй байна.

Улмаар улам бүр өсөн нэмэгдэж байгаа байгалийн аюулт үзэгдлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үндэсний хэмжээний бодлого, үйл ажиллагаа нэн ялангуяа сургууль, цэцэрлэгийн орчинд ихээхэн үгүйлэгдэж байна. Одоогоор ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтын агуулга тусгагдаагүй байна. Иймд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтын агуулга оруулах, цэцэрлэг, сургууль бүр гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй байх, хүүхдийн оролцоог хангах, хуульд заасан зохих төсвийг төсөвлөж хэвших шаардлагатай байгаагаас гадна хамгийн гол нь боловсролыг нөхөн олгох, тасалдуулахгүй байхад чиглэсэн механизмыг бүрдүүлэх нь цаг үеийн шаардлага болжээ.

<sup>355</sup> Мөн тэнд

## Цахим орчин дахь хүүхэд хамгаалал

Манай улсын хувьд цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, ухаалаг утасны хэрэглээг дагаад цахим гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж, 2016 онд 97, 2017 онд 195, 2018 онд 659, 2019 оны 5 сарын байдлаар 384 буюу нийт 1,335 цахим гэмт хэрэг бүртгэгджээ.

Эдгээрээс дийлэнх нь эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүүхдүүд байдаг бөгөөд энэ нь цахим гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийн талаар мэдлэг дутмаг, бага насны хүүхдэд тавих хараа хяналт сул зэргээс үүдэлтэй юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт “Цахим мэдээлэлд хууль бусаар халдсан, цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэсэн, борлуулсан, хор хөнөөлт программ хангамж бүтээсэн, ашигласан, тараасан тохиолдолд 2,700-40,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн цахим гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байдаг. Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцогддог бөгөөд дэлхийн эдийн засагт жилд дунджаар 1 их наяд орчим ам.долларын хохирол учруулдаг аж. Уг гэмт хэргийг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй болсоор байна. Иймд цахим гэмт хэрэг гэж юу болох, түүний онцлог шинж чанар, гэмт этгээдүүдийн үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсноор хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой<sup>356</sup>.

Монгол Улсад цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил төлөвшилд сөрөг нөлөөтэй мэдээ мэдээллээс үүсэн гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой “Цахим орчинд хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл”-ийн төслийг боловсруулаад байна<sup>357</sup>.

356 Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газар, мэдээллийн сайт-Цахим гэмт хэргийн талаар онцлох баримтууд, 2020.2.14.- <https://gia.gov.mn/49/item/643>

357 ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл,



Цахим орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын телевизийн холбоо, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн төлөөлөл хамтран “Санамж бичиг” байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа талаар ХЭҮК-ын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэлд дурджээ<sup>358</sup>.

Цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр “Зөв тусгал”, “Илрүүлэлт”, “Хичээлийн шинэ жил” зэрэг нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд, “Цахим тоглоом” нэгдсэн шалгалт 3 удаа, хэсэгчилсэн арга хэмжээг дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд 78 удаа тус тус зохион

2020 он, 111 дэх тал.

358 Дээр дурдсан бүтээл, ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 111 дэх тал.



Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцогддог.



**Хүүхэд, өсвөр  
үеийнхний  
нийгмийн  
сүлжээний  
зохистой  
хэрэглээг бий  
болгох зорилгоор  
“Зөвийг түгээе”  
аяныг зохион  
байгуулсан.**

байгуулж, цахим тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг 213 аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 92 удаагийн сургалт, 22 удаагийн уулзалт, 5 удаагийн өдөрлөг, 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 12,310 иргэнийг хамруулжээ. Цахим тоглоомын хор уршгийг иргэдэд сурталчлах, хууль, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр 464 гарын авлага, 2,706 зурагт хуудас, 15,363 санамж, сэрэмжлүүлэг тус тус тарааж, ерөнхий боловсролын сургууль, цахим тоглоомын газарт 92 удаагийн сургалтад 4,520 хүүхдийг хамруулсан байна<sup>359</sup>.

Хүүхэд, өсвөр үеийнхний нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг бий болгох зорилгоор “Зөвийг түгээе” аяныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, “Fargo Foundation Mongolia” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 10 дугаар сард нэг сарын хугацаатай зохион байгуулжээ. Аяны хүрээнд цахим орчны зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 40 гаруй зурагт хуудас, 18 видео хичээл, 12 шторк, бусад мэдээ мэдээллийг бэлтгэн төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагын маркетингийн сувгаар олон нийтэд хүргэжээ<sup>360</sup>.

### **Лесбиян, гей, бисексуал, трансжендер хүүхдүүд**

Монгол Улсын соёрхон баталсан олон улсын эрх зүйн гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд бид хүүхдийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон билээ. 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд бэлгийн, хүйсийн чиг баримжаатай холбоотойгоор хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглосон боловч Лесбиян, гей, бисексуал, трансжендер хүүхдүүд хавчилт, шахалт, дарамтад нийгмийн бүхий л орчинд өртсөөр байна. Тухайлбал,<sup>361</sup>

359 Дээр дурдсан бүтээл, ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 109-110 дах тал.

360 Дээр дурдсан бүтээл, ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он, 110 дах тал.

361 ЛГБТ Төв, ЛГБТ хүүхдийн нөхцөл байдлын тайлан, 2017

- 79% ЛГБТ хүүхэд нь өөрсдийн бэлгийн чиг баримжаа, цөөнх байхтай холбоотойгоор ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхагдаж, хавчилт шахалтад ордог;
- 9.4% ЛГБТ хүүхэд нь бие махбодын хүчирхийлэлд хүндээр өртдөг;
- 45.16% ЛГБТ хүүхэд нь гэртээ ялгаварлан гадуурхагдаж, хүчирхийлэлд өртөж, хавчилт шахалтад ордог;
- 13% ЛГБТ хүүхэд нь өөрсдийн бэлгийн чиг баримжаа, цөөнх байхтай холбоотойгоор сэтгэцийн эмчид үзүүлэхдээ таагүй хандлагыг мэдэрдэг;
- 21% ЛГБТ хүүхэд боловсролын орчинд бэлгийн чиг баримжааны талаарх тодорхой хэмжээний мэдээлэлтэй танилцах боломжтой байсан;
- Зөвхөн 19 хүүхдийн 1 нь өөрсдийн бэлгийн чиг баримжаагаа ямар нэгэн аюулгүйгээр гэрийнхэндээ хэлжээ;
- Зөвхөн 19 хүүхдийн 1 нь өөрсдийн бэлгийн чиг баримжаагаа ямар нэгэн аюулгүйгээр найз нөхөд, ангийнхандаа хэлсэн байна.



**Нийгэмд ЛГБТ  
хүмүүсийг  
сэтгэцийн  
өвчтэй, гаж  
донтой зэргээр  
буруу ойлгох нь  
элбэг.**

Дээрхээс үзэхэд ЛГБТ хүүхдүүдийн талаарх эцэг эх, боловсролын болон эрүүл мэндийн ажилтан, нийгмийн мэдлэг, хандлага, ойлголт муу байгаагийн сацуу сургуулийн орчинд бэлгийн боловсрол олгох асуудал учир дутагдалтай, мөн багш, нийгмийн ажилтны ёс зүйн дүрэмд үзэн ядах өнгө аяс, хандлагыг хориглох талаар тусгаагүй байдаг зэрэг нь тэднийг ялгаварлан гадуурхалтад өртөхөд нөлөөлж байна. Улмаар нийгэмд ЛГБТ хүмүүсийг сэтгэцийн өвчтэй, гаж донтой зэргээр буруу ойлгох нь элбэг. Үүнээс үүдэлтэйгээр ЛГБТ хүүхдүүд нь сэтгэцийн өвчтэй болох, архи согтууруулах ундаа болон мансуурах бодист донтох, амиа хорлох, сэтгэл санаа болон бие махбодын дарамтад байнга өртөж байна.<sup>362</sup> Иймд ялгаварлан гадуурхах, мэдлэг хандлага өөрчлөх асуудлын тухайд бид ЛГБТ хүүхдүүдийн асуудлыг тусган нөлөөллийн үйл ажиллагааг чөлөөт нийгэм болон хүний ёсонд нийцүүлэн хийх нь зүйтэй байна.

362 Мөн тэнд



## Төсвийн зохистой хуваарилалт

Аливаа тэтгэмж, халамжийн бодлого нь халамжаас хараат байдлыг бий болгох ёсгүй байдаг. Харин ажилтай, орлоготой, бие даан амьдрах чадвартай иргэнийг бий болгоход чиглэсэн дэмжлэгийн аргыг үүрэг хариуцлагын механизмын хамт хэрэгжүүлдэг билээ.

Боломж, эрэлт хэрэгцээ, нөхцөл байдал зэргийг харгалзан, зах зээлийн нийгэмд харилцан адилгүй эдийн засаг, нийгмийн нөхцөлд амьдарч буй угаас ялгаатай хүмүүст тэгш хуваарилах бодлогыг хэрэгжүүлэх нь өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр дүнгүй дахин хуваарилалт болохоос гадна зорилтот бүлгийг бодитой дэмжихэд сөргөөр нөлөөлж байгааг анхаарах нь зүйтэй байна. Амьжиргааны доод түвшинг хангах болон тэгш, шударга хуваарилах асуудлуудыг ялгаж ойлгох шаардлагатай байна.

Гамшиг зудад он дараалан маш их төсвийг зарцуулж байна. Малын, бэлчээрийн зохистой ашиглалтыг бий болгосноор цөлжилт, элсний нүүдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход онцгой ач холбогдолтой төдийгүй ган зудад ч бэлэн байх нөхцөл байдлыг бий болгоно. Иймд төсвийн үр ашигтай хуваарилалтын талаарх судалгааг бүхий л салбар болон нэгдсэн байдлаар хийж, хэрэггүй зардлыг танах, хот, хөдөө, ядуу ерхийн, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдийг ижил, тэгш боломжоор хангах, хүүхдийн хөгжил, улс орны ирээдүйн сайн сайханд чиглэсэн хөрөнгө оруулалтыг түлхүү хийхэд анхаарах шаардлагатай байна. Үүнээс гадна өсвөр үе залуучуудын сонгуулийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

## 45 ТӨР, ИРГЭНИЙ НИЙГЭМ, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

Хүүхдийн эрхийн асуудал бүрийн тухайд хамаарах хамтын ажиллагаа, оролцоо, талуудын үүргийн талаар өмнөх хэсгүүдэд авч үзсэн болно. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын болон гэр бүлд зориулсан үйлчилгээг үзүүлэхэд төрөөс ТББ, иргэний нийгмийн оролцоог дэмжих, хамтран ажиллах бодлогыг барьж байгааг онцлууштай байна.

Гэсэн хэдий ч хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өрнүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, механизмыг төрөөс хараахан бий болгоогүй байна. Тухайлбал, уул уурхай, ерөнхий эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөн эрчимтэй өрнөж байгаа билээ. Энэ хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн хүүхдэд ээлтэй ажиллах хуваарийн бодлогыг дэмжих, мөн бичил уул уурхай эрхлэгчдийн хүүхдүүдийн талаар авч хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, хамтын ажиллагаа үгүйлэгдэж байна.<sup>363</sup>

Энэ асуудлаар 2017 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмжид төрийн аливаа

<sup>363</sup> НҮБ-ын Хүүхдийн Сан, Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөө, 2017



дэмжлэгийг хувийн хэвшилд үзүүлэхэд тухайн бизнесийн байгууллага нь хүүхдийн эрхийг хэр ханган хэрэгжүүлдгийг анхаардаг болох, хохирлыг арилгах арга хэмжээ авахуулдаг болох талаар онцолсон юм. Иймд төрийн урамшууллын болон хөшүүргийн механизмыг бүрдүүлэх нь хүүхдийн эрхийг бизнесийн салбарт хангахад чухал байна.

Үндсэндээ хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн ажиллагааг уялдуулах, үр дүнтэй болгоход чиглэсэн арга хэмжээг цаашид хөгжүүлэх, авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ЗӨВЛӨМЖ



### Боловсролын арга хэмжээний хүрээнд

Бага насны хүүхдийн хөгжил, СӨБ-д анхаарлаа үргэлжлүүлэн хандуулж, СӨБ-ын хүртээмж болон чанарыг сайжруулахад хөтөлбөрийн үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай. Үүнд: СӨБ-ийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хот суурин газрын хүүхдүүд болон хөдөөгийн малчдын хүүхдүүдийн нөхцөл, хэрэгцээнд нийцсэн сурч, хөгжих, улмаар сургуульд бэлтгэгдэхэд дэмжлэг үзүүлэхэд анхаарах, бага насны хүүхдийн хөгжлийн талаарх эцэг эхийн ойлголтыг нэмэгдүүлж, хандлагад нөлөөлөх замаар эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн тогтвортой хөгжүүлэх арга хэмжээ авч ажиллах хэрэгцээ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ЕБС-д тэгш хамруулан сургахтай холбоотой бодлого журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, эдгээр хүүхдүүдийн сурах эрхийг хангахад чиглэсэн ажлыг түлхүү хийх шаардлагатай байна. Үүнд салбар хоорондын мэдээлэл, уялдаа холбоог сайжруулах, ЕБС-ийн удирдлага, багш, ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжих боломж бололцоогоор хангах, сургуулийн сурагчид хамт олон, олон нийтийн дундах хэвшмэл, гадуурхах үзлийг бодит мэдээлэл, эерэг хандлагаар халахад хувь нэмрээ оруулах нь чухал болоод байна. Багшийн арга зүйг сайжруулах замаар бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хүүхдийн ялгаатай хэрэгцээнд тохирсон байдлаар хэрэгжүүлэх чадавхыг цаашид бэхжүүлэх шаардлагатай.

Дунд сургуулийн сурагчдад эрүүл мэндийн чанартай боловсролын суурийг тавьж өгөх нь эрүүл монгол хүн өсгөхөд чухал ач холбогдолтой гэдгийг анхаарч өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн хичээлээр болон хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр эрүүл амьдрах ухаанд суралцуулах хэрэгцээтэй байна. 2020 оны эхээр дэлхий нийтэд тархсан КОВИД-ын цар тахал, цаашид гарч болзошгүй байгалийн аюулт үзэгдэл, гамшиг зэрэгтэй уялдуулан боловсролын салбарт гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг сайжруулахтай холбоотой ажлууд нэн шаардлагатай болж байна.

Тиймээс онцгой байдлын үеийн боловсролын асуудалд анхаарлаа хандуулан салбарын хэмжээнд энэ чиглэлээр зөвлөлдөх, шат шатанд бэлэн байдлын төлөвлөгөөтэй болох, үүнд мониторинг хийж, сайжруулдаг байх тогтолцоог бий болгоход дэмжих ажиллах хэрэгтэй байгааг онцолж байна.

Боловсролын орчин дахь эрүүл ахуй, ариун цэврийн асуудал хангалтгүй, хэт ачаалалтай, барилга байшин хуучин байгаа учраас амьсгалын замын болон бохир гарын өвчин, хоол боловсруулах, шар зэрэг өвчлөлийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Энэ асуудалд төсөв хангалтгүй хуваарилагдаж байгаа учраас боловсролын орчин дахь эрүүл ахуй, ариун цэврийн асуудлаар хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна.



### Эрүүл мэнд, хоол тэжээлийн талаарх арга хэмжээний хүрээнд

Эрүүл мэндийн салбарын дийлэнх төсвийг урсгал зардал болон өвчлөлийг хожуу үед эмчлэхэд зарцуулж байгаа учраас урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгаа, нөлөөлөл, эрүүл зан үйлийг хэвшүүлэх арга хэмжээнд санхүү, хүний нөөц төдийлөн хүрэлцэхгүй байна. Иймд хүүхэд багачууд, залуучуудын ухамсар, мэдлэг, хандлага, эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээг зохих байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжтой байна.

Хараа, шүд, сонсгол, таргалалт, осол, гэмтэл гээд сэргийлж болох өвчин хүүхдүүдийн дунд ихээхэн тархалттай байна. Иймд эцэг эхчүүдийн хоол тэжээл, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг мөн тэдний хүүхдийнхээ эрүүл мэндийн байдлыг хянах чадавхыг нэмэгдүүлэхэд, ялангуяа өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, онцгой байдлын үед авч хэрэгжүүлдэг сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх сайн туршлага, бохирдлын сөрөг нөлөөг багасгах болон өвлийн улирлын үед амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, түгээхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, сургалт, нөлөөллийн ажлыг хийх боломжтой юм.



Түүнчлэн олон улсын нотолгоонд суурилсан ИНСПАЙР стратегийн хүрээнд тусгасан, эрүүл мэндийн боловсрол олгох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, амьдрах ур чадвар олгох, чадавх бэхжүүлэх зэрэг олон зорилгыг хангахад чиглэсэн, гэр бүл, олон нийт, үе тэнгийн мэдээлэл сурталчилгаа, сургалт, нөлөөллийн арга барилын дагуу хэрэгждэг сайн туршлага болсон төсөл хөтөлбөрүүдээс хэрэгжүүлэх боломжтой юм.<sup>364</sup>



## Иргэний эрх ба эрх чөлөөтэй холбоотой арга хэмжээний хүрээнд

Сонгуультай холбоотой хүүхдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, нөлөөллийн ажиллагаа хийх хэрэгцээтэй байна. Хүүхдэд ээлтэй төсөв хуваарилах аргачлалыг ашиглах, арга зүйг нэвтрүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд, УИХ-тай хамтран ажиллах боломжтой юм.

Хүүхдийн оролцоог хангах үлгэрчилсэн журам батлах хүрээнд хүүхдийн бодит оролцооны үр дүнгийн жишиг шалгуур үзүүлэлтийг нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор бий болгон тусгах ажлыг бусад төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх боломжтой байна. Хүүхдийн эрхийг бизнесийн салбарт хангахад чиглэсэн төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, механизмыг бусад төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх мөн боломжтой. Түүнчлэн хүүхдэд эрх зүйн боловсрол олгох, өөрийн эрх, үүргээ мэддэг байж, эрхээ зөрчигдөхөд хэнд хандахаа мэддэг болгох арга хэмжээг хэрэгжүүлэх; орон нутгийн удирдлагын түвшинд хүүхдийн оролцоог хангах зэрэг ажиллагааг хамтран, санаачлан хэрэгжүүлэх боломжтой юм.



## Хүүхэд хамгааллын арга хэмжээний хүрээнд

Хүүхэд хамгаалах тогтолцоог үргэлжлүүлэн бэхжүүлэх шаардлагатай байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эерэг аргаар хүмүүжүүлэх аргыг улсын хэмжээнд нэвтрүүлэх, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг бүх насны хүний онцлогт тохирсон хэлбэрээр өрнүүлэх, бүх шатны төрийн, төрийн бус, соёл, шашны байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай

364 WHO, INSPIRE: Seven Strategies for Ending Violence Against Children, 2016

хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хамтран ажиллах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой байна.

Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээний хүрээнд хамтарсан багийн гишүүдийн кейс илрүүлэх, бүртгэх, кейс менежментийн үйлчилгээг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн сацуу шаардлагатай гарын авлага, арга зүйн зааварчилгааг боловсруулан гаргах нь зүйтэй байна. Түүнчлэн, шат шатны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд нь хөтөлбөрийн үр дүнд хяналт, шалгалт явуулах болон мэдээллийн санг ашиглах чадавхаа бэхжүүлэх боломжтой юм. Хамтарсан баг нь салбар дундын бүтэц учраас оролцогч талуудын дээд удирдлагууд тус хамтарсан багийн үйл ажиллагааг хүүхдийн дээд эрх ашгийг хангах НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын дагуу ажлын тэргүүлэх чиглэлд авч үзэн, шаардлагатай хүний нөөц, хөрөнгө, зохицуулалтын бусад дэмжлэгээр тогтмол хангах шаардлагатай байна. Илрүүлэлт сайн байгаа хамтарсан багуудыг олон тооны зөрчил, хэрэг гарч байна гэж буруутгадаг практик байгаа нь харамсалтай.

Хохирогчийг нөхөн сэргээх ажиллагааны хүрээнд эерэг аргаар хүмүүжүүлэх арга, урлагийн сэтгэл засал, нийгэмшүүлэх циркээр дамжуулан хүүхдийг нөхөн сэргээх, хөгжлийг дэмжих зэрэг дэвшилтэт нөхөн сэргээх арга зүйг нэвтрүүлэх нь чухал байна. Түүнчлэн гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, боловсролын байгууллага, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн асуудал зэрэг хүүхэд хамгааллын асуудлууд тулгамдаж байгаа учраас сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхыг бүхий л боловсролын байгууллагын нийгмийн ажилтан, эмч, багш нарт төдийгүй эцэг эхэд эзэмшүүлэх, мэдээллээр хангах, зохих байгууллагуудтай хамтран ажиллах нь цаг үеийн шаардлага болсон.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн ихэнх дуудлага нь мэдээлэл, зөвлөгөө хүссэн дуудлага байсан, мөн өсвөр үе залуучууд, ялангуяа охидод зөвлөгөө өгөх үйлчилгээ дутагдалтай байгаа тул хүүхдийн эрх, эрүүл мэнд, хамгааллын асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгөх цахим платформыг ГБХЗХГ-тай хамтран бий болгох талаар судлах, турших боломжтой юм. Энэ хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих зорилгоор зохих эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой юм.

Хүүхдийг Ивээх Сан улс орнуудад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд дараах хүчин зүйлүүд чухал нөлөөтэй гэж үздэг. Үүнд: Хууль эрх зүйн орчин бүрдэх, бодлогын зохицуулалт хийгдэх, үндэсний хэтийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгагдах, Засгийн газрын байгууллагуудын үр дүнтэй зохицуулалт, нийгмийн үйлчилгээ үзүүлэгч хүчийг бүх талаар бэхжүүлэх, орон нутгийн зүгээс авах урьдчилан сэргийлэх ба яаралтай хариу арга хэмжээ авах механизм бий болгох, орон нутгийн зүгээс үзүүлэх халамж, асаргаа ба хамгааллын интенвенцүүд, хандлага ба туршлага, нөөц бололцоог хангалттайгаар тасралтгүй идэвхжүүлэх, мэдээлэл цуглуулах тогтолцоо бүрдүүлэх зэрэг болно. Хүүхдийг Ивээх Сан улс орнуудад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд дараах хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлөгддөг гэж үздэг. Үүнд: Системийн сэтгэлгээгүй төлөвлөлт, зохицуулалт ба системийн элементүүд хоорондоо уялдаагүй байх, системийн нийтлэг чиг хандлагаас гадуур дан ганц элементтэй ажиллах, хэт амбицтай эсвэл амбицгүй төлөвлөлт, орон нутгийн контекстэд тохиромжгүй загварыг стандартчилах, үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанарт биш хэлбэрт анхаарах, систем хуваагдмал ба бүрэн бус байх, зэрэгцээ, замбараагүй систем үүсгэхээс хамгаалагдсан байх, орон нутгийн итгэл үнэмшил, практик дээр суурилах тогтолцооны хүчин чармайлт хангалтгүй байх зэрэг болно.

**ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОТ ГАЗРУУДЫГ ЖИШЭЭЛЭН АВЧ ҮЗВЭЛ, НЭГ ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮН АМЫН ДУНДАЖ ТОО 7740, ҮҮНЭЭС 2718 ХҮҮХЭД, ӨРХИЙН ТОО 2066 БАЙНА.**

Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн үйл ажиллагааг боловсронгуй болгоход дараах алхмуудыг хийх шаардлагатай гэж ХИС үзэж байна.

Хүүхэд хамгааллын кэйс менежментэд баримт бичгийн нэг стандарт баримтлах, төр энэ үйлчилгээгээр дамжуулан хот хөдөөд хүүхэд эрхээ эдлэх тэгш боломжийг хангах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн эрсдэлт нөхцөл байдалд буй хүүхдийг илрүүлэх ажлыг дэмжих, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг нэмэгдүүлэх, хөрөнгө нөөцийг тасралтгүйгээр идэвхжүүлэх шинэлэг арга аргачлалыг

эрэлхийлэх шаардлагатай байна. Хүүхэд хамгааллын төсвийн хуваарилалтыг үр ашигтай, үр дүнтэй, хүрэлцээтэй байлгахад анхаарах шаардлагатай байна. Төсвийн төлөвлөлтөд хүүхэд зарцуулах хувь хэмжээг батлах, хүүхдийн төлөөх төсвийн шийдвэр, төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн боломж, чадавхыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна. Үйл ажиллагааны “амьд байх зардлаас” үргэлжийн бэлэн байдлын төсөвт анхаарах; төлөвлөлт, зарцуулалтын ур чадвар, хянах шаардлагатай байна.

Хамтарсан багийн гишүүд, тэр дундаа нийгмийн ажилтны мэргэшсэн байдалд анхаарах, мэргэжлийн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, дэмжих удирдлагын ёс зүйг сайжруулах ба дэмжлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Төрийн албанд тэнцэх ажилтны шалгуураар орон нутагт хэт өндөр шалгуур тавихаар нийгмийн ажилтан боловсрон хүчин олдохгүй байна. Тогтвортой байдлыг хангах зорилгоор орон нутгийн их дээд сургуультай урт хугацаанд хамтрах ажиллахын чухлыг зөвлөж байна.

Хамтарсан багийн гишүүд, тэр дундаа кэйс дээр ажилладаг нийгмийн ажилтны ажлын байрнаас авдаг стрессыг бууруулах ажлыг тогтмолжуулж, аюулгүй байдлыг хангах бодит механизм бий болгох, хамтарсан багийн гишүүдийг энэ чиглэлийн даатгалд хамруулах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.

Бүх шатны Хүүхдийн төлөө зөвлөл давтамжтайгаар Хүүхэд хамгааллын хамтарсан багийн сонголыг зохион байгуулж, салбар дундын уялдааг хангаж шийдвэр гаргаж дэмждэг байх хэрэгтэй байна.

Салбарын байгууллагуудын харъяалах удирдлагууд Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн үйл ажиллагаанд ач холбогдол өгч, ажилтнаа дэмжин ажиллахыг зөвлөж байна.

Системийн бусад бүрэлдэхүүнтэй хамтран ажиллах боломж ба талуудын чадамжийг бий болгох шаардлагатай байна.

Хүүхэд хамгаалалд Төр ба хувийн хэвшлийг түншлэлийг бий болгох нь чухал байна. Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлтэй хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр, урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол хамтран ажиллах бололцоог бий болгох хэрэгтэй байна.

Засаг дарга нарын ажлын үнэлгээнд “Хүүхдийн дээдэрхашгийг биелүүлж ажилласан” асуудлыг авч үзэх, хамтарсан баг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үед Захиргааны хариуцлага тооцох практикийг авч үзэх хэрэгтэй байна.

Хүүхдийн эрхийн тухай хуульд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль зүй, хөдөө аж ахуй, хоолны үйлдвэрлэл, бизнесийн зэрэг салбар чиглэлийн байгууллагын хүүхдийн эрхийг хангах үүрэг, оролцоог нэмэх; Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг харьяалах салбарын удирдлагын үүрэг, харьяалах салбарын дэмжлэгийг зааж оруулах хэрэгтэй байна.

Мөн олон улсад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, зохих арга хэмжээ авах талаарх нэгдсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг агуулсан цахим платформ хуудсыг нийгмийн ажилтан, эмч, багш зэрэг салбарын мэргэжилтнүүдэд төдийгүй бусад мэргэжлийн бус хүмүүсийг сургах, цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор ашигладаг сайн туршлагыг ХИС нь ГБХЗХГ-тай хамтран турших, хэрэгжүүлэх боломжтой юм. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх хуулийн төслийг боловсруулахад ГБХЗХГ-тай мөн хамтран ажиллах боломжтой юм.



### Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах нь чухал бөгөөд энэ хүрээнд хүүхэд өөрөө санаачлан өөрөө хэрэгжүүлэх арга хэмжээг боловсролын болон онцгой байдлын байгууллагуудтай хамтран өргөнөөр хэрэгжүүлэх боломжтой юм. Ингэхдээ гамшгийн эрсдэлийн үнэлгээнээс эхлээд гамшгийн эрсдэлийн чиглэлээрх авч хэрэгжүүлсэн ажлын хяналт-шинжилгээ, үнэлгээний бүхий л шатанд хүүхдийн утга учиртай оролцоог хангах шаардлагатай байна.

Гамшиг, онцгой байдлын өмнө, үед болон дараах бүхий л нөхцөлд хүүхдийн аюулгүй орчинд боловсрол эзэмших эрхийг тасралтгүй хангахад анхаарч, сургуулийн барилга байгууламжийн аюулгүй байдал, сургуулийн гамшгийн менежмент, гамшгийн эрсдэлийн талаарх боловсрол гэсэн гурван тулгуурт сургуулийн цогц аюулгүй байдлыг

хангах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна. Ялангуяа, цэцэрлэг, сургууль бүрийг гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөгөө боловсруулахад болон гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтын агуулгаар тэднийг хангахад нь онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах боломжтой юм. Ингэхдээ гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад тухайн жилийн төсвийн 1%-ийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулах талаар заасан боловч орон нутагт энэхүү үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул үүнийг хэрэгжүүлэхэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах болон гамшгийн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд хүүхэд хамгааллын чадавх, тогтолцоог бэхжүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Үүнд: хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах, төөрч салсан хүүхдийг гэр бүл нь эргэн нэгтгэх, боловсрол, эрүүл мэнд, өрхийн амьжиргаа зэрэг бусад салбаруудад хүүхэд хамгааллын асуудлыг уялдуулах, гамшиг онцгой байдал үүссэн нөхцөлд хүүхэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй, үр дүнтэй хүргэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлууд багтана.



### Хүүхдийн ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд

Хот, хөдөөгийн ядуу өрхийн болон нийгэм эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн хүүхэд болон 15-24 насны залуусыг ирээдүйдээ зохистой ажил, бизнес эрхэлж, орлоготой болоход нь туслах хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол эзэмшүүлэх, ажил мэргэжлийн сургалт, ажлын байрны дадлага, ажилд холбох чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Зорилтот бүлгийн өрхийн байдалд нийцсэн шаардлагатай мэдээлэл, ур чадварыг олгох, бичил санхүүжилт олгох, хэрэгцээт тоног төхөөрөмж, хөрөнгөөр дэмжих, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд холбох зэргээр өрхийн амьжиргааг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг богино болон урт хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн гамшиг, онцгой байдлын нөхцөлд хамгийн их өртсөн болон өртөх эрсдэлтэй, зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг хамгаалах, даван туулах чадавхыг нэмэгдүүлэх, амьжиргааг сэргээн босгоход чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд нөхцөлт болон нөхцөлт бус мөнгөн тусламжийн хөтөлбөр, хүнсний тусламж, хүнсний

талон түгээх, түр ажлын байраар хангах замаар орлого олох боломжоор хангах, хадгаламж нэмэгдүүлэх, орлого зарлагаа хянадаг болох, шаардлагатай мэдээлэл, ур чадварыг олгох, бичил санхүүжилт олгох, хэрэгцээт тоног төхөөрөмж, хөрөнгөөр дэмжих, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд холбох гэх зэрэг үйл ажиллагаа багтана.

Эдгээр өрхөд чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд гэр бүлийн гишүүдийн онцлог хэрэгцээг тооцож, эцсийн үр дүн нь хүүхдэд үр ашиг авчрах, тэдний хэрэгцээг хангасан байхад анхаарах нь нэн чухал.

Зорилтот бүлгийн хүүхэд залуус, өрхийг дээрх чиглэлүүдээр дэмжих чиглэлээр шийдвэр гаргагчдад нөлөө үзүүлэх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах нь зүйтэй байна.



### Хамтын ажиллагааны хүрээнд

ГБХЗХГ нь ХИС-гийн гол хамтран ажиллагч байгууллага бөгөөд үүнээс гадна хүүхдийн эрхийн асуудал бүрийн тухайд тухайн салбарын, ялангуяа БСШУСЯ, ХНХЯ, ЭМЯ ОБЕГ-тай, мөн бүх шатны төрийн байгууллагатай хамтран ажиллах нь чухал байна. Үүний зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэднийг чадавхаа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээс гадна соёл, шашны байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хүүхдийн эрхийн мэдлэг хандлага, гэр бүлийн нандин харилцаа, бат бөх байдлыг дэмжих, нэмэгдүүлэхэд нөөц бололцоогоо нэгтгэн хамтран ажиллах боломжтой юм. УИХ-ын эмэгтэйчүүдийн бүлэг нь эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг учраас нөлөөллийн ажиллагаанд тэдэнтэй хамтран ажиллахаас гадна хүүхдийн эрх ашгийг үр дүнтэй төлөөлөхөд нь дэмжлэг үзүүлэх үүднээс тогтмол мэдлэг, мэдээлэл солилцох урсгалыг бий болгох нь чухал юм.

## Эх сурвалж

### Монгол хэлээр:

1. Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ, ХИС, 2018 он
2. Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн хүрээ (2018-2025), iv тайлан, ҮХГ, НҮБ, 2018 он
3. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан ҮСХ, 2018 он
4. Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, 2017 он
5. “Ядуурлын дүр төрх” тайлан, ҮСХ, Дэлхийн Банк, 2018 он
6. “Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ”, ҮСХ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2019 он
7. Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, гүйцэтгэлийн аудитын дүн
8. Дэлхийн Банк Монголд Тойм, Дэлхийн Банк, 2018 он
9. “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга”, 2019, ҮСХ, 2019 он
10. Монгол Улсын өрийн өнөөгийн байдал, Монгол банк, 2018 он
11. ҮСХ, Коронавирус ба эдийн засаг, 2020 он
12. Гадаад худалдааны тойм, Монгол Банк, 2020 оны 6 сар
13. Алсын хараа 2050, 2019 он
14. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2019 он
15. Дэлхийн банк, Монголын эдийн засгийн тойм, 2018 он
16. МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019 он
17. Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, COVID-19 ба Хөгжлийн бэрхшээл, 2020 он
18. Коронавируст цар тахлын үр нөлөөний түргэвчилсэн үнэлгээ, Хүүхдийг Ивээх Сан, 2020 он
19. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний хөгжлийн үзүүлэлт, 2018 он
20. МУ-ын Засгийн Газар, Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019 он
21. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 19 дэх илтгэл, 2020 он
22. Суурь судалгааны тайлан, ЖҮХ, ҮСХ, 2020 он
23. 2018, 2019 оны төсвийн гүйцэтгэл, Сангийн Яам
24. ҮСХ-ны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он
25. Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, «Бага дунд боловсролын жендерийн дүн шинжилгээ,» Швейцарийн Хөгжлийн Агентлаг, 2016 он

26. НҮБ-ын Хүүхдийн Сан, «Өсвөр насны охидын сарын тэмдгийн эрүүл ахуй» Улаанбаатар, 2017 он
27. Хүний Эрхийн Үндэсний Комисс, «Монгол Улсын Хүний Эрхий Үндэсний Комиссын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан» Улаанбаатар, 2019 он
28. Монгол Улсын Их Сургууль: Социологи, Нийгмийн ажлын тэнхим, «Н.Болдмаа: Дээд боловсролын салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага» Социологи, pp. 162-171, 2019 он
29. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2018 он
30. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг” танилцуулга
31. ХЗҮХ, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, 2016 он
32. Дэлхийн Банк, Дэлхийн Банк Монголд Тойм, 2018 он
33. ҮСХ, Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд, 2019 он
34. НҮБ-ын Хүүхдийн Сан, “Хүйтэн уур амьсгалтай орнуудын ариун цэврийн байгууламжийн шийдэл” олон улсын зөвлөлдөх уулзалтын материалууд, 2017 он
35. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006
36. Д.Баярсайхан, Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал, 2012 он
37. Транспэрэнси Интернэшнл, Авлигын төсөөллийн индекс, 2019 он
38. Азийн Хөгжлийн Банк, Иргэний нийгмийн танилцуулга: Монгол Улс, 2019 он
39. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, ХЗДХЯ, ШХА, Баасанжав Консалтинг, Иргэдийн оролцоо II төсөл, 2017 он
40. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017 он
41. Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхтэй холбоотой хууль эрхзүйн баримт бичиг эмхэтгэл, УИХ, ХНХЯ, 2019 он
42. ХНХЯ, ГБХЗХГ, ЖАЙКА, ХИС, “Монгол Улсад Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөгөөний материалууд, 2018 он
43. Дэлхийн Банк, «Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн» Улаанбаатар, 2016 он
44. ҮСХ, “Боловсрол, Шинжлэх Ухаан 2018: Монгол Улсын Боловсролын салбарын 2018 оны танилцуулга,” Улаанбаатар, 2019 он
45. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, «Малчдын аж байдлын судалгаа» Улаанбаатар, 2018 он

46. Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, «Боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн товч танилцуулга» Улаанбаатар, 2019 он
47. Үндэсний Статистикийн Хороо, «Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018» Улаанбаатар, 2019 он
48. Дэлхийн Банк, «Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний Хүртээмж, Чанар ба Хүүхдийн Хөгжлийн Үр дүн» Улаанбаатар, 2016 он
49. Монгол Улсын Засгийн газар, «Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр» Улаанбаатар, 2017-2020, 2017 он
50. Баян-Өлгий аймаг засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, Нийгмийн зарим үзүүлэлтүүд 2019 он
51. Үндэсний Аудитын Газар, «Баян-Өлгий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан» Өлгий хот, 2019 он
52. Сангийн Яам, «Иргэдийн Төсөв 2020: Монгол Улсын Нэгдсэн Төсвийн Төсөл» Улаанбаатар, 2020 он
53. Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, «2019 оны үйл ажиллагааны тайлан» Улаанбаатар, 2020 он
54. Азийн Хөгжлийн Банк, «Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудлаарх суурь судалгаа» Эрдэм патнерс, Улаанбаатар, 2019 он
55. Үндэсний Статистикийн Хороо, «Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ» Улаанбаатар, 2019 он
56. Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, «Боловсролын салбарын тойм судалгаа» Улаанбаатар, 2013 он
57. Эрүүл мэндийн хөгжлийн төв - Эрүүл мэндийн үзүүлэлт 2018,2019 он
58. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018 он
59. Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан “Монгол Улс – Нийгмийн түүвэр судалгаа – 2018 инфографик” 2018 он
60. Ц.Амаржаргал “Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс 2019”, 2019 он
61. Үндэсний Статистикийн Хороо “Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд”, 2019 он
62. ГССҮТ, Осол гэмтлийн тандалтын тайлан 2018 он
63. ХХААХҮЯ Монгол Хүүхдийн биеийн хэмжээ тодорхойлох судалгаа, 2019 он
64. Эрүүл мэндийн хөгжлийн төв “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 2020 оны эхний 3 сарын байдлаар”
65. Үндэсний Статистикийн Хороо “Эрүүл мэндийн салбарын танилцуулга”, 2019

66. 2018-2020 оны Төсвийн тухай хууль.
67. ЭМЯ. НҮБ-ын Хүүхдийн сан. 2017 он, Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал: Үндэсний тав дахь судалгааны тайлан. Улаанбаатар.
68. ЭМЯ. АХБ. 2018 он, Монгол Улс дахь стандартын бус, бүртгэлгүй, дуураймал эмийн тархалтын судалгаа. Төслийн эцсийн тайлан. Улаанбаатар.
69. Монгол Улсын Үндсэн хууль
70. А. Хишигтөгс, Социоаналитик: Ерөнхийллийн онол, 2018 он
71. НҮБ-ын Хүүхдийн Сан; Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, «Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн сүм хийдэд татагдаж буй шалтгаан: Түргэвчилсэн үнэлгээний тайлан,» Улаанбаатар, 2014 он
72. Хүүхдийг Ивээх Сан, Хүүхэд Хүүхдийн Төлөө ТББ, Дэлхийн Зөн Монгол “Бүх хүүхдийн эрхийн төлөө: НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх Хүүхдийн илтгэл - Монгол Улс,» Улаанбаатар, 2015 он
73. Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, «2019 оны үйл ажиллагааны тайлан,» Улаанбаатар, 2020 он
74. Цагдаагийн Ерөнхий Газар, 2019 оны улсын нийт дүн
75. Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Статистикийн газар, «Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал,» Улаанбаатар, 2018 он
76. ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2020 он
77. НҮБ-ын Хүүхдийн Сан. Хүүхэд бүр төрснөө бүртгүүлэх эрхтэй: Төрсний бүртгэлийн тэгш бус байдал болон хандлага. Нью-Йорк: НҮБ-ын Хүүхдийн Сан, 2013 он
78. Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт, «Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын статистик,» ХНХЯ, Улаанбаатар, 2018 он
79. Дэлхийн Банк, «Улаанбаатар хотын ядуурлын байдал: Ядуурлын хэлбэрүүдийг ойлгон, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь» Улаанбаатар, 2016 он
80. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он.
81. ЦЕГ, Улсын хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 6 дах тал ; ЦЕГ, Улсын хэмжээнд 2020 оны 02 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг
82. ХЭҮК, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он
83. Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дах илтгэл, 2020 он
84. Хүүхэд хамгааллын кластерын 2020 оны эхний улирлын тайлан.
85. UPR- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 3 дах илтгэл (төсөл
86. Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагын хамтарсан “Иргэний оролцоо 2” төслийн хүрээнд “МУ-ын хуулиуд дахь иргэний оролцооны

- талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ судалгааны үр дүнгийн тайлан, 2018 он
87. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Д.Нямгэрэлийн 2018 оны 7/1726 тоот албан бичгээс хэсэгчлэн тусгав.
88. Монгол Улсын Засгийн газар 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”.
89. ЭХХШтХууль
90. Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл, 2018
91. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2018 он “Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар” судалгааны дүнгээс
92. УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Конгрессыг зохион байгуулах үндэсний хорооны дарга С.Чинзориг “Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын санаачилга, туршлага, сургамж” илтгэл
93. “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан,
94. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017
95. Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл, 2018
96. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011
97. ХИС, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдлын суурь судалгаа, 2017; ХИС, “Зудад өртсөн малчин өрхийн хүүхдэд боловсрол нөхөн олгох нь” төсөл, 2018
98. ХИС, 2013-2019 оны жилийн үйл ажиллагааны тайлан
99. “Гэр бүл-хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин” эцэг эхийн үндэсний зөвлөгөөн, 2017
100. Хүүхдийн төлөө үндэсний газар, Цахим орчин дахь хүүхэд хамгаалал, 2015
101. Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх ухааны сургуулийн Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхим, 2016; Eagle news, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар хэлэлцэж байна, 2018
102. ХИС, “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа, 2017, 9 дэх тал
103. ХЗҮХ, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” судалгаа, 2013
104. Мөн тэнд
105. Б.Баярмаа, Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, СЭМҮТ, 2018
106. ХНХЯ, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хурал, 2018
107. Эшлэл 360, мөн тэнд
108. ЛГБТ Төв, ЛГБТ хүүхдийн нөхцөл байдлын тайлан, 2017
109. Мөн тэнд

110. АХБ, Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2015, 12 дахь тал
111. Мөн тэнд, 18 дахь тал
112. 2017 оны Төсвийн тухай хууль
113. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Иргэдэд «Эрдэнэт»-ээс хувьцаа эзэмшүүлж, хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгохоор боллоо, 2017
114. НҮБ-ын Хүүхдийн Сан, Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөө, 2017

#### Англи хэлээр:

1. World economic forum, The global gender gap index 2020, 9-р тал
2. Fund for Peace, the Flagile States Index 2019
3. World risk report, 2019
4. IQAir, World air quality report, 2018, 2019
5. World Bank, Worldwide governance Indicators, 2018
6. Gro M. Foucault, Discipline and Punish: The Birth of the Prison, Knopf Doubleday Publishing up , 2012.
7. N. Smelser, Sociology, New Jersey: Prentice Hall, 1988.
8. A. Giddens, Sociology, Cambridge: Polity Press, 2009.
9. I. Illich, Deschooling Society, Harmondsworth, 1973.
10. Protection Cluster Situation Report (16 April 2020)
11. World Health Organization. 2017. Joint External Evaluation of International Health Regulation Core Capacities of Mongolia. Geneva.
12. J.Dorjdagva et al. 2016. Catastrophic Health Expenditure and Impoverishment in Mongolia. International Journal for Equity in Health. 15(105).
13. UNDP. 2019. Overview of the Human Development Report 2019. Beyond income, beyond averages, beyond today: Inequalities in human development in the 21st century. New York.
14. М, Блак нар. “Бага Насны Хүүхдийн Хөгжилд Анхаарах нь: Амьдралын Мөчлөгүүдээр Ангилсан Шинжлэх Ухаанч Нотолгоо.” Ланцет 389, дугаар. 10064 (2016): 77-90. doi:10.1016/s0140-6736(16)31389-7; Ж, Шонкофф нар. “Бага Насны Хүүхдүүдэд Учирч Буй Саад Бэрхшээл, Хөнөөлт Сэтгэл Зовнилын Насан Туршийн Нөлөө.” Педиатрикс 129, дугаар. 1 (2011): 232-46. doi:10.1542/peds.2011-2663.
15. J. Cassidy, “The Nature of a Child’s Ties,” in Handbook of Attachment: Theory, Research and Clinical Applications, New York, Guilford Press, 1999, pp. 3-20.

16. Bandura, Aggression: A social learning analysis, Englewood Clidds, NJ: Prentice Hall, 1973.
17. Ainsworth, Patterns of Attachment: A Psychological Study of the Strange Situation, Hillsdale: Lawrence Erlbaum, 1978.
18. A. Giddens, Sociology, Cambridge: Polity Press, 2009.
19. A.F.Weber, The Growth of Cities in the Nineteenth Century: A Study in Statistics, HardPress Publishing, 2012.
20. United Nations Emergency Response Fund, CERF Annual Report, 2016
21. Dandarchuluun Khishigt, The Effects of Universal Child Benefits on Female Labor Supply and Household Expenditure in Mongolia, Degree of Doctor in Economics of Graduate School Korea University, 2017
22. WHO, INSPIRE: Seven Strategies for Ending Violence Against Children, 2016
23. ДЭМБ, Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан, 8 дэх нүүр. [https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO\\_NMH\\_VIP\\_11.01\\_mon.pdf?jsessionid=271CEC82724724B29DF51BF2AB46D2BD?sequence=61](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO_NMH_VIP_11.01_mon.pdf?jsessionid=271CEC82724724B29DF51BF2AB46D2BD?sequence=61)

#### Хууль тогтоомж:

1. Үндсэн хууль
2. Хүүхдийн эрхийн тухай хууль
3. Хүүхэд хамгааллын тухай хууль
4. Донорын тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010 он
7. Төсвийн тухай хууль 2018, 2019
8. Багшийн хөгжлийн тухай хууль
9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
10. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
11. Зөрчлийн тухай хууль
12. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль
13. Иргэний хууль
14. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
15. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
16. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
17. Эрүүгийн тухай хууль
18. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль
19. Эрүүл ахуйн тухай хууль

20. Гэр бүлийн тухай хууль
21. Боловсролын тухай багц хуулиуд
22. Гамшгаас хамгаалах тухай хууль
23. Төрийн албаны тухай хууль
24. Сонгуулийн тухай хууль болон бусад хуулиад
25. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016
26. Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016
27. Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2016-2020, 2016
28. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2017
29. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
30. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017-2026), 2017
31. “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021), 2010
32. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр (2016-2025 он), 2015
33. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
34. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2018-2022), 2017
35. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
36. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025), 2016
37. Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр (2019-2022), 2019 (15-34 нас)
38. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр, (2018-2023), 2018
39. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2020), 2017
40. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2017-2025), 2017
41. Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
42. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2017-2021), 2017
43. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, (2017-2021), 2017
44. “Осол, гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөр, (2018-2022), 2018
45. “Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр, (2019-2023), 2019
46. “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2015-2020), 2019
47. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2019-2024), 2019
48. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2024), 2016
49. Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2011-2020), 2011

### Цахим мэдээллийн сан:

1. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <http://www.1212.mn>
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <http://www.legalinfo.mn>
3. Цагдаагийн Ерөнхий Газар-ын цахим мэдээллийн сан [www.police.gov.mn](http://www.police.gov.mn)
4. Цаг уур, орчны шинжилгээний газар [www.namem.gov.mn](http://www.namem.gov.mn)
5. Дэлхийн Банк <https://www.worldbank.org/mn/country/mongolia/overview>
6. ОБЕГ, <https://nema.gov.mn>
7. ҮСХ <https://www.nso.mn>
8. ГБХЗХГ-ын мэдээллийн сан- <http://www.fcy.gov.mn>
9. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, мета мэдээллийн сан <https://mecss.gov.mn>
10. Korea Herald мэдээллээс орчуулсан линк, <https://ikon.mn/n/1q0k>
11. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, Улаанбаатар, 2017. 37 дахь нүүр [http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514\\_02.pdf](http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514_02.pdf)
12. Баян-Өлгий аймаг засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, Хүн ам, өрхийн тоо 2019, <http://www.bayan-ulgii.nso.mn/>
13. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, Улаанбаатар, 2017. 37 дахь нүүр. <http://www.hudulmur-halamj.gov.mn>
14. Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл байдлыг зөрчсөн 5423 асуудал байна. <http://www.ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=41562>
15. Төслийн тайлант үйл ажиллагааны үеэр төслийн багийнхнаас өгсөн ярилцлагаас дурдав. <https://ikon.mn/n/1dyo>
16. ДЭМБ-Нээлттэй нийгэм форум-“Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл” асуудал дэвшүүлсэн тайлан-[https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028\\_mon.pdf?sequence=9&isAllowed=y](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y)
17. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар <https://mlsp.gov.mn/uploads/news/files/3b7c0cd4a89b54380c5f1bea0787488c24c58abd.pdf>
18. [https://www.unicef.org/publications/files/Birth\\_Registration\\_11\\_Dec\\_13.pdf](https://www.unicef.org/publications/files/Birth_Registration_11_Dec_13.pdf)
19. 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2019 оны 6-р сарын 20-ны өдөр, <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-trafficking-in-persons-report-mn/>



20. Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан-2019 [https://drive.google.com/file/d/1vcgQDKYh3Bo-RNHjYJdWm3r91Izcybsf\\_/view](https://drive.google.com/file/d/1vcgQDKYh3Bo-RNHjYJdWm3r91Izcybsf_/view)
21. <http://www.zaluucom.mn>
22. <https://montsame.mn>
23. Нээлттэй нийгэм форум. Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл асуудал дэвшүүлсэн тайлан. [https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028\\_mon.pdf?sequence=9&isAllowed=y](https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y)
24. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-human-rights-report/>
25. <http://forum.parliament.mn/projects/56>
26. <http://eagle.mn/>
27. НХГБХГ <http://child.gov.mn>
28. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар <http://hudulmur-halamj.gov.mn>
29. ХНХЯ <http://www.mlsp.gov.mn>
30. Монгол Улсын засгийн газар “Илрүүлэлт-2019” нэгдсэн арга хэмжээ <https://www.zasag.mn/m/ulaanbaatar/view/22114>
31. 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2019 оны 6-р сарын 20-ны өдөр, <https://mn.usembassy.gov/mn>
32. ОУХБ <https://www.ilo.org>
33. ГХЯ [www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn)
34. МХЕГ-ын мэдээ мэдээлэл, <http://home.inspection.gov.mn>

© Гэрэл зургийн эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.



**Save the Children**

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Аризона төв, 3, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [Mongolia.secretary@savethechildren.org](mailto:Mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

ISBN: 978-99978-895-4-6



9 789997 889546